НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

ЦУВРАЛ 7

НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

ЦУВРАЛ 7

Улаанбаатар, 2022

ННА 67.3
ДАА 340.009
Ш-978

НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА
ЦУВРАЛ 7

СУДЛААЧИД:
1. Б.Хонгорзул, Б.Доржпагма
2. М.Сувд, Д.Эрдэнэчимэг, М.Ариунаа
3. Б.Энхбаяр, Б.Досжан

Дугаар хариуцсан редактор С.Билгүүн

© Нээлттэй Нийгэм Форум, 2022.

Энэхүү цувралд багтсан судалгаануудын дүгнэлт, санал нь судалгааг хийж гүйцэтгэсэн судлаачдын байр суурь, үзэл бодол бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN 978-9919-9926-3-7

Шүүхийн шийдвэрийн судалгаа

ЦУВРАЛ 7

1 БАГА ҮНИЙН ДҮНТЭЙ ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БҮЙ ШҮҮХИЙН ПРАКТИКТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ 9

2 АРБИТРЫН ҮНДСЭН ШИЙДВЭРТЭЙ ХОЛБООТОЙ ИРГЭНИЙ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ПРАКТИК 93

3 ГЭНЭТИЙН БҮЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧНИЙ ШИНЖТЭЙ ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛААС ҮҮССЭН ХЭРЭГ МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ 175

ӨМНӨХ ҮГ

Энэ удаагийн шүүхийн шийдвэрийн судалгааны цуврал иргэний шүүхийн шийдвэртэй холбоотой гурван тайланг танилцуулж байна. Сүүлийн жилүүдэд иргэний шүүхийн шийдвэрийн судалгаа эрчимжиж, олон төрлийн маргаан шийдвэрлэж буй дотоодын шүүхийн практикийг бусад улсын эрх зүйн зохицуулалтын онцлог, практиктай харьцуулан судалсан судалгааны тоо нэмэгдэж байна.

Бага үнийн дүнтэй хэрэг маргааныг талуудын хувьд чирэгдэл багатай, шүүхийн хувьд үр ашигтайгаар хэрхэн ажиллаж шийдвэрлэх, арбитрын шийдвэрийг шүүхэд хянан шийдвэрлэхэд ямар асуудалд түлхүү анхаарах, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүссэн маргааныг талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс хэрхэн шийдвэрлэх зэрэг иргэдийн эрх ашгийг хөндсөн, тулгамдаж буй асуудлуудыг сонгон судалсан нийт судлаачдадаа талархал илэрхийлье! Судалгааны тайланд шүүмж бичиж ажилласан хууль зүйн доктор, дэд профессор Т.Мэндсайхан, дугаар эрхэлсэн редактор С.Билгүүн, хэвлэлийн редакторааар ажилласан С.Отгонцэцэг нарт гүн талархал илэрхийлье!

Нээлттэй Нийгэм Форумын шүүхийн шийдвэрийн судалгааны тэтгэлэгт хөтөлбөр 2022 оны хувьд нээлттэй үргэлжилж байгаа бөгөөд судлаач, хуульчид шүүхийн практикт тулгамдсан, ач холбогдол бүхий асуудал сонгон, судалгааны төсөл ирүүлэх боломжтойг энэ ташрамд дуулгая.

ННФ-ын Гүйцэтгэх захирал
П.Эрдэнэжаргал

РЕДАКЦЫН ЗУРВАС

Нээлттэй Нийгэм Форумын Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд эрхлэн гаргадаг шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний энэ удаагийн цуврал гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас үүссэн маргаан, арбитрын үндсэн шийдвэрийг давж заалдах журмаар шүүх хянан шийдвэрлэж байгаа практик болон бага үнийн дүнтэй иргэний хэргийг хянан шийдвэрлэж буй шүүхийн практикийг судалсан судалгааг багцлан Та бүхэнд толилуулж байна.

Уг цуврал арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдлийг Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээс хянан шийдвэрлэсэн байдлын талаарх судалгаа орсон. Тус судалгаа Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээс энэ төрлийн маргааныг хянан шийдвэрлэж буй практик, тулгамдаж буй асуудлууд, гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал зэргийг тусгаснаараа хууль тогтоомжийг нэг мөр ойлгож хэрэглэх зэрэг ач холбогдолтой.

Мөн цуврал бага үнийн дүнтэй маргааныг иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэж буй практикийг судалсан судалгаа багтсан. Монгол Улсад шүүхийн шинэтгэлийн үйл явц эрчимтэй өрнөж байгаа боловч шүүхээс хэрэг шийдвэрлэх арга, ажиллагааг журамласан процессын хуулиудын шинэтгэлийг

хийгээгүй байна. Процессын хууль тогтоомжийн шинэтгэлийн нэг чиглэл нь бага үнийн дүнтэй хэрэг маргааныг бага зардлаар, түргэн шуурхай, чирэгдэл багатайгаар шийдвэрлэж, шүүхийн ачааллыг багасгах, бүтээмжийг нь нэмэгдүүлэхэд чиглэх учиртай. Тус судалгаагаар энэ төрлийн иргэний хэргийг шийдвэрлэж буй одоогийн практик, гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт, туршлага зэргийг тухайлан шинжиж судалсан нь цаашид хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгоход дөхөм болно гэж найдаж байна.

Сүүлийн хоёр жилийн хугацаанд үргэлжилсэн Ковид-19 цар тахалтай холбоотойгоор нийгэм, эдийн засгийн олон төрлийн сорилт тулгарсан хэвээр байна. Энэхүү цуврал орсон судалгаанд Ковид-19 цар тахал болон гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй бусад онцгой нөхцөл байдлын улмаас үүссэн маргааныг хянан шийдвэрлэж буй шүүхийн практикийг нарийвчлан задалж, хууль хэрэглэх, нотлох баримт үнэлэхтэй холбоотой өргөн хүрээний асуудлыг багтаажээ.

Дугаар хариуцсан редактор
С.Билгүүн

1

БАГА ҮНИЙН ДҮНТЭЙ ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ШҮҮХИЙН ПРАКТИКТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА

БУЯНЖАРГАЛЫН ХОНГОРЗУЛ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төвийн судлаач.

2008-2013 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйн бакалавр, 2013-2015 онд Япон Улсын Нагояагийн Их сургуулийн Хууль зүйн сургуулийг хууль зүйн магистр, 2015-2018 онд мөн сургуулийн докторантурын хөтөлбөрт суралцсан. Иргэний процессын эрх зүй, шүүхийн бус аргаар маргаан шийдвэрлэх эрх зүйг сонирхон судалдаг.

БАТТОГТОХЫН ДОРЖПАГМА

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төвийн судлаач.

Б.Доржпагма нь социологич мэргэжилтэй. Эрх зүйн социологи, боловсрол, засаглал, жендер болон Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төслийн үр нөлөө, зардлын тооцоо, хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний чиглэлээр судалгаа хийдэг. Хөгжлийн бодлогын магистр (MDP) зэрэгтэй.

Судлаачид:
Б.Хонгорзул (LL.M.)
Б.Доржпагма (MDP)

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ 12
ГРАФИК, ХҮСНЭГТ, ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ 13

НЭГ. УДИРТГАЛ 15
1.1. Сэдвийг сонгосон үндэслэл 15
1.2. Сэдвийн судлагдсан байдал, судалгааны арга зүй 18
1.3. Судалгааны ач холбогдол 20

ХОЁР. БАГА ҮНИЙН ДҮНТЭЙ ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ШҮҮХИЙН ПРАКТИК 21
2.1. Шүүхийн статистик 21
2.2. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ 33
2.3. Тулгамдсан асуудал 37

ГУРАВ. ЭРХ ЗҮЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА 42
3.1. Япон Улсын хууль зүйн зохицуулалт 42
3.1.1. Жижиг хэргийн буюу хялбаршуулсан шүүх 42
3.1.2. Жижиг хэргийн буюу хялбаршуулсан шүүхийн процедуртай холбоотой онцлог зохицуулалт 43

3.1.3. Хэрэг хянан шийдвэрлэх хялбаршуулсан ажиллагаа 45
3.1.4. Шүүгчийн орон тооны бус зөвлөх, мэргэжилтэн /Шихоиин/ 52
3.1.5. Шүүхийн статистик 53
3.2. Англи Улсын хууль зүйн зохицуулалт 56
3.2.1. Бага үнийн дүнтэй хэргийг харьяалан шийдвэрлэдэг шүүх 56
3.2.2. Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх хялбаршуулсан ажиллагаа, түүний хууль зүйн зохицуулалт 58
3.2.3. Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэж буй өнөөгийн нөхцөл байдал 61
3.3. Хэсгийн дүгнэлт 64

ДӨРӨВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ 68

ХАВСРАЛТ 74
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ 90

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
ИХШХШтХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоо
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо
ХК	Хувьцаат компани
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг

ГРАФИК, ХҮСНЭГТ, ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

График №1. Шийдвэрлэсэн нийт иргэний хэрэгт бага үнийн дүнтэй хэргийн эзлэх хувь

График №2. Бага үнийн дүнтэй хэргийн төрөл

График №3. Иргэд хоорондын зээл болон банк, ББСБ, ХЗХ-ноос олгосон зээлийн маргааны харьцаа

График №4. Шүүхээр хянан шийдвэрлэгдсэн бага үнийн дүнтэй хэргийн тоо /Шүүхийн байршлаар/

График №5. Бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийн үнийн дүн

График №6. Шүүхээс бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэсэн байдал

График №7. Дээд шатны шүүхээр хянагдсан бага үнийн дүнтэй хэргийн тоо, төрөл

График №8. Бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэсэн дундаж хугацаа

График №9. Нэхэмжлэлийн үнийн дүн /Иргэд хоорондын зээлийн маргаан/

График №10. Шүүхээс хянан шийдвэрлэсэн байдал

График №11. Дээд шатны шүүхээр хянагдсан маргааны тоо

График №12. Нэхэмжлэлийн үнийн дүн /Үйлчилгээний төлбөртэй холбоотой маргаан/

График №13. Шүүхээс хянан шийдвэрлэсэн байдал

График №14. Дээд шатны шүүхээр хянагдсан маргааны тоо

График №15. Нэхэмжлэлийн үнийн дүн /Улсаас олгосон хөнгөлөлттэй зээлийн маргаан/
График №16. Шүүхээс хянан шийдвэрлэсэн байдал
График №17. Дээд шатны шүүхээр хянагдсан маргааны тоо
График №18. Хэргийн төрөл, нэхэмжлэлийн үнийн дүн /Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ/
График №19. Шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал
График №20 Сөрөг нэхэмжлэл гаргасан байдал
График №21. Иргэд хоорондын зээлийн маргааны хүү
График №22. Мужийн шүүхийн шийдвэрлэсэн хэргийн нэхэмжлэлийн үнийн дүн /2004 он/

Хүснэгт №1. Жижиг хэргийн буюу хялбаршуулсан шүүх болон шүүгчийн тоо /2020 оны байдлаар/
Хүснэгт №2. Хүлээн авсан, шийдвэрлэсэн, үлдэгдэл хэргийн тоо /Эрүү, иргэний нийт хэрэг/
Хүснэгт №3. Бага үнийн дүнтэй иргэний хэргийн тоо
Хүснэгт №4. Бага үнийн дүнтэй хэрэг шийдвэрлэсэн байдал
Хүснэгт №5. Ердийн иргэний хэрэг болон бага үнийн дүнтэй иргэний хэрэг шийдвэрлэсэн дундаж хугацааны харьцуулалт

Хавсралт №1. Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ /2013-2019 он/
Хавсралт №2. Иргэний нийт хэргийн анхан шатны шүүхээс авсан тоон судалгааны хүснэгт
Хавсралт №3. Бага үнийн дүнтэй иргэний хэргийн тоон судалгааны нэгтгэл
Хавсралт №4. Улсын хэмжээнд шийдвэрлэсэн иргэний нийт хэрэг болон түүнд эзлэх бага үнийн дүнтэй иргэний хэргийн тоо /Шүүх тус бүрээр/
Хавсралт №5. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ

1

НЭГ. УДИРТГАЛ

1.1. СЭДВИЙГ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ

Иргэний хэргийн анхан шатны шүүхээр 2013-2019 онд хянан шийдвэрлэсэн хэргийн дунджаас үзвэл нийт хэргийн 47 хувийг Иргэний хуулиар шийдвэрлэсэн иргэний эрх зүйн маргаан, 34 хувийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар шийдвэрлэсэн онцгой ажиллагааны болон бусад хэрэг, 11 хувийг гэр бүлийн эрх зүйн маргаан, 4 хувийг хөдөлмөрийн эрх зүйн маргаан, үлдсэн 5 хувийг бусад хуулиар шийдвэрлэсэн маргаан тус тус эзэлж байна.[1] Иргэний эдгээр хэрэг дотроос төрөл зүйл олонтой, шийдвэрлэхэд ээдрээ төвөгтэй байж болохуйц, шүүхийн ажлын ачааллын дийлэнх хувийг эзэлдэг төрөл нь иргэний эрх зүйн маргаан юм.

Иймд иргэний эрх зүйн маргааныг шүүхээр хянан шийдвэрлэхдээ тухайн маргааны онцлог шинжид тохирсон, хэрэг хянан шийдвэрлэх шуурхай, зардал багатай, үр нөлөөтэй ажиллагаа бий болгох нь шүүхийн ажлын ачааллыг бууруулах, шүүхийн нөөц бололцоог зөв хуваарилах, шүүхийн шийдвэрийн чанар, тогтвортой байдлыг дээшлүүлэх, улмаар шударга ёсны үйлчилгээг иргэдэд тэгш, хүртээмжтэй хүргэхэд чухал нөлөөтэй юм. Өөрөөр хэлбэл, хэрэг хянан шийдвэрлэх зөвхөн нэг төрлийн процедур байх бус тухайн хэрэг маргааны төрөл, онцлогоос хамаарсан төрөлжсөн процедур бий болгох нь зүйтэй бөгөөд

[1] 74 дугаар хуудасны "Хавсралт №1"-ээс дэлгэрүүлж үзнэ үү.

үүнийг бусад улсад *кэйс менежмент* гэж нэрлэж байна. Харин манай улсад энэ ойлголтыг хэргийн хөдөлгөөн гэж нэрлэж хэвшжээ.

Шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй хэргийн хөдөлгөөнд тогтмол хяналт тавин сайн менежмент хийж хэргийг шийдвэрлэхийн тулд хэргийн бүртгэл, хяналтын системийг процессын хуультай маш сайн уялдуулж, тогтмол шинэчилж байх, түүнээс шүүхийн статистикийг дэлгэрэнгүй гаргадаг байх нь шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлын нэг юм. Тухайлбал, шүүхийн статистикийн хувьд өнөөгийн иргэний хэргийн шүүхийн статистикаас мэдэх боломжгүй дараах төрлийн тоон мэдээ гаргадаг болох нь хэргийн хөдөлгөөнд менежмент хийх, шүүхийн практик судлалд өндөр ач холбогдолтой юм. Үүнд шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулсан дундаж хугацаа (онцлох маргааны төрөл тус бүрээр гаргах), тухайн шатны шүүхэд нийт хэдэн удаа шүүх хурал зарлаж, хэргийг шийдсэн болох, үүнээс шүүх хурал хойшилсон шалтгаан нөхцөлийг аль болох дэлгэрэнгүй байдлаар тоочих, өөрөөр хэлбэл, бусад гэсэн сонголтын хувийг аль болох багасгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй оролцсон нэхэмжлэгч, хариуцагчийн тоо, хувь болон эсрэгээрээ өмгөөлөгч, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлээгүй нэхэмжлэгч, хариуцагчийн тоо, хувь зэргийг тогтмол гаргаж байх, цаашлаад шүүхийн практикийг судлахад ач холбогдолтой тоон мэдээллээр шүүн таслах ажиллагааны статистикийн мэдээний агуулгыг байнга сайжруулж байх шаардлагатай. Ингэснээр тухайн хэрэг маргааны онцлогт тохирсон байдлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг төрөлжүүлж, хуульчлах боломж бүрдэх юм.

Гэтэл одоогийн байдлаар иргэний нийт хэргийн шүүхийн хэмжээнд ашиглаж буй “Иргэн 2014” бүртгэл, хяналтын системийн боловсронгуй бус байдлаас шалтгаалан шүүн таслах

ажиллагааны нэгдсэн статистикийг дээрх маягаар олон асуулгатай, дэлгэрэнгүй байдлаар гаргах боломжгүй байгаа бөгөөд ихэнх шүүх "гар аргаар" мэдээгээ нэгтгэдэг. Энэ нь цаг хугацаа, хүч хөдөлмөр ихээр шаардаг ч шүүн таслах ажиллагааны тоон мэдээ үнэн зөв гарах магадлал багатай, тогтсон маягтын дагуу хураангуй байдлаар гарч ирсэн. Өнөөг хүртэл хэргийн бүртгэл, хяналт болон шүүн таслах ажиллагааны статистик нь салангид явж ирсэн, мөн одоогийн гаргаж буй шүүхийн статистикаас шүүхийн практикийг нарийвчлан судлах боломжгүй байдгаас манай улсад иргэний хэргийн шүүхийн практик судлал харьцангуй бага хөгжиж байна. Мөн мэргэшсэн хүний нөөц болон төсөв мөнгөний хүрэлцээгүй байдлын улмаас энэ асуудал дорвитой шийдвэрлэгдээгүй байна.

Иймд иргэний хэргийн шүүхийн ажлын ачааллыг бууруулах, шүүхийн шийдвэрийн чанар, тогтвортой байдлыг сайжруулах, шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд нэн тэргүүнд *кэйс менежмент* буюу хэргийн хөдөлгөөнд тавих хяналт, удирдлагыг техник, эдийн засаг болон мэргэжил, арга зүйн талаас нь сайжруулж, боловсронгуй болгох шаардлагатай юм. Гэвч энэ нь одоогийн ашиглаж буй хэргийн бүртгэл, хяналтын систем болон шүүхийн статистикийн хүрсэн түвшнээс харахад богино хугацаанд шийдэгдэх асуудал биш юм.

Энэхүү судалгааны хүрээнд судалгааны баг нь дээрх асуудал шийдэгдэхийг хүлээж суух биш, өөрсдийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй иргэний эрх зүйн маргаан дотор багагүй хувь эзэлж байх магадлалтай, үйл баримтын хувьд тодорхой, нэхэмжлэлийн үнийн дүн багатай, ялангуяа зээлийн маргаан болон авсан бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулаагүйн улмаас үүссэн маргааныг шүүхээр хэрхэн хянан шийдвэрлэж буй практикт дүн шинжилгээ хийхийг зорилоо.

Ийнхүү зорих болсон шалтгаан нь нэгдүгээрт, эрх зүй, эдийн засгийн өндөр хөгжилтэй орнуудад бага үнийн дүнтэй иргэний хэргийг ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас өөр, хялбаршуулсан журмаар шийдвэрлэж (Зарим улс бага үнийн дүнтэй иргэний хэрэг болон эрүүгийн хөнгөн хэргийг дагнан шийдвэрлэдэг анхан шатны хялбаршуулсан шүүхтэй байна), шүүхээр үйлчлүүлэгч иргэдийн цаг хугацаа, зардал мөнгийг хэмнэх, зөрчигдсөн эрхээ шуурхай сэргээлгэх боломж олгодог сайн туршлага байна. Энэ нь мөн нөгөө талаасаа шүүхийн ажлын ачааллыг бууруулах, төсөв зардал хэмнэх ач холбогдолтой юм.

Хоёрдугаарт, үүнтэй адил нийт хэрэгт эзлэх бага үнийн дүнтэй иргэний хэргийн хувь хэмжээ Монгол Улсад ямар байгаа, бага үнийн дүнтэй хэрэг гэдэгт ихэвчлэн ямар төрлийн иргэний хэрэг хамаарах, тэдгээр хэргийг шүүхээр ямар хугацаанд, хэрхэн хянан шийдвэрлэж буйд дүн шинжилгээ хийснээр иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд шинэ төрлийн, хялбаршуулсан процедур бий болгох хэрэгцээ, шаардлага үүссэн эсэхийг судлах зорилгоор энэхүү сэдвийг сонгосон юм.

Тус судалгааг хийж гүйцэтгэснээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарим хэсгийг боловсронгуй болгохтой холбоотой тодорхой санал дэвшүүлэх, улмаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг шинэчлэн найруулах ажилд бага ч болов хувь нэмэр оруулах зорилготой юм.

1.2. СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ, СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Тус сэдвийн хүрээнд монгол хэлээр гарсан судалгааны эх сурвалж хомс байна. Судалгааны арга зүйн хувьд судалгааны

бэлтгэл шатанд ярилцлага болон анкет асуулгын арга ашиглаж, иргэний нийт хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн бага үнийн дүнтэй иргэний хэрэгтэй холбоотой шүүхийн тоон мэдээг сүүлийн хоёр жилийн байдлаар /2018, 2019 он/ цуглуулж, дэлгэрэнгүй дүн шинжилгээ хийхийг зорилоо.[2] Дүн шинжилгээ хийхдээ иргэний хэргийн шүүхээр хянан шийдвэрлэж буй хэрэг маргаанаас иргэд хоорондын зээлийн маргаан, авсан бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулаагүйтэй холбоотой маргаан, улсаас иргэд, аж ахуйн нэгжид олгосон хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлттэй холбоотой маргаан гэсэн гурван төрлийн маргааны хүрээнд дийлэнх тохиолдолд үйл баримтын хувьд тодорхой, маргаан багатай, нэхэмжлэлийн үнийн дүн нь 13 сая төгрөг хүртэлх бага үнийн дүнтэй байх магадлалтай гэсэн үзүүлэлтүүдээр судалгааныхаа хүрээг хумьсан болно.

Мөн дүн шинжилгээ хийхдээ дараах үзүүлэлтийг шалгуур болголоо. Үүнд иргэний нийт хэрэгт дээрх төрлийн хэргийн эзлэх хувь хэмжээ, шүүхийн байршлаас хамаарсан хэргийн тоо, нэхэмжлэлийн үнийн дүн, шүүхээс хянан шийдвэрлэсэн байдал, дээд шатны шүүхэд хянагдсан байдал, шүүхээр хянан шийдвэрлэхэд зарцуулсан дундаж хугацаа зэрэгт дүн шинжилгээ хийв. Үүнээс гадна дээрх төрлийн хэргээс хяналтын шатны шүүхээр хянагдсан нийт хэргийн тоог гаргаж, түүнээс нэхэмжлэлийн үнийн дүн, хэргийн төрөл, шийдвэрлэсэн шүүхийн байршил /төвийн зургаан дүүрэг, Орхон, Дархан-Уул аймаг, сум дундын зарим шүүх/ зэргийг харгалзан үзэж, нийт 13

[2] Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсийн дарга болон орон нутгийн зарим шүүхийн Тамгын газрын холбогдох мэргэжилтэнтэй холбогдож, иргэний хэргийн шүүхийн практикт түгээмэл шийдвэрлэгддэг бөгөөд үйл баримтын хувьд маргаан багатай, бага үнийн дүнтэй ямар төрлийн маргаан зонхилдог болохыг урьдчилсан байдлаар тандан судалж, түүний үндсэн дээр тоон судалгааны маягт боловсруулсан. Үүний дараа боловсруулсан судалгааны маягтаа иргэний хэргийн анхан шатны нийт шүүхийн Тамгын газарт илгээж, тэндээс бөглөж ирүүлсэн маягтад тулгуурлан тус судалгааны тайланд ашиглагдсан тоон мэдээллийг боловсруулсан болно.

шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийлээ. Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхдээ материаллаг хуулийн хэрэглээнд анхаарах бус, өмнө нь дурдсан шалгуур үзүүлэлтүүдээс гадна анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал хэрхэн хангагдсанд гол анхаарлаа хандуулсан.

1.3. СУДАЛГААНЫ АЧ ХОЛБОГДОЛ

Иргэний эрх зүйн маргаанаас үйл баримтын хувьд тодорхой, маргаан багатай, бага үнийн дүнтэй маргааныг хянан шийдвэрлэж буй шүүхийн практикт дүн шинжилгээ хийх замаар тулгамдсан асуудлыг тодорхойлж, энэ төрлийн маргааныг хянан шийдвэрлэхэд илүү тохиромжтой, хялбаршуулсан процедур нэвтрүүлэх хувилбар санал болгоход уг судалгааны гол ач холбогдол оршино.

ХОЁР. БАГА ҮНИЙН ДҮНТЭЙ ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ШҮҮХИЙН ПРАКТИК

2.1. ШҮҮХИЙН СТАТИСТИК

График №1. Шийдвэрлэсэн нийт иргэний хэрэгт бага үнийн дүнтэй хэргийн эзлэх хувь



Монгол Улсын хэмжээнд 2019 онд 43,397 иргэний хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэнээс 20,624 буюу бараг 48 хувь нь иргэний эрх зүйн маргаан байсан бол үүнээс бага үнийн дүнтэй хэрэг 5,710 байсан нь улсын хэмжээний дүнд 13 хувийг эзэлж байна. Мөн бага үнийн дүнтэй иргэний хэрэг 2018 онд 5.411 шийдвэрлэгдсэн бол 2019 онд 5,710 болж 299-өөр буюу 5.3 хувиар өсжээ.

График №2. Бага үнийн дүнтэй хэргийн төрөл



Бага үнийн дүнтэй хэргийг төрлөөр нь авч үзвэл 2019 онд үйлчилгээний төлбөртэй холбоотой маргаан 2,924 буюу 51 хувийг эзэлж буй бол зээлийн маргаан 2,117 буюу 37 хувь, улсаас олгосон хөнгөлөлттэй зээлийн маргаан 514 буюу 9 хувийг тус тус эзэлж байна. Эндээс үзвэл бага үнийн дүнтэй хэрэгт үйлчилгээний төлбөрийн болон иргэд хоорондын зээлийн маргаан 91 хувийг эзэлдэг буюу 10 хэрэг тутмын 9 нь энэ төрөлд хамаарч байна. Мөн гар утасны аппликейшнээр дамжуулж зээл олгох, зээл авах зэрэг цахим зээлийн үйлчилгээ зах зээлд шинээр нэвтэрсэнтэй холбоотой энэ төрлийн зээлийн маргаан өсөх хандлагатай байгаа нь судалгааны явцад ажиглагдлаа. Тухайлбал, шүүх энэ төрлийн 11 маргааныг 2018 онд шийдвэрлэсэн бол 2019 онд 155 маргаан шийдвэрлэж, тоо нь огцом өсжээ.

График №3. Иргэд хоорондын зээл болон банк, ББСБ, ХЗХ-ноос олгосон зээлийн маргааны харьцаа



Иргэний хэргийн анхан шатны шүүх нь 2019 онд иргэд хоорондын зээлийн 2,117 маргаан, банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршооны зээлийн 1,684 маргаан шийдвэрлэсэн байна. Үүнээс үзвэл мөн онд иргэд хоорондын зээлийн гэрээний маргаан нь банк, ББСБ, ХЗХ-ны зээлийн гэрээний маргаанаас 433-аар буюу 20.4 хувиар илүү шийдвэрлэгджээ. Дээрд дурдсанчлан цахим зээлийн үйлчилгээтэй холбоотой маргаан ч огцом өссөн дүнтэй байна.

График №4. Шүүхээр хянан шийдвэрлэгдсэн бага үнийн дүнтэй хэргийн тоо /Шүүхийн байршлаар/

Бага үнийн дүнтэй хэргийн 60 орчим хувийг нийслэлд, 40 орчим хувийг орон нутагт шийдвэрлэж байгаагаас 10 хүрэхгүй хувийг сум дундын шүүхэд шийдвэрлэжээ.

График №5. Бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийн үнийн дүн



Бага үнийн дүнтэй хэргийг нэхэмжлэлийнх нь үнийн дүнгээр авч үзвэл 90 хувь нь 13 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй, 10 хувь нь 13 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй байна.[3]

График №6. Шүүхээс бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэсэн байдал



[3] Бага үнийн дүнтэй иргэний хэргийг нэхэмжлэлийнх нь үнийн дүнгээр дээрх байдлаар таван хэсэгт ангилсан нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7.1 дэх зохи-

Бага үнийн дүнтэй хэргийг шүүхээр шийдвэрлэж буй байдлыг авч үзвэл дийлэнх буюу 2018 онд 72.6 хувь, 2019 онд 73.5 хувийг ИХШХШтХ-ийн 74 дүгээр зүйлийн 74.1 буюу хялбаршуулсан журмаар шийдвэрлэжээ /Хэрэг үүсгэснээс хойш шүүх хурал хүртэл хугацаан дахь талуудын эвлэрэл, зохицлыг ойлгоно/. Энэ нь ИХШХШтХ-ийн 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсгийн дагуу шийдвэрлэсэн хэргийн тоо 318-аар буюу 8 хувиар өссөн гэсэн үг юм. Үлдсэн цөөн хувьд нь шүүх хурлын явцад талууд эвлэрч, тохиролцсон болон талууд мэтгэлцэж, шүүхийн шийдвэрээр хэргийг эцэслэн шийдвэрлэсэн тохиолдлууд хамаарч байна.

График №7. Дээд шатны шүүхээр хянагдсан бага үнийн дүнтэй хэргийн тоо, төрөл



цуулалтыг гол шалгуур үзүүлэлт болгосонтой холбоотой юм. Учир нь Монгол Улсын иргэний хэргийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн статистик мэдээнд шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэргийн нэхэмжлэлийн үнийн дүнгийн талаарх мэдээлэл байдаггүй тул хуулийн энэхүү заалтаас өөр шалгуур болгох үзүүлэлт байгаагүй юм. Уг судалгаагаар цар хүрээний хувьд 13 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй, гурван төрлийн иргэний хэргийг бага үнийн дүнтэй хэрэг гэж авч үзэж, дүн шинжилгээ хийсэн боловч эдгээр гурван төрлийн хэргийн хувьд 13 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй хэрэг хэчнээн хувь байдгийг мэдэх зорилгоор судалгааны маягтад нэхэмжлэлийн үнийн дүн нь 13 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй гэдэг сонголт нэмж, холбогдох дүн шинжилгээ хийсэн юм.

2019 онд бүртгэгдсэн бага үнийн дүнтэй 5,710 хэргийн хувьд 3.5 хувь буюу 200 нь давж заалдах шатны шүүхэд, 1.8 хувь буюу 100 нь хяналтын шатны шүүхэд хандсан байна. Давж заалдах шатны шүүхэд хандсан хэргийн тоо 2019 онд өмнөх оныхоос 7 хувиар буурсан бол хяналтын шатны шүүхэд хандах байдал 13 хувиар өсжээ. Мөн иргэд хоорондын зээлийн маргааны талууд дээд шатны шүүхэд гомдол гаргах нь бусад хоёр төрлийн маргаантай харьцуулахад эрс өндөр байна.

График №8. Бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэсэн дундаж хугацаа



Судалгааны явцад дээр дурдсан бага үнийн дүнтэй гурван төрлийн хэргийн хувьд шүүхэд хэрэг үүсгэснээс хойш хэргийг эцэслэн хянаж шийдвэрлэсэн дундаж хугацааг нэг бүрчлэн гаргах зорилготой байсан боловч энэ нь хэргийн хөдөлгөөний бүртгэл, хяналтын системээс шууд гаргах боломжгүй үзүүлэлт байсан. Үүнийг тооцоолон гаргахын тулд хавтаст хэрэг тус бүртэй танилцаж, гар аргаар хугацааг тооцож гаргах шаардлага үүсэхээр байгаа бөгөөд энэ нь ихээхэн цаг хугацаа, хүн хүч шаардах тул эдгээр төрлийн маргааныг шүүхээр хянан шийдвэрлэхдээ зөвхөн хамгийн урт болон богино хугацаа зарцуулж шийдвэрлэсэн хэргийн тоон судалгааг авсан. Шүүхүүдээс ирүүлсэн уг тооноос график №8-д үзүүлсэнчлэн гурван хэм-

жээсээр хэрэг хянан шийдвэрлэсэн дундаж хугацааг баримжаалж гаргасан болно. Иймд дээрх тооцоолол нь зөвхөн баримжаалал болох онцлогтой.

Ингээд доорх хэсэгт бага үнийн дүнтэй гурван төрлийн хэргийг төрөл тус бүрээр нь нэхэмжлэлийн үнийн дүн, шүүхээс хянан шийдвэрлэсэн байдал, дээд шатны шүүхэд хянагдсан байдлаар нь задлан авч үзье.

1. Иргэд хоорондын зээлийн маргаан

Иргэний хэргийн анхан шатны шүүх нь 2018 онд иргэд хоорондын болон онлайн зээлийн 2396 маргаан, 2019 онд 2272 маргаан тус тус шийдвэрлэсэн байна.

График №9. Нэхэмжлэлийн үнийн дүн



Зээлийн маргааны нэхэмжлэлийн үнийн дүнг авч үзвэл 2019 оны байдлаар дийлэнх буюу 51 хувь нь 1,3 сая төгрөгөөс 13 сая төгрөгийн хооронд байгаа бол 19 хувь нь 13 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй байна.

График №10. Шүүхээс хянан шийдвэрлэсэн байдал



Зээлийн маргааныг шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл 2019 онд бараг 57 хувь буюу 1,286 нь ИХШХШтХ-ийн 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсгийн дагуу, бараг 17 хувь буюу 378 нь ИХШХШтХ-ийн 106 дугаар зүйлийн 106.5 дахь хэсгийн дагуу, ойролцоогоор 27 хувь буюу 608 нь ИХШХШтХ-ийн 115 дугаар зүйлийн 115.2 дахь хэсгийн дагуу тус тус шийдэгджээ. Эндээс үзвэл зээлийн хоёр маргаан тутмын нэг нь ИХШХШтХ-ийн 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсгийн дагуу шийдэгддэг байна.

График №11. Дээд шатны шүүхээр хянагдсан маргааны тоо



2019 онд шүүхээр шийдвэрлэгдсэн зээлийн гэрээний 2,117 маргааны 152 буюу 7.2 хувь нь давж заалдах шатны шүүхээр, 75 буюу 3.5 хувь нь хяналтын шатны шүүхээр хянагдсан байна. Энэ нь өмнөх оныхоос буурсан үзүүлэлттэй харагдаж байна.

2. Үйлчилгээний төлбөртэй холбоотой маргаан

Иргэний хэргийн анхан шатны шүүх үйлчилгээний төлбөртэй холбоотой нийт 2,491 маргааныг 2018 онд, 2,924 маргааныг 2019 онд шийдвэрлэсэн байна.

График №12. Нэхэмжлэлийн үнийн дүн



Үйлчилгээний төлбөртэй холбоотой маргааны нэхэмжлэлийн үнийн дүнг авч үзвэл 2019 оны байдлаар дийлэнх буюу 58 хувь нь 130,001-650,000 төгрөгийн хооронд байгаа бол 21 хувь нь 650,001-1,300,000 төгрөгийн үнийн дүнтэй байна.

График №13. Шүүхээс хянан шийдвэрлэсэн байдал



Үйлчилгээний төлбөртэй холбоотой маргааныг шүүхээс хянан шийдвэрлэсэн байдлыг авч үзвэл 2019 онд 85 хувь нь ИХШХШтХ-ийн 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсгийн дагуу, 7 хувь нь ИХШХШтХ-ийн 106 дугаар зүйлийн 106.5 дахь хэсгийн дагуу, 8 хувь нь ИХШХШтХ-ийн 115 дугаар зүйлийн 115.2 дахь хэсгийн дагуу тус тус шийдэгджээ. Үүнээс үзвэл энэ төрлийн маргааныг иргэд хоорондын зээлийн маргаантай харьцуулахад талууд хамгийн их эвлэрэн зохицдог болох нь харагдаж байна.

График №14. Дээд шатны шүүхээр хянагдсан маргааны тоо



2019 онд шүүхээр хянан шийдвэрлэгдсэн үйлчилгээний төлбөртэй холбоотой 2,924 маргааны 25 буюу 0.85 хувьд давж заалдсан бол 9 буюу 0.31 хувьд хяналтын шатны шүүхэд гомдол гаргажээ. Үүнээс үзвэл энэ төрлийн маргааныг иргэд хоорондын зээлийн маргаантай харьцуулахад дээд шатны шүүхэд хянуулах практик маш бага болох нь харагдаж байна.

3. Улсаас олгосон хөнгөлөлттэй зээлийн маргаан

Иргэний хэргийн анхан шатны шүүх нь улсаас олгосон хөнгөлөлттэй зээлийн 524 маргааныг 2018 онд, 514 маргааныг 2019 онд шийдвэрлэсэн байна.

График №15. Нэхэмжлэлийн үнийн дүн



Улсаас олгосон хөнгөлөлттэй зээлийн маргааны нэхэмжлэлийн үнийн дүнг авч үзвэл 2019 оны байдлаар дийлэнх буюу 64 хувь нь 1,3 сая төгрөгөөс 13 сая төгрөгийн хооронд байгаа бол 15 хувь нь 13 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй байна.

График №16. Шүүхээс хянан шийдвэрлэсэн байдал



Улсаас олгосон хөнгөлөлттэй зээлийн маргааныг шүүхээс шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл 2019 онд 82 хувь нь ИХШХШтХ-ийн 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсэгт заасны дагуу, 6 хувь нь ИХШХШтХ-ийн 106 дугаар зүйлийн 106.5 дахь хэсэгт заасны дагуу, 12 хувь нь ИХШХШтХ-ийн 115 дугаар зүйлийн 115.2 дахь хэсэгт заасны дагуу тус тус шийдэгджээ. Иргэд хоорондын зээлийн маргаантай харьцуулахад энэ төрлийн маргаанд талууд илүү их хувиар эвлэрэн зохицдог болох нь харагдаж байна.

График №17. Дээд шатны шүүхээр хянагдсан маргааны тоо



2019 онд шийдвэрлэгдсэн улсаас олгосон хөнгөлөлттэй зээлтэй холбоотой 514 маргааны 23 буюу 4.5 хувь нь давж заалдах шатны шүүхэд хандсан бол 16 буюу 3.1 хувь нь хяналтын шатны шүүхэд хандсан байна. Эндээс үзвэл тус онд дээд шатны шүүхэд хандсан маргааны тоо эрс өсжээ.

2.2. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

График №18. Хэргийн төрөл, нэхэмжлэлийн үнийн дүн



Хяналтын шатны шүүхээр хянагдсан бага үнийн дүнтэй 13 хэрэгт дүн шинжилгээ хийж үзэхэд 10 буюу 76.9 хувь нь иргэд хоорондын зээлийн маргаан, 2 буюу 15.4 хувь нь сууц өмчлөгчдийн холбооны төлбөрийн маргаан, 1 буюу 7.7 хувь нь дулааны төлбөрийн маргаан байв. Иргэд хоорондын зээлийн маргааны 10 хэргийн нэхэмжлэлийн үнийн дүнг харвал дийлэнх

буюу 9 нь 5-12.5 сая төгрөгийн хооронд байгаа бол 1 нь 500,001-1,500,000 төгрөг байв. Сууц өмчлөгчдийн холбооны төлбөрийн маргааны нэхэмжлэлийн үнийн дүн бусад төрлийн маргааны-хаас хамгийн бага буюу 500,000 хүртэлх мянган төгрөг байв.

Мөн дүн шинжилгээ хийсэн бага үнийн дүнтэй хэргийн 1 нь аж ахуйн нэгж, байгууллага хоорондын дулааны төлбөрийн маргаан байсан бөгөөд 1,5-5 сая төгрөгийн үнийн дүнтэй байв. Ерөнхийдөө нэхэмжлэлийн үнийн дүнгийн хувьд хэрэг маргааны төрлөөс хамаарч 348,000-12,500,000 төгрөгийн хооронд байна.

График №19. Шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал



Судалгааны хүрээнд авч үзсэн бага үнийн дүнтэй хэргийн 84.6 хувьд нь анхан шатны шүүхийн шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан бол 15.4 хувьд нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэжээ. Мөн давж заалдах шатны шүүхийн магадлалаар анхан шатны шүүхийн шийдвэрийн 38.5 хувь нь өөрчлөгдсөн бол хяналтын шатны шүүхийн тогтоолоор 23.1 хувь нь өөрчлөгдсөн байна. Эндээс үзвэл бага үнийн дүнтэй хэрэг нь хяналтын шатны шүүх дээр өөрчлөгдөх нь бага буюу таван маргаан тутмын нэг нь өөрчлөгджээ.

График №20. Сөрөг нэхэмжлэл гаргасан байдал



Дүн шинжилгээнд хамруулсан бага үнийн дүнтэй 13 хэргийн сөрөг нэхэмжлэл гаргасан байдлыг авч үзэхэд 4 хэрэг буюу 31 хувьд сөрөг нэхэмжлэл гаргасан байна.

График №21. Иргэд хоорондын зээлийн маргааны хүү



Бага үнийн дүнтэй хэрэгт иргэд хоорондын зээлийн гэрээний маргаан дийлэнх хувийг эзэлж буй талаар өмнөх хэсэгт дурдсан билээ. Иргэд хоорондын зээлийн маргааны хүүг харвал 30 хувь нь сарын 10 хувийн хүүтэй, 40 хувь нь сарын 5 хувийн хүүтэй зээлүүд байна. Эндээс үзвэл иргэд хоорондын зээл нь өндөр хүүтэй, үндсэн зээл болон хүүгээ хугацаанд нь төлж барагдуулаагүйн улмаас шүүхээр шийдвэрлүүлэх явдал түгээмэл гэж ойлгож болох юм. Мөн иргэд хоорондын зээлийн маргааныг цаашид нарийвчлан судлах шаардлагатай. Хяналтын шатны шүүхээр хянагдсан бага үнийн дүнтэй 13 хэргийн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж үзэхэд 7 хэргийн шүүхийн шийдвэрт буюу 53.8 хувьд нь Иргэний хуулийн 281 дүгээр зүйлийн 281.1 дэх хэсгийг үндэслэн шийдвэрлэжээ.

2.3. ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Өмнөх хэсэгт бага үнийн дүнтэй тодорхой төрлийн иргэний хэргийг шүүхээр хянан шийдвэрлэж буй байдлыг шүүн таслах ажиллагааны тоон мэдээ, шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ гэсэн тоон болон чанарын судалгааны арга ашиглан уг судалгааны ажлыг эхлүүлэхээс өмнөх дурдсан хоёр оны хүрээнд тодруулан авч үзсэнээр дараах дүгнэлт хийлээ. Үүнд:

1. Иргэд хоорондын зээл, улсаас олгосон хөнгөлөлттэй зээл зэрэг зээлийн гэрээний харилцаанаас үүссэн маргаан, авсан бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулаагүй гэсэн зөвхөн гурван төрлийн маргааны хүрээнд авч үзэхэд улсын хэмжээнд шүүхээр шийдвэрлэсэн иргэний нийт хэрэгт энэ төрлийн маргааны эзлэх хэмжээ 10-13 хувьтай байсан бөгөөд цаашид өсөх хандлагатай байв. Түүнчлэн судалгааны хүрээнд эдгээр гурван төрлийн маргааны адил нарийвчлан авч үзээгүй боловч 2018, 2019 онд шүүхээр мөн л хянан шийдвэрлэсэн банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо зэрэг санхүүгийн байгууллагаас олгосон зээлийн маргааны тоог оролцуулбал (Нэхэмжлэлийн үнийн дүн нь ихэнх тохиолдолд 13 сая төгрөгөөс давах магадлалтай байж болно) 16-17 хувьтай болж байна. Үүнээс үзвэл харьцангуй бага үнийн дүнтэй, үйл баримтын хувьд тодорхой, маргаан багатай хэрэг шүүхийн практикт тогтмол багагүй хувь эзэлдэг бөгөөд цаашид ч тоо нь өсөх хандлага ажиглагдлаа.

2. Улсаас олгосон хөнгөлөлттэй зээлийн гэрээний маргаан нь бусад төрлийн бага үнийн дүнтэй маргаанаас харьцангуй бага хувьтай байсан бол иргэд хоорондын зээл болон үйлчилгээний төлбөртэй холбоотой маргаан бараг тэнцүү харьцаатай байв. Мөн иргэд хоорондын зээлийн маргааныг банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээ-

лийн хоршоо зэрэг санхүүгийн байгууллагаас олгосон зээлийн маргаантай харьцуулж үзвэл тооны хувьд 2018 онд ялимгүй их байсан бол 2019 онд нэлээд өндөр дүнтэй байв.

3. Байршлын хувьд дээрх төрлийн маргааны 60 орчим хувийг хүн ам төвлөрсөн нийслэлд шийдвэрлэжээ.

4. Шийдвэрлэсэн байдлын хувьд ИХШХШтХ-ийн 74 дүгээр зүйл, 106 дугаар зүйлийн 106.5 дахь хэсэг зэрэг шүүх хурлын өмнөх үе болон шүүх хурлын явц дахь талуудын эвлэрэл, зохицлоор шийдэгдсэн хэрэг 84 хувийг эзэлж байв.

5. Нэхэмжлэлийн үнийн дүнгийн хувьд дээрх төрлийн маргааны 90 орчим хувь нь 13 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй байв.

Дээрх тоо баримтууд нь манай улсад бага үнийн дүнтэй иргэний хэргийг хялбаршуулсан, шуурхай журмаар шийдвэрлэх тусгай зохицуулалт бий болгох хэрэгцээ шаардлага байгааг илтгэж байна. Мөн шүүн таслах ажиллагааны тоон мэдээнээс дараах хоёр үзүүлэлт анхаарал татсан бөгөөд тэдгээрийг тулгамдсан асуудлууд гэж үзэж болно. Тодруулбал, нэг дэх асуудал нь дээрх төрлийн бага үнийн дүнтэй иргэний хэргийн 3.5-4 хувьд нь талууд давж заалдсан бол 1.6-1.8 хувьд нь өмнөх шатны шүүхийн шийдвэрүүдийг хяналтын шатны шүүхээр хянуулсан гэх үзүүлэлт юм. Хоёр дахь асуудал нь эдгээр төрлийн хэргийг хянан шийдвэрлэсэн дундаж хугацааг тооцоолж гаргах нь хүн хүч болон техникийн нөхцөл байдлаас хамаарч хүндрэлтэй байсан боловч барагцаалбал 27 орчим хувьд нь буюу 1/3-д нь 60 ба түүнээс дээш хоног зарцуулж шийдсэн байх магадлалтай байв.

Дээрх хоёр үзүүлэлтээс угтаа нэхэмжлэлийн үнийн дүн харьцангуй бага, үйл баримтын хувьд тодорхой, маргаан багатай хэрэгт талууд гурван шатны шүүх дамжиж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрсан болох нь харагдаж байна.

Энэхүү судалгааны хүрээнд уг нөхцөл байдал үүсэхэд талуудын идэвх оролцоо, хариуцлага нөлөөлсөн эсэх, өөрөөр хэлбэл, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг санаатайгаар удаашруулж, хугацаа хожих зорилго байсан эсэх, эсхүл шүүхийн зүгээс зохион байгуулалтыг сайтар хангаж, хууль, журмыг ягштал даган мөрдүүлж, зөв тайлбарлан хэрэглэж чадсан эсэхэд хөдөлшгүй дүгнэлт хийх боломжгүй боловч дээрх хоёр үзүүлэлт нь шүүх болон талуудын хувьд эдийн засаг, цаг хугацааны хувьд алдагдалтай, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үр нөлөө багатай явагдсан гэдгийг баталж байна.

Чанарын судалгаа болох шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний үр дүнгээс авч үзвэл анхан шатны шүүхийн шийдвэрийн чанар, тогтвортой байдал сайн хангагджээ. Тухайлбал, дүн шинжилгээ хийсэн шүүхийн нийт 13 шийдвэрийн хүрээнд авч үзэхэд анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан таван магадлалын хувьд ганц л хэрэгт шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон бол бусад тохиолдолд гагцхүү үндэслэл болгосон хуулийн зүйл, заалт болон мөнгөн дүнгийн тооцооллыг залруулсан төдий байв.

Хяналтын шатанд шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулсан 3 тохиолдол илэрсэн бөгөөд хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр буцаасан 1, хэргийг хэрэгсэхгүй болгосон 1, өмнөх хоёр шатны шүүхийн мөнгөн дүнгийн тооцооллын алдааг залруулсан 1 тохиолдол байв (Дээрх тохиолдлууд нь доод шатны шүүх шүүн таслах ажиллагаанд хариуцлагагүй, хайнга хандсан, материаллаг болон процессын хуулийг зөв тайлбарлан хэрэглэж чадаагүйг илтгэнэ). Энэ гурван тохиолдолд талууд хяналтын шатны шүүхэд гомдол гаргаж, хэргээ дахин хянуулсан нь ач холбогдолтой байсан боловч хууль хэрэглээний нэг мөр байдлыг хангуулах, хууль тайлбарлан хэрэглэхтэй холбоотой эргэлзээтэй байдлыг арилгах үүрэгтэй онолын шүүхийн хувьд дээрх төрлийн бага үнийн дүнтэй, үйл баримтын хувьд тодорхой хэр-

гийг хүлээн авч шийдвэрлэх нь зохимжгүй бөгөөд энэ нь тус шүүхийн ажлын ачааллыг нэмэгдүүлээд зогсохгүй уг шүүхийн мөн чанар болон үндсэн чиг үүргийн хэрэгжилтэд харшлах юм.

Дээр дурдсанаас гадна энэхүү судалгааны тайлангийн сэдэв, судлах зүйлийн хүрээнд шууд хамаарахгүй боловч дараах асуудлыг хөндөх нь зүйтэй гэж үзлээ. Тухайлбал, санхүүгийн байгууллагаас олгосон зээл болон улсаас олгосон хөнгөлөлттэй зээлийн маргааны хувьд (Энэ төрлийн зээлийн маргаан цаашид улам өсөх магадлалтай. Учир нь Ковид-19 цар тахалтай тэмцэж, эдийн засгаа аврах цогц хөтөлбөрийн хүрээнд олон иргэн, аж ахуйн нэгжид улсаас хөнгөлөлттэй зээл олгоод байгаа) зээлийн харилцаанаас үүссэн маргааныг шүүхэд шийдвэрлүүлэхээс илүү эдгээр зээл олгогчийн дэргэдэх мэргэжлийн холбоод (Банкны холбоо, Банк бус санхүүгийн байгууллагын холбоо, Хадгаламж, зээлийн хоршоо эрхлэгчдийн холбоо гэх мэт) нь мэргэшсэн, хараат бус санхүүгийн эвлэрүүлэн зуучлах байгууллага байгуулж, зээлийн харилцаанаас үүссэн маргааныг тэдгээр байгууллага урьдчилан шийдвэрлэдэг журамтай байх хууль зүйн зохицуулалт бий болгох шаардлагатай байна. Энэ нь талуудын шүүхэд хандах эрхийг (Access to justice) зөрчсөн явдал огт биш юм. Учир нь иргэний эрх зүйн маргаан нь зах зээлийн харилцаа, нийгмийн хөгжлийг даган байнга өөрчлөгдөж, өсөн нэмэгдэж байдаг онцлогтой бөгөөд эрүү, захиргааны хэрэгтэй харьцуулахад талууд заавал шүүхэд хандаж, эрхээ сэргээлгэхээсээ илүү хоорондын хэлэлцээр, зөвшилцөл, эвлэрлээр хэргийг шийдэх нь иргэний эрх зүйн маргааны мөн чанарт нийцдэг. Үүнээс гадна цаг хугацаа, зардал хэмнэх, талууд хоорондын харилцааг эв найрамдалтай авч үлдэх зэрэгт ихээхэн ач холбогдолтой тул дэлхий дахинд шүүхийн шинэтгэлийн хүрээнд шүүхийн бус аргаар хэрэг маргааныг шийдвэрлэх явдлыг дэмждэг. Энэ утгаараа зээл олгогч бизнесийн байгууллагууд өөрсдийн зээлийн үйлчилгээтэй холбоотой маргаанаа шүүхийн шатнаас өмнө урьдчилан шийд-

вэрлүүлэх тогтолцоотой болох нь тэдний цаг хугацаа, зардлыг хэмнэх төдийгүй шүүхийн ачааллыг бууруулах ач холбогдолтой тул үүнийг хуулиар зохицуулах хэрэгтэй байна.

Хэрэв дээрх агуулга бүхий хууль зүйн зохицуулалт бий болговол шүүн таслах ажиллагааны ачааллыг бодитоор бууруулах магадлалтай бөгөөд үүний зэрэгцээ бага үнийн дүнтэй хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх зохицуулалтыг хослуулан хэрэглэвэл илүү үр дүнд хүрэх юм.

ГУРАВ. ЭРХ ЗҮЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

3.1. ЯПОН УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

3.1.1. Жижиг хэргийн буюу хялбаршуулсан шүүх

Тус улсын шүүхийн тогтолцоо нь Дээд шүүх, давж заалдах шатны шүүх, анхан шатны шүүх гэсэн гурван шатны шүүхээс бүрддэг. Шүүхийн тухай хуульд зааснаар давж заалдах шатны шүүх, орон нутгийн шүүх, гэр бүлийн шүүх, жижиг хэргийн буюу хялбаршуулсан шүүх гэсэн дөрвөн төрлийн шүүхийг доод шатны шүүх гэж үзэж, тус тусын харьяалан шийдвэрлэх хэргийг нь хуулиар тогтоосон аж.[4] Шүүхийн бүтэц, зохион байгуулалтын хувьд дараах хэлбэртэй байна. Үүнд нийт засаг захиргааны нэгж болох 47 мужийн хүрээнд жижиг хэргийн буюу хялбаршуулсан нийт 438 шүүх, орон нутгийн шүүх нь төв 50 шүүх, салбар 203 шүүх, гэр бүлийн шүүх нь төв 50 шүүх, салбар 203 шүүх, явуулын 77 шүүх, давж заалдах шатны шүүх нь төв 8 шүүх, салбар 6 шүүх, оюуны өмчийн маргааныг дагнан шийдвэрлэх давж заалдах шатны шүүх 1, тус улсын нийслэлд орших Дээд шүүх гэсэн бүтэц, зохион байгуулалттай байна.[5]

[4] https://www.courts.go.jp/about/sosiki/gaiyo/index.html, Тус улсын Дээд шүүхийн албан ёсны сайтаас авав.

[5] https://www.courts.go.jp/about/sosiki/gaiyo/index.html, Тус улсын Дээд шүүхийн албан ёсны сайтаас авав.

Энэхүү судалгааны хүрээнд жижиг хэргийн буюу хялбаршуулсан шүүх болон тус шүүх дэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар дэлгэрүүлэн авч үзье. Дээр дурдсанчлан тус улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд энэ төрлийн анхан шатны 438 шүүх орших бөгөөд АНУ-ын Small claim court буюу бага үнийн дүнтэй, жижиг хэргийн шүүхийг загвар болгон шүүхээр үйлчлүүлэгч иргэдэд ойр дөхөм, үйлчлүүлэхэд хялбар шүүх бий болгохыг зорьсон байна.[6]

Тус шүүх нь иргэн болон эрүүгийн хэргийг анхан шатны журмаар харьяалан шийдвэрлэдэг бөгөөд иргэний хэргийн тухайд нэхэмжлэлийн үнийн дүн нь 1,400,000 иен буюу 35 сая орчим төгрөг хүртэлх үнийн дүнтэй хэрэг, эрүүгийн хэргийн хувьд торгохоос бага ял оногдуулах эрүүгийн гэмт хэрэг, хулгай, хөрөнгө завших зэрэг харьцангуй хөнгөн гэмт хэргийг дагнан шийдвэрлэдэг. Иймд тус шүүх нь торгохоос бага ял,[7] эсхүл гурван жилээс бага хугацаагаар хорих ял оногдуулах шийдвэр гаргадаг тул үүнээс илүү хүнд санкцтай эрүүгийн гэмт хэргийг харьяалах шүүхэд нь шилжүүлдэг байна.

3.1.2. Жижиг хэргийн буюу хялбаршуулсан шүүхийн процедуртай холбоотой онцлог зохицуулалт

Ердийн анхан шатны шүүхээс тус шүүхийн ялгаатай тал нь иргэний хэргийг илүү хялбаршуулсан журмаар хянан шийд-

---

6 草地未紀「小額訴訟における和解の意義とその問題点—ある簡易裁判所における傍聴観察データを基に—」(2001. 11), Кусачи Мики. Бага үнийн дүнтэй иргэний маргаан хянан шийдвэрлэх ажиллагаан дахь эвлэрэл, түүний ач холбогдол болон тулгамдсан асуудал: Нэгэн жижиг хэргийн шүүхэд хийсэн ажиглалт, судалгааны үр дүнд үндэслэх нь. 2001 оны 11 дүгээр сар, судалгааны тайлангийн 151 дэх тал.

7 Тус улсын Эрүүгийн хуулиар цаазаар авах ял, албадан хөдөлмөр эрхлүүлэх заалттай хугацаатай болон хугацаагүй хорих ял, албадан хөдөлмөр эрхлүүлэх заалтгүй 1 сараас 20 жил хүртэлх хугацааны хорих ял, 10,000 иенээс дээших үнийн дүнгээр торгох ял, 1-30 хоног хүртэлх хугацаагаар баривчлах ял, 1000-10,000 хүртэлх иенээр торгох ял, нэмэгдэл ял болгож гэмт хэрэг үйлдэхэд ашигласан эд зүйлс болон гэмт хэрэг үйлдэж олсон орлого, эд зүйлийг хураан авах ялыг хуульчилсан байна.

вэрлэдгээрээ онцлог. Тодруулбал, дараах хэдэн зохицуулалтыг дурдаж болно:

1. Шүүхэд нэхэмжлэлийг амаар гаргах боломжтой (Иргэний процессын хуулийн 271, 273 дугаар зүйл), нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлийг заавал нарийн тодруулалгүйгээр маргааны гол үйл баримтыг дурдахад хангалттай байх (Иргэний процессын хуулийн 272 дугаар зүйл);

2. Шүүх хуралд гаргах тайлбар, мэдүүлгээ урьдчилж заавал бичгээр гаргасан байх шаардлагагүй байдаг бол ердийн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэхүү шаардлага заавал тавигддаг (Иргэний процессын хуулийн 276 дугаар зүйл);

3. Зохигчид эхний болон түүнээс хойших шүүх хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд тэдний бичгээр гаргаж өгсөн тайлбар, мэдүүлэгт үндэслэж шүүх хурал явуулах боломжтой (Иргэний процессын хуулийн 277 дугаар зүйл). Гэрчийн мэдүүлгийг заавал биечлэн авалгүйгээр бичгээр авах боломжтой (Иргэний процессын хуулийн 278 дугаар зүйл) зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бичгээр явуулах байдлыг илүү хүлээн зөвшөөрсөн зохицуулалт хийснээр шүүн таслах ажиллагааг шуурхай явуулах нөхцөл бүрдүүлсэн гэж үздэг.

Дээрх зохицуулалтаас гадна

1. Эвлэрлийн гэрээг баталгаажуулах захирамж (Иргэний процессын хуулийн 275.2 дугаар зүйл);

2. Шүүн таслах ажиллагаанд шүүхийн орон тооны бус, цагийн зөвлөх, мэргэжилтэн оролцуулах тухай зохицуулалт (Иргэний процессын хуулийн 279 дүгээр зүйл);

3. Шүүхийн шийдвэрийг товч бүтэцтэй бичих (Иргэний процессын хуулийн 280 дугаар зүйл);

4. Гэрчийн мэдүүлэг болон нотлох баримт шинжлэн судалсан тухай шүүх хуралдааны тэмдэглэлийг товч, хураангуйлан бичих (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмын 170 дугаар зүйл) зэрэг зохицуулалтыг нэрлэж болно.

Тус шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчид өмгөөлөгчгүйгээр оролцох нь элбэг боловч 2003 оноос тодорхой шалгуур, шаардлага хангасан Шихошоши буюу туслах өмгөөлөгчид шүүхийн шүүн таслах ажиллагаанд талуудыг төлөөлөх эрх олгосон байна (Шүүхийн тухай хуулийн 3.1.6).

3.1.3. Хэрэг хянан шийдвэрлэх хялбаршуулсан ажиллагаа

Үүнд дараах гурван төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хамаарна:

1/ мөнгөн дүнгийн үүргийн гүйцэтгэлийг шуурхай шаардах ажиллагаа;

2/ вексель, чек зэрэгтэй холбоотой төлбөр, тооцооны үүргийн гүйцэтгэлийг шуурхай шаардах ажиллагаа;

3/ бага үнийн дүнтэй иргэний хэргийг шуурхай шийдвэрлэх ажиллагаа бий.

Эдгээрээс судалгааны хүрээ болон судлах зүйлээс хамаарч бага үнийн дүнтэй иргэний хэргийг шуурхай шийдвэрлэх ажиллагааг дэлгэрүүлэн авч үзэх боловч үүний өмнө бусад хоёр ажиллагааг товч танилцуулах нь зүйтэй гэж үзлээ.

1/ Мөнгөн дүнгийн үүргийн гүйцэтгэлийг шуурхай шаардах ажиллагаа

Тус ажиллагаа нь ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай харьцуулахад нэхэмжлэгчид хялбар, шуурхай, хямд зардлаар маргаанаа шийдвэрлүүлэх, гүйцэтгэх хуудас олж авах боломж олгодгоороо онцлог юм.[8] Иймээс тус улсын шүүхийн практикт ихэвчлэн кредит карт болон хэрэглээний зээлтэй холбоотой үүргийн гүйцэтгэлийг шаардахад хэрэглэгддэг бөгөөд шаардах эрх үүссэн эсэх болон нэхэмжилж буй үнийн дүнгийн талаар талуудын хооронд маргаан байхгүй, гагцхүү үүргийн гүйцэтгэлийн хугацаа хэтэрсэн маргааныг шуурхай шийдвэрлэхэд тус ажиллагаа тохиромжтой гэж үздэг.[9]

Энэхүү ажиллагаагаар хэрэг үүсгэхийн тулд нэхэмжлэгч нь хариуцагчийн оршин суугаа газрын харьяалах жижиг хэргийн буюу хялбаршуулсан шүүхийн шүүгчийн туслахад нэхэмжлэл гаргана (Иргэний процессын хуулийн 383.1). Нэхэмжлэл хүлээн авсан шүүгчийн туслах үүргийн гүйцэтгэлийг даруй хангуулах тухай захирамж гаргаж, хариуцагчид гардуулна (Иргэний процессын хуулийн 386.1). Хариуцагч нь захирамж хүлээн авснаас хойш хоёр долоо хоногийн дотор захирамжид гомдол гаргавал тухайн маргаан нь ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжинэ (Иргэний процессын хуулийн 395 дугаар зүйл).

Харин ийнхүү заасан хугацаанд гомдол гаргаагүй тохиолдолд шүүгчийн туслах нь захирамжийн хамт шийдвэр гүйцэтгэх хуудас үйлдэж хариуцагчид хүргүүлэх бөгөөд нэхэмжлэгч ч шийдвэр гүйцэтгэлийн байгууллагад шууд хандах эрхтэй болно (Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийн 22.4). Хариуцагч шүүхээс хүргүүлсэн дээрх баримт бич-

[8] 小島武司[編]『よくわかる民事訴訟法』(ミネルヴァ書房、2013年)、Эмхэтгэсэн Кожима Такэши. Ойлгоход хялбар иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй. 2013, 179 дэх тал.

[9] Мөн тэнд.

гийг хүлээн авснаас хойш хоёр долоо хоногийн дотор гомдол гаргаагүй бол захирамж шүүхийн шийдвэрийн нэгэн адил хүчин чадалтай болж, үүргийн гүйцэтгэлийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар хангуулах боломжтой болдог (Иргэний процессын хуулийн 396, Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуулийн 22.7).

Хэрэг хянан шийдвэрлэх энэхүү ажиллагаа нь шүүхийн практикт түгээмэл хэрэглэгдэх болсноор 2004 оны Иргэний процессын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, нэхэмжлэл гаргах, шүүгчийн туслах захирамж үйлдэх, тэдгээрийг хариуцагчид хүргүүлэх зэрэг бүх процесс ажиллагааг 100 хувь цахимаар явуулах боломж бүрдүүлсэн байна (Иргэний процессын хуулийн 397-402 дугаар зүйл).[10]

2/ Вексель, чек зэрэгтэй холбоотой төлбөр, тооцооны үүргийн гүйцэтгэлийг шуурхай шаардах ажиллагаа

Энэхүү ажиллагааны зорилго нь вексель, чек зэрэгтэй холбоотой төлбөр, тооцооны үүргийн гүйцэтгэлийг гаргуулах, хуулиар тогтоосон хүү, алдангийг хохиролд шаардахад оршдог (Иргэний процессын хуулийн 350.1, 367.1). Вексельтэй холбоотой төлбөр, тооцооны үүргийн гүйцэтгэлийг шаардахад өмнө дурдсанчлан 1,400,000 иен хүртэлх үнийн дүнтэй бол жижиг хэргийн буюу хялбаршуулсан шүүхэд, түүнээс дээш үнийн дүнтэй бол орон нутгийн ердийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргана. Шүүхийн харьяаллын хувьд хариуцагчийн оршин суугаа газрын шүүх, эсхүл тус вексель, чекийн төлбөр, тооцоог хийх ёстой газрын шүүхэд ч нэхэмжлэл гаргаж болно (Иргэний процессын хуулийн 350.2). Түүнчлэн нэхэмжлэгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болохоос өмнө л бол хэзээ ч хамаагүй хариуцагчаас зөвшөөрөл авалгүйгээр хэргээ ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжүүлж болдог.

---

[10] Мөн тэнд.

Хэрэг хянан шийдвэрлэх тус хялбаршуулсан ажиллагаа нь дараах онцлогтой. Тухайлбал:

1. Нотлох баримтын хувьд зөвхөн бичмэл нотлох баримт гаргах (Иргэний процессын хуулийн 352.1) бөгөөд гаргасан вексель, чек болон түүнийг гаргах үндэслэл болсон талууд хоорондын гэрээ зэргийг л үндэслэж тухайн маргааныг шийдвэрлэдэг.

2. Зөвхөн нэг удаагийн шүүх хурлаар хэргийг эцэслэн шийдвэрлэдэг (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмын 214 дүгээр зүйл) бөгөөд сөрөг нэхэмжлэл гаргахыг хуулиар хориглодог (Иргэний процессын хуулийн 351 дугаар зүйл).

3. Шүүхээс гарсан шийдвэрийг давж заалдах боломжгүй (Иргэний процессын хуулийн 356 дугаар зүйл) боловч тухайн шүүхэд гаргасан шийдвэртэй нь холбогдуулж гомдол гаргах боломжтой (Иргэний процессын хуулийн 357 дугаар зүйл) бөгөөд гомдол гаргасан тохиолдолд тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүхийн шийдвэр гаргахын өмнөх байдал руу буцаж, ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын дагуу тус маргааныг эцэслэн шийдвэрлэдэг байна (Иргэний процессын хуулийн 361 дүгээр зүйл).

Хэрэг хянан шийдвэрлэх дээрх хоёр төрлийн ажиллагаа нь кредит карт, хэрэглээний зээлийн эргэн төлөлттэй холбоотой үүргийн гүйцэтгэл болон вексель, чек зэрэг төлбөр тооцооны үүргийн гүйцэтгэлтэй холбоотой үүссэн маргааныг шуурхай шийдвэрлэхэд зориулагдсан хялбаршуулсан процесс ажиллагаа болох нь харагдаж байна. Энэ төрлийн шуурхай процесс ажиллагаа нь манай улсын иргэний хэргийн шүүн таслах ажиллагаанд ч ач холбогдолтой байхыг үгүйсгэхгүй тул товч танилцуулахыг зорилоо. Тэгвэл дор энэхүү судалгааны гол сэдэв болох бага

үнийн дүнтэй бусад төрлийн иргэний хэргийг тус улсад хэрхэн шуурхай бөгөөд хялбаршуулсан журмаар шийдвэрлэдэг болохыг авч үзэв.

3/ Бага үнийн дүнтэй иргэний хэргийг шуурхай хянан шийдвэрлэх ажиллагаа

Тус зохицуулалт нь нэхэмжлэлийн үнийн дүн нь 600,000 иен (15 сая орчим төгрөг) хүртэлх мөнгөн дүнтэй иргэний хэргийг бага зардлаар, хялбар, шуурхай шийдвэрлэх зорилготой 1996 оны Иргэний процессын хуулийн шинэчилсэн найруулгын нэгэн шинэ зохицуулалт болж батлагдсан.[11]

Уг зохицуулалт дараах хэдэн онцлогтой:

1. Зарчмын хувьд энэ төрлийн иргэний хэргийг зөвхөн нэг удаагийн шүүх хурлаар эцэслэн шийдвэрлэнэ (Иргэний процессын хуулийн 370 дугаар зүйл).

2. Зохигч нь шүүх хурлын өмнө болон шүүх хурлын үеэр бүхий л тайлбар, татгалзлын үндэслэлээ шүүхэд гаргаж өгөх ёстой (Иргэний процессын хуулийн 370.2). Мөн нотлох баримт шинжлэн судлах ажиллагаа нь зөвхөн шүүх хурлын үеэр шинжлэн судлах боломжтой гэрч болон нотлох баримтын хүрээгээр хязгаарлагдана (Иргэний процессын хуулийн 371 дүгээр зүйл).

3. Сөрөг нэхэмжлэл гаргахыг хуулиар хориглосон (Иргэний процессын хуулийн 369 дүгээр зүйл).

4. Хариуцагчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сонгох боломж олгосон бөгөөд хариуцагч нь шүүх хурал болохын өмнө, эсхүл шүүх хурал дуусахын өмнө тухайн

[11] Эшлэлийн №7-гийн 180-181 дэх тал.

хэргийг ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар шийдвэрлүүлэх хүсэлтээ гаргаж болно (Иргэний процессын хуулийн 373.1).

5. Мөн шүүгч тухайн төрлийн иргэний хэргийг уг шуурхай бөгөөд хялбаршуулсан ажиллагааны дагуу хянан шийдвэрлэх нь тохиромжгүй гэж үзвэл өөрийн үзэмжээр тус хэргийг ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжүүлэх шийдвэр гаргаж болно (Иргэний процессын хуулийн 373.3).

6. Хэргийн онцлогоос хамаарах боловч ихэвчлэн энэ төрлийн иргэний хэргийг шүүх хуралдаан нэг цагийн дотор дуусгавар болдог.

7. Гэрч асуулгах, талуудаас мэдүүлэг авах нь ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай харьцуулахад нарийн тогтсон дараалал, дэггүй, илүү хялбаршуулсан байдлаар буюу шүүгчийн тохиромжтой гэж үзсэн дараалаар явагдаж, зарим тохиолдолд эдгээр ажиллагааг цахимаар явуулах боломжтой байдаг (Иргэний процессын хуулийн 372.2, 372.3).

8. Талууд эвлэрээгүй тохиолдолд шүүх хурал дуусгавар болж, шүүгч тухайн өдөртөө багтаан шийдвэрээ танилцуулдаг (Иргэний процессын хуулийн 372.2, 372.3).

9. Шүүгч нь хариуцагчийн санхүүгийн чадавх болон бусад нөхцөл байдлыг харгалзан үзэж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш гурван жилийн дотор үүрэг гүйцэтгэх хугацааг хойшлуулах, үүргийг хуваж гүйцэтгүүлэх, алданги, торгуулиас чөлөөлөх зэрэг асуудлыг шийдвэрлэж, шүүхийн шийдвэрт тусгаж болдог (Иргэний процессын хуулийн 375.1).

10. Шүүхийн шийдвэрийг давж заалдах боломжгүй боловч уг шийдвэрийг гаргасан шүүхэд гомдол гаргаж, шийдвэрийг дахин хянуулах боломжтой (Иргэний процессын хуулийн 377 дугаар зүйл). Гэвч үүрэг гүйцэтгэх хугацааг хойшлуулах, төлбөрийг хуваж төлөх хуваарь зэргийг шийдвэрлэсэн байдлын талаар гомдол гаргах боломжгүй юм (Иргэний процессын хуулийн 375.3).

11. Хэрэв хуулийн дагуу шүүхийн шийдвэрт гомдол гаргасан бол хэргийг ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар эцэслэн шийдвэрлэнэ (Иргэний процессын хуулийн 379.1). Өөрөөр хэлбэл, шүүн таслах ажиллагааг ганц удаагийн шүүх хурлаар дуусгавар болгохгүй, мөн дээр дурдсанчлан, шинжлэн судлах нотлох баримтын хязгаарлалт ч байхгүй болно гэсэн үг юм.

12. Гомдлоор хянан шийдвэрлэсэн хэргийн шүүхийн шийдвэрийг давж заалдахыг хуулиар хориглосон. Гагцхүү Үндсэн хууль зөрчсөн гэсэн үндэслэлээр шийдвэрийг дээд шатны шүүхээр хянуулах тухай давж заалдах тусгай гомдол гаргахыг хуулиар хүлээн зөвшөөрсөн (Иргэний процессын хуулийн 380 дугаар зүйл).

13. Хэрэг хянан шийдвэрлэх шуурхай бөгөөд хялбаршуулсан энэ ажиллагааг бизнесийн байгууллага өр зээлээ барагдуулах хэрэгсэл болгон хэт ихээр ашиглахаас урьдчилан сэргийлж, ердийн иргэд ч адил тэнцүү үйлчлүүлэх боломж бий болгох үүднээс нэхэмжлэл гаргах тоонд хязгаар тогтоосон байдаг. Тодруулбал, нэг шүүхэд жилд бага үнийн дүнтэй 10 хүртэлх иргэний хэрэг шийдвэрлүүлэх нэхэмжлэл гаргаж болно гэж тодорхой заажээ (Иргэний процессын хуулийн 368.1, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмын 223 дугаар зүйл).

14. 2004 оны Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор шүүхийн шийдвэр гаргуулсан үүрэг гүйцэтгүүлэгч нь уг ажиллагаанд хандаж, тухайн шийдвэр гаргасан шүүхийн шүүгчийн туслахад шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулах хүсэлт гаргах боломжтой болсон юм (Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 167.2).

3.1.4. Шүүгчийн орон тооны бус зөвлөх, мэргэжилтэн (Шихоиин)

Жижиг хэргийн буюу хялбаршуулсан шүүхийн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ажил, амьдралын арвин туршлагатай, мэргэжлийн нарийн мэдлэгтэй энгийн иргэд дотроос шүүгчийн орон тооны бус зөвлөх, мэргэжилтнээр сонгогдсон хүнийг тухайн хэрэг маргааны онцлогт тохируулж шүүн таслах ажиллагаанд оролцуулдаг.[12] Тус орон тооны бус зөвлөх, мэргэжилтэн нь талуудыг эвлэрүүлэхэд шүүгчтэй хамтарч ажиллах, шүүн таслах ажиллагааны явцад шүүгчид хэрэг болохуйц зөвлөгөө, мэдээлэл өгөх, хэргийг хэрхэн шийдвэрлэх талаар санал гаргах зэрэг чиг үүрэг гүйцэтгэдэг (Иргэний процессын хуулийн 279.1). Гэвч эдгээр мэргэжилтний зөвлөгөө, мэдээлэл, саналыг шүүгч шүүн таслах ажиллагаа болон шүүхийн шийдвэр гаргахад харгалзан үзэж болох төдий бөгөөд эцсийн шийдвэрийг шүүгч гаргадаг.[13]

Дээрх байдлаар шүүн таслах ажиллагаанд оролцох боломжтой шүүгчийн орон тооны бус зөвлөх, мэргэжилтнийг жил бүр орон нутгийн анхан шатны шүүхээс сонгон шалгаруулж, нэрсийн

[12] https://www.courts.go.jp/saiban/zinbutu/sihoiin/index.html, Тус улсын Дээд шүүхийн албан ёсны сайтаас авав.

[13] https://www.courts.go.jp/saiban/zinbutu/sihoiin/index.html, Тус улсын Дээд шүүхийн албан ёсны сайтаас авав.

жагсаалт гаргах бөгөөд тус жагсаалтаас тухайн жижиг хэргийн буюу хялбаршуулсан шүүх нь хэргийн онцлогт тохируулж зөвлөх, мэргэжилтнээ сонгож, шүүн таслах ажиллагаанд оролцуулдаг (Иргэний процессын хуулийн 279.3). Ийнхүү шүүгчийн орон тооны бус зөвлөхөөр сонгогдож ажиллахад тусгай шалгуур, шаардлага тавигдаагүй байна. Гэхдээ ихэвчлэн өмгөөлөгч, их сургуулийн профессор сонгогддог хэдий ч хууль зүйн ямар ч мэдлэггүй хүн, тухайлбал, тухайн орон нутгийн асуудлаа нарийн мэддэг иргэн, анагаах ухаан, эрүүл мэндийн салбарын нарийн мэдлэгтэй хүн, эсхүл үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээний талаар нарийн мэдлэгтэй хүн зэрэг тусгай мэдлэг шаардсан, шийдвэрлэхэд ээдрээ төвөгтэй хэрэгт орон тооны бус зөвлөх, мэргэжилтнийг оролцуулдаг байна.[14]

Тус шүүгчийн зөвлөх, мэргэжилтэн нь шүүхийн үндсэн ажилтан биш, орон тооны бус ажилтанд тооцогдох бөгөөд шүүхээс хүсэлт гаргаснаар шүүн таслах ажиллагаанд оролцсон тохиолдолд шаардлагатай унааны зардал болон өдрийн ажлын хөлсийг нь улсаас олгодог байна (Иргэний процессын хуулийн 279.5).

3.1.5. Шүүхийн статистик

Тус улсын Дээд шүүхээс жил бүр гаргадаг Шүүхийн тайлангийн номоос шүүхийн доорх статистикийг авч оруулсан болно. Статистикаас үзэхэд тус улсад 2020 оны байдлаар нийт 438 жижиг хэргийн буюу хялбаршуулсан шүүх, түүнд нь 806 шүүгч ажиллаж байна. 2020 оны байдлаар дээрх тооны шүүгчээс гадна шүүгчийн орон тооны бус зөвлөх, мэргэжилтэн улсын хэмжээнд нийт 5,023 байна.[15]

---

[14] https://www.courts.go.jp/saiban/zinbutu/sihoiin/index.html, Тус улсын Дээд шүүхийн албан ёсны сайтаас авав.

[15] 最高裁判所『裁判所データブック2020』, Япон Улсын Дээд шүүх. Шүүхийн тайлан. 2020, 24 дэх тал.

Хүснэгт №1. Жижиг хэргийн буюу хялбаршуулсан шүүх болон шүүгчийн тоо /2020 оны байдлаар/

Тус шүүхийн төрөл, хэлбэр	Орон нутгийн анхан шатны шүүхийн төв болон салбар шүүхтэй хамт байрлах шүүх	253	**Нийт шүүхийн тоо 438[16]**	**Нийт шүүгчийн тоо 806[17]**
	Бие даасан бусад шүүх	185		

Тус төрлийн шүүхэд сүүлийн гурван жилд эрүү, иргэний нийт 300 мянга орчим хэрэг шийдвэрлэж байна.

Хүснэгт №2.[18] Хүлээн авсан, шийдвэрлэсэн, үлдэгдэл хэргийн тоо /Эрүү, иргэний нийт хэрэг/

Он	Шинээр хүлээн авсан хэрэг	Шийдвэрлэсэн хэрэг	Үлдэгдэл хэрэг
2017	336,384	337,142	70,130
2018	341,349	339,102	72,377
2019	344,101	337,800	78,678

Эдгээрээс 8-10 мянга орчим хэргийг бага үнийн дүнтэй иргэний хэргийн хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн бөгөөд энэ тоо жил бүр буурах төлөвтэй байна.

[16] Тус тайлангийн 1 дэх тал.

[17] Тус тайлангийн 22 дахь тал.

[18] Тус тайлангийн 36 дахь тал.

Хүснэгт №3.[19] Бага үнийн дүнтэй иргэний хэргийн тоо

Он	Шинээр хүлээн авсан хэрэг	Шийдвэрлэсэн хэрэг	Үлдэгдэл хэрэг
2017	10,041	10,164	2,134
2018	9,310	9,312	2,132
2019	8,542	8,668	2,006

Эдгээр хэргийг шүүхээс шийдвэрлэсэн байдлыг авч үзвэл талуудын эвлэрлээс илүү шүүхийн шийдвэрээр хэргийг эцэслэн шийдвэрлэдэг бөгөөд хоёр тал шүүх хуралд оролцож мэтгэлцэх нь харьцангуй бага буюу аль нэг тал нь шүүх хуралд ирснээр шүүх хурал болж, шүүхийн шийдвэр гарсан байна.

Хүснэгт №4.[20] Бага үнийн дүнтэй хэрэг шийдвэрлэсэн байдал

Он	Шүүхийн шийдвэрээр шийдвэрлэсэн хэргийн тоо			Зохигчид нь эвлэрсэн хэргийн тоо	Бусад
	Нийт хэргийн тоо	Зохигчид мэтгэлцсэн	Зохигчдын аль нэг тал ирээгүй		
2017	4,149	1,815	2,383	3,105	2,910
2018	3,803	1,583	2,218	2,659	2,850
2019	3,691	1,618	2,072	2,267	2,710

Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн энэ хугацааг авч үзвэл мэдээж, ердийн хэрэг хянан шийдвэрлэх хугацаанаас харьцангуй богино байна.

[19] Тус тайлангийн 53 дахь тал.

[20] Мөн тэнд.

Хүснэгт №5.[21] Ердийн иргэний хэрэг болон бага үнийн дүнтэй иргэний хэрэг шийдвэрлэсэн дундаж хугацааны харьцуулалт

Он	Ердийн иргэний хэрэг шийдвэрлэсэн дундаж хугацаа /сараар/	Бага үнийн дүнтэй иргэний хэрэг шийдвэрлэсэн дундаж хугацаа /сараар/
2017	2.8	1.9
2018	2.7	1.9
2019	2.8	2.1

3.2. АНГЛИ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

3.2.1. Бага үнийн дүнтэй хэргийг харьяалан шийдвэрлэдэг шүүх

Англи Улсын шүүхийн тогтолцоо нь Магистратын шүүх, Титмийн шүүх, Мужийн шүүх, Дээд шатны шүүх, Давж заалдах шатны шүүх болон Дээд шүүхээс бүрдэх ба иргэний хэргийн хувьд Мужийн шүүх (Магистратын шүүхийн тодорхой хэргүүд), Дээд шатны шүүх, Давж заалдах шатны шүүхийн Иргэний хэргийн танхим, Дээд шүүх гэсэн бүтэцтэйгээр хэрэг хянан шийдвэрлэдэг. Магистратын шүүх (Magistrates' courts) нь Английн хамгийн доод шатны шүүх бөгөөд гурван магистрат, эсхүл дүүргийн нэг шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хэрэг хянан шийдвэрлэдэг. Энэ шүүх нь ихэвчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэдэг боловч гэр бүлийн маргаан, хотын албан татвартай холбоотой хэрэг зэрэг зарим төрлийн иргэний хэргийг шийдвэрлэдэг ба өөрийн

[21] Тус тайлангийн 77 дахь тал.

эрх хэмжээнээс хэтэрсэн, эсхүл шийдвэрлэхэд ээдрээ төвөгтэй гэж үзвэл тухайн хэргийг дараагийн шатны шүүхэд шилжүүлэх боломжтой байдаг.[22]

Мужийн шүүх (County court) нь иргэний дийлэнх хэргийг хянан шийдвэрлэдэг бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дүүргийн шүүгчийн орлогч, дүүргийн шүүгч, тойргийн шүүгчид оролцдог. Тойргийн шүүгчид нь дүүргийн шүүгчдээс илүү өргөн харьяаллын хэрэг шийдвэрлэдэг ахлах шүүгчид юм. Дүүргийн шүүгчид нь бага үнийн дүнтэй иргэний хэрэг болон хуваарилагдсан аливаа хэргийг түргэвчилсэн (fast track) журмаар хянан шийдвэрлэдэг. Мужийн шүүх нь нутаг дэвсгэрийн хуваарилалтын дагуу байгуулагдсан шүүх биш бөгөөд одоогийн байдлаар Англи Улсад мужийн 270 шүүх үйл ажиллагаа явуулж байна. Энэ шүүх нь дээд шатныхаа шүүхийг бодвол харьцангуй шуурхай, зардал бага шаардагдах шүүх юм.

Англи Улсын хувьд бага үнийн дүнтэй хэрэг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг давж заалдах нь хязгаарлалттай байдаг бөгөөд давж заалдах гомдол гаргах тал нь анхан шатны шүүгчээс зөвшөөрөл авч, давж заалдах гомдлын үндэслэлээ гаргадаг. Мөн бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэдэг дагнасан, тусгай шүүх байдаггүй бөгөөд энэ төрлийн хэргийг Мужийн шүүх (County court) хялбаршуулсан журмаар хянан хэлэлцдэг.[23] Энэ утгаараа Английн Мужийн шүүхийг ихэвчлэн "Бага үнийн дүнтэй хэргийн шүүх" гэж нэрлэдэг.

Английн 1998 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай журамд Дээд шүүх болон Мужийн шүүхэд бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой тодорхой зохи-

---

[22] Англи Улс дахь иргэний болон эрүүгийн хэргийн шүүх, трибуналын тогтолцоо. Сүүлд нэвтэрсэн: 2021.04.12. https://england.shelter.org.uk/legal/courts_and_legal_action/structure_of_civil_courts,_tribunals_and_criminal_courts_in_england

[23] Европын холбооны бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа. Сүүлд нэвтэрсэн: 2021.04.13. https://www.europarl.europa.eu/RegData/etudes/IDAN/2014/542137/EPRS_IDA(2014)542137_REV1_EN.pdf

цуулалт оруулсан ба энэ шинэчлэл нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хялбаршуулж шуурхайлах зорилго агуулжээ. 1999 оны дөрөвдүгээр сараас эхлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тухай журам хэрэгжиж эхэлснээр Мужийн шүүхэд бага үнийн дүнтэй хэрэг хянан хэлэлцэж эхэлсэн байна. Мужийн шүүх нь хэргийн хөдөлгөөний менежментийн дагуу хэргийг гурван төрлийн журмын (процедурын) аль нэгэнд хуваарилж шийдвэрлэдэг. Үүнд multi-track буюу олон чигт (нэхэмжлэлийн шинж чанараас хамаарч Мужийн шүүх, эсхүл дээд шатны шүүхээр хянан хэлэлцэж болох 25,000 паундаас дээш үнийн дүнтэй нэхэмжлэл), fast track буюу түргэвчилсэн (10,000-25,000 паундын хоорондох үнийн дүнтэй нэхэмжлэл) болон бага үнийн дүнтэй хэрэг (small claim track) багтдаг. Эдгээр гурван төрлийн хэрэг хянан шийдвэрлэх журмаас бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх журмыг доор дэлгэрүүлэн авч үзье.

3.2.2. Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх хялбаршуулсан ажиллагаа, түүний хууль зүйн зохицуулалт

Мужийн шүүх нь иргэний хэргийг, дээр дурдсанчлан, гурван төрлийн журмаар хянан шийдвэрлэдэг (multi-track, fast track, small claim track) ба түүний дотроос бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэж буй дараах зохицуулалтыг онцолж болох юм. Үүнд:

1. Талууд шүүхэд нэхэмжлэл гаргасны дараа шүүхээс талуудад ерөнхий болон тусгай зааварчилгаа өгнө. Үүнд, тухайлбал, талууд шүүх хурал товлосон өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө шинжээчийн дүгнэлт зэрэг шүүх хуралд шаардлагатай баримт бичгийг шүүхэд хүргүүлэх зэрэг ажил багтана. Мөн урьдчилсан хэлэлцүүлэг болон шүүх хурлын тов тогтооно. Түүнчлэн шүүх талуудаас шүүх хурал хийлгүйгээр нэхэмжлэлийн шаардлагыг

хүлээн зөвшөөрч, биелүүлэх эсэхийг асууж тодруулах ба хэрэв талууд үүнийг хүлээн зөвшөөрвөл энэ тухайгаа товлосон хугацаанд шүүхэд мэдэгдэх үүрэгтэй (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай журмын 27.4.1 дүгээр зүйл);

2. Шүүхээс санал болгосны дагуу талууд нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд шүүхийн зүгээс шүүх хурал болохоос 21 хоногийн өмнө шүүх хурлын тов болон шүүх хурал үргэлжлэх хугацааны тухай талуудад мэдэгдэнэ (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай журмын 27.4.2 дугаар зүйл);

3. Шүүх хурлын үеэр шинжээч нь шүүгчийн зөвшөөрөлгүйгээр нотлох баримт гаргах эрхгүй (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай журмын 27.5 дугаар зүйл);

4. Шүүхээс талуудын гаргасан хүсэлт болон тодорхой нөхцөл хангагдсан үед урьдчилсан хэлэлцүүлэг зохион байгуулах ба багадаа 14 хоногийн өмнө энэ тухай талуудад мэдэгдэж, мөн талууд зөвшөөрвөл дахин шүүх хурал хийхгүйгээр урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд хэргийг хянан шийдвэрлэж болдог (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай журмын 27.6 дугаар зүйл);

5. Шүүх хурал нь ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай харьцуулахад уян хатан, хялбаршуулсан байдлаар явагдах бөгөөд нотлох баримт үнэлэх хатуу дэг журам, дараалал үйлчлэхгүй. Гэсэн ч шүүх шийдвэрийнхээ шалтгаан, үндэслэлийг тайлбарлах ёстой (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай журмын 27.8 дугаар зүйл). Мөн шүүх хурлыг шүүгчийн өрөөнд зохион байгуулж болох ба шүүх хурлын танхимд зохион байгуулах эсэх асуудал нь нээлттэй юм;

6. Шүүх хуралд талуудын аль нэг нь ирэх боломжгүй бол энэ тухайгаа шүүхэд болон нөгөө талдаа долоо хоногийн өмнө бичгээр мэдэгдэх ба биечлэн оролцох боломжгүй болсон шалтгаан болон бусад нотлох баримтыг нь шүүх шийдвэрээ гаргахдаа харгалзан үзнэ. Хэрэв нэхэмжлэгч шүүх хуралд ирээгүй бөгөөд энэ тухайгаа шүүхэд бичгээр мэдэгдээгүй бол шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож болно. Харин хариуцагч шүүх хуралд ирээгүй бөгөөд энэ тухайгаа шүүхэд бичгээр мэдэгдээгүй бол шүүх зөвхөн нэхэмжлэгч талын нотлох баримтыг үндэслэн шийдвэрээ гаргаж болно. Талуудын аль нь ч өмнө дурдсан мэдэгдлийг гаргаагүй бол шүүхээс нэхэмжлэл болон сөрөг нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож болно (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай журмын 27.9 дүгээр зүйл);

7. Шүүх болон талууд зөвшөөрвөл нэхэмжлэлийг шүүх хурал хийлгүйгээр шийдвэрлэж болно (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай журмын 27.10 дугаар зүйл);

8. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай журмын 27.9 дүгээр зүйлд заасны дагуу аль нэг тал, талууд, эсхүл тэдний хууль ёсны төлөөлөгч нь шүүх хуралд ирээгүй, энэ тухайгаа шүүхэд бичгээр мэдэгдээгүйн улмаас гарсан шүүхийн шийдвэрийг талууд хүчингүй болгож, хэргийг дахин хянан хэлэлцүүлэх хүсэлт гаргаж болно. Гэхдээ шүүх хуралд ирэхгүйгээ мэдэгдэх боломжгүй байсан хүндэтгэн үзэх шалтгаан, мөн шүүх хуралд биечлэн ирсэн тохиолдолд ялалт байгуулах боломжтой байсан зэрэг нөхцөлийг харгалзан үзсэний үндсэн дээр шүүх хүсэлтийг хүлээн авна. Харин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай журмын 27.10 дугаар зүйлд заасны дагуу шүүх хурал хийлгүйгээр хэргийг шийд-

вэрлэсэн бол шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хянан хэлэлцүүлэх хүсэлт гаргах эрхгүй (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай журмын 27.11 дүгээр зүйл).

3.2.3. Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэж буй өнөөгийн нөхцөл байдал

Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх хялбаршуулсан ажиллагаа нь олон чигт, эсхүл түргэвчилсэн төрөлтэй харьцуулахад хэргийг илүү хялбар бөгөөд уян хатан байдлаар хянан шийдвэрлэдэг. Ихэнх Мужийн шүүхийн хүлээн авч, шийдвэрлэж буй бага үнийн дүнтэй хэрэг нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хоорондын өр, төлбөрийн маргаан байдаг. Бага үнийн дүнтэй хэрэгт талууд заавал өмгөөлөгч авах шаардлагагүй байдаг.

Бага үнийн дүнтэй хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхийн тулд шүүгч нь талуудын хүсэл зоригийг харгалзан үзэх бөгөөд нэхэмжлэлийн үнийн дүн 10,000 паундаас хэтрэхгүй байх, нэхэмжлэлийн төрөл нь зээлийн болон өр төлбөрийн нэхэмжлэл байх шаардлагатай. Бага үнийн дүнтэй хэргийг дараах төрөлд хуваж болно. Үүнд худалдах, худалдан авах гэрээнээс үүдсэн маргаан (төлбөрөө төлсөн боловч бараагаа хүлээн аваагүй, барааны чанар доголдолтой байсан гэх мэт), иргэд болон аж ахуйн нэгж, байгууллага хоорондын бага үнийн дүнтэй маргаан, түрээслүүлэгч болон түрээслэгч хоорондын байрны засвар үйлчилгээ, түрээсийн төлбөрийн маргаан зэрэг хэрэг маргаан багтдаг.[24]

[24] Бага үнийн дүнтэй хэрэг. Сүүлд нэвтэрсэн: 2021.04.12. https://publications.parliament.uk/pa/cm200506/cmselect/cmconst/519/519.pdf

График №22. Мужийн шүүхийн шийдвэрлэсэн хэргийн нэхэмжлэлийн үнийн дүн /2004 он/



Эх сурвалж: Үндсэн хуулийн асуудал эрхэлсэн газар

Англи, Уэльсийн Мужийн шүүхэд гаргасан нэхэмжлэлийн үнийн дүнг харвал дийлэнх буюу 71.6 хувь нь 5,000 паундаас доогуур үнэтэй байна (бага үнийн дүнтэй нэхэмжлэл). Мөн 2004 онд хүлээн авсан 46,100 хэргийн нэхэмжлэлийн 31,350 буюу 68 хувь нь өр төлбөрийн маргаан байжээ.[25] Энэ үзүүлэлт 2019 оны нэгдүгээр улирлын байдлаар буурч, 57 хувь нь бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх журмаар, 36 хувь нь түргэвчилсэн, 7 хувь нь олон чигт журмаар шийдвэрлэгджээ.[26]

[25] Англи болон Уэльсийн шүүхийн тоон мэдээлэл. 2005. Сүүлд нэвтэрсэн: 2021.04.15. https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/272356/6903.pdf

[26] Иргэний хэргийн шүүхийн тоон мэдээлэл, 2019 оны 1 дүгээр улирал. Сүүлд нэвтэрсэн: 2021.04.16. https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/806896/civil-justice-statistics-quarterly-Jan-Mar-2019.pdf

Англи, Уэльсэд бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэл гаргах босгыг 10,000 паундаар[27] тогтоосон. Мөн хэргийн төрлөөс хамаарч ялгаатай үнийн дүнгийн босго тогтоожээ. Тухайлбал, түрээслэгчээс засвар хийх болон бусад ажилд зориулж түрээслүүлэгчийн эсрэг нэхэмжлэл гаргасан тохиолдолд энэ ажлын үнэ нь £1,000-аас хэтрэхгүй байх бөгөөд түрээслүүлэгчийн учруулсан хохиролтой холбоотой бусад нэхэмжлэлийн үнэ мөн энэ босго дотор багтах ёстой аж. Мөн талууд харилцан тохирч, хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх боломжтой гэж үзвэл 10,000 паундаас дээш нэхэмжлэлийг бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх журмаар шийдвэрлүүлэх боломжтой. Нөгөө талаас нэхэмжлэлийн үнийн дүн нь босго дотроо байгаа ч тухайн хэргийг ээдрээ, төвөгтэй гэж үзвэл шүүгч захирамж гарган, хэргийг ердийн журмаар шийдвэрлэдэг.

Хэргийн төрлийн хувьд бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх журмаар зарчмын хувьд бүх төрлийн иргэний хэргийг хянан шийдвэрлэх боломжтой бөгөөд ихэнх тохиолдолд дараах төрлийн иргэний хэргийг хянан шийдвэрлэдэг. Үүнд:

- өр барагдуулах нэхэмжлэл, зээлээр худалдаж авсан барааны буцаалт;
- хүний биед хөнгөн гэмтэл учруулсан, гэм хор;
- бараа, эд хөрөнгийн гэрээний зөрчил;
- орон сууцны маргаан.

Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх журам нь ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас ялгаатай юм. Тухайлбал, талууд заавал өмгөөлөгчтэй байх шаардлагагүй бөгөөд шүүгч шүүн таслах ажиллагааны талаар талуудад тайлбарлаж өгдөг. Мөн талууд "өөрсдийн төлөөлөгч"-ийг томилж болдог. Төлөөлөгч

[27] 2021 оны 4 дүгээр сарын 12-ны байдлаар 1 паунд 3918 төгрөгтэй тэнцэж байна. Энэ нь нийт 39,188,800 төгрөг хүртэлх нэхэмжлэлийн үнийн дүнтэй маргааныг хамарч байна.

нь өмгөөлөгч биш бөгөөд талуудыг шүүхэд төлөөлж, шүүх хуралд оролцох боломжтой субъект юм.

Ерөнхийдөө бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь бусад төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас илүү хялбар бөгөөд шүүгчийн захирамжаар шинжээчийн дүгнэлт, гэрчийн мэдүүлэг авч болдог. Түүнчлэн шүүх хурал хийлгүйгээр хэргийг зөвхөн бичгийн журмаар хянан шийдвэрлэх боломжтой бөгөөд үүнийг аль ч тал эсэргүүцэж болдог. Хугацааны хувьд бага үнийн дүнтэй хэргийг зургаан долоо хоногийн хугацаанд шийдвэрлэх боломжтой ба хэрэг ээдрээ төвөгтэй бөгөөд шүүх хурал хийх шаардлагатай бол зургаан сар хүртэл хугацаанд үргэлжилж болдог.[28]

Англи Улсын мужийн шүүх дэх бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх хялбаршуулсан журам нь шүүх хуралд оролцогчид шуурхай бөгөөд бага зардлаар эрхээ сэргээлгэхэд чиглэсэн бөгөөд ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай харьцуулахад илүү уян хатан байдгаараа онцлог. Мөн уг ажиллагаа нь талуудын бага үнийн дүнтэй нэхэмжлэлд шүүхийн их хэмжээний зардал гарахаас урьдчилан сэргийлэх зорилготой юм.

3.3. ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

Эрх зүйн харьцуулсан судалгаанд Ази болон Европын эрх зүйн хөгжлийн түвшин нь харьцангуй өндөр хоёр орны хүрээнд бага үнийн дүнтэй иргэний хэрэг хянан шийдвэрлэх хялбаршуулсан журмын талаарх зохицуулалтыг судаллаа. Дээрх хоёр улсын хууль зүйн зохицуулалтыг судалж үзэхэд дараах ижил төстэй болон ялгаатай зохицуулалтууд ажиглагдав:

[28] Европын холбооны бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа. Сүүлд нэвтэрсэн: 2021.04.13. https://www.europarl.europa.eu/RegData/etudes/IDAN/2014/ 542137 /EPRS_IDA(2014)542137_REV1_EN.pdf

1. Эдгээр улс нь бага үнийн дүнтэй иргэний хэргийг хялбаршуулсан, шуурхай журмаар хянан шийдвэрлэх тусгайлсан зохицуулалт бий болгосон;

2. Эдгээр улс нь бага үнийн дүнтэй иргэний хэргийг хялбаршуулсан, шуурхай журмаар хянан шийдвэрлэхдээ хэрэг маргааны төрлийг онцгойлон зааж өгөөгүй;

3. Шүүхэд нэхэмжлэл гаргах, хариу тайлбар гаргах, хэрэгт холбогдох нотлох баримт бүрдүүлэх, гэрч асуулгах, шүүх хурлаар хэрэг хянан хэлэлцэх зэрэг процесс ажиллагаа нь ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай харьцуулахад тогтсон дэг журмаас илүү уян хатан бөгөөд хялбаршуулсан шинжтэй байна. Япон Улсын хувьд нэг удаагийн шүүх хурлаар хэргийг эцэслэн шийдвэрлэдэг бөгөөд сөрөг нэхэмжлэл гаргахыг хуулиар хориглосон. Иймд нэг удаагийн шүүх хурлаар хэргийг эцэслэн шийдвэрлэхэд шаардлагатай бөгөөд боломжтой байгаа нотлох баримт, тайлбарын хүрээгээр шүүхийн мэтгэлцээн хязгаарлагддаг;

4. Япон Улсын хувьд хэргийг ганц удаагийн шүүх хурлаар хянан шийдвэрлэдэг, ингэхдээ талууд эвлэрэн зохицоход шүүгчийн зүгээс идэвхтэй дэмжлэг үзүүлдэг бол Англи Улсын хувьд шүүх хурал хийхгүйгээр нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрч, биелүүлэх боломжтой эсэхийг эхлээд талуудаас заавал урьдчилан тодруулж асуудаг, мөн хэргийг ихэвчлэн үндсэн шүүх хурлын өмнөх урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр хянан шийдвэрлэдэг зэргээрээ ижил төстэй байна. Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хялбаршуулах үүднээс бичгийн журмаар явуулахыг хүлээн зөвшөөрснөөрөө төстэй юм;

5. Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрх нь хуулиар хязгаарлагдсан;

6. Шүүх хуралд заавал өмгөөлөгчтэй оролцох шаардлагагүй байдаг. Гэхдээ Япон Улсын хувьд Шихошоши буюу өмгөөлөгчийн эрхгүй /шүүхэд хэргийн оролцогчийг төлөөлөх эрхгүй/ туслах өмгөөлөгч зэрэг хууль зүйн мэргэжилтэнд жижиг хэргийн буюу хялбаршуулсан шүүхэд талуудыг төлөөлөх эрхийг хуулиар хүлээн зөвшөөрсөн;

7. Бага үнийн дүнтэй иргэний хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхээс гадна талуудын аль нэг хүсэлт гаргасан, эсхүл шүүх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тухайн хэргийг ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжүүлэх боломжтой зэрэг зохицуулалт нь төстэй байна.

Харин дараах хэдэн зохицуулалтын хувьд ялгаатай байна. Үүнд:

1. Япон Улсын хувьд орон нутгийн анхан шатны шүүхээс тусдаа жижиг хэргийн буюу хялбаршуулсан шүүх гэх дагнасан шүүхтэй байна. Тус шүүх нь ердийн иргэний хэргийн анхан шатны шүүхтэй харьцуулахад бага үнийн дүнтэй, жижиг хэргийг иргэд бага зардлаар, шуурхай шийдвэрлүүлдэг, процесс ажиллагааны хувьд илүү уян хатан, хялбаршуулсан шинжтэйгээрээ гол ялгаатай юм. Харин Англи Улсын хувьд ийм төрлийн дагнасан шүүх байхгүй ч ердийн анхан шатны шүүх нь бага үнийн дүнтэй иргэний хэргийг ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас хялбаршуулсан журмаар харьяалан шийдвэрлэдэг байна;

2. Бага үнийн дүнтэй иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд нэхэмжлэлийн үнийн дүн нь хоорондоо ялгаатай юм. Япон Улсын хувьд 600,000 иен буюу 15 сая орчим төгрөг бол Англи Улсын хувьд 10,000 паунд буюу 39 сая орчим төгрөг байна;

3. Япон Улсын хувьд бага үнийн дүнтэй иргэний хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгчээс гадна Шихоиин буюу шүүгчийн шүүн таслах ажиллагаа болон шүүхийн шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй орон тооны бус зөвлөх, мэргэжилтэн оролцож зөвлөдөг;

4. Япон Улсын хувьд бага үнийн дүнтэй иргэний хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд тухайн нэг бизнесийн байгууллагаас нэхэмжлэл гаргах тооны хязгаарыг тогтоож өгснөөрөө ялгаатай;

5. Англи Улсын хувьд талуудын эзгүйд хэргийг шүүх хурлаар хянан шийдвэрлэсэн тохиолдолд талуудаас энэхүү шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох хүсэлт гаргах боломжтой юм. Гэхдээ шүүхийн зүгээс энэхүү хүсэлтийг хүлээн авахдаа талууд шүүх хуралд ирэх-гүйгээ мэдэгдэх боломжгүй байсан хүндэтгэн үзэх шалтгаан, мөн шүүх хуралд биечлэн ирсэн тохиолдолд ялалт байгуулах боломжтой байсан зэрэг нөхцөлийг харгалзан үзсэний үндсэн дээр хүсэлт хүлээн авахыг шийддэг ялгаатай зохицуулалт байна.

ДӨРӨВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ

Уг судалгаагаар бага үнийн дүнтэй иргэний хэрэг хянан шийдвэрлэж буй шүүхийн практикт дүн шинжилгээ хийснээр энэ төрлийн хэргийг хянан шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудлыг тодруулах, улмаар иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд шуурхай бөгөөд хялбаршуулсан журам нэвтрүүлснээр тэдгээр асуудлыг шийдвэрлэх боломжтой эсэхэд дүгнэлт хийхийг зорьсон юм.

Бага үнийн дүнтэй хэргийг шүүхээр хянан шийдвэрлэж буй өнөөгийн нөхцөл байдлыг шүүн таслах ажиллагааны тоон мэдээ, шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ гэсэн тоон болон чанарын судалгааны аргууд ашиглан тодрууллаа. Уг асуудлыг судлахдаа:

1. Иргэд хоорондын зээл болон банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо зэрэг санхүүгийн байгууллагаас олгосон зээлийн маргаан (Үүнд шинэ үйлчилгээ болох онлайн зээл ч хамаарна);

2. Улсаас иргэд, аж ахуйн нэгжид олгосон хөнгөлөлттэй зээлийн маргаан;

3. Үйлчилгээний төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулаагүй зэрэг үндсэн гурван төрлийн маргааны хүрээнд авч үзэхэд энэ төрлийн маргааны иргэний эрх зүйн нийт маргаанд эзлэх хувь хэмжээ 10-аас дээш хувьтай байгаа нь ажиглагдсан юм. Мөн иргэд хоорондын маш өндөр хүүтэй зээлээс бусад хоёр төрлийн маргааны хувьд 80-аас дээш хувьд нь талуудын эвлэрлээр

хэргийг хянан шийдвэрлэсэн эерэг үзүүлэлттэй байсан бөгөөд энэ нь угтаа ийм төрлийн маргаан нь үйл баримтын хувьд тодорхой, маргаан багатай болохыг илтгэж байна.

Харин иргэд хоорондын зээлийн маргаан буюу мөнгө хүүлэлттэй холбоотой хэрэгт зээлийн эргэн төлөх хуваарийн дагуу хүү, алданги, нэмэгдүүлсэн хүүгээ хугацаанд нь төлөөгүй, төлөх үүрэгтэй эсэх, мөн талуудын хооронд бичгээр байгуулсан зээлийн гэрээ байгаа эсэхээс хамаарч маргаан гардаг тул бага зэргийн ээдрээ, төвөгтэй болох нь анзаарагдлаа. Гэвч энэхүү нөхцөл байдал нь "Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай" бие даасан хууль баталж, зээлийн хүүгийн хэмжээний хязгаарыг тогтоох, хувиараа зээл олгогчдод хяналт тавьж, бүртгэснээр шийдвэрлэгдэх магадлалтай асуудал бөгөөд одоогоор энэхүү хуулийн төсөл боловсруулалт, хэлэлцүүлгийн шатандаа байгаа тул тус хуулийн агуулга, үр нөлөөг шүүхийн практиктай хослуулан судалж, үнэлэх нь цаашдын, өөр судалгааны сэдэв болох нь ажиглагдсан юм.

Одоогоор манай улсын шүүхийн тогтолцоонд жижиг хэргийн буюу хялбаршуулсан шүүх байхгүй, өнөөгийн даган мөрдөж буй Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар бага үнийн дүнтэй хэргийг хялбаршуулсан журмаар шуурхай шийдвэрлэх тусгайлсан зохицуулалт байхгүй байна. Уг судалгаагаар жижиг хэргийн буюу хялбаршуулсан шүүх бий болгох хэрэгтэй гэсэн дүгнэлт гаргах боломжгүй юм. Учир нь шүүх байгуулахад зардал, хөрөнгө их шаардагдах тул өргөн хүрээний, нарийн судалгаа хэрэгтэй (Япон Улсын адил хөнгөн төрлийн эрүүгийн хэргийг хамтад нь шийдвэрлэдэг шүүх байх боломжтой эсэх зэргийг судлахын тулд эрүүгийн шүүхийн практикийг ч судлах шаардлага үүснэ).

Гэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд бага үнийн дүнтэй иргэний хэргийг шуурхай, хялбаршуулсан журмаар шийдвэрлэх тусгайлсан зохицуулалт бий

болгож, хэргийн оролцогчдод ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас өөр, альтернатив сонголт бий болгох нь ач холбогдолтой бөгөөд ийм хэрэгцээ, шаардлага бодитоор үүссэн нь судалгааны үр дүнгээс харагдлаа.

Харин хэрхэн хуульчлах, хуульчлахдаа юу анхаарах тал дээр харьцуулсан судалгааны хэсгээс зарим дэвшилттэй зохицуулалт ажиглагдлаа. Тэдгээрийг санал болгож дараах байдлаар хураангуйлав. Үүнд:

1. Англи Улс шиг нэхэмжлэл хүлээн авахдаа нэхэмжилж буй үнийн дүн болон маргааны шинж чанараас хамаарч гурван төрлийн ялгаатай процедураар хэрэг хянан шийдвэрлэж буй байдлыг харгалзан үзэж, Монгол Улсад энэ төрлийн ялгамжтай хэргийн хөдөлгөөний зохицуулалт бий болгох боломжтой эсэхийг судлах. Энэхүү судалгааны хүрээнд бага үнийн дүнтэй иргэний хэрэг хянан шийдвэрлэх шуурхай бөгөөд хялбаршуулсан зохицуулалт бий болгох бүрэн боломжтой гэж үзлээ;

2. Бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн үнийн дүнг тогтоохдоо 13 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй гэж тогтоох (Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн зохицуулалтыг харгалзан үзэх). Шаардлагатай тохиолдолд үнийн дүнг өсгөх, бууруулах;

3. Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх шуурхай бөгөөд хялбаршуулсан журмыг хуульчлах тухайд Япон Улсын хууль зүйн зохицуулалт манай улсад илүү тохиромжтой байна. Учир нь тус улс “Шуурхай бөгөөд хялбаршуулсан” гэдэг үзэл санааг хуульдаа бүрэн тусгасан байна;

4. 1/ Нэхэмжлэлийг амаар юм уу тогтсон загварын дагуу хялбар байдлаар мэдүүлэх; 2/ Нэхэмжлэлийн шаардлагын хууль зүйн үндэслэлийг заавал тодруулалгүйгээр

зөвхөн хууль зүйн факт дурдахад хангалттай байх зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүхээр үйлчлүүлэгч иргэн хүн үйлчлүүлэхэд хялбар, ойлгомжтой байх. Ингэснээр бага үнийн дүнтэй хэрэгт заавал өмгөөлөгч авахгүйгээр, бага зардлаар эрхээ сэргээлгэх боломжтой байхад анхаарах;

5. Зарлан товлох боломжтой шүүх хурлын тоог хязгаарлах. Тухайлбал, Япон Улсын хувьд нэг удаагийн шүүх хурлаар хэргийг хэлэлцэж дуусгавар болгодог ба ингэхийн тулд нэг удаагийн шүүх хурлаар хянан хэлэлцэх боломжтой нотлох баримт, тайлбарын хүрээгээр шүүхийн мэтгэлцээнийг хязгаарладаг;

6. Хэргийг ээдрээ, төвөгтэй болгохгүйн тулд сөрөг нэхэмжлэл гаргахыг хязгаарлах;

7. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай байлгах, удаашруулахгүйн тулд давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарлах. Нэн шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тухайн шүүхийн шийдвэр гаргасан анхан шатны шүүхэд гомдол гаргаж, шүүхийн шийдвэрийг дахин хянуулдаг байх. Ингэж хянуулсны дараа ч мөн адил давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарлах. Энэ нь хэргийн оролцогчдын шударга шүүхээр шүүлгэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах Үндсэн хуулиар олгогдсон эрхийг зөрчсөнд тооцогдохгүй гэж үзнэ. Учир нь нэхэмжлэгч тал шүүхэд нэхэмжлэл гаргахдаа бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх шуурхай процедурыг сонгох уу, эсхүл ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар хэргээ хянан шийдвэрлүүлэх үү гэдгээ сонгох эрхтэй байхаар хуульчлах боломжтой юм;

8. Нөгөө талаас хариуцагчийн процессын эрхийн баталгааг хангахын тулд түүнд энэхүү хялбаршуулсан журмаас татгалзах эрх олгох, хэргийг ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжүүлэх боломжтой байхаар хуульчлах;

9. Англи Улсын хууль зүйн зохицуулалтын адил хэргийг талуудын эзгүйд шийдвэрлэсэн бөгөөд талууд, эсхүл талуудын аль нэг нь уг шүүхийн шийдвэрийг эсэргүүцэж, гомдол гаргах тохиолдолд зөвхөн 1/ шүүх хуралд ирж чадаагүй хүндэтгэн үзэх шалтгаанаа нотолсон; 2/ шүүх хуралд биечлэн ирж оролцсоноор ялалт байгуулах бодит үндэслэл байсан гэдгийг нотолсон тохиолдолд талуудын хүсэлтийг хүлээн авдаг байхаар зохицуулах;

10. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй тохиолдолд шүүгч нэн тэргүүнд талуудыг эвлэрүүлэхэд анхаарах. Ингэхдээ Япон Улсын зохицуулалтын адил шүүгч нь хариуцагчийн санхүүгийн чадавх болон бусад нөхцөл байдлыг харгалзан үзэж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш гурван жилийн дотор үүрэг гүйцэтгэх хугацааг хойшлуулах, үүргийг хуваж гүйцэтгүүлэх, алданги, торгуулиас чөлөөлөх зэрэг асуудал шийдвэрлэж, шүүхийн шийдвэрт тусгах эрхтэй байх. Ингэснээр шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг хялбаршуулах, шүүхийн шийдвэрийг хариуцагч сайн дураар биелүүлэх сэдлийг нэмэгдүүлэх давуу талтай;

11. Банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо болон бизнесийн бусад байгууллага уг хялбаршуулсан ажиллагааг өр төлбөрөө барагдуулах хэрэгсэл болгон хэт их ашиглахаас урьдчилан сэргийлж, тухайн байгууллагаас энэ төрлийн ажиллагаанд жилдээ гаргах нэхэмжлэлийнх нь тоог хязгаарлах. Ингэс-

нээр иргэд энэхүү ажиллагааг ижил, тэнцүү ашиглах боломжийг нэмэгдүүлэх сайн талтай зэргийг шинээр энэ төрлийн хууль зүйн зохицуулалт бий болгохдоо манай улс анхаарвал зохистой байна.

Мөн талуудыг эвлэрүүлэх, шүүгчид зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны бус мэргэжилтнийг шүүхэд нэмэлтээр ажиллуулах нь тусгай мэдлэг шаардсан маргаанд хямд бөгөөд зардал, чирэгдэл багатайгаар шинжээчийн дүгнэлт орлуулах, талуудын эвлэрлийг дэмжих, шүүн таслах ажиллагааны чанарыг сайжруулах, уг ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, шүүхэд итгэх итгэлийг нь бататгах сайн талтай юм. Гэвч ийм зохицуулалт бий болгож, шүүхийн практикт хэвшүүлэхэд нэмэлт зардал шаардагдах бөгөөд төсөв мөнгөний дутагдалтай байдаг манай шүүхэд хэрэгжихэд хүндрэлтэй юм.

ХАВСРАЛТ №1

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ /2013-2019 он/

Хэрэг маргааны төрөл/он	2013	2014	2015	2016	2017	2018	2019	Дундаж
Шийдвэрлэсэн нийт иргэний хэрэг	35314	33996	40674	46173	45233	48155	43397	41848.9
Иргэний эрх зүйн маргаан	12738	14708	20805	24826	22783	21616	20624	19728.6
Үүнээс эзлэх хувь	36.1%	43.3%	51.2%	53.8%	50.4%	44.9%	47.5%	47%
ИХШХШтХ-аар шийдвэрлэсэн хэрэг	15571	12421	11532	11942	13600	18318	14654	14005.4
Үүнээс эзлэх хувь	44.1%	36.5%	28.4%	25.9%	30.1%	38.0%	33.8%	34%
Гэр бүлийн эрх зүйн маргаан	4276	4207	4539	4674	4566	4763	4449	4496.3
Үүнээс эзлэх хувь	12.1%	12.4%	11.2%	10.1%	10.1%	9.9%	10.3%	11%
Хөдөлмөрийн эрх зүйн маргаан	1080	1377	1487	2220	2214	1785	1302	1637.9
Үүнээс эзлэх хувь	3.1%	4.1%	3.7%	4.8%	4.9%	3.7%	3.0%	4%
Бусад хуулиар	1649	1283	2311	2511	2070	1673	2368	1980.7
Үүнээс эзлэх хувь	4.7%	3.8%	5.7%	5.4%	4.6%	3.5%	5.5%	5%

Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн “Монгол Улсын шүүхийн тайлан”, 2013-2019 он.

ХАВСРАЛТ №2

Иргэний нийт хэргийн анхан шатны шүүхээс авсан тоон судалгааны хүснэгт

№	Нэхэмжлэгч		Он		Нийт маргааны тоо
1	Иргэд хооронды зээл	2018			0-130,000₮
		2019			130,001-650,000₮
					650,001-1,300,000₮
					1,300,001-13,000,000₮
					13,000,001-эс дээш
					ИХШХШтХ-ний 74.1
					ИХШХШтХ-ний 106.5
					ИХШХШтХ-ний 115.2
					Хамтрин бүрэлдэхүүн
					Хамтрин үрт хонор
					Дарж зааглах шатны шүүх
					Хөдөлгөөн шатны шүүх

Нэхэмжлэлийн үнийн дүн

0-130,000₮

130,001-650,000₮

650,001-1,300,000₮

1,300,001-13,000,000₮

13,000,001-эс дээш

Шийдвэрлэсэн бай дал

ИХШХШтХ-ний 74.1

ИХШХШтХ-ний 106.5

ИХШХШтХ-ний 115.2

ИХШХШтХ-ний 115.2-оор хэрлийг шийдвэрлэх зарцуулсан хугацаа

Хамтрин үрт хонор

Дарж зааглах шатны шүүх

Хөдөлгөөн шатны шүүх

Дээд шатны шүүхэд хандсан маргааны тоо

Хавсралт №2-ын үргэлжлэл

2	Lend.MN, Ard.mn Kmobimn зэрэг онлайн зээл	2018													
		2019													
3	Халаалтын төлбөр	2018													
		2019													
4	Цахилгааны төлбөр	2018													
		2019													
5	СӨХ-ны төлбөр	2018													
		2019													
6	“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн төлбөр	2018													
		2019													
7	Гар утасны оператор	2018													
		2019													
8	Интернэтийн төлбөр	2018													
		2019													
9	Сум хөгжүүлэх сангаас олгосон зээл	2018													
		2019													
10	Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас олгосон зээл	2018													
		2019													

11	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас олгосон зээл	2018													
		2019													
12	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас олгосон зээл	2018													
		2019													
13	Бусад	2018													
		2019													

ХАВСРАЛТ №3

Бага үнийн дүнтэй иргэний хэргийн тоон судалгааны нэгтгэл

№	Нэхэмжлэгч	Он	Нийт маргааны тоо	Нэхэмжлэлийн үнийн дүн					Шийдвэрлэсэн байдал			Дээд шатны шүүхэд хандсан маргааны тоо	
				0-130,000₮	130,001-650,000₮	650,001-1,300,000₮	1,300,001-13,000,000₮	13,000,001-ээс дээш	ИХШХШтХ-ийн 74.1-ээр	ИХШХШтХ-ийн 106.5-аар	ИХШХШтХ-ийн 115.2-оор	Давж заалдах шатны шүүх	Хяналтын шатны шүүх
1	Иргэд хоорондын зээл	2018	2385	27	244	337	1301	476	1341	417	627	189	82
		2019	2117	23	198	306	1147	443	1139	374	604	152	75
2	Lend.MN, Ard.mn Kmobi.mn зэрэг онлайн зээл	2018	11	0	10	0	0	1	11	0	0	0	0
		2019	155	4	133	16	2	0	147	4	4	0	0
3	Халаалтын төлбөр	2018	167	0	74	52	33	8	140	5	22	3	0
		2019	216	0	78	49	64	25	181	13	22	6	2
4	Цахилгааны төлбөр	2018	86	2	43	16	16	9	70	7	9	1	1
		2019	41	1	11	14	11	4	28	4	9	0	0
5	СӨХ-ны төлбөр	2018	767	23	495	186	59	4	549	88	130	18	2
		2019	707	19	402	203	67	16	511	84	112	18	7

6	“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн төлбөр	2018	2	1	0	0	0	1	2	0	0	0	0
		2019	7	2	2	2	1	0	6	0	1	0	0
7	Гар утасны оператор	2018	1289	139	690	344	113	3	1155	96	38	2	1
		2019	1721	154	1085	335	141	6	1559	92	70	1	0
8	Интернэтийн төлбөр	2018	180	74	92	11	2	1	155	5	20	0	0
		2019	232	84	127	16	5	0	200	11	21	0	0
9	Сум хөгжүүлэх сангаас олгосон зээл	2018	264	1	5	18	199	41	237	17	10	0	0
		2019	287	4	9	16	220	38	249	10	28	10	6
10	Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас олгосон зээл	2018	69	0	0	2	47	20	58	6	5	0	0
		2019	11	0	0	1	2	8	5	1	5	2	2
11	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас олгосон зээл	2018	151	15	85	33	18	0	132	10	9	0	0
		2019	167	0	36	34	87	10	147	13	7	0	0
12	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас олгосон зээл	2018	25	0	1	3	10	11	17	4	4	1	1
		2019	35	0	0	4	13	18	14	5	16	9	7
13	Бусад	2018	15	0	3	0	4	8	9	1	5	0	0
		2019	14	0	2	1	6	5	8	1	5	2	1

ХАВСРАЛТ №4

Улсын хэмжээнд шийдвэрлэсэн иргэний нийт хэрэг болон түүнд эзлэх бага үнийн дүнтэй иргэний хэргийн тоо /Шүүх тус бүрээр/

№	Анхан шатны шүүх	Бага үнийн дүнтэй хэрэг		Иргэний эрх зүйн хэрэг маргаан		Шийдвэрлэсэн нийт иргэний хэрэг	
		2018	2019	2018	2019	2018	2019
1	Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	649	614	3663	3385	5637	5159
2	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	345	334	2035	1812	3492	2983
3	Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	259	224	1715	1476	3195	3478
4	Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	602	508	2626	2387	4676	4098
5	Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	398	344	2565	2361	3869	3755
6	Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	796	788	2726	2192	4236	3861
7	Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	64	74	161	309	350	574

8	Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	108	176	272	296	489	492
9	Багахангай дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх			10	26	15	32
10	Архангай аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх	62	43	210	176	1134	805
11	Баян-Өлгий аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх	68	108	339	301	887	800
12	Баянхонгор аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх	29	64	174	209	1033	997
13	Булган аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх	52	62	163	181	751	712
14	Говь-Алтай аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх	22	30	72	71	605	451
15	Говьсүмбэр аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх	27	33	100	113	223	212
16	Дархан-Уул аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх	224	232	662	569	1422	1290
17	Дорноговь аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх	71	62	155	132	485	424
18	Дорнод аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх	166	227	511	520	1050	1032

Хавсралт №4-ийн үргэлжлэл

19	Дундговь аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх	37	40	85	119	841	558
20	Завхан аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх	22	8	122	78	869	538
21	Орхон аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх	235	323	668	990	1396	1760
22	Өмнөговь аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх	68	55	153	153	565	398
23	Өвөрхангай аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх	79	67	203	195	995	726
24	Сүхбаатар аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх	53	28	109	150	647	535
25	Сэлэнгэ аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх	152	214	306	396	596	701
26	Төв аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх	81	98	263	288	1459	1460
27	Увс аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх	41	32	245	151	1076	562
28	Ховд аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх	57	77	142	160	854	682
29	Хөвсгөл аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх	138	164	238	287	1910	1302

30	Хэнтий аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүх	110	265	227	331	800	784
31	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх	34	29	130	120	324	294
32	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	35	17	51	43	365	336
33	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх	24	29	44	63	193	154
34	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх	56	60	83	103	515	376
35	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх	121	136	186	231	374	448
36	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх	55	63	86	109	193	201
37	Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх	58	40	68	62	438	249
38	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүх	13	42	48	79	196	178

ХАВСРАЛТ №5

Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ

№	Маргааны төрөл	Нэхэмжилсэн үнийн дүн	Сөрөг нэхэмжлэл гаргасан эсэх	Шийдвэрлэсэн байдал					Товч тайлбар
				Анхан шатны шүүх		Давж заалдах шатны шүүх		Дээд шүүх	
				Үндэслэл болгосон хуулийн заалт	Шийдвэр	Үндэслэл болгосон хуулийн заалт	Магадлал	Тогтоол	
1	Иргэд хоорондын зээлийн маргаан	12,500,000₮	Зээлийн гэрээ хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох, хөлсөөр ажиллах гэрээний үүрэгт 2,487,300₮ гаргуулах	**Үндсэн нэхэмжлэл:** ИХ-ийн 281.1, 282.1 **Сөрөг нэхэмжлэл:** ИХ-ийн 359.1, 360.1	**БГД 102/ ШШ2018/01828** Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг, сөрөг нэхэмжлэлийн шаардлагын мөн зарим хэсгийг хангасан.		**2018.08.31. №1938** Шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, зохигчдын гомдлыг хангаагүй.	**001/ ХТ2019/00182** Шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, зохигчдын гомдлыг хангаагүй.	Сарын 5% хүүтэй зээл
2	Иргэд хоорондын зээлийн маргаан	9,010,000₮	Гаргаагүй	ИХ-ийн 124.1, 458.1	**БГД 102/ ШШ2019/00370** Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан.	ИХ-ийн 124.1 гэснийг ИХ-ийн 281.1, 282.1, 232.6 гэж өөрчилж, ИХ-ийн 458.1-ийг хассан.	**2019.05.13. №862** Шүүхийн шийдвэрт хууль хэрэг-лээний өөрч-лөлт оруулж, бусад заалтыг хэвээр үл-дээж, хариу-цагчийн гомд-лыг хангаагүй.	**001/ ХТ2020/00323** Магадлалыг хэвээр үлдээж, хариуцагчийн гомдлыг хангаагүй.	Сарын 5% хүүтэй зээл

3	Иргэд хоорондын зээлийн маргаан	10,000,000₮	Зээлийн төлбөрт илүү төлсөн 10,000,000₮ -ийг буцаан гаргуулах	ИХ-ийн 281.1, 232.6, 492.1	**ХУД 183/ ШШШ2018/01242** Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэстийг хангаж, сөрөг нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.		**2018.07.20. №1688** Шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагчийн иттэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан гомдлыг хангаагүй.	**001/ ХТ2018/01747** Шийдвэр, маргаалд өөрчлөлт оруулж, хэналтын журмаар гаргасан хариуцагчийн иттэмжлэгдсэн төлөөлөгчийн гомдлын зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн. Өмнөх хоёр шатны шүүхийн тооцооллын алдааг залруулсан.	Сарын 8%-ийн хүүгээ, 0.5%-ийн алдангийн тооцох эсэх
4	СӨХ-ны төлбөрийн маргаан	439,700₮	Гаргаагүй	ИХ-ийн 147.1, Сууц өмчлөгчдийн эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 13.2.3	**ХУД 183/ ШШШ2018/02274** Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэстийг хангасан.	Шийдвэрийн үндэслэл болгосон хуулийн нэрийг залруулж, үйл баримт нотлогдоогүй гэсэн үндэслэлээр хариуцагчаас гаргуулах менгэн дүнд өөрчлөлт оруулсан.	**2018.12.12. №2444** Шийдвэрт өөрчлөлт оруулсан.	**001/ ХТ2019/00621** Магадлалыг хэвээр үлдээж, хариуцагчийн иттэмжлэгдсэн төлөөлөгчийн гомдлыг хангаагүй.	Нийт 15 сарын СӨХ--ны төлбөр

Хавсралт №5-ын үргэлжлэл

5	Иргэд хоорондын зээлийн маргаан	8,700,000₮	Гаргаагүй		**ХУД** **183/ ШШ2019/00312** Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан.		**2019.05.03. №788** Шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагчийн гомдлыг хангаагүй.	**001/ ХТ2020/00192** Шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, хариуцагчийн гомдлыг хангаагүй.	Нийт 7 удаа зээл олгосон бөгөөд сүүлийн 3 удаагийн зээл олголтоос хүүг урьдчилж суутган авсан.
6	Иргэд хоорондын зээлийн маргаан	7,640,000₮	Гаргаагүй	ИХ-ийн 281.1, 282.1	**ЧД** **182/ ШШ2018/00185** Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан.	Тооцооллын алдааг залруулсан.	**2018.03.26. №777** Шийдвэрт өөрчлөлт оруулж, бусад хэсгийг хэвээр үлдээсэн.	**001/ ХТ2018/01283** Магадлалыг хэвээр үлдээж, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гомдлыг хангаагүй.	Сарын 5%-ийн хүүтэй, 0.5%-ийн алданги тооцох зээл

7	Прял хоорондын зээлийн маргаан	6,630,000₮	Зээлийн гэрээг хүчин төгөлдөр бусад тооцуулах	**Үндсэн нэхэмжлэл:** ИХ-ийн 281.1, 232.6 **Сөрөг нэхэмжлэл:** ИХ-ийн 56.1.1	**БЗД** **101/ ШШ2018/01375** Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, сөрөг нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.	**2018.06.11. №1364** Шийдвэрийг хэвээр үлдээж, харилцагчийн өмгөөлөгчийн гомдлыг хангаагүй.	**001/ ХТ2018/01568** Харилцагчийн гомдлыг хангаж, анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр буцаасан. Үндэслэл нь нотлох баримт үнэлсэн байдал учир дутагдалтай, хэрэгт авагдсан нотлох баримтын хэмжээнд хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжгүй гэж үзсэн.	Сарын 10%-ний хүүгээр, алдагдал тооцох зээл
8	Прял хоорондын зээлийн маргаан	1,100,000₮	Гаргаагүй	ИХ-ийн 281.1	**СХД** **184/ ШШ2019/00186** Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан.	**2019.03.22. №524** Шийдвэрийг хэвээр үлдээсэн.	**001/ ХТ2019/00907** Шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, харилцагчийн гомдлыг хангаагүй.	Сарын 10%-ний хүүгээр зээл

Хавсралт №5-ын үргэлжлэл

9	Дулааны төлбөрийн маргаан, зохигчдын аль аль нь ААН	4,064,485₮	Засварын зардал болон нөхөн олговорт 9,507,550₮ шаардсан.	ИХ-ийн 74.1, Эрчим хүчний тухай хуулийн 30.1.2, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 15.1.1	**Дархан-Уул аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019.01.30. №137** Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, сөрөг нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.		**2019.03.27. №43** Шийдвэрийг хэвээр үлдээсэн.	**001/ ХТ2020/00068** Шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож, үндсэн нэхэмжлэл болон сөрөг нэхэмжлэлийг тус тус хэрэгсэхгүй болгосон. Үндэслэл нь холбогдох хуулийн зохицуулалтыг буруу тайлбарлан хэрэглэсэн.	Хариуцагч болох ААН-ээс 2013-2018 он хүртэлх дулааны төлбөр шаардсан.
10	СӨХ-ны төлбөрийн маргаан	348,120₮	Гаргаагүй	ИХ-ийн 147.1, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 13.2.3	**Дархан-Уул аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018.01.16. №97** Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан.	ИХ-ийн 75.2.3-т зааснаар гэж нэмэлт оруулсан.	**2018.02.12. №12** Шийдвэрийн тогтоох хэсгийн нэг дэх заалтад нэмэлт оруулж, бусад заалтыг хэвээр үлдээсэн.	**001/ ХТ2018/00922** Магадлалыг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн гомдлыг хангаагүй.	Нийт гурван сарын СӨХ-ны төлбөрийн үлдэгдлийг шаардсан.

11	Иргэд хоорондын зөвшөөрлийн маргаан	7,102,326₮	Гаргаагүй	ИХ-ийн 281.1, 282.2, 232.4	**Орхон аймгийн сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 142/ШШШ2019/00083** Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан.	ИХ-ийн 281.1, 282.4, 232.6	**2019.02.28. №32** Шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.	**001/ ХТ2019/00935** Магадлалыг хэвээр үлдээсэн. Гэхдээ ИХ-ийн 281.1, 232.6-д заасан үндэслэл тогтоогдоогүй тул гэсэн тодотгол оруулж, өөрчилсөн.
12	Иргэд хоорондын зөвлөл	7,000,000₮	Гаргаагүй	ИХ-ийн 281.1, 283.1	**Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүхийн 2018.10.17 №149** Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан.	ИХ-ийн 282.4	**2018.12.19. №56** Шийдвэрийг хэвээр үлдээсэн.	**01/ ХТ2019/00664** Шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, харуцагч болон түүний өмгөөлөгчдийн гомдлыг хангаагүй.
13	Иргэд хоорондын зөвлөл	9,200,000₮	Гаргаагүй	ИХ-ийн 281.1	**Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүхийн 2018.01.10. №10** Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан.		**2018.02.28. №13** Шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан. Харуцагчийн төлөх мөнгөн дүнг бууруулсан.	**001/ ХТ2018/00987** Магадлалыг хэвээр үлдээж, харуцагч, түүний өмгөөлөгчийн гомдлыг хангаагүй.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль, журам, хяналтын шүүхийн тогтоол

- Англи Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай журам
- Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
- Япон Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
- Монгол Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тогтоолууд

Ном, гарын авлага

- Шүүхийн ерөнхий зөвлөл. Монгол Улсын шүүхийн тайлан. 2013-2019 он.
- Япон Улсын Дээд шүүх. Шүүхийн тайлан, 2020 он.
- 小島武司[編]『よくわかる民事訴訟法』(ミネルヴァ書房、2013年)、Эмхэтгэсэн Кожима Такэши. Ойлгоход хялбар иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй. 2013 он.
- 司法書士Monthly　SHIHO-SHOSHI『特集　少額訴訟制度ー施行10年』(2008年) Япон Улсын Шихошошигийн холбооноос эмхэтгэн гаргадаг сар бүрийн сэтгүүлийн 2008 оны тусгай дугаар “Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэрэгжиж эхэлсний 10 жилийн ой”.

Эрдэм шинжилгээний өгүүлэл

- 石川明「少額裁判制度の創設について：訴法改正作業の一環として」（1995年）Ишикава Акира. Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалт бий болгох тухай: Иргэний процессын хуулийн шинэчлэлийн нэг хэсэг болох нь. 1995 он.
- 草地未紀「少額訴訟手続における和解の意義とその問題点–ある簡易裁判所における傍聴観察データを基に▪」Күсачи Мики. Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь эвлэрлийн ач холбогдол болон түүний тулгамдсан асуудал: Нэгэн жижиг хэргийн шүүх дэх ажиглалт, судалгааны үр дүнд үндэслэх нь. 2001 он.

Бусад

- Харьцуулсан судалгааны хэсэгт эшилсэн хэрэгцээт веб холбоос (Тухайн улсын Дээд шүүх болон төрийн бусад байгууллагын албан ёсны сайтууд).

2

АРБИТРЫН ҮНДСЭН ШИЙДВЭРТЭЙ ХОЛБООТОЙ ИРГЭНИЙ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ПРАКТИК

СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА

МАНЬБАДАРЫН СУВД

Отгонтэнгэр Их сургууль (ОТИС)-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч.

1998 онд ОТИС-ийн Хууль зүйн сургуулийг олон улсын эрх зүйч мэргэжлээр төгсөж, 1999 онд МУИС-ийн Хууль зүйн сургуульд хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан. 2016 онд Хууль сахиулахын их сургуулийн Хууль зүйн докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд хууль зүйн доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан.

Египет Улсад байгаль орчныг хамгаалах чиглэлээр, Исланд Улсад газрын тогтвортой менежментийн чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн. Судалгаа, шинжилгээний 50 гаруй бүтээлээ нийтийн хүртээл болгосон.

ДАШПУНЦАГИЙН ЭРДЭНЭЧИМЭГ

Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал.

1998 онд ОТИС-ийн Хууль зүйн сургуулийг олон улсын эрх зүйч мэргэжлээр төгсөж, 2010 онд Япон Улсын Нагояагийн Их сургуульд хууль зүйн магистр (LL.M.)-ын зэрэг хамгаалсан. 2013 онд АНУ-ын Калифорнийн Их сургуулийн Беркли дэх хуулийн сургуульд /UC Berkley law/ зочин судлаачаар ажиллаж байсан бөгөөд 2017 онд Дэлхийн Оюуны өмчийн байгууллага болон Италийн Туриний Их сургуульд магистр (LL.M.)-ын зэрэг хамгаалсан. 2019 онд Дотоод хэргийн их сургуулийн дэргэдэх Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд хууль зүйн доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан. Судалгаа, шинжилгээний 50 гаруй бүтээлээ нийтийн хүртээл болгосон.

Судлаачид:
М.Сувд (Ph.D)
Д.Эрдэнэчимэг (Ph.D)
М.Ариунаа (LL.M.)

МӨНХДАЛАЙН АРИУНАА

Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш.

1984 онд Хууль цаазын дунд сургуулийг, 1989 онд МУИС-ийг эрх зүйч мэргэжлээр тус тус төгссөн. 2000 онд Удирдлагын Академийг төрийн удирдлагын арга зүйчээр дүүргэсэн.

Нийслэлийн Цагдаагийн газар, ШУА-ийн Төр, эрх зүйн хүрээлэн, Үндэсний архивын газар, Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн яам зэрэг байгууллагад ажиллаж байсан туршлагатай. Судалгаа, шинжилгээний 50 гаруй бүтээлээ нийтийн хүртээл болгосон.

2

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ 97
УДИРТГАЛ 98

НЭГ. ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ 112
1.1. Арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулахаар гаргасан өргөдлийн агуулга, хууль зүйн үндэслэлд хийсэн дүн шинжилгээ 114
1.2. Арбитрын үндсэн шийдвэрийн үндэслэл, хууль хэрэглээнд хийсэн дүн шинжилгээ 120
1.3. Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн тогтоолын хууль зүйн үндэслэл, хууль хэрэглээнд хийсэн дүн шинжилгээ 122
1.4. Чанарын судалгааны асуулгын дүн шинжилгээ 131

ХОЁР. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА 136
2.1. Арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгох талаарх ЮНСИТРАЛ-ын Олон улсын арилжааны арбитрын загвар хуулийн зохицуулалт 136
2.2. Арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгох талаарх гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалтын туршлага 139

2.2.1. ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалтын туршлага 140
2.2.2. ОХУ-ын эрх зүйн зохицуулалтын туршлага 143
2.2.3. Япон Улсын эрх зүйн зохицуулалтын туршлага 145
2.2.4. БНХАУ-ын эрх зүйн зохицуулалтын туршлага 148
2.2.5. Швед Улсын эрх зүйн зохицуулалтын туршлага 151
2.3. Арбитрын үндсэн шийдвэр, түүнийг хүчингүй болгох талаарх үндэсний эрх зүйн зохицуулалт, боловсронгуй болгох зарим асуудал 155

ДҮГНЭЛТ 163
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ 169
ХАВСРАЛТ 172

2

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ИХШХШтХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
НИХДЗШШ	Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх
МОУА	Монголын Олон улсын арбитр
МОУБҮА	Монголын Олон улсын ба Үндэсний арбитр
МҮХАҮТ	Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
ОХУ	Оросын Холбооны Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ЮНСИТРАЛ	НҮБ-ын Олон улсын худалдааны эрхийн комисс

УДИРТГАЛ

Арбитрын үндсэн шийдвэрийг давж заалдах шатны шүүхээс хүчингүй болгох нь арбитраар маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд чухал үр дагавартай ба сүүлийн жилүүдэд зохигчид арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах талаар шүүхэд өргөдөл гаргах явдал нэмэгдэх хандлагатай болж байна. Арбитрын үндсэн шийдвэрийг НИХДЗШШ хянаад уг шийдвэрийн холбогдох хэсгийг, эсхүл бүхэлд нь хүчингүй болгох нь зохигчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх, хуульд заасан эрхээ хамгаалуулах хугацаа алдах, арбитрын зардал гэх мэт асуудал үүсгэх үр дагавартай тул шүүхээс арбитрын үндсэн шийдвэрийн холбогдох хэсгийг болон бүхэлд нь хүчингүй болгосон, арбитрын үндсэн шийдвэрийг хэвээр үлдээсэн шүүхийн тогтоолд хууль зүйн дүн шинжилгээ хийх, хууль зүйн үндэслэл бүхий дүгнэлт өгөх нь практикийн ач холбогдолтой.

Арбитрын ойлголт, онцлог, түүхэн хөгжил, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа, түүний үндэсний ба олон улсын эрх зүйн зохицуулалт гэх мэт арбитраар хэрэг маргаан хянан шийдвэрлэх эрх зүйн асуудлыг судалсан өгүүлэл, нийтлэл цөөнгүй байгаагийн зэрэгцээ арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэлээд өргөн хүрээнд судлан нийтийн хүртээл болгосон бүтээлүүд бий. Тухайлбал, доктор М.Уянга “Монгол Улсад гадаадын худалдааны арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх эрх зүйн асуудал”, хуульч С.Энхцэцэг “Арбитрын шийдвэрийг баталгаажуулах ба гүйцэтгэх эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилт”, “Гадаадын арбитрын

шийдвэрийг Монгол Улсад хүлээн зөвшөөрөх, биелүүлэх эрх зүйн зохицуулалтын түүхэн хөгжил", судлаач Д.Маралгоо "Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхээс татгалзах асуудал", М.Болор-Эрдэнэ "Гадаад улсын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай ба нийгмийн дэг журам", Ж.Түвшинзаяа "Монгол Улс дахь гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт" зэрэг өгүүлэл, нийтлэлд арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх асуудлын талаар судалж нийтлүүлсэн байна. Хуульч, арбитрч А.Доржготов, шүүгч Б.Ундрах, судлаач Д.Маралгоо нар "Арбитрын ажиллагаан дахь шүүхийн оролцоо" гэсэн ижил сэдэвт өгүүлэл тус тус нийтлүүлж, арбитрын ажиллагаан дахь шүүхийн оролцооны асуудлыг хөндөн, ялгаатай үзэл баримтлалаар авч үзсэн ажээ. Хуульч, арбитрч Ч.Гүнждагва "Арбитрын хуулийн шинэчилсэн найруулгын эргэн тойронд нийтлэл" /2015/-д, хуульч, арбитрч, доктор Т.Мэндсайхан "Гадаад улсын хууль, олон улсын гэрээг арбитрын практикт хэрэглэх нь", "Монголын Үндэсний арбитрын шийдвэрлэсэн хэрэг маргаанд гадаадын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх асуудалд" сэдэвт өгүүлэлд арбитраар маргаан хянан шийдвэрлэхэд хууль хэрэглээний асуудлыг хөндсөн, хуульч, арбитрч Б.Цогнямын "Арбитрт хэрэг маргааныг шийдвэрлэхдээ хуулийг зөв хэрэглэх нь", "Арбитрчийн хамгаалалт, хариуцлагын асуудал" сэдэвт өгүүлэлд арбитр маргааныг шийдвэрлэхэд хууль сонгож хэрэглэх асуудлыг чухалчилж, арбитрчийн эрх зүйн байдлыг хуульчлан баталгаажуулахын хамт арбитрчийг хариуцлагажуулах асуудлыг судалсан байна. Хуульч, арбитрч М.Сувд "Арбитрын тухай хуулиудыг харьцуулан судалсан нь" сэдэвт судалгааны өгүүлэл нийтлүүлж, Гадаад худалдааны арбитрын тухай хуулийг Арбитрын тухай хуультай харьцуулан судалж, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын дэвшилтэт болон дутагдалтай асуудлыг хөндсөн байна.

Харин арбитрын үндсэн шийдвэртэй холбоотой шүүхийн хууль хэрэглээ, практик, тулгамдсан асуудлын чиглэлээр тусгайлан судалсан нэг сэдэвт бүтээл байхгүй. Ялангуяа НИХДЗШШ-ээр арбитрын үндсэн шийдвэрийг хянан шийдвэрлэж уг шийдвэрийг хэвээр үлдээсэн, арбитрын үндсэн шийдвэрийн холбогдох хэсгийг болон уг шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгосон шүүхийн тогтоолд хууль зүйн дүн шинжилгээ хийж, энэ талаарх эрх зүйн зохицуулалт, практик, тулгамдсан асуудлыг тодорхойлж, хууль зүйн дүгнэлт хийх, санал, зөвлөмж боловсруулах, судалгааны үр дүнг нийтийн хүртээл болгох туршлага дутмаг, эдгээр асуудлаар хийсэн судалгаа одоогоор байхгүй байгаа тул уг сэдвийн хүрээнд судалгааны ажил гүйцэтгэх зайлшгүй шаардлагатай гэж үзсэн болно.

Түүнчлэн арбитрын үндсэн шийдвэртэй холбоотой НИХДЗШШ-ийн хууль хэрэглээ, уг шийдвэрийг эс зөвшөөрч хүчингүй болгуулах тухай талууд болон тэдгээрийн төлөөлөгчийн шүүхэд гаргасан өргөдөлд үндэслэн арбитрын үндсэн шийдвэрийг хянан шийдвэрлэж хүчингүй болгосны хууль зүйн үр дагавар, зохигчдын эрхийн зөрчил зэрэг практикт тулгамдсан асуудлын талаарх үндэсний ба олон улсын эрх зүйн хэм хэмжээний харилцан хамаарлыг судалах шаардлага байгаа юм. Цаашид энэ асуудлаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлийг тодорхойлон дүгнэлт хийх, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журам, арбитрын үндсэн шийдвэр, шүүхийн тогтоолын агуулга, үндэслэл, хууль хэрэглээ, хууль зүйн үндэслэлийн талаар санал, зөвлөмж боловсруулах зорилгоор Эрх зүйн хөгжлийн төлөө ТББ-ын судлаачдын баг энэхүү дүн шинжилгээг хийлээ.

Судалгааны зорилгод хүрэхийн тулд арбитрын үндсэн шийдвэрийг Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээс хянан шийдвэрлэсэн шүүхийн тогтоолд үндсэн гурван чиглэлээр хууль зүйн дүн шинжилгээ хийх зорилт дэвшүүлэв. Үүнд:

1. Арбитрын үндсэн шийдвэрийг хэвээр үлдээсэн шүүхийн тогтоолд дүн шинжилгээ хийж, маргааныг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан шийдвэрлэж гаргасан арбитрын үндсэн шийдвэрийн агуулга, хууль зүйн үндэслэл, хууль хэрэглээний байдалд дүгнэлт хийн, арбитрын сайн туршлагыг тодорхойлох;

2. Арбитрын үндсэн шийдвэрийн холбогдох хэсгийг хүчингүй болгож шийдвэрлэсэн шүүхийн тогтоолын хууль зүйн үндэслэл, хууль хэрэглээний байдалд дүн шинжилгээ хийж, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарвал зохих нийтлэг алдааг бүлэглэн дүгнэж, санал, зөвлөмж боловсруулах;

3. Арбитрын үндсэн шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгосон шүүхийн тогтоолын хууль зүйн үндэслэл, хууль хэрэглээний байдалд дүн шинжилгээ хийж, шүүхээс хүчингүй болгож шийдвэрлэсэн үндэслэлийг судлан тогтоож, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарвал зохих нийтлэг алдааг бүлэглэн дүгнэж, санал, зөвлөмж боловсруулах зэрэг болно.

Судалгааны хүрээнд арбитрын хуралдааныг нээлттэй хийх талаар талуудын харилцан тохирсон саналд үндэслэн арбитрын бүрэлдэхүүн шийдвэрлэж тогтсон арбитрын хэрэг хянан шийдвэрлэх 18 журам, арбитрын шийдвэр, НИХДЗШШ-ийн 18 тогтоол (3 шийдвэрийг хүчингүй болгож, 15 шийдвэрийг хэвээр үлдээсэн байна), 2017 онд шинэчлэн найруулж батлсан Арбитрын тухай хууль үйлчилж эхэлснээс хойш 2020 он хүртэлх хугацаанд НИХДЗШШ-ээс хаалттай хийсэн арбитрын хуралдааны арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн 13 тогтоол (Хаалттай хуралдаан хийсэнтэй холбогдуулж арбитрын ажиллагааны журам, арбитрын шийдвэрийг үлдээсэн болно) буюу нийт 67 эрх зүйн баримт бичигт хууль зүйн дүн шинжилгээ хийсэнд уг судалгааны онцлог оршино.

Энэхүү судалгааг гүйцэтгэхдээ НИХДЗШШ-ийн тогтоол, арбитрын үндсэн шийдвэр, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журмуудыг дараах ангиллаар харьцуулан судалж, хууль зүйн дүн шинжилгээ хийсэн болно. Үүнд:

1. Арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулахаар гаргасан өргөдлийн агуулга, хууль зүйн үндэслэлд хийсэн дүн шинжилгээ;
2. Арбитрын үндсэн шийдвэрийн үндэслэл, хууль хэрэглээнд хийсэн дүн шинжилгээ;
3. НИХДЗШШ-ийн тогтоолын хууль зүйн үндэслэл, хууль хэрэглээнд хийсэн дүн шинжилгээ багтав.

Судалгааны ажлын таамаглал

А. Арбитрын үндсэн шийдвэрийг НИХДЗШШ хүчингүй болгож шийдвэрлэх явдал олшрох хандлагатай болж байна.

2003 онд батлагдсан Арбитрын тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш хоёр жилийн хугацаанд арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгох тухай нийт долоон хүсэлт хүлээн авч хянаад арбитрын шийдвэрийг хэвээр үлдээн шийдвэрлэж[1] байсан боловч 2013-2020 онд (2017 оны шинэчлэн найруулсан хууль үйлчилж эхэлснээс өнөөг хүртэлх хугацаанд) талууд арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулахаар НИХДЗШШ-д өргөдөл гаргаж хандсан тохиолдлын тоо өссөн үзүүлэлттэй байна. Сүүлийн найман жилийн хугацаанд талууд НИХДЗШШ-д нийт 71 удаа (Жилд дунджаар есөн удаа гомдол гаргасан) өргөдөл гаргаснаас 30 гаруй хувьд нь НИХДЗШШ-ээс арбитрын үндсэн шийдвэрийн холбогдох хэсгийг болон уг шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгосон, 70 орчим хувьд нь

[1] Б.Ундрах. Арбитрын ажиллагаан дахь шүүхийн оролцоо. Арбитрын сэдэвт эрдэм шинжилгээний нийтлэлийн эмхэтгэл, УБ., 2020, 272 дахь тал.

арбитрын шийдвэрийг хэвээр үлдээсэн тогтоол гаргасан[2] гэсэн судалгааны үр дүн гарав. Энэхүү судалгаанаас дүгнэвэл цаашид уг асуудлыг судлах хууль зүйн болон практикийн хэрэгцээ шаардлага зайлшгүй байгааг илэрхийлж байна.

Б. Арбитрын үндсэн шийдвэрийг НИХДЗШШ хүчингүй болгосноор арбитрын ажиллагааг удаашруулах, зардлыг нь өсгөх, маргаан шийдвэрлэх арбитрын ажиллагааны үр нөлөөг бууруулах сөрөг үр дагаврууд гарч байгааг шийдвэрлэхэд чиглэсэн хууль зүйн зохицуулалт бий болгох, эрх зүйн холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох хууль зүйн хэрэгцээ, шаардлага бий.

Арбитрын шийдвэртэй холбоотой НИХДЗШШ-ийн хууль хэрэглээ, практик, тулгамдсан асуудлыг судалснаар арбитр, шүүхийн практик дахь хууль хэрэглээний өнөөгийн байдлыг тодорхойлох, арбитрын үндсэн шийдвэрийн хууль ёсны байх, заавал биелэгдэх үндэслэлийг хангах, хэрэг маргаан шийдвэрлэж буй өнөөгийн практикт шүүхийн оролцоо ямар байгаад үнэлэлт өгч, зохист түвшинд хэрхэн байлгаж болох талаар эрх зүйн таамаглал дэвшүүлэх, зарим шийдлийг томьёолох боломж бүрдэнэ гэж үзсэн болно.

Талууд арбитрын үндсэн шийдвэрийг эс зөвшөөрвөл хуульд заасан үндэслэл, журмын дагуу арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдлөө шүүхэд гаргах харилцааны талаарх зохицуулалтыг (2003 онд үйлчилж байсан Арбитрын тухай хуулийн 40 дүгээр зүйлээр зохицуулж байсан) илүү боловсронгуй болгох зорилгоор арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн шүүхийн тогтоолд хууль зүйн дүн шинжилгээ хийх судалгаагаар одоогийн үйлчилж буй Арбитрын тухай хуулийн 47.2, 47.3-т тусган хуульчилсан эрх

[2] Б.Маралгуа. Монголын Олон улсын арбитр. 2020.

зүйн зохицуулалтын хэрэгжилтийн өнөөгийн практикт үнэлэлт, дүгнэлт хийх зайлшгүй шаардлага бий.

Судалгааны объект болгон сонгож судалсан эрх зүйн нийт 67 актад хууль зүйн дүн шинжилгээ хийсний үр дүнд эрх зүйн холбогдох зохицуулалтыг боловсронгуй болговол зохих үндэслэл бүхий дүгнэлт хийн, санал боловсруулж дэвшүүлсэн таамаглалд хариулт өгөх нь зүйн хэрэг.

Судалгааны арга зүй

Арбитрын үндсэн шийдвэрийг хэвээр үлдээсэн, холбогдох хэсгийг болон бүхэлд нь хүчингүй болгож шийдвэрлэсэн НИХДЗШШ-ийн тогтоолыг судалгааны объект болгож, уг тогтоолд дараах аргачлалаар хууль зүйн дүн шинжилгээ хийв.

НИХДЗШШ-ийн тогтоолд хийх хууль зүйн дүн шинжилгээний үндэслэл

Арбитрын үндсэн шийдвэрийг хэвээр үлдээсэн, холбогдох хэсгийг болон бүхэлд нь хүчингүй болгож шийдвэрлэсэн НИХДЗШШ-ийн тогтоолыг задлан шинжилж, тухайн эрх зүйн актын хууль зүйн асуудал, үндэслэлд эрдэмтэн судлаачдын үзэл баримтлал, үндэсний ба олон улсын эрх зүйн хэм хэмжээг үндэслэн хууль зүйн тайлбар хийсэн болно. Ингэж хууль зүйн дүн шинжилгээ хийснээр арбитраар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, маргаан хянан шийдвэрлэж арбитрын үндсэн шийдвэр гаргахтай холбогдсон онол, олон улсын практик, хууль тогтоомжийн харилцан хамаарал, хууль хэрэгжилтийн байдал, шүүхийн тогтоол судлах арга техникийг хөгжүүлэх ач холбогдолтой юм.

Хууль зүйн дүн шинжилгээ хийхэд тохиромжтой гэх үндэслэл бүхий шүүхийн тогтоол

Зохигчид арбитрын урьдчилсан хуралдаанаар арбитрын хуралдааны нээлттэй ба хаалттай хэлбэрийн талаар тохиролцохоос гадна арбитрын үндсэн шийдвэр гаргуулахдаа олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлүүлэх эсэхийг харилцан тохиролцох тухай эрх зүйн зохицуулалтыг үндэслэл болгов. Иймд бидний судалгааны хүрээ арбитрын үндсэн шийдвэрийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэлж болох талаар зохигчид харилцан тохиролцсоныг арбитрын бүрэлдэхүүн хүлээн зөвшөөрч гаргасан арбитрын үндсэн шийдвэр, түүнийг хэвээр үлдээсэн, холбогдох хэсгийг болон бүхэлд нь хүчингүй болгосон НИХДЗШШ-ийн тогтоолыг хамарч байгаагаараа онцлог юм.

Судалгаанд сонгож авсан арбитр, шүүхийн эрх зүйн актад дүн шинжилгээ хийхдээ арбитрын болон шүүх бүрэлдэхүүний нэр, зохигчдын бүтэн нэрийг хэрэглэхгүй, зөвхөн үсгээр товчилж бичих аргаар судалгааг гүйцэтгэсэн ба арбитрын үндсэн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн тогтоолын агуулга, хэлбэрт тавигдсан хууль зүйн шаардлагад хууль зүйн нарийвчилсан дүн шинжилгээ хийхийн тулд хууль зүйн шинжлэх ухаанд хэрэглэгддэг судалгааны дараах арга, арга зүйг ашиглав. Үүнд:

- Үндэсний ба олон улсын эрх зүйн хэм хэмжээг судлах, дүгнэлт хийх;
- Баримт бичиг судалж үнэлгээ өгөх;
- Харьцуулан судлах;
- Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх арга;
- Тохиолдол шинжлэх;
- Сонгон судалсан арбитр, шүүхийн эрх зүйн актад дүн шинжилгээ хийх.

НИХДЗШШ-ийн тогтоолыг судлахдаа дараах хүснэгтийн бүтцийн хүрээнд асуудлыг тодорхойлж, арбитрын үндсэн шийдвэр, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журам буюу эрх зүйн нийт 67 актад нэг бүрчлэн дүн шинжилгээ хийсэн судалгааг хавсралтад багтаасан болно.

№	Бүтэц	Агуулга
1	Танилцуулах хэсэг	Шийдвэрлэсэн шүүх: Шүүхийн тогтоолын дугаар: Шүүхийн тогтоолын огноо: Арбитрын шийдвэрийн дугаар: Арбитрын шийдвэрийн огноо: Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журам, огноо:
2	Хэргийн тухай товч тайлбар	Хэрэг маргааны үйл баримт
3	Арбитрын үндсэн шийдвэрийн агуулга	Процессын түүх Одоогийн шийдвэрийн зүйлчлэл Хэргийн онолын агуулга ба үндэслэл
4	Арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулахаар гаргасан өргөдлийн агуулга	Талууд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн шүүхэд хандаж гаргасан өргөдлийн агуулгыг бүлэглэн илэрхийлэх
5	Шүүхийн тогтоолын үндэслэл	Шүүх өргөдлийг хянасан хууль зүйн үндэслэл
6	Шүүхийн тогтоолын зүйлчлэл	Шүүхийн тогтоолын хууль хэрэглээ

7	Дүн шинжилгээ	Асуудал Эрх зүйн онол, үзэл баримтлал Тогтоолд өгөх үнэлгээ Тогтоолын ач холбогдол Цаашид тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зарим арга замыг тодорхойлох
8	Эх сурвалж	Ашигласан материал

Тоон судалгаа

2003-2005 он хүртэлх хугацаанд арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгох тухай нийт долоон хүсэлт хүлээн авч хянан шийдвэрлэж[3] байсан ба 2013-2016 онд 21, харин 2017-2020 онд буюу Арбитрын тухай хууль шинэчлэгдэн батлагдсанаас хойших хугацаанд шүүхийн 50 тогтоол гарсан тухай тоон судалгаанаас дүгнэхэд арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулахаар НИХДЗШШ-д хандсан тохиолдлын тоо сүүлийн жилүүдэд өссөн үзүүлэлттэй байна. Эдгээр 71 тогтоолоос арбитрын үндсэн шийдвэрийн холбогдох хэсгийг болон шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгосон 22, арбитрын шийдвэрийг хэвээр үлдээсэн шүүхийн 49 тогтоол гарсан[4] нь арбитрын шийдвэр, түүнийг хүчингүй болгохтой холбогдох эрх зүйн зохицуулалт, арбитрын ажиллагааны журам, арбитрын үндсэн шийдвэр, шүүхийн тогтоолд хууль зүйн дүн шинжилгээ хийх хууль зүйн болон практикийн хэрэгцээ шаардлага зайлшгүй байгааг харуулж байна гэж үзсэн билээ.

---

[3] Б.Ундрах. Арбитрын ажиллагаан дахь шүүхийн оролцоо. Арбитрын сэдэвт эрдэм шинжилгээний нийтлэлийн эмхэтгэл, УБ., 2020, 272 дахь тал.

[4] Б.Маралгуа. Монголын Олон улсын арбитр. 2020.

НИХДЗШШ-ийн тогтоол	Хүсэлтийг хангасан /арбитрын үндсэн шийдвэрийн холбогдох хэсгийг болон бүхэлд нь хүчингүй болгосон/	Хүсэлтийг хангаагүй /арбитрын үндсэн шийдвэрийг хэвээр үлдээсэн/
2013 он		
12	4	8
2014 он		
5	1	4
2015 он		
2	0	2
2016 он		
2	1	1
2017 он		
11	1	10
2018 он		
19	8	11
2019 он		
9	6	3
2020 он		
11	1	10
Нийт		
71	**22**	**49**

Чанарын судалгаа

НИХДЗШШ-ийн тогтоолыг судлан хууль зүйн дүн шинжилгээ хийхдээ дараах судалгааны асуултын хүрээнд дүгнэлт хийв. Үүнд:

– Зохигчид арбитрын үндсэн шийдвэрийн ямар зүйлд нь гомдолтой байж, НИХДЗШШ-д хандсан үндэслэл, шалтгаан нь юу вэ?

- Арбитрын үндсэн шийдвэр хүчингүй болсон шалтгаан, алдаа нь юу вэ?
- Арбитрын бүрэлдэхүүн арбитрын урьдчилсан хуралдааны явцад зохигчдын эрхийг зөрчсөн үү?
- Арбитрын бүрэлдэхүүн арбитрын үндсэн хуралдааны явцад зохигчдын эрхийг зөрчсөн үү?
- Арбитрын урьдчилсан хуралдааны журам зөрчсөнөөс шалтгаалж арбитрын үндсэн шийдвэр хүчингүй болсон уу?
- Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зохигчдын эрхийг зөрчсөн үү?
- НИХДЗШШ арбитрын үндсэн шийдвэрийн холбогдох хэсгийг болон бүхэлд нь хүчингүй болгож буй нийтлэг үндэслэл нь юу вэ?

Судалгааны төлөөлөх чадвар

Сүүлийн найман жилийн байдлаар МОУА-ын жилдээ хянан шийдвэрлэж байгаа хэргийн тоон статистик судалгааг авч үзэхэд дараах үзүүлэлттэй байна.

Он	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
	МОУА-аар шийдвэрлэсэн хэргийн тоо							
Шийдвэрлэсэн хэргийн тоо	44	31	64	100	71	74	76	89
	НИХДЗШШ-д арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулахаар өргөдөл гаргасан тоо							
НИХДЗШШ-ийн тогтоолын тоо	12	5	2	2	11	19	9	11

Сүүлийн найман жилийн хугацаанд нийт 549 хэрэгт арбитрын үндсэн шийдвэр гаргасны 12.9 хувь буюу 71 шийдвэрийг талууд эс зөвшөөрч, арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулахаар НИХДЗШШ-д өргөдөл гаргасныг харуулж буй дээрх судалгаанд үндэслэн МОУА-ын архив, мэдээллийн сангаас шүүхийн 71 тогтоолд шүүлт хийсэн билээ. Энэ 71 тогтоолын 22 нь буюу 31 хувьд нь арбитрын үндсэн шийдвэрийн холбогдох хэсгийг ба бүхэлд нь хүчингүй болгож шийдвэрлэсэн байна. Арбитрын шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн НИХДЗШШ-ийн 22 тогтоолын 16-д нь буюу 72.72 хувьд нь хууль зүйн дүн шинжилгээ хийсэн нь судалгааны төлөөлөх чадварыг илэрхийлсэн үзүүлэлт гэж дүгнэсэн болно.

Арбитрын тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д "Талууд өөрөөр тохиролцоогүй бол доор дурдсанаас бусад тохиолдолд арбитрын шийдвэр, тогтоол, арбитрын ажиллагааны явцад талуудаас ирүүлсэн мэдээллийн нууцлалыг талууд, арбитрын бүрэлдэхүүн, байнгын арбитр хадгалах үүрэгтэй", мөн хуулийн 50.1.3-т "арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгох, гүйцэтгүүлэхээр шүүхэд өргөдөл гаргасан" гэж хуульчилсан хэм хэмжээнд үндэслэн дараах хоёр үндэслэл, чиглэлээр судалгааны объектын хүрээг ангилан судлав. Үүнд:

1. "Талууд өөрөөр тохиролцоогүй бол ..." гэх үндэслэлийг арбитрын ажиллагааны урьдчилсан хуралдаанаас талууд, арбитрын бүрэлдэхүүн, талуудын итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч зэрэг оролцогчдын тохиролцоонд үндэслэн тогтсон арбитрын ажиллагааны журамд арбитрын хуралдааныг нээлттэй хийснийг шалгуур болгон судлахад 18 хуралдаан нээлттэй болсон ба эдгээр хуралдаанаас гарсан арбитрын ажиллагааны журам, арбитрын үндсэн шийдвэр, НИХДЗШШ-ийн тогтоол - нийт 54 эрх зүйн акт,

2. "Талууд өөрөөр тохиролцсон бол ..." гэх үндэслэлийг арбитрын ажиллагааны урьдчилсан хуралдаанаас талууд,

арбитрын бүрэлдэхүүн, талуудын итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч зэрэг оролцогчдын тохиролцоонд үндэслэн тогтсон арбитрын ажиллагааны журамд арбитрын хуралдааныг хаалттай хийснийг, мөн 2017 оны Арбитрын тухай хууль үйлчилж эхэлснээс хойших хугацаанд НИХДЗШШ-ийн 16 тогтоолоор арбитрын үндсэн шийдвэрийн холбогдох хэсгийг болон уг шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгосныг тус тус шалгуур болгон судалсан тул НИХДЗШШ-ийн 13 тогтоол буюу эрх зүйн нийт 67 баримт бичгийг судалгааны объект болгон сонгон авсан нь судалгааны төлөөлөх чадварыг илэрхийлсэн гэх үндэслэлтэй. Арбитрын эдгээр 31 үндсэн шийдвэрийн 16-г НИХДЗШШ-ийн тогтоолоор хүчингүй болгож, 15-ыг нь хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна *(НИХДЗШШ-ийн тогтоол тус бүрд хууль зүйн дүн шинжилгээ хийсэн судалгааг хавсаргав).*

Судалгааны зүйл болох арбитрын үндсэн шийдвэрийг бүхэлд нь болон хэсэгчлэн хүчингүй болгосон, эсхүл хэвээр үлдээсэн тухай НИХДЗШШ-ийн тогтоолууд нь Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим санд ороогүй байгаа тул судалгааны зорилго, зорилтын хүрээнд зохиогчдын хүсэлтээр арбитрын урьдчилсан хуралдаанаар нээлттэй хийсэн хуралдааны шийдвэрүүдийг хянан шийдвэрлэсэн арбитрын 18 үндсэн шийдвэр, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх тухай 18 журам, 18 шүүхийн тогтоол, арбитрын хаалттай хуралдааны шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн НИХДЗШШ-ийн 13 тогтоол буюу эрх зүйн нийт 67 баримт бичгийг тус байгууллагын архив, мэдээллийн сангаас шүүх ажилд туслалцаа үзүүлж хамтран ажилласан МҮХАҮТ-ын дэргэдэх МОУА-ын удирдлага, ажлын албанд талархлаа илэрхийлье!

НЭГ. ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Арбитрын үндсэн шийдвэрийн хэлбэр, агуулга нь хуульд заасан шаардлагыг хангасан эсэхээс хамаарч уг шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, гүйцэтгэх эсэх асуудал үүсдэгээрээ онцлог байдаг. Үүнтэй уялдаж талууд арбитрын бүрэлдэхүүний санал, хүсэлтээр арбитрын үндсэн шийдвэрт засвар оруулах, тайлбарлах, нэмэлт шийдвэр гаргах[5] эрх зүйн зохицуулалт бас бий.

Арбитрын бүрэлдэхүүн зөвлөлдөж, олонхын саналаар гаргасан шийдвэрээ талуудад танилцуулах (талууд танилцуулахад оролцохгүй байж болно) бөгөөд танилцуулснаас хойш 14 хоногийн дотор арбитрын шийдвэрийг бичгээр гаргах дүрэмтэй.[6] Арбитрын үндсэн шийдвэр нь хуульд заасан хэлбэр, агуулгатай, цугларсан нотлох баримтад үндэслэн талууд, арбитрын бүрэлдэхүүний тохиролцож тогтсон үндэсний болон олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэн, арбитрын хэлэлцээр бүхий харьяаллын маргааныг хянан шийдвэрлэж, арбитрын үндсэн шийдвэр гаргах эрх зүйн зохицуулалттай.

Арбитрын үндсэн шийдвэрийг заавал биелүүлэх хүчинтэй гэж хүлээн зөвшөөрөх олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу гүйцэтгэх ажиллагаатай холбогдон шүүхэд хандах бүрдүүлбэр[7], мөн арбитрын үндсэн шийдвэрийг гүйцэтгэхээс татгалзах үндэс-

[5] Арбитрын тухай хуулийн 46 дугаар зүйл.

[6] Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн 26 дугаар зүйлийн 26.4.

[7] Арбитрын тухай хуулийн 48 дугаар зүйл.

лэл,[8] арбитрын үндсэн шийдвэрийн биелэлттэй холбогдох эрх зүйн хэм хэмжээ бий.

Олон улсад арбитрын шийдвэрийг хүчингүй болгох нэг үндэслэл нь нийтийн эрх ашиг болж байна. Өнөөдрийг хүртэл эрдэмтэд энэ асуудлаар маргаантай байдаг. Үүний учир нь улс бүр өөрийн үндэсний шүүхийн тогтолцооноос хамааралтайгаар харилцан адилгүй журам хэрэгжүүлдэгтэй холбоотой байна. Гэхдээ сүүлийн үед гадаадын орнууд Арбитрын тухай хуульдаа нийтийн эрх ашгийн тухай онол, үзэл баримтлал тусгахыг эрмэлзэх болсон байна[9]. Ингэж байж олон улсын хэмжээнд арбитрын хэм хэмжээ бүрэн дүүрэн хэрэгжих үндэслэлтэй юм. Арбитрын шийдвэр эцсийн байх учир нийтийн эрх ашигтай зөрчилдсөн тохиолдолд шийдвэр хүчингүй болох үндэслэлийг гадаадын орнууд хуульчлан зохицуулдаг байна.

Арбитрын ажиллагаан дахь шүүхийн оролцооны нэг хэлбэр нь арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай шүүхийн ажиллагаа юм. Энэ талаар Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлд хуульчилсан ба уг зүйлийн хэрэгжилтийн байдлыг судлахдаа дараах үндсэн гурван чиглэлээр судалгааг бүлэглэн ангилж, хууль зүйн дүн шинжилгээ хийн, үүнд үндэслэн чанарын судалгааны асуултын хүрээнд дүгнэлт хийсэн болно. Үүнд:

1. Арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулахаар гаргасан өргөдлийн агуулга, хууль зүйн үндэслэлд хийсэн дүн шинжилгээ;
2. Арбитрын үндсэн шийдвэрийн үндэслэл, хууль хэрэглээнд хийсэн дүн шинжилгээ;
3. НИХДЗШШ-ийн тогтоолын хууль зүйн үндэслэл, хууль хэрэглээнд хийсэн дүн шинжилгээ.

---

8 Арбитрын тухай хуулийн 49 дүгээр зүйл.

9 Sameer Sattar. Enforcement of Arbitral awards and public policy: Same concept, different approach. 2019.

Мөн дээр дурдсан гурван бүлэг судалгаанд үндэслэн чанарын судалгааны асуулгын дүгнэлт гэсэн судалгааг багтаав.

1.1. АРБИТРЫН ҮНДСЭН ШИЙДВЭРИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГУУЛАХААР ГАРГАСАН ӨРГӨДЛИЙН АГУУЛГА, ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Сонгон судалсан НИХДЗШШ-ийн 31 тогтоолд тусгагдсан талуудын өргөдлийн агуулга нь дараах хэд хэдэн үндэслэл, чиглэлтэй байна. Үүнд:

1. Арбитрын тухай хуулийн 47.2.1.а-д "арбитрын хэлэлцээрийн аль нэг тал эрх зүйн чадамжгүй, эсхүл арбитрын хэлэлцээр нь талуудын тохиролцон сонгосон улсын хуульд зааснаар, эсхүл тийнхүү тохиролцон сонгоогүй бол Монгол Улсын хуульд зааснаар хүчин төгөлдөр бус" гэсэн хэм хэмжээг үндэслэл болгож арбитрын хэлэлцээр хүчин төгөлдөр мөн эсэхийг шинжлэн судлахгүйгээр арбитр хэргийг шийдвэрлэн үндсэн шийдвэр гаргасан тул арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах;

2. Арбитрын тухай хуулийн 47.2.1.б-д "өргөдөл гаргагч талд арбитрч томилох, арбитрын ажиллагааны тухай зохих ёсоор мэдэгдээгүйн улмаас арбитрын ажиллагаанд зохих ёсоор оролцох боломжгүй байсан" гэсэн хэм хэмжээг үндэслэл болгож арбитрчийг томилох журам зөрчиж арбитрч томилсон нь хуулийг ноцтой зөрчсөн тул арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах;

3. Арбитрын тухай хуулийн 47.2.1.в-д "арбитрын бүрэлдэхүүн нэхэмжлэлийн шаардлагад тусгаагүй, хамааралгүй маргааны талаар үндсэн шийдвэр гаргасан. Хэрэв нэхэмжлэлийн

шаардлагад тусгаагүй, хамааралгүй асуудлаар гаргасан арбитрын үндсэн шийдвэрийг нэхэмжлэлийн шаардлагад тусгасан асуудлаар гаргасан шийдвэрээс салгах боломжтой бол холбогдох хэсгийг хүчингүй болгоно" гэсэн хэм хэмжээг үндэслэл болгож арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах;

Дээрх хэм хэмжээг үндэслэн шүүхэд гаргасан өргөдлийн шаардлагын агуулгад шинжилгээ хийхэд дараах гомдлууд хамаарч байна:

- Арбитрын бүрэлдэхүүн хариуцагчийн өмнөөс, түүний татгалзалд дурдагдаагүй асуудлаар үндсэн зээл, зээлийн хүү, алданги тооцон Арбитрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д заасан зарчмаас хальж, процессын хувьд ноцтой зөрчилтэй шийдвэр гаргасан гэх;
- Хэргийн үйл баримтыг тогтоолгүй, нэхэмжлэгчийн маргаагүй үндэслэлээр нэхэмжлэлийг үндэслэлгүйгээр хангаж шийдвэрлэсэн гэх.

4. Арбитрын тухай хуулийн 47.2.1.г-д "талуудын тохиролцоо нь энэ хуулийн заавал дагаж мөрдөх заалтыг зөрчсөнөөс бусад тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн, арбитрын ажиллагаа талуудын тохиролцоонд нийцээгүй, эсхүл тийнхүү тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн, арбитрын ажиллагаа нь энэ хуульд нийцээгүй" гэсэн хэм хэмжээг үндэслэл болгож арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах;

Дээрх хэм хэмжээг үндэслэн шүүхэд гаргасан өргөдлийн шаардлагын агуулгад шинжилгээ хийхэд дараах гомдлууд хамаарч байна:

– Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журам тогтоох урьдчилсан хуралдаанаар Иргэний хууль, ИХШХШтХ хэрэглэн маргааныг шийдвэрлэхээр тохиролцсон журмыг хариуцагч талын итгэмжлэгдсэн төлөөлөгч зөвшөөрөөгүй, гарын үсэг зураагүй байхад маргааныг шийдвэрлэн шийдвэр гаргаж Арбитрын ажиллагааны журам зөрчсөн;

– Арбитрын ажиллагааны журам баталсан ажиллагаа, түүнээс гарсан шийдвэрт гомдол гаргасан байхад гомдлыг шийдвэрлээгүй, Арбитрын ажиллагааны журам баталсан өдрийн шүүх хурлын тэмдэглэл хэрэгт байхгүй, хурлын тэмдэглэл хөтлөөгүй.

5. Арбитрын тухай хуулийн 47.2.2.а-д “Монгол Улсын хуулиар уг маргаан арбитрын харьяаллын маргаан биш” гэсэн хэм хэмжээг үндэслэл болгож арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах;

Дээрх хэм хэмжээг үндэслэн шүүхэд гаргасан өргөдлийн шаардлагын агуулгад шинжилгээ хийхэд дараах гомдлууд хамаарч байна:

– Талуудын хооронд байгуулсан гэрээнд шүүх, арбитрын байгууллагаар шийдвэрлүүлэхээр сонголт хийх эрхтэйгээр тохиролцсон байхад арбитрын урьдчилсан болон жинхэнэ хуралдаан дээр арбитрын харьяаллын хэрэг мөн гэж үзсэн нь хариуцагч талын шүүхээр шийдвэрлүүлэх сонголттой байсныг харгалзан үзээгүй;

– Талуудын хооронд хэд хэдэн гэрээ байгуулагдсан тохиолдолд нэг гэрээнд нь Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлэхээр заасан байтал хоёр дахь гэрээнд буй арбитрын хэлэлцээрээр хэргийн харьяалал тогтоож, шүүхээр шийдвэрлүүлэх нөхцөлтэй нөгөө гэрээг баримтлан шийдвэр гаргасан нь, өөрөөр хэлбэл, нэхэмжлэлийн шаардлага арбитрын харьяалал мөн эсэх нь тодорхойгүй байхад хэргийг шийдвэрлэсэн нь Арбитрын тухай хууль ноцтой зөрчсөн.

6. Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлд хамааралгүй асуудлаар гаргасан өргөдлийн агуулгад шинжилгээ хийхэд дараах гомдлууд хамаарч байна:

– Арбитрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.2 дахь хэсэгт зааснаар нотлох баримтын талаар тайлбар гаргах нэхэмжлэгчийн эрхийг зөрчсөн;

– Бусад хууль, тухайлбал, Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйл, 16 дугаар зүйлийг шинжээчид зөрчсөн;

– Арбитрын хуралдааны явцад нэхэмжлэгч тал 70 хуудас нотлох баримт танилцуулан гардуулахад хариуцагч тал уг баримттай танилцах хүсэлт гаргаж, арбитрын бүрэлдэхүүн зөвлөлдөн мэргэжлийн тусгай мэдлэг шаардлагатай санхүүгийн шинжээч томилох шийдвэр гаргаснаар шүүх хуралдаан хойшилсон ба Арбитрын үндсэн хуралдаан дээр 70 хуудас нотлох баримтаас санхүүгийн баримт болон зээлийн баримт, түүний орчуулга болох 1-16 хуудас баримтуудыг нотлох баримтаас хасаж шийдвэрлэсэн;

– Арбитрын хуралдаанд гаргасан тайлбар, хэрэгт цугларсан нотлох баримтыг бүрэн шинжлэн судлалгүйгээр арбитрын бүрэлдэхүүн Иргэний хуулийн холбогдох заалтыг тайлбарлаж хэрэглэсэн нь үндэслэлгүй шийдвэр болсон;

– Арбитрын ажиллагааны явцад мэргэжлийн орчуулагчийг шинжээчээр томилуулж, орчуулгын хувьд гэрээ нь зөрүүтэй эсэхийг тогтоолгох, барилгын мэргэшсэн шинжээч томилж, ажлын гүйцэтгэл, хувь хэмжээг тогтоолгох хүсэлт тус тус гаргасан боловч арбитрын бүрэлдэхүүн дээрх хүсэлтийг хангаагүйгээс Иргэний хуулийн 352 дугаар зүйлийн 352.2.3-т заасан эрхээ хэрэгжүүлж чадаагүй;

– Гэрээний үүргийг гэрээ байгуулсан үеийн долларын ханшаар тооцоогүй, арбитрын байгууллага хууль зөрчиж хийсэн гэрээ болохыг шийдвэртээ хүлээн зөвшөөрсөн атлаа хууль зөрчсөн гэрээг баримтлан маргааныг шийдвэрлэсэн нь хууль буруу хэрэглэсэн;

– Арбитрын шийдвэрээ агуулгын хувьд засварлаж, арбитраас хангасан дүн болон хэрэгсэхгүй болгосон дүнг өөрчилж, нийт зуу гаруй сая төгрөгийн хүрээнд өөрчлөлт оруулсан;

– Хариуцагчийн зүгээс нэхэмжлэлд дэлгэрэнгүй тайлбар гаргах, шүүх хуралдаанд хариуцагчийн төлөөлөгчийг биечлэн оролцуулах хүсэлт гаргасан ч арбитр хүсэлтийг хүлээн авалгүй хэргийг шийдвэрлэж, эрх ашгаа хамгаалах боломжоор хангаагүй зэрэг.

7. Арбитрын ажиллагаанд төлөөлөх эрхгүй этгээд оролцсон, нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан маргааныг арбитр шийдвэрлэж үндсэн шийдвэр гаргасан гэх өргөдлийн агуулгад шинжилгээ хийхэд дараах гомдлууд хамаарч байна:

- Арбитр хэрэг хянан шийдвэрлэхдээ нэхэмжлэгч компанийг төлөөлөх эрх бүхий этгээд хэн болохыг баримтаар тогтоолгүй шийдвэрлэсэн нь эрх зүйн чадамжтай эсэхэд эргэлзээ төрүүлэхүйц нөхцөл байдал үүсгэж байгаа ба маргаанд хамааралгүй этгээдийг оролцуулж, арбитрын хэрэг шийдвэрлэх журмыг ноцтой зөрчсөн;
- Нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан нь хууль, дүрэм зөрчсөн;
- Төлөөлөх эрхгүй этгээд гэрээ байгуулснаас үүдэн хүчин төгөлдөр бус гэрээний маргааныг арбитрын бүрэлдэхүүн шийдвэрлэсэн;
- Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль бус итгэмжлэлээр оролцсон маргааныг хянан шийдвэрлэсэн гэх мэт.

Дүгнэлт: Хууль зүйн дүн шинжилгээ хийсэн НИХДЗШШ-ийн тогтоолд буй талуудын гаргасан өргөдлийн дийлэнх хувь нь Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлд хамааралгүй, мөн шүүх хянах эрхгүй асуудлаар өргөдөл гаргасан нь арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл биш байх тул арбитрын шийдвэрийг хэвээр үлдээж, харин хуульд заасан үндэслэл бүхий өргөдлийг хянан НИХДЗШШ арбитрын үндсэн шийдвэрийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.

1.2. АРБИТРЫН ҮНДСЭН ШИЙДВЭРИЙН ҮНДЭСЛЭЛ, ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

1. Судалгаанд хамрагдсан НИХДЗШШ-ийн 31 тогтоолоос арбитрын шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн 16 тогтоол байв. Энэ нь НИХДЗШШ-ээс хүчингүй болгож шийдвэрлэсэн арбитрын нийт шийдвэрийн 51,61 хувийг эзэлж байгаа нь цаашид тухайн арбитрын бүрэлдэхүүн анхаарах ёстой асуудлын нэг мөн. Тухайлбал, талууд арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамд гарын үсэг зурж хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд арбитрын ажиллагааг үргэлжлүүлэн явуулж үндсэн шийдвэр гаргасан, арбитрын хэлэлцээр хууль зүйн хувьд хүчин төгөлдөр эсэхийг сайтар нягтлахгүйгээр арбитрын харьяаллын маргаан хэмээн тогтоосон, талуудын тохиролцоонд нийцээгүй хэлбэрээр арбитрын ажиллагаа явуулсан зэрэг шалтгаан, үндэслэлээр арбитрын шийдвэр хүчингүй болсон байх тул эдгээр асуудлыг арбитрын бүрэлдэхүүний анхаарвал зохих асуудал мөн гэж үзлээ.

2. Арбитрын бүрэлдэхүүн, талууд хэлэлцэн тохиролцож арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журамд арбитрын хэлэлцээр, хэргийн харьяаллын талаарх журмын 4 дэх хэсгийн 4.1-д “2015 оны 5 дугаар сарын 28-ны өдөр “А” ХХК, “Б” ХХК-ийн хооронд байгуулагдсан гэрээ”-ний 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт “Энэ гэрээтэй холбоотой аливаа үл ойлголцол, маргаантай асуудлыг талууд ойлголцох, буулт хийх замаар шийдэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд эс хүрвээс МҮХАҮТ-ын дэргэдэх МҮА-аар шийдвэрлүүлнэ” гэж заасан тул Арбитрын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу арбитрын хэлэлцээрийг хийсэн гэж үзэж, мөн хэрэг хянан шийдвэрлэх журмын 5.1-д Арбитрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 2015 оны 5 дугаар сарын 28-ны өдөр “А” ХХК, “Б” ХХК-ийн

хооронд байгуулагдсан “Газар тариалангийн зориулалттай тоног төхөөрөмжөөр ажил гүйцэтгэх тухай гэрээ”-ний 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн уг маргааныг арбитрын харьяаллын маргаан болохыг арбитрын бүрэлдэхүүн хэлэлцэж шийдвэрлэв гэжээ. Нэхэмжлэгч, хариуцагч талууд арбитрын хэлэлцээр болон хэргийн харьяаллын талаар маргаагүй болно гэж тус тус заасан. Гэвч уг журмыг[10] тохиролцон батлах урьдчилсан хуралдааныг 2017 оны 2 дугаар сарын 07-ны өдөр хийсэн байх тул 2017 оны 1 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсөн Арбитрын тухай хуульд тусгасан арбитрын хэлэлцээр, арбитрын харьяаллын маргааны талаарх хэм хэмжээг үндэслэл болгох хууль зүйн шаардлагатай боловч хүчингүй болсон арбитрын хуулийн заалтыг баримталсан нь тухайн арбитрын бүрэлдэхүүн арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журам гаргахдаа хайхрамжгүй хандсан байна гэж дүгнэв.

3. Арбитрын тухай хуулийн 47.2.1.в-д хуульчилсан “арбитрын бүрэлдэхүүн нэхэмжлэлийн шаардлагад тусгаагүй, хамааралгүй маргааны талаар үндсэн шийдвэр гаргасан. Хэрэв нэхэмжлэлийн шаардлагад тусгаагүй, хамааралгүй асуудлаар гаргасан арбитрын үндсэн шийдвэрийг нэхэмжлэлийн шаардлагад тусгасан асуудлаар гаргасан шийдвэрээс салгах боломжтой бол холбогдох хэсгийг хүчингүй болгоно” гэсэн хэм хэмжээг үндэслэн арбитрын шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн НИХДЗШШ-ийн таван тогтоол гарсан нь тухайн арбитрын бүрэлдэхүүн нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд маргаан хянан шийдвэрлэх зарчмыг баримталж ажиллахад зайлшгүй анхаарах асуудал мөн гэж үзэв. Түүнчлэн уг хэм хэмжээг илүү тодорхой болгох чиглэлийг судалгааны дүгнэлтэд тусгав.

[10] “А” ХХК-ийн нэхэмжлэлтэй “М” ХХК-д холбогдох гэрээний маргаан. 2017.

4. Арбитрын тухай хуулийн 47.2.1.г-д заасан “талуудын тохиролцоо нь энэ хуулийн заавал дагаж мөрдөх заалтыг зөрчсөнөөс бусад тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн, арбитрын ажиллагаа талуудын тохиролцоонд нийцээгүй, эсхүл тийнхүү тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн, арбитрын ажиллагаа нь энэ хуульд нийцээгүй” гэх хэм хэмжээг үндэслэн арбитрын шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн НИХДЗШШ-ийн таван тогтоол гарсан нь тухайн арбитрын бүрэлдэхүүний анхаарах асуудлын нэг боловч уг хэм хэмжээг шүүх хэрэглэхэд хэр ойлгомжтой зохицуулалт вэ гэдэгт хууль зүйн дүн шинжилгээ хийснээр уг хуулийн заалтыг илүү тодорхой болгох талаар санал дэвшүүлж, судалгааны дүгнэлтэд тусгав.

5. Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журам, арбитрын үндсэн шийдвэрт үг үсэг, техникийн шинжтэй алдаа цөөнгүй байгааг цаашид анхаарах шаардлагатай байна.

1.3. НИХДЗШШ-ИЙН ТОГТООЛЫН ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ, ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

НИХДЗШШ-ийн тогтоолын хянасан хэсэгт буй хууль зүйн үндэслэлд арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогт тулгуурлан хууль зүйн агуулгыг зохистой илэрхийлэх чиглэлээр дутагдал бүхий зарим дүгнэлт хийсэн нь ажиглагдав. Тухайлбал, НИХДЗШШ-ийн тогтоолоор[11] уг арбитрын шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэхдээ дараах үндсэн хоёр үндэслэлийг гаргасан байна:

[11] БНХАУ-ын “Ю” ХК-ийн нэхэмжлэлтэй хэрэг. 59 дэх тал.

1. Талуудын хооронд байгуулсан 2015 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн гэрээ, 2016 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн Төлбөрийн гэрээ арбитрын хэрэгт авагдсаныг тус тус дурдсан ба эдгээр гэрээнд зааснаар уг гэрээний биелэлттэй холбоотой бүх төрлийн маргааныг талуудын нөхөрсөг, найрсаг хэлэлцээрийн дагуу шийдвэрлэх, маргааны нөхцөл байдалд хүрвэл "Хятад Улсын элчингийн Гадаад худалдааны арбитрын комисст асуудлыг өргөн барина" гэж заасныг үндэслэн талууд МҮХАҮТ-ын дэргэдэх МОУБҮА-аар маргаан шийдвэрлүүлэх талаар арбитрын хэлэлцээр байгуулаагүй байна гэж дүгнэн, Арбитрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсэгт зааснаар нэхэмжлэл болон хариу тайлбарт арбитрын хэлэлцээр байгаа талаар тусгаж, нөгөө тал түүнийг үгүйсгээгүй бол арбитрын хэлэлцээрийг бичгээр үйлдсэн гэж үзэх тухай хэм хэмжээг үндэслэл болгосон.

2. БНХАУ-д үүсэн байгуулагдсан маргаан бүхий "Ю" ХК нь "Б" ХХК-д холбогдуулан МҮХАҮТ-ын дэргэдэх МОУБҮА-т нэхэмжлэл гаргасан боловч тухайн хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд түүнийг гаргасан гэж үзэхэд эргэлзээтэй байна. Дээрх нэхэмжлэлийг тус компанийн захирал гэх Г гаргасан боловч хэргийн баримтад тухайн этгээд нь нэхэмжлэгчийг төлөөлөх эрхтэйг нотлох баримт байхгүй байна гэж дүгнэсэн ажээ. Төлөөлөх эрхтэй этгээд арбитрт хандан нэхэмжлэл гаргасан гэх нөхцөл байдал тогтоогдоогүй тохиолдолд нэхэмжлэгч "Ю" ХК нь Арбитрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсэгт зааснаар тус арбитрын хэргийг шийдвэрлэхүйц хэлэлцээртэй гэж үзэх боломжгүй юм. Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.1.а-д "энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан арбитрын хэлэлцээрийн аль нэг тал эрх зүйн чадамжгүй, эсхүл арбитрын хэлэлцээр нь талуудын тохиролцон сонгосон улсын хуульд зааснаар, эсхүл тийнхүү тохиролцон сонгоогүй бол Монгол Улсын хуульд зааснаар хүчин төгөлдөр бус" гэсэн хэм хэмжээг баримтлан

шүүх арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгох зохицуулалт, мөн хуулийн 47.2 дахь хэсэгт заасныг тус тус баримтлан шийдвэрлэсэн байна.

Дээр дурдсан НИХДЗШШ-ийн тогтоол болон арбитрын шийдвэрийг зэрэгцүүлэн хууль зүйн дүн шинжилгээ хийснээр дараах дүгнэлтэд хүрэв. Үүнд:

1. Арбитрын бүрэлдэхүүн 2015 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр "Дамжуулагч шугамын тоног төхөөрөмж Монгол Улсад ханган нийлүүлэх гэрээ"-ний 15 дугаар зүйлд "маргааныг арбитраар шийдвэрлүүлэх"-ээр тохиролцсон гэрээний нөхцөлийг баримтлан Арбитрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсэгт заасны дагуу арбитрын хэлэлцээртэй гэж дүгнэн, Арбитрын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, талуудын хооронд байгуулсан уг гэрээний 15 дугаар зүйлд заасныг тус тус үндэслэн уг маргааныг арбитрын харьяаллын маргаан хэмээн шийдвэрлэжээ. Талууд арбитрын хэлэлцээр болон хэргийн харьяаллын талаар маргаагүй бөгөөд арбитрын урьдчилсан хуралдаанаар МҮХАҮТ-ын дэргэдэх МОУБҮА-аар уг маргааныг хянан шийдвэрлүүлэхээр тохиролцсон талаар арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журамд тусгасан байна. Мөн арбитрын шийдвэрт энэ талаар тусгасан нь арбитрын бүрэлдэхүүн 2015 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн гэрээний нөхцөлийг баримтлан арбитрын харьяаллын маргаан гэж тогтоосон тул уг маргааныг хянан шийдвэрлэжээ.

2. Харин НИХДЗШШ 2016 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн Төлбөрийн гэрээний нөхцөлийг үндэслэн МҮХАҮТ-ын дэргэдэх МОУБҮА-аар харьяаллын маргаан биш, Хятад Улсын элчингийн Гадаад худалдааны арбитрын комисс шийдвэрлэх маргаан гэж дүгнэсэн байна.

Эдгээр дүгнэлтэд дурдсанаар арбитрын бүрэлдэхүүн нь талуудын хооронд байгуулсан үндсэн гэрээний нөхцөлийг, шүү-

хийн хувьд талуудын хооронд байгуулсан үндсэн гэрээтэй холбогдуулан байгуулсан төлбөрийн гэрээний нөхцөлийг тус тус үндэслэн хоёр өөр гэрээний нөхцөлөөр арбитрын хэлэлцээрийг дүгнэжээ. Энэ тохиолдолд арбитр, шүүх хоёрын аль аль нь хууль зүйн үндэслэлтэй дүгнэлт гаргасан гэж үзэх боломжтой хэдий ч талуудын маргааны үндэслэл болсон анхдагч гэрээнд тусгасан нөхцөлийг, мөн талууд, арбитрын бүрэлдэхүүний хэлэлцэн тохиролцсон арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журмаар хуралдааны явцад биечлэн тайлбар, тодруулга хийж тохиролцсон нөхцөлийг тус тус үндэслэн арбитрын хэлэлцээр хүчинтэй эсэхийг тогтоох нь илүү тохиромжтой байх магадлалтай. Иймээс арбитрын шийдвэрт тусгагдсан арбитрын хэлэлцээр хүчинтэй байх боломжтой. Өөрөөр хэлбэл, зөвхөн төлбөрийн гэрээний нөхцөлийг үндэслэн хэргийн харьяаллыг тогтоох замаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад маргаан үүсэх үндэслэл болсон гэрээг зайлшгүй харгалзан үзэх шаардлага бий болно. Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журмыг тохиролцох урьдчилсан хуралдаанд талууд арбитрын хэлэлцээр болон хэргийн харьяаллын талаар маргаагүй, мөн арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад уг асуудлын талаар арбитрын бүрэлдэхүүнд ямар нэгэн гомдол гаргаагүй гэх мэт процессоор дүгнэхэд талуудын хооронд байгуулсан арбитрын үндсэн гэрээгээр тохиролцсон нөхцөлийг баримталж арбитрын хэлэлцээр хүчинтэй, арбитрын харьяаллын маргаан хэмээн тогтоосон арбитрын шийдвэр нь хууль зүйн үндэслэлтэй боловч хэрэг хянан шийдвэрлэхдээ зөвхөн МҮХАҮТ-ын дэргэдэх арбитрын хэлэлцээр бүхий гэрээний маргааныг хянан шийдвэрлээд арбитрын хэлэлцээрийг БНХАУ-ын харьяаллаар тохиролцсон гэрээг баримтлахгүй байх ч шийдэл ажиглагдав. Түүнчлэн талуудын хооронд байгуулсан дээрх хоёр гэрээ нь маргаан хянан шийдвэрлэхэд харилцан хамаарал бүхий гэрээ болох тул цаг хугацааны хувьд, нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд, мөн логикийн хувьд ч үндсэн гэрээний нөхцөлөөр хэлэлцээрийг

хүчинтэйд тооцон арбитрын харьяаллын маргааныг тогтоох нь зохигчдын эрхийг хамгаалахад чиглэсэн хууль зүйн ач холбогдолтой алхам юм.

НИХДЗШШ "Арбитрт нэхэмжлэл гаргасан этгээд нь тухайн хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд гэж үзэхэд эргэлзээтэй байна, хэргийн баримтад тухайн этгээд нь нэхэмжлэгчийг төлөөлөх эрхтэйг нотлох баримт байхгүй байна, нэхэмжлэгчийг төлөөлөх эрхтэй этгээд арбитрт хандан нэхэмжлэл гаргасан гэх нөхцөл байдал тогтоогдоогүй тохиолдолд Арбитрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсэгт зааснаар тус арбитрын хэргийг шийдвэрлэхүйц хэлэлцээртэй гэж үзэх боломжгүй юм" гэж дүгнэн, Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.1.а-д "энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан арбитрын хэлэлцээрийн аль нэг тал эрх зүйн чадамжгүй..." гэсэн хэм хэмжээг үндэслэн, арбитрын шийдвэрийг хүчингүй болгосон шийдвэрийн үндэслэлд хууль зүйн дүгнэлт өгөх нь зохистой. Учир нь шүүхийн шийдвэрийн энэхүү дүгнэлтийн агуулгаас үзэхэд компанийг төлөөлөх эрх бүхий этгээд арбитрт нэхэмжлэл гаргасан эсэх асуудал тогтоогдохгүй байна гэсэн дүгнэлтэд үндэслэн арбитрын хэлэлцээрийг хүчин төгөлдөр бус гэж дүгнэн шийдвэрлэжээ. Шүүхийн шийдвэрийн үндэслэлд дүн шинжилгээ хийж үзэхэд "Арбитрт нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасныг арбитрын бүрэлдэхүүн сайтар тогтоохгүйгээр маргааныг шийдвэрлэсэн" гэсэн агуулга бүхий өргөдлийн шаардлагыг шүүх хянахдаа арбитрын хэлэлцээрийн нэг тал нь эрх зүйн чадамжгүй гэсэн үндэслэлээр шийдвэрлэсэн нь анхаарал татсан асуудал байв. Мөн өргөдөл гаргагч нь арбитрын хэлэлцээрийн хүчинтэй эсэхэд гомдол гаргаагүй байхад шүүх арбитрын хэлэлцээрийн талаарх асуудлыг шийдвэрийн үндэслэл болгон арбитрын шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн нь ИХШХШтХ-ийн 160[3].4-т буй "Шүүх Арбитрын тухай хуулийн 47.2-т заасан арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл байгаа эсэхийг талуудын өргөдлийн шаардлага болон татгалзлаа үндэслэж байгаа,

шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтыг шинжлэх замаар тогтоо-но" гэсэн хэм хэмжээнд үндэслэсэн гэж дүгнэх боломжтой хэдий ч хариуцагч талын гомдлын шаардлагад "Арбитрын хэлэлцээ-рийн нэг тал нь эрх зүйн чадамжгүй байсан" гэсэн шаардлага, татгалзал дурдагдаагүй байна, магадгүй, шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтаар шүүх үүнийг тогтоосон байхыг үгүйсгэхгүй. Гэвч Арбитрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д арбитрын хэлэлцээрийг "Арбитрын хэлэлцээр гэж гэрээний үндсэн дээр үүссэн эсэхээс үл хамааран бий болсон эрх зүйн харилцаатай холбоотойгоор талуудын хооронд үүссэн, эсхүл үүсэж болох али-ваа маргаан, эсхүл түүний тодорхой хэсгийг арбитрын журмаар шийдвэрлүүлэх тухай талуудын тохиролцоог хэлнэ" гэж хуульд томьёолон тодорхойлж хуульчилсан хэм хэмжээнд үндэслэн дүгнэвэл арбитрт нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд, арбитрын хэлэлцээр гэсэн хоёр ухагдахуун нь хууль зүйн агуулгаараа ял-гаатай болохыг илэрхийлж байна.

– Хариуцагчийн төлөөлөгч арбитрын хэлэлцээр хүчин төгөл-дөр мөн эсэхийг шинжлэн судлахгүйгээр арбитр хэргийг шийдвэрлэн үндсэн шийдвэр гаргасан гэх өргөдлийг хянах-даа арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Оюуны өмчийн газар, Улсын бүртгэлийн ерөнхий газраас лавлагаа гаргуулах хүсэлт гаргасан болохоос уг арбитрын хэлэлцээр хүчин төгөлдөр эсэх талаар тат-галзлаа гаргаагүй байна, харин маргааны үйл баримттай холбоотой гэрч асуулгах, шинжээч томилуулах хүсэлтүүд гаргаж байсан. Эдгээр үйл баримтаас харахад арбитрын хэлэлцээрийн хүчин төгөлдөр байдлын талаар арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргаж байгаагүй асуудлаар давж заалдах шатны шүүхээс дүгнэлт өгөх боломжгүй гэж шийдвэрлэжээ. Шүүхийн тогтоолын[12] хууль зүйн үндэслэлд дүн шинжилгээ хийж үзвэл нэг

[12] "А" ХХК-ийн нэхэмжлэлтэй арбитрын хэрэг. 2010/Ш2017/00463.

> талаас арбитрын хэлэлцээр хүчин төгөлдөр эсэх талаар татгалзлаа гаргаагүйг дүгнэсэн, нөгөө талаас арбитрын хэлэлцээрийн хүчин төгөлдөр байдлын талаар арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргаж байгаагүй асуудлаар давж заалдах шатны шүүхээс дүгнэлт өгөх боломжгүй гэж үзсэн нь хоёрдмол агуулга бүхий гэх үндэслэлтэй байна. Учир нь арбитрын хэлэлцээрийн талаар арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гомдлоо гаргаж байгаагүй гэж дүгнэсэн боловч энэ дүгнэлтээ үгүйсгэх байдлаар уг асуудлыг шүүх хянах боломжгүй гэжээ. Иймд шүүх арбитрын шийдвэрийг хэвээр үлдээх шийдвэрийн үндэслэлээ тодорхой илэрхийлэх нь чухал гэж үзэв.

ИХШХШтХ-д заасан үндэслэлээр өргөдлийн шаардлага болон татгалзалд үндэслэн хянах ёстой атал өргөдөлд дурдаагүй асуудалд хууль зүйн дүгнэлт өгсөн тохиолдол НИХДЗШШ-ийн тогтоолд байв. Тухайлбал, шүүх шийдвэрийнхээ үндэслэл хэсэгт “Хариуцагч тал зохигчдын тайлбарыг ИХШХШтХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2 дахь хэсэгт заасны дагуу үнэлээгүй ...” гэж дурдсан нь хариуцагч талын гомдолд дурдаагүй асуудлыг шийдвэрийн үндэслэл хэсэг болгосон гэж дүгнэв. Учир нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д “Шүүх хэргийн оролцогчийн гаргасан нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлнэ”, мөн хуулийн 40.2-т “Нотлох баримтыг тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлнэ” гэсэн хэм хэмжээ бий. Хуулийн энэхүү зохицуулалтын агуулга бол нотлох баримтыг шүүх үнэлэх талаарх зохицуулалт тул хариуцагч талын гомдолд уг асуудлыг хөндөөгүй, харин арбитрын ажиллагаанд талуудын тэгш эрхийг хангасан эсэхэд гомдол гаргасан байна. Өөрөөр хэлбэл, арбитрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д “Арбитрын

ажиллагаанд талууд тэгш эрхтэй оролцох ба талууд өөрийн байр суурийг илэрхийлэх боломжоор бүрэн хангагдана” гэж заасныг, мөн Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн 19 дүгээр зүйлд заасан үндэслэл журмыг баримталсан хэдий ч шүүх хариуцагч талын гомдлын энэ хэсэгт тодорхой бус дүгнэлт хийжээ гэх хууль зүйн үндэслэлтэй байна. Гэсэн хэдий ч уг гомдлын шаардлага нь Арбитрын тухай хуулийн 47-д заасан арбитрын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй юм.

НИХДЗШШ-ийн хууль хэрэглээнд дүн шинжилгээ хийхэд Монгол Улсад үйлчилж буй хуульд байхгүй зүйл шийдвэрийн-хээ тогтоох хэсгийн хууль зүйн үндэслэлд дурдсан хэд хэдэн тохиолдол байв. Тухайлбал:

– НИХДЗШШ-ийн тогтоол[13] агуулгын хувьд хууль зүйн үндэслэлтэй ч, "ИХШХШтХ-ийн 1604 зүйлийн 1604.3 дахь хэсэгт зааснаар" энэ тогтоол эцсийн шийдвэр болохыг дурдсан боловч ИХШХШтХ-д 1604 дүгээр зүйл гэж байхгүй тул шүүх хууль хэрэглээний асуудалд хайнга хандсан нь цаашид зайлшгүй анхаарах шаардлагатай асуудал мөн гэж үзэж байна.

– НИХДЗШШ-ийн тогтоолын[14] хянавал хэсэгт хариуцагчийн гаргасан хүсэлтэд нотлох баримт бүрдүүлэх асуудлыг тусгасан байх боловч энэ нь Арбитрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39,1 дэх хэсэгт заасан шүүхийн журмаар нотлох баримт гаргуулах үндэслэлд хамааралгүй байхын зэрэгцээ мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2-т “...арбитрын бүрэлдэхүүний бүрэн эрхэд аливаа нотлох баримтыг нотлох чадвартай, хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв эргэлзээгүй болохыг тодорхойлох эрх хамаарна” гэж заасан тул арбитрын бүрэлдэхүүн өөрөө хариуцагчийн

[13] “Н” ХХК-ийн нэхэмжлэлтэй арбитрын хэрэг. 82.

[14] “А” ХХК-ийн нэхэмжлэлтэй арбитрын хэрэг. 210ШТ2018/00065.

хүсэлтийг хангах эсэх асуудлыг шийдэх эрхтэй байна гэжээ. Гэвч Арбитрын тухай хуулийн 31 дүгээр зүйл нь 31.1, 31.2 гэсэн хоёр хэсэгтэй. Өөрөөр хэлбэл, хуульд 31.1.2 гэсэн заалт байхгүй.

ИХШХШтХ-ийн 160.1.2, мөн 160^4.2-т хуульчилсан шүүхийн "тогтоолд хуульд зааснаас гадна доор дурдсан зүйлийг тусгана", 160^4.2.2-т буй "маргаж байгаа шийдвэрийг гаргасан арбитрч буюу арбитрын бүрэлдэхүүн" гэсэн заалтыг баримтлаагүй дараах тогтоолууд байв. Үүнд:

- НИХДЗШШ-ийн 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн тогтоол;[15]
- НИХДЗШШ-ийн 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн тогтоол;[16]
- НИХДЗШШ-ийн 2017 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн тогтоол;[17]
- НИХДЗШШ-ийн 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн тогтоол.[18]
- НИХДЗШШ-ийн тогтоолд[19] хууль хэрэглээний хувьд ИХШХШтХ-ийн 160^2.2-т заасны дагуу өргөдөл гаргагчийн төлсөн улсын тэмдэгтийн хураамжийн талаар шийдвэрлээгүй;

НИХДЗШШ-ийн тогтоолд үг үсэг, техникийн алдаа цөөнгүй байгааг цаашид анхаарах шаардлагатай асуудлын нэг мөн гэж дүгнэв.

15 "Э" ХКК-ийн нэхэмжлэлтэй "М" ХХК-д холбогдох арбитрын хэрэг. 502.

16 "З"ХХК-ийн нэхэмжлэлтэй "Б" ХХК-д холбогдох арбитрын хэрэг. 66.

17 "А" ХХК-ийн нэхэмжлэлтэй "М" ХХК-д холбогдох арбитрын хэрэг. 210ШТ2017/00463.

18 "Н" ХХК-ийн нэхэмжлэлтэй "Г" ХХК-д холбогдох арбитрын хэрэг. 82.

19 "А" ХХК-ийн нэхэмжлэлтэй "Б" ХХК-д холбогдох арбитрын хэрэг, 210ШТ2018/00065

1.4. ЧАНАРЫН СУДАЛГААНЫ АСУУЛГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Дээр дурдсан гурван бүлэг судалгаанд үндэслэн чанарын судалгааны дараах асуултын хүрээнд дүгнэлт хийв. Үүнд:

– Зохигчид арбитрын үндсэн шийдвэрийн ямар зүйлд нь гомдолтой байж, НИХДЗШШ-д хандсан үндэслэл, шалтгаан нь юу вэ?

Хууль зүйн дүн шинжилгээ хийсэн 31 тогтоолын 70 гаруй хувьд нь хуульд заасан үндэслэлд хамааралгүй асуудлаар өргөдөл гаргасныг шүүх тогтоолдоо дурдсан байна. Харин 31 тогтоолын 16 тогтоол буюу 51.61 хувьд нь арбитрын шийдвэрийг хүчингүй болгож (Арбитрын 3 шийдвэрийн зарим хэсгийг, 13 шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгосон) шийдвэрлэсэн нь зохигчид хуульд заасан үндэслэлээр өргөдөл гаргасан гэх үндэслэлтэй байна. Зохигчид арбитрын үндсэн шийдвэрийн ямар зүйлд нь гомдолтой байсан талаар судалгааны 2.1-д нарийвчлан авч үзсэнтэй танилцана уу.

– Арбитрын үндсэн шийдвэр хүчингүй болсон шалтгаан, алдаа нь юу вэ? Уг асуултын хариултыг дүгнэхдээ арбитрын тухай хуулийн зүйл, заалт тус бүрээр судалж гаргавал:

1. Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.1.а-д “арбитрын хэлэлцээрийн аль нэг тал эрх зүйн чадамжгүй, эсхүл арбитрын хэлэлцээр нь талуудын тохиролцон сонгосон улсын хуульд зааснаар, эсхүл тийнхүү тохиролцон сонгоогүй бол Монгол Улсын хуульд зааснаар хүчин төгөлдөр бус” гэсэн хэм хэмжээг үндэслэл болгож арбитрын шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдол 1 байна.

2. Арбитрын тухай хуулийн 47.2.1.б-д “өргөдөл гаргагч талд арбитрч томилох, арбитрын ажиллагааны тухай зохих ёсоор мэдэгдээгүйн улмаас арбитрын ажиллагаанд зохих

ёсоор оролцох боломжгүй байсан" гэсэн хэм хэмжээг үндэслэл болгож арбитрын шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдол 2 байна.

3. Арбитрын тухай хуулийн 47.2.1.в-д "арбитрын бүрэлдэхүүн нэхэмжлэлийн шаардлагад тусгаагүй, хамааралгүй маргааны талаар үндсэн шийдвэр гаргасан. Хэрэв нэхэмжлэлийн шаардлагад тусгаагүй, хамааралгүй асуудлаар гаргасан арбитрын үндсэн шийдвэрийг нэхэмжлэлийн шаардлагад тусгасан асуудлаар гаргасан шийдвэрээс салгах боломжтой бол холбогдох хэсгийг хүчингүй болгоно" гэсэн хэм хэмжээг үндэслэл болгож арбитрын шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдол 5 байна.

4. Арбитрын тухай хуулийн 47.2.1.г-д "талуудын тохиролцоо нь энэ хуулийн заавал дагаж мөрдөх заалтыг зөрчсөнөөс бусад тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн, арбитрын ажиллагаа талуудын тохиролцоонд нийцээгүй, эсхүл тийнхүү тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн, арбитрын ажиллагаа нь энэ хуульд нийцээгүй" гэсэн хэм хэмжээг үндэслэл болгож арбитрын шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдол 5 байна.

5. Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.1.а болон 47.2.1.в заалтыг хамтад нь үндэслэн хүчингүй болгосон арбитрын үндсэн шийдвэр 1 байна.

6. Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.1-ийг үндэслэн хүчингүй болгосон арбитрын үндсэн шийдвэр 1 байна.

7. Өмнө үйлчилж байсан Арбитрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.5-ыг үндэслэн хүчингүй болгосон арбитрын үндсэн шийдвэр 1 байна.

Дээрх судалгааг нэгтгэн дүгнэвэл Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.1.в, 47.2.1.г-д заасан үндэслэлүүд арбитрын 10 шийдвэрийг хүчингүй болгох үндсэн шалтгаан, арбитрын шийдвэрийн алдаа болжээ.

– *Арбитрын бүрэлдэхүүн арбитрын урьдчилсан хуралдааны явцад зохигчдын эрхийг зөрчсөн үү?*

Арбитрын тухай хуулийн 47-д заасан зохицуулалт, зохигчдын өргөдөл дэх гомдлын агуулга, шүүхийн тогтоолыг харьцуулан судлахад арбитрын бүрэлдэхүүн арбитрын урьдчилсан хуралдааны явцад зохигчдын ямар нэгэн эрхийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдоогүй болно.

– *Арбитрын бүрэлдэхүүн арбитрын үндсэн хуралдааны явцад зохигчдын эрхийг зөрчсөн үү?*

Арбитрын тухай хуулийн 47-д заасан зохицуулалт, зохигчдын өргөдөл дэх гомдлын агуулга, шүүхийн тогтоолыг харьцуулан судлахад арбитрын бүрэлдэхүүн арбитрын үндсэн хуралдааны явцад зохигчдын ямар нэгэн эрхийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдоогүй болно.

– *Арбитрын урьдчилсан хуралдааны журам зөрчсөнөөс шалтгаалж арбитрын үндсэн шийдвэр хүчингүй болсон уу?*

Арбитрын тухай хуулийн 47-д заасан зохицуулалт, зохигчдын өргөдөл дэх гомдлын агуулга, шүүхийн тогтоолыг харьцуулан судлахад арбитрын урьдчилсан хуралдааны журам зөрчсөнөөс шалтгаалж арбитрын үндсэн шийдвэр хүчингүй болсон гэх 1 тохиолдол байв. Энэ нь хариуцагч тал хэрэг хянан шийдвэрлэх журамд гарын үсэг зураагүй байхад арбитрын үндсэн хуралдаан хийж арбитрын шийдвэр гаргасан хэмээн Арбитрын тухай хуулийн 47.2.1.г-д заасан үндэслэлээр талуудын тохиролцоонд нийцээгүй гэж үзэж НИХДЗШШ уг шийдвэрийг хүчингүй

болгожээ. Энэ асуудлыг цаашид хуулиар тодорхой болгох нь зүйтэй гэж үзэв.

– *Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зохигчдын эрхийг зөрчсөн үү?*

Арбитрын тухай хуулийн 47-д заасан зохицуулалт, зохигчдын өргөдөл дэх гомдлын агуулга, шүүхийн тогтоолыг харьцуулан судлахад арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зохигчдын эрхийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдоогүй болно.

– *НИХДЗШШ арбитрын үндсэн шийдвэрийн холбогдох хэсгийг болон бүхэлд нь хүчингүй болгож буй нийтлэг үндэслэл нь юу вэ?*

Судалгааны объектын хүрээнд НИХДЗШШ арбитрын үндсэн шийдвэрийн холбогдох хэсгийг болон уг шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгож шийдвэрлэсэн 16 тохиолдлын 3-т нь арбитрын үндсэн шийдвэрийн холбогдох хэсгийг, 13-т нь арбитрын шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгож шийдвэрлэсэн байна. НИХДЗШШ-ийн тогтоолын нийтлэг үндэслэл нь дараах тоон үзүүлэлттэй байна. Үүнд:

Арбитрын тухай хуулийн холбогдох заалт	Шийд-вэрийн тоо
47.2.1.а. энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан арбитрын хэлэлцээрийн аль нэг тал эрх зүйн чадамжгүй, эсхүл арбитрын хэлэлцээр нь талуудын тохиролцон сонгосон улсын хуульд зааснаар, эсхүл тийнхүү тохиролцон сонгоогүй бол Монгол Улсын хуульд зааснаар хүчин төгөлдөр бус;	1

47.2.1.б. өргөдөл гаргагч талд арбитрч томилох, арбитрын ажиллагааны тухай зохих ёсоор мэдэгдээгүйн улмаас арбитрын ажиллагаанд зохих ёсоор оролцох боломжгүй байсан;	2
47.2.1.в. арбитрын бүрэлдэхүүн нэхэмжлэлийн шаардлагад тусгаагүй, хамааралгүй маргааны талаар үндсэн шийдвэр гаргасан. Хэрэв нэхэмжлэлийн шаардлагад тусгаагүй, хамааралгүй асуудлаар гаргасан арбитрын үндсэн шийдвэрийг нэхэмжлэлийн шаардлагад тусгасан асуудлаар гаргасан шийдвэрээс салгах боломжтой бол холбогдох хэсгийг хүчингүй болгоно;	5
47.2.1.г. талуудын тохиролцоо нь энэ хуулийн заавал дагаж мөрдөх заалтыг зөрчсөнөөс бусад тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн, арбитрын ажиллагаа талуудын тохиролцоонд нийцээгүй, эсхүл тийнхүү тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн, арбитрын ажиллагаа нь энэ хуульд нийцээгүй.	5
47.2.1.а болон **47.2.1.в** заалт хамтдаа;	1
47.2.1;	1
Өмнө үйлчилж байсан арбитрын тухай хуулийн **40.2.5.** тухайн маргаан нь арбитрын харьяаллын маргаан биш болох нь нотлогдсон;	1

ХОЁР. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

2.1. АРБИТРЫН ҮНДСЭН ШИЙДВЭРИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТАЛААРХ ЮНСИТРАЛ-ЫН ОЛОН УЛСЫН АРИЛЖААНЫ АРБИТРЫН ЗАГВАР ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2006 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн А/61/453 тоот тогтоолд "Арбитрын ажиллагааны хууль болон олон улсын арилжааны арбитрын ажиллагааны хэрэгцээ, шаардлагыг ижилтгэх зорилгоор Загвар хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулсан зүйл, заалтыг, эсхүл нэмэлт, өөрчлөлт орсон Загвар хуулийг бүхэлд нь нутагшуулан батлах талаар бүх гишүүн улс анхаарлаа хандуулах, үндэсний хууль батлах, эсхүл шинэчлэн батлах" тухай заасныг үндэслэл болгон Монгол Улс 2017 онд ЮНСИТРАЛ-ын загвар хуульд нийцүүлэн Арбитрын тухай хуулийг шинэчлэн найруулж баталсан билээ. Үүний үндсэн зорилго нь, дээр дурдсанчлан, Загвар хуулийн үндсэн үзэл баримтлалыг үндэсний хуульдаа нутагшуулан тусгасан улсуудын нэрийн жагсаалтад бүртгүүлэх асуудал байсан ба уг зорилгодоо хүрсэн[20] гэж үзэж болохоор байна.

ЮНСИТРАЛ-ын Олон улсын арилжааны арбитрын загвар хуулийн 34 дүгээр зүйлд шүүхэд хандах замаар, нотлох баримт

[20] https://uncitral.un.org/en/texts/arbitration/modellaw/commercial_arbitration/status

бүхий үндэслэлээр арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах өргөдөл гаргах, мөн шүүх хүчингүй болгох асуудлыг тогтоох талаар тусгажээ.

I. Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах өргөдлийн агуулга, үндэслэлийг дараах байдлаар заасан байна. Үүнд:
   - 7 дугаар зүйлд зааснаар арбитрын хэлэлцээр байгуулсан аль нэг тал эрх зүйн чадамжгүй, эсвэл арбитрын хэлэлцээр нь талуудын гэрээгээр тохиролцсон улсын хууль буюу ийм тохиролцоогүй бол тухайн улсын хуулиар хүчин төгөлдөр бус;
   - Арбитрч томилох, арбитрт хэрэг хянан хэлэлцэх ажиллагааны тухай мэдэгдээгүй, эсхүл бусад шалтгаанаар өөрийн тайлбарыг гаргаж чадаагүй;
   - Арбитрын хэлэлцээрт тусгагдаагүй, эсвэл арбитрын хэлэлцээрээс гадуурх асуудлаар тогтоол гаргасан;
   - Арбитрын хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүнийг томилох болон хэрэг шийдвэрлэх журам талуудын тохиролцсоноос өөрөөр тогтоогдсон. Харин талуудын тохиролцоо нь энэ хуулийн талуудын татгалзах эрхгүй аливаа журамтай зөрчилдсөн буюу энэ хуулийн алив журмыг зөрчсөн бол энэ заалт хамаарахгүй гэсэн үндэслэлүүд багтсан ажээ.

II. Шүүх дараах байдлыг тогтоосон бол арбитрын шийдвэрийг хүчингүй болгохоор заасан байна. Үүнд:
   - Тухайн улсын хуулиар маргааны зүйл нь арбитрын хэрэг хянан хэлэлцэх ажиллагааны зүйл биш;
   - Арбитрын шийдвэр тухайн улсын нийтлэг журамд нийцээгүй;
   - Талууд шийдвэр хүлээн авснаас хойш гурван сар өнгөрсөн бол арбитрын шийдвэрт гомдол гаргах эрхгүй. Хэрэв хүсэлтийг 33 дугаар зүйлийн дагуу гаргасан бол арбитрын

бүрэлдэхүүн хүсэлтийг шийдвэрлэснээс хойш гурван сар өнгөрсөн бол арбитрын шийдвэрт гомдол гаргах эрхгүй;

– Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулахаар шүүхэд хандсан үед хэрэв шүүх боломжтой гэж үзсэн, эсвэл аль нэг тал хүссэн бол арбитрт хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг сэргээн явуулах боломж олгох, арбитрын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэлийг арилгах арга хэмжээ авахаар арбитр санал гаргасан бол шүүх шийдвэр гаргахаар тогтоосон хугацааг түдгэлзүүлж болно гэжээ.

Хүчин төгөлдөр үйлчилж буй Арбитрын тухай хуульд өмнө үйлчилж байсан хуулийн (2003 оны Арбитрын тухай хуулийн) зохицуулалтын дэвшилтэт зохицуулалтыг хэвээр үлдээж, 2006 онд нэмэлт, өөрчлөлт орсон загвар хуульд үндэслэн түүнийг боловсруулж, даган мөрдөж буй гэх боловч дээрх зохицуулалтыг үндэсний хуульд шууд хуулбарлах байдлаар хуульчилснаар арбитрын үндсэн шийдвэрийг шүүх хүчингүй болгоход уг хэм хэмжээг хэрэглэхэд хүндрэлтэй байгаагаас шалтгаалан арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тохиолдол ихсэх хандлагатай байна гэж үзэв. Өөрөөр хэлбэл, уг загвар хуулийн үндсэн үзэл баримтлалыг үндэсний хуульд тусгах боломжтой хэдий ч арбитрын шийдвэрийг шүүх хүчингүй болгох зохицуулалтыг үндэсний арбитраар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогт нийцүүлэн хуульчлах практикийн хэрэгцээ шаардлага байна гэж дүгнэлээ. Судалгааны 2.3 дахь хэсэгт Арбитрын тухай хуулийн арбитрын үндсэн шийдвэрийг шүүх хүчингүй болгохтой холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулсан болно.

2.2. АРБИТРЫН ҮНДСЭН ШИЙДВЭРИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУРШЛАГА

Арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгохтой холбогдох харилцааг хэрхэн хуульчлан зохицуулсан талаарх гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалтын туршлагыг харьцуулан судлахдаа судалгаанд хамрагдах улсуудыг дараах үндэслэлээр сонгосон болно. Үүнд:

1. НҮБ-ын Олон улсын худалдааны эрхийн комисс (ЮНСИТРАЛ)-ын Олон улсын арилжааны арбитрын загвар хуулийн үндсэн үзэл баримтлалыг үндэсний хууль тогтоомждоо тусган мөрдөж буй 85 улс жагсаалтад[21] багтсан (Монгол Улс 2017 онд уг жагсаалтад багтан хүлээн зөвшөөрөгдсөн) ба эдгээр орноос ХБНГУ, ОХУ, Япон гэсэн гурван улсыг сонгож, арбитрын тухай хуулийнх нь холбогдох зохицуулалтуудыг харьцуулан судалж, хууль зүйн дүгнэлт хийв.
2. Дээр дурдсан жагсаалтад багтаагүй боловч арбитраар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар олон улсад нэр хүндтэй, хүлээн зөвшөөрөгдсөн, сайн туршлага бүхий орнуудаас Швед, БНХАУ /Дурдсан жагсаалтад энэ улсын нэр багтсан боловч хэдэн онд зөвшөөрсөн гэдэг хугацаа нь байдаггүй тул анхаарал татсан гэж хэлж болно/-ыг сонгож, эдгээр орны арбитрын тухай хуулийн холбогдох зохицуулалтыг харьцуулан судалж, хууль зүйн дүгнэлт хийлээ.

[21] https://uncitral.un.org/en/texts/arbitration/modellaw/commercial_arbitration/status

2.2.1. ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалтын туршлага

ХБНГУ-ын арбитрын тухай актын "Арбитрын шийдвэрийн талаар өргөдөл гаргах" гэсэн нэртэй 7 дугаар бүлгийн 1059 дүгээр хэсэг дэх талууд арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулахтай холбогдох харилцааг зохицуулсан[22] эрх зүйн зохицуулалтыг судлахад дараах зохицуулалттай байна:

(1) Арбитрын шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ хэсгийн 2, 3 дугаар дэд хэсэгт заасны дагуу арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдлөө шүүхэд гаргаж болно.

(2) Арбитрын шийдвэрийг зөвхөн дараах тохиолдолд хүчингүй болгож болно:

1. Өргөдөл гаргагч нь дараах үндэслэл бүхий шалтгааныг нотолсон бол:

   а) энэ хэсгийн 1029 ба 1031-д заасан арбитрын хэлэлцээрт оролцогч тал нь тэдгээрийн хүчин төгөлдөр хуульд заасны дагуу эрх зүйн чадамжгүй, эсхүл арбитрын хэлэлцээр хуульд зааснаар хүчин төгөлдөр бус, эсвэл Германы хууль тогтоомжийн дагуу хүчин төгөлдөр бус бол;

   б) түүнд арбитрчийг томилох, эсхүл арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар зохих ёсоор мэдэгдээгүй, эсхүл ямар нэгэн байдлаар өөрийн хэргийг танилцуулах боломжгүй болсон;

   в) нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд маргааныг шийдвэрлээгүй шийдвэр гаргасан, нэхэмжлэлд дурдагдаагүй асуудлаар шийдвэр гаргасан, хэрэв нэхэмжлэлийн

[22] German Arbitration Act The following provisions of the Arbitral Proceedings Reform Act have entered into force on 1 January 1998. Subsequent amendments, i.a. by the Civil Procedure Reform Act of 27 Jul. 2001 and the Law of Contracts Reform Act of 26 Nov. 2001 have been incorporated. Article 1, No. 7 of the Arbitral Proceedings Reform Act, Chapter VII, Recourse against award, Section 1059.

шаардлагад хамааралгүй, тусгаагүй асуудлаар шийдвэрлэсэн арбитрын шийдвэрийг нэхэмжлэлийн шаардлагад тусгасан асуудал бүхий бусад хэсгээс нь салгах боломжтой бол зөвхөн нэхэмжлэлийн шаардлагад тусгагдаагүй асуудал шийдвэрлэсэн хэсгийг нь хүчингүй болгоно;

г) арбитрын хуралдаан, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь энэхүү хуулийн нөхцөл, журамд заагаагүй байсан буюу талуудын хэлэлцэн тохиролцсон хэлэлцээрт нийцээгүй байсан нь шийдвэрт нөлөөлсөн бол.

2. Шүүх дараах байдлыг тогтоосон бол:

а) тухайн маргаан нь Германы хуулийн дагуу арбитрын журмаар шийдвэрлэх харьяаллын маргаан бус;

б) арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхэд нийтийн хэв журамтай (ordre public) зөрчилдөхөөр бол.

(3) Хэрэв талууд өөрөөр тохиролцоогүй бол шүүхэд хандах өргөдлийг гурван сарын хугацаа өнгөрсний дараа гаргаж болохгүй. Өргөдөл гаргах хугацаа нь өргөдөл гаргагч арбитрын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс эхэлнэ. Хэрэв 1058 дугаар хэсэгт буй хүсэлт гаргасан бол уг хүсэлтийг шийдвэрлэсэн шийдвэрийг хүлээн авснаас хойш нэг сараас илүүгүй хугацаагаар сунгана. Германы шүүхээс уг шийдвэрийг албадан гүйцэтгэхийг мэдэгдсэний дараа арбитрын энэ шийдвэрийг хүчингүй болгох өргөдөл гаргах эрхгүй.

(4) Шүүхээс арбитрын шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдолд арбитрын уг шийдвэрийг хүчингүй болгосон талаар арбитрын шүүхэд мэдэгдэж шилжүүлнэ.

(5) Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох эсрэг заалт байхгүй тохиолдолд арбитрын хэлэлцээрийн дагуу маргааныг дахин авч хэлэлцэнэ.

ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалтын туршлага судалсны дүгнэлт

– Арбитрын шийдвэрийг шүүхэд хандаж хүчингүй болгуулахдаа өргөдөл гаргагч нь хэлэлцээрт оролцогч тал эрх зүйн чадамжгүй, эсхүл арбитрын хэлэлцээр талуудын хуульд зааснаар хүчин төгөлдөр бус, эсвэл Германы хууль тогтоомжийн дагуу хүчин төгөлдөр бус болсон, арбитрчийг томилох, эсхүл арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар зохих ёсоор мэдэгдээгүй, эсхүл ямар нэгэн байдлаар арбитрын ажиллагаанд оролцох боломжгүй болсон, нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд маргааныг шийдвэрлээгүй шийдвэр гаргасан, нэхэмжлэлд дурдагдаагүй асуудлаар шийдвэр гаргасан, нэхэмжлэлийн шаардлагад хамааралгүй, тусгаагүй асуудлаар шийдвэр гаргасан, арбитрын хуралдаан, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь энэхүү хуульд заасан нөхцөл, журамд нийцээгүй байсан нь шийдвэрт нөлөөлсөн гэсэн нөхцөл байдлуудыг нотлох үүрэгтэй байхаар хуульчилжээ.

– Шүүх уг маргаан нь харьяаллын бус, арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхэд нийтийн хэв журамтай (ordre public) зөрчилдөх шинжтэй гэдгийг тогтоосон тохиолдолд арбитрын шийдвэрийг хүчингүй болгохыг хуульчилсан ба өргөдлийг арбитрын шийдвэр хүлээн авсан өдрөөс хойш гурван сарын дотор хүлээн авч шийдвэрлэх, шүүхээс арбитрын шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдолд арбитрын уг шийдвэрийг хүчингүй болгосон талаар арбитрын шүүхэд мэдэгдэх, хүчингүй болгосон шүүхийн шийдвэрт үндэслэн арбитрын маргааныг дахин авч хэлэлцэх асуудлыг хамтад нь хуульчилсан байна. Эдгээр зохицуулалтын агуулга нь Монгол Улсын арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлтэй төсөөтэй боловч арбитрын шийдвэр хүчингүй болсон нөхцөлд уг маргааныг дахин хянан хэлэлцэх асуудлыг давхар зохицуулснаараа онцлог ажээ.

2.2.2. ОХУ-ын эрх зүйн зохицуулалтын туршлага

ОХУ 1993 онд Олон улсын худалдааны арбитрын тухай хууль батлан, 2015 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, даган мөрдөж байна. Уг хуулийн "Арбитрын шийдвэрийн талаар өргөдөл гаргах" гэсэн нэртэй 7 дугаар хэсгийн "Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай өргөдөл гаргах" хэмээх 34 дүгээр зүйлд талууд арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулахтай холбогдох харилцааг зохицуулсан[23] байна. Үүнд:

1. Арбитрын шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ зүйлийн 2 ба 3 дахь заалтад заасны дагуу арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах өргөдлөө шүүхэд гаргана. Хэрэв талуудын арбитрын хэлэлцээрт байнгын арбитрын байгууллагаар маргаанаа шийдвэрлүүлэхээр заасан бол талууд шийдвэр эцсийнх байх талаар зааж болно. Энэхүү эцсийн шийдвэрийг хүчингүй болгуулах боломжгүй. Хэрэв арбитрын хэлэлцээрт "шийдвэр эцсийнх байна" гэж заагаагүй бол ийм шийдвэрийг энэ зүйлийн 2-т заасан үндэслэлээр шүүх хүчингүй болгож болно, арбитрын шийдвэрийг хүчингүй болгохдоо энэ зүйлийн 2-ын 2 дахь дэд хэсэгт заасан үндэслэлээр хүчингүй болгоно, энэ тохиолдолд өргөдөл гаргасан тал арбитрын шийдвэрийг хүчингүй болгосонд гомдол гаргах боломжгүй.
2. Шүүх арбитрын шийдвэрийг зөвхөн дараах тохиолдолд хүчингүй болгож болно:
   а) шийдвэрийг хүчингүй болгуулахаар өргөдөл гаргагч тал өргөдлийн шаардлагаа нотлох тохиолдол: 7 дугаар зүйлд зааснаар арбитрын хэлэлцээрт оролцогч тал нь эрх зүйн чадамжгүй байсан; эсхүл хэлэлцээр нь хүчин төгөлдөр бус, эсвэл ОХУ-ын хууль тогтоомжийн дагуу хүчин төгөлдөр бус бол; арбитрчийг томилох, арбитрын хуралдаан

[23] Russian federation law on international commercial arbitration, The law no 5338-1 in force since July 7, 1993 as amended on December 3, 2008; December 29, 2015, Section vii. Recourse against award, Article 34.

болох газар, хугацаа, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар зохих ёсоор мэдэгдээгүй, эсхүл хүндэтгэн үзэх ямар нэгэн шалтгаанаар хэргийн талаар танилцуулах боломж олгоогүй, эсхүл арбитрын хэлэлцээрт тусгаагүй өөр маргааныг шийдвэрлэн шийдвэр гаргасан, арбитрын хэлэлцээрт хамааралгүй асуудлаар шийдвэр гаргасан, арбитрын хэлэлцээрт хамааралгүй, тусгаагүй асуудлаар шийдвэрийн агуулга нь гарсан бол шийдвэрийг хүчингүй болгож болно;

б) шүүх дараах нөхцөл байдлыг тогтоосон бол: Холбооны хууль тогтоомжид заасны дагуу арбитрын харьяаллын маргаан биш бол, шийдвэр нь ОХУ-ын нийтлэг ашиг сонирхолтой зөрчилдөхөөр бол.

3. Шийдвэрийг эс зөвшөөрч өргөдөл гаргах тал шийдвэр хүлээн авсан өдрөөс хойш гурван сарын дараа шийдвэрийг хүчингүй болгуулах өргөдөл гаргах, хэрэв 33 дугаар зүйлийн дагуу хүсэлт гаргасан бол уг хүсэлтийг гаргасан өдрөөс хойш;

4. Энэ зүйлийн 2 дугаар зүйлийн 1 дэх дэд хэсэгт заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрийг хүчингүй болгуулах тухай аль нэг тал хүсэлт гаргасан бөгөөд арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах өргөдөл хүлээн авсан шүүх боломжтой гэж үзвэл арбитрын ажиллагааг сэргээж, арбитрын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэлийг арилгах боломжийг арбитрын бүрэлдэхүүнд олгох зорилгоор арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай өргөдлийг хянан шийдвэрлэх ажиллагааг тодорхой хугацаа тогтоон түдгэлзүүлж болно.

ОХУ-ын эрх зүйн зохицуулалтын туршлага судалсны дүгнэлт

– Талуудын арбитрын хэлэлцээрт байнгын арбитраар маргааныг шийдвэрлүүлэхээр тохиролцож, уг хэлэлцээрт “Арбит-

рын шийдвэр эцсийнх байна” хэмээн тохиролцсон тохиолдолд арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах боломжгүй гэж хуульчилснаараа өвөрмөц онцлогтой байна. Энэ нь талууд болон арбитрын ажиллагааг хөнгөвчлөх, арбитрт итгэх итгэл үнэмшилтэй байх дэвшилтэт зохицуулалт байх тул Монгол Улсад туршлага болгох ач холбогдол бүхий хэм хэмжээ гэж дүгнэв.

– Өргөдөл гаргагч тал арбитрын хэлэлцээрт оролцогч тал нь эрх зүйн чадамжгүй байсан, мөн хэлэлцээр нь хуулийн дагуу хүчин төгөлдөр бус, эсвэл ОХУ-ын хууль тогтоомжийн дагуу хүчин төгөлдөр бус бол; арбитрчийг томилох, арбитрын хуралдаан болох газар, хугацаа, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар зохих ёсоор мэдэгдээгүй, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаанаар хэргийн талаар танилцуулах боломж олгоогүй, арбитрын хэлэлцээрт хамааралгүй асуудлаар шийдвэр гаргасан гэх мэт үндэслэлүүдийг нотлох үүрэгтэй ба шүүх Холбооны хууль тогтоомжид заасны дагуу арбитрын харьяаллын маргаан биш бол, мөн арбитрын шийдвэр нь ОХУ-ын нийтлэг ашиг сонирхолтой зөрчилдөх нөхцөл байдлыг тогтоосон бол арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгох зохицуулалттай байна. Энэ зохицуулалтын агуулга нь ЮНСИТРАЛ-ын загвар хуулийн зохицуулалтын агуулгатай үндсэндээ төсөөтэй байна.

2.2.3. Япон Улсын эрх зүйн зохицуулалтын туршлага

Япон Улс 2003 онд арбитрын акт батлан өнөөг хүртэл даган мөрдөж байна. Уг хуулийн “Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай” гэсэн нэртэй 7 дугаар бүлгийн 44 дүгээр зүйл дэх талууд арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулахтай холбогдох харилцааг зохицуулсан[24] эрх зүйн зохицуулалтын талаар судлав.

[24] Arbitration act, Act No. 138 of August 1, 2003, Chapter VII Setting Aside of Arbitral Award, Article 44.

VII бүлэг. Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай 44 дүгээр зүйл.

(1) Дараах үндэслэлүүдийн аль нэг нь байгаа бол талууд арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах хүсэлтээ шүүхэд гаргаж болно:

(i) талуудын эрх зүйн хязгаарлагдмал чадамжаас хамаарч арбитрын хэлэлцээр хүчин төгөлдөр бус;

(ii) арбитрын хэлэлцээрт хэрэглэх ёстой гэж талуудын тохиролцсон хууль, тогтоомжийн дагуу талуудын эрх зүйн хязгаарлагдмал чадамжаас бусад үндэслэлээр арбитрын хэлэлцээр хүчин төгөлдөр бус (хэрэв энэ нэр томьёог Японы хууль тогтоомжид хэрэглээгүй нөхцөлд);

(iii) арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд, эсхүл арбитрчийг томилох ажиллагаанд өргөдөл гаргагч нь Японы хууль тогтоомжийн дагуу шаардлагатай мэдээллийг хүлээн аваагүй (хэрэв талууд хэлэлцээр, хууль тогтоомжид заасан нийтийн хэв журамтай холбоогүй нөхцөлийн талаар хэлэлцээртэй бол);

(iv) өргөдөл гаргагч нь арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож чадаагүй;

(v) арбитрын хэлэлцээрт хамааралгүй асуудлаар арбитрын шийдвэр гарсан, эсхүл арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүсэлт гаргасан;

(vi) арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон арбитрын хуралдааны явцад бүрэлдэхүүн Японы хууль тогтоомжийг зөрчсөн (хэрэв талууд хэлэлцээр, хууль тогтоомжид заасан нийтийн хэв журамтай холбоогүй нөхцөлийн талаар хэлэлцээртэй бол);

(vii) арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гаргасан өргөдөл нь Японы хууль тогтоомжийн дагуу арбитрын хэлэлцээрт хамааралгүй маргаантай холбоотой;

(viii) арбитрын шүүхийн агуулга нь Японы нийтийн ашиг сонирхлыг зөрчихөөр бол.

(2) Арбитрын бичгээр гаргасан шийдвэрийн хуулбарыг гардан авсан үеэс эхлэн гурван сарын дотор өргөдөл гаргах ба (41 дүгээр зүйлд заасан нөхцөл, журмын дагуу арбитрын хуралдааны бичгээр гаргасан шийдвэрийг хамруулна) эсхүл 46 дугаар зүйлд зааснаар гүйцэтгэхээр бол.

(3) (1) дэх хэсэгт заасан өргөдөл нь шүүхийн харьяаллын дагуу байх бөгөөд шүүх өргөдлийг өөрийн эрх хэмжээний дагуу өөр шүүхийн харьяалалтай бол шилжүүлж болно.

(4) 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг буюу өмнөх хэсгийн (1) дэх хэсэгт заасан нөхцөл, журмын дагуу шийдвэрийг эс зөвшөөрч, өргөдөлд холбогдох асуудлаар давж заалдах гомдол гаргаж болно.

(5) Шүүх (1) дэх хэсэгт заасан өргөдлийн талаар талуудад амаар хариу өгч, эсхүл шүүх хуралдаан хийлгүйгээр шийдвэр гаргаж болохгүй.

(6) (1) дэх хэсэгт заасны дагуу өргөдөл гаргасан бол шүүх ((i) - (vi) дахь хэсэгт заасан үндэслэлээр өргөдөл гаргагч ийм үндэслэл байгааг нотолсон тохиолдолд зөвхөн) арбитрын шийдвэрийг хүчингүй болгож болно.

(7) (1) дэх хэсэгт заасан үндэслэл, (v) заалт байгаа бөгөөд тухайн зүйлд заасан асуудлаар хамааралтай хэсгийг арбитрын шийдвэрийн бусад хэсгээс салгаж болохоор бол арбитрын шийдвэрийн тэр хэсгийг шүүх хүчингүй болгоно.

(8) (1) дэх хэсэгт заасан өргөдлийн талаар гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл давж заалдах гомдол гаргаж болно.

Япон Улсын эрх зүйн зохицуулалтын туршлага судалсны дүгнэлт

– Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах хүсэлт гаргагч нь шүүхэд хандах, шүүх нь харьяаллын бус бол харьяаллын дагуу хэлэлцэх шүүхэд хүсэлтийг шилжүүлэх, тухайн шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл давж заалдах шатны шүүхэд хандахаар хуульчилснаараа талуудад хүндрэл учруулахуйц шат дамжлагатай байхаар зохицуулсан нь тухайн орны онцлогтой холбоотой байж болох юм. Харин хүсэлт гаргагч арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах үндэслэл, шүүх түүнийг хүчингүйд тооцох үндэслэл, журам нь Монгол Улс болон судалсан орнуудын зохицуулалттай төсөөтэй байна.

2.2.4. БНХАУ-ын эрх зүйн зохицуулалтын туршлага

БНХАУ 1995 онд Арбитрын тухай хууль батлан өнөөг хүртэл даган мөрдөж байна. Уг хуулийн “Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах өргөдөл гаргах тухай” гэсэн нэртэй 5 дугаар бүлгийн 58-61 дэх зүйлүүдэд талууд арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулахтай холбогдох харилцааг зохицуулсан[25] эрх зүйн зохицуулалттай байна.

58 дугаар зүйл.
Дараах нөхцөл байдлыг нотлох баримтаар нотлох тохиолдолд арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулахаар шүүхэд хандана:

(1) арбитрын хэлэлцээр байхгүй;

[25] Arbitration Law of the People's Republic of China, Chapter V Application for Setting Aside Arbitration Award, Article 58.

(2) арбитрын хэлэлцээрт хамааралгүй асуудлаар арбитрын шийдвэр гаргасан, эсхүл арбитрын комиссын бүрэлдэхүүн бүрэн эрхээ хэтрүүлсэн;

(3) арбитрын хуралдаан ба арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь арбитрын хэрэг шийдвэрлэх журмын дагуу явагдаагүй, хууль тогтоомжид нийцээгүй;

(4) шийдвэр дэх нотлох баримтыг хуурамчаар үйлдсэн;

(5) нөгөө тал нь арбитрт нөлөөлөхүйц хангалттай нотлох баримтыг нуун дарагдуулсан;

(6) арбитрчид хэргийг шийдвэрлэхдээ бусдын эд хөрөнгийг завшсан, хувийн ашиг сонирхлыг хангах үүднээс хууль зөрчсөн. Хэрэв Ардын шүүхээс албан ёсоор байгуулсан бүрэлдэхүүн өмнө дурдсан нөхцөл байдал тогтоогдож байна гэж үзвэл Ардын шүүх арбитрын шийдвэрийг хүчингүй болгоно. Хэрэв Ардын шүүх арбитрын шийдвэр нь нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл шийдвэрийг хүчингүй болгох шийдвэр гаргана.

59 дүгээр зүйл.
Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдөл гаргахыг хүссэн тал шийдвэр хүлээн авснаас хойш зургаан сарын дотор ийм өргөдөл гаргана.

60 дугаар зүйл.
Ардын шүүх арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай өргөдөл хүлээн авснаас хойш хоёр сарын дотор шийдвэрийг хүчингүй болгох, эсхүл татгалзах шийдвэр гаргана.

61 дүгээр зүйл.
Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох өргөдөл хүлээн авсны дараа Ардын шүүх хэргийг арбитрын журмаар дахин хэлэлцүүлж болно гэж үзвэл тодорхой хугацааны дотор арбитрын

шийдвэрийг хүчингүй болгох эсэх асуудлыг дахин хянан шийдвэрлэхээ мэдэгдэнэ. Тохиргоог хойшлуулах журмыг хэвээр үлдээх ёстой. Хэрэв арбитр хэргийг дахин хянан хэлэлцэхээс татгалзвал Ардын шүүх хэрэг шийдвэрлэх журмыг хойшлуулах шийдвэр гаргана.

БНХАУ-ын эрх зүйн зохицуулалтын туршлага судалсны дүгнэлт

– Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулахаар хандаж буй тал нь арбитрын хэлэлцээр байхгүй, арбитрын хэлэлцээрт хамааралгүй асуудлаар арбитрын шийдвэр гаргасан, эсхүл арбитрын комиссын бүрэлдэхүүн бүрэн эрхээ хэтрүүлсэн, арбитрын хуралдаан ба ажиллагаа нь арбитрын хэрэг шийдвэрлэх журмын дагуу явагдаагүй, хууль тогтоомжид нийцээгүй, шийдвэр дэх нотлох баримтыг хуурамчаар үйлдсэн, нөгөө тал нь арбитрт нөлөөлөхүйц хангалттай нотлох баримтыг нуун дарагдуулсан, эсхүл арбитрчид хэргийг шийдвэрлэхдээ бусдын эд хөрөнгийг завшсан, хувийн ашиг сонирхлоо хангах үүднээс хууль зөрчсөн гэх үндэслэлээ нотлох тохиолдолд Ардын шүүхээс албан ёсоор байгуулсан бүрэлдэхүүн дээрх нөхцөл байдал тогтоогдож байна гэж үзвэл, мөн арбитрын шийдвэр нь нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл Ардын шүүхээс арбитрын шийдвэрийг хүчингүй болгох талаар хуульчилжээ. Эрх зүйн энэхүү зохицуулалтын онцлог нь нотлох баримт хуурамчаар үйлдсэн, нотлох баримтыг арбитрт зориуд ирүүлээгүй, арбитрын бүрэлдэхүүн ашиг сонирхлын зөрчилтэй, авлигын шинжтэй байдлаар маргааныг шийдвэрлэн шийдвэр гаргасан асуудлыг нотолсон нөхцөлд арбитрын шийдвэрийг хүчингүй болгох талаар хуульчилсан онцлогтой байна. Энэ нь ЮНСИТРАЛ-ын загвар хуульд байхгүй ба БНХАУ арбитрын тухай үндэсний хуульдаа өөрийн орны онцлогийг тусгаж хуульчилсан дэвшилтэт зохицуулалттай байна. Үүнийг Монгол Улсад туршлага болгон

Арбитрын тухай хуульд тусгаж болохоор хэм хэмжээ байна гэж дүгнэв.

2.2.5. Швед Улсын эрх зүйн зохицуулалтын туршлага

Швед Улс 1999 онд Арбитрын тухай хууль батлан өнөөг хүртэл даган мөрдөж байна. Уг хуулийн "Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох ба шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх" гэсэн нэртэй 33-36 дахь зүйлүүдэд талууд арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулахтай холбогдох харилцааг доор дурдсанаар зохицуулжээ:[26]

Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох ба шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх

33 дугаар зүйл.

Арбитрын шийдвэрийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:

1. Швед Улсын хуулийн дагуу арбитраар шийдвэрлүүлэх маргаан биш бол;
2. Арбитраас гаргасан шийдвэр нь Швед Улсын үндсэн хуультай зөрчилдөж байгаа бол;
3. Энэ хуулийн 31 дүгээр зүйлд заасан арбитрын шийдвэр бичгээр байх ба түүнд арбитрчид гарын үсэг зурна гэсэн шаардлага хангаагүй бол зэрэг болно. Шийдвэрийг хэсэгчлэн хүчингүй болгож болно.

34 дүгээр зүйл.

Энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан нөхцөл байхгүй бол аль нэг талын гаргасан хүсэлтийн дагуу шийдвэрийн биелэлтийг бүхэлд нь болон хэсэгчлэн түдгэлзүүлж болно.

[26] The Swedish Arbitration Act (SFS 1999:116).

1. Талуудын хооронд байгуулсан арбитрын хэлэлцээр хүчин төгөлдөр бус;
2. Арбитрын ажиллагаа нь талуудын тогтоосон хугацаанаас хэтэрсэн, эсхүл арбитрын бүрэлдэхүүн эрх хэмжээгээ хэтрүүлсэн;
3. Энэ хуулийн 47 дугаар зүйлд зааснаар арбитрын ажиллагааг Швед Улсад явуулж болохгүй нөхцөл байдал бий болсон;
4. Талуудын хооронд байгуулсан гэрээ болон хуульд заасан шаардлагыг зөрчиж арбитрчийг томилсон;
5. Энэ хуулийн 6, 7 болон 8 дугаар зүйлд заасны дагуу арбитрчийг татгалзан гаргасан, эсхүл 6. Аль нэг талын буруутай үйл ажиллагаанаас хамааралгүйгээр арбитрын шийдвэрт нөлөөлөх, арбитрын ажиллагааг тасалдуулах зэрэг болно.

Маргааны зүйлийг тодорхойлох, арбитрчийг томилох эрхийг аль нэг талд дангаар нь олгохгүй. Энэ хуулийн 10, 11 дүгээр зүйлд заасны дагуу аль нэг тал нь энэ хуулийн 8 дугаар зүйлийг үндэслэн 5 дугаар зүйлийн эхний доголд зааснаар эрхээ алдаж болно.

Энэ хуулийн 32 дугаар зүйлд зааснаар шийдвэрт нэмэлт, засвар оруулсныг хүлээн авснаас хойш гурван сар, мөн талууд шийдвэрийг хүлээн авснаас хойш гурван сарын дотор ямар нэгэн нэмэлт, засвар, тайлбар оруулаагүй бол шийдвэр эцсийн байдлаар хүчин төгөлдөр болно.

35 дугаар зүйл.
Арбитр нь арбитрын шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгохоос урьдчилан сэргийлэхийн тулд арбитрын ажиллагааны явцыг хянах ба эсхүл тохиромжтой арга хэмжээ авах үүднээс арбитрын шийдвэрийг түдгэлзүүлж, хүчингүй болгож болно.

1. Шүүх нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авах нь зүйтэй гэж үзсэн бөгөөд аль нэг талаас түдгэлзүүлэх хүсэлт ирүүлсэн;
2. Хоёр талаас хоёулангаас нь түдгэлзүүлэх хүсэлт ирүүлсэн бол.

Шүүхээс тогтоосон хугацаанд талуудын хүсэлтээр арбитрын ажиллагааг дахин явуулж, эхний шийдвэрийн маргаантай асуудлыг хэлэлцэн, арбитрын бүрэлдэхүүнээс шинэ шийдвэр гаргаж болно.

Шүүхээр хянан шийдвэрлэх тухай хуулийн 43 дугаар зүйл, 11 дүгээр зүйлийн 2-т заасан "15 өдрөөс хэтрэхгүй" гэснийг үл харгалзан арбитрын ажиллагааг үргэлжлүүлэн явуулна.

36 дугаар зүйл.
Арбитрын бүрэлдэхүүн нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд маргааныг шийдвэрлээгүй тохиолдолд талуудын хүсэлтээр шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулна. Талууд шийдвэр хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, эсхүл энэ хуулийн 32 дугаар зүйлд зааснаар арбитрын шийдвэрт оруулсан нэмэлт, засварыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор дээрхтэй холбоотой хүсэлт гаргаж болно. Хариуцлага хүлээх талд хүлээлгэх үүргийг арбитрын шийдвэрт тодорхой тусгасан байна.

Арбитрын бүрэлдэхүүн маргаан шийдвэрлэхэд мэдлэг, ур чадвар дутсан бол энэ зүйлийн эхний доголд заасан хүсэлтийг хүлээн авч, энэ хуулийн 42 дугаар зүйлд зааснаар зардал гаргуулж шийдвэрлэнэ. Талууд дээрхээс өөр үндэслэлээр энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан журмын дагуу хүсэлт гарган шийдвэрлүүлж болно.

Швед Улсын эрх зүйн зохицуулалтын туршлага судалсны дүгнэлт

– Швед Улсын хуулийн дагуу арбитраар шийдвэрлүүлэх маргаан биш, арбитраас гаргасан шийдвэр нь Швед Улсын Үндсэн хуультай зөрчилдөж байгаа бол арбитрын шийдвэр бичгээр байх ба түүнд арбитрчид гарын үсэг зурна гэсэн шаардлага хангаагүй бол арбитрын шийдвэрийг бүхэлд нь болон хэсэгчлэн хүчингүй болгох үндэслэл болдог байна.
– Арбитрын шийдвэрт нэмэлт, засвар оруулсныг хүлээн авснаас хойш гурван сар, мөн талууд шийдвэрийг хүлээн авснаас хойш гурван сарын дотор ямар нэгэн нэмэлт, засвар, тайлбар оруулах санал гаргаагүй бол шийдвэр эцсийн байдлаар хүчин төгөлдөр болох талаар хуульчилсан онцлогтой байна. Энэ нь арбитрын нэмэлт шийдвэр гаргах хугацааны дараа уг шийдвэрийг хүчингүй болгуулах асуудлыг авч хэлэлцэхийг хуульчилснаараа ач холбогдолтой байна.

2.3. АРБИТРЫН ҮНДСЭН ШИЙДВЭР, ТҮҮНИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТАЛААРХ ҮНДЭСНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

Арбитрын үндсэн шийдвэр, түүнийг хүчингүй болгохтой холбогдох харилцааг 2003, 2017 оны арбитрын тухай хуулиудаар харьцуулан судалж, тайлбар, дүгнэлт хийв.

№	Арбитрын тухай 2003 оны Монгол Улсын хуулийн 40 дүгээр зүйл	2017 оны шинэчлэн найруулсан Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйл	Тайлбар, дүгнэлт
1	Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай хүсэлт гаргах 40.1.Талууд гагцхүү энэ хуулийн 40.2-т заасан үндэслэлээр арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай хүсэлтийг арбитрын ажиллагаа явагдсан газрын давж заалдах шатны шүүхэд гаргаж болно.	47 дугаар зүйл. Арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгох тухай өргөдөл гаргах 47.1.Талууд арбитрын үндсэн шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ хуулийн 47.2, 47.3-т заасан үндэслэл, журмын дагуу арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдлөө шүүхэд гаргана.	Үйлчилж буй хуулийн 47.1-д заасан заалтыг хэвээр үлдээж, өргөдөл гаргагч нь энэ хуулийн 47.2-т заасан үндэслэлийг нотлох баримтаар нотлох үүрэгтэй гэж тодорхой болгох.

Хүснэгтийн үргэлжлэл

2	40.2.Давж заалдах шатны шүүх зөвхөн доор дурдсан тохиолдолд арбитрын шийдвэрийг хүчингүй болгох эрхтэй: 40.2.1.арбитрын хэлэлцээрийн аль нэг тал эрх зүйн чадвар, чадамжгүй байсан, эсхүл арбитрын хэлэлцээрт хэрэглэхээр тохиролцсон улсын хуулийн дагуу, хэрэв ийнхүү тохиролцоогүй бол Монгол Улсын хуулийн дагуу тухайн арбитрын хэлэлцээр хүчин төгөлдөр бус болсон; 40.2.2.арбитрч томилох тухай болон арбитрын ажиллагааны талаар арбитрын бүрэлдэхүүн талуудад зохих ёсоор мэдэгдээгүй, эсхүл нэхэмжлэлийн шаардлага, татгалзал, мэдүүлэг, холбогдох бусад нотлох баримтын талаар тайлбар хийх боломжоор тэднийг хангаагүй;	47.2.Энэ хуулийн 47.5-д заасан шүүх нь арбитрын үндсэн шийдвэрийг зөвхөн дараах үндэслэлээр хүчингүй болгоно: 47.2.1.өргөдөл гаргагч тал дараах аль нэг нөхцөл байдлыг нотолсон: 47.2.1.а.энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан арбитрын хэлэлцээрийн аль нэг тал эрх зүйн чадамжгүй, эсхүл арбитрын хэлэлцээр нь талуудын тохиролцон сонгосон улсын хуульд зааснаар, эсхүл тийнхүү тохиролцон сонгоогүй бол Монгол Улсын хуульд зааснаар хүчин төгөлдөр бус; 47.2.1.б.өргөдөл гаргагч талд арбитрч томилох, арбитрын ажиллагааны тухай зохих ёсоор мэдэгдээгүйн улмаас арбитрын ажиллагаанд зохих ёсоор оролцох боломжгүй байсан;	47.2.1.а, б, в, г гэх мэт дугаарлалт хууль тогтоомжийн хуульд заасан шаардлагыг хангасан эсэхэд үндэслэж үсгийн дугааруудыг хасаж, арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэлүүдийг заалт болгох боломжтой байна. Судалгаанд хуулийн 47 дугаар зүйлийг хэрхэн боловсронгуй болгох санал боловсруулаа.

2	40.2.3.арбитрын бүрэлдэхүүнийг бүрдүүлэх болон арбитрын бусад ажиллагаа явуулах талаар талуудын тохиролцсон журмыг тухайн арбитрын бүрэлдэхүүн зөрчсөн; 40.2.4.арбитрын бүрэлдэхүүн арбитрын хэлэлцээрт хамааралгүй асуудлаар шийдвэр гаргасан, түүнчлэн уг шийдвэрт заасан арбитрт хамааралгүй хэсгийг шийдвэрийн бусад заалтаас салгаж хүчингүй болгох боломжгүй; 40.2.5.тухайн маргаан нь арбитрын харьяаллын маргаан биш болох нь нотлогдсон; 40.2.6.тухайн арбитрын шийдвэр Монгол Улсын нийтлэг ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдалд харшлахаар бол.	47.2.1.в.арбитрын бүрэлдэхүүн нэхэмжлэлийн шаардлагад тусгаагүй, хамааралгүй маргааны талаар үндсэн шийдвэр гаргасан. Хэрэв нэхэмжлэлийн шаардлагад тусгаагүй, хамааралгүй асуудлаар гаргасан арбитрын үндсэн шийдвэрийг нэхэмжлэлийн шаардлагад тусгасан асуудлаар гаргасан шийдвэрээс салгах боломжтой бол холбогдох хэсгийг хүчингүй болгоно; 47.2.1.г.талуудын тохиролцоо нь энэ хуулийн заавал дагаж мөрдөх заалтыг зөрчсөнөөс бусад тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн, арбитрын ажиллагаа талуудын тохиролцоонд нийцээгүй, эсхүл тийнхүү тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн, арбитрын ажиллагаа нь энэ хуульд нийцээгүй.	

Хүснэгтийн үргэлжлэл

2		47.2.2.шүүх дараах нөхцөл, байдлыг тогтоосон бол: 47.2.2.а.Монгол Улсын хуулиар уг маргаан арбитрын харьяаллын маргаан биш; 47.2.2.б.арбитрын үндсэн шийдвэр Монгол Улсын нийтлэг ашиг сонирхлыг зөрчсөн.	
3	40.3.Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох хүсэлтийг уг шийдвэрийг хүлээж авснаас хойш гурван сарын дотор гаргаж болох бөгөөд хэрэв талууд энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан үндэслэлээр арбитрын бүрэлдэхүүнд хүсэлт гаргасан бол уг хүсэлтийг шийдвэрлэснээс хойш энэхүү хугацааг тооцно.	47.3.Талууд арбитрын үндсэн шийдвэрийг хүлээн авснаас хойш, эсхүл энэ хуулийн 46 дугаар зүйлийн дагуу гаргасан хүсэлтийг шийдвэрлэснээс хойш дотоодын арбитрын ажиллагааны хувьд 30 хоногийн дотор, олон улсын арбитрын ажиллагааны хувьд 90 хоногийн дотор энэ хуулийн 47.1-д заасан өргөдлийг шүүхэд гаргана.	Үйлчилж буй зохицуулалтыг хэвээр үлдээх

4	40.4.Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох зөрчил гарсан бөгөөд түүнийг арбитрын бүрэлдэхүүнээр өөрөөр нь засуулах хүсэлтийг аль нэг тал гаргасан бол давж заалдах шатны шүүх арбитрын шийдвэрийг хянах ажиллагааг тодорхой хугацаа тогтоон түдгэлзүүлж болно.	47.4.Аль нэг тал хүсэлт гаргасан бөгөөд арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдөл хүлээн авсан шүүх боломжтой гэж үзсэн бол арбитрын ажиллагааг сэргээж, арбитрын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэлийг арилгах боломжийг арбитрын бүрэлдэхүүнд олгох зорилгоор арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай өргөдлийг хянан шийдвэрлэх ажиллагааг тодорхой хугацаа тогтоон түдгэлзүүлж болно.	Үйлчилж буй зохицуулалтыг хэвээр үлдээх
5	40.5.Арбитрын бүрэлдэхүүн энэ хуулийн 40.4-т заасны дагуу давж заалдах шатны шүүхээс тогтоосон хугацаанд зөрчлийг засаагүй бол давж заалдах шатны шүүх түдгэлзүүлсэн шийдвэрээ хүчингүй болгож, давж заалдсан гомдлыг хэлэлцэн шийдвэр гаргана.	47.5.Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдлийг энэ хуулийн 6.2-т заасан шүүхэд гаргах бөгөөд уг өргөдлийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр эцсийн шийдвэр байна.	Үйлчилж буй зохицуулалтыг хэвээр үлдээх

2017 онд шинэчлэн найруулсан Арбитрын тухай хууль батлагдсантай уялдуулан ИХШХШтХ-ийн 160^1-д "Арбитрын ажиллагаанд шүүх оролцох[27]", 160^2-т "Арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдөл[28]", 160^3-т "Арбитрын

---

[27] 160^1.1.Арбитрын хэлэлцээрийн аль нэг тал, эсхүл арбитр нь энэ хуулийн 160^2-т зааснаас бусад Арбитрын тухай хуульд заасан өргөдөл, хүсэлтээ мөн хуульд заасан харьяаллын шүүхэд ирүүлнэ.

160^1.2.Энэ хуулийн 160^1.1-д заасан өргөдөл, хүсэлтэд арбитрын хэлэлцээрийн талуудын нэр, хаяг, арбитрын ажиллагааны харьяалал, маргаан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа буюу явуулсан арбитр, нэхэмжлэлийн шаардлага, шүүхийн шийдвэрээр хэрэгжүүлэхийг хүсэж байгаа ажиллагааг явуулах үндэслэл, шаардлагын талаар тусгана.

160^1.3.Шүүх хүсэлтийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэр гаргах бөгөөд шүүх шийдвэртээ хүсэлтийг хангасан болон хангахаас татгалзсан үндэслэлийг заана.

[28] 160^2.1.Арбитрын хэлэлцээрийн тал нь Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан үндэслэлээр арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдлөө Арбитрын тухай хуульд заасан харьяаллын шүүхэд гаргаж болно.

160^2.2.Энэ хуулийн 160^2.1-д заасан өргөдөл гаргагч нь хуульд заасны дагуу улсын тэмдэгтийн хураамж төлнө.

160^2.3.Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдлийг бичгээр үйлдэж, өргөдөл гаргагч буюу түүний хууль ёсны төлөөлөгч гарын үсэг зурна.

160^2.4.Өргөдөлд дараах зүйлийг тусгана:

160^2.4.1.гарчиг;

160^2.4.2.үндсэн шийдвэр гаргасан арбитрч, арбитрын бүрэлдэхүүний нэр;

160^2.4.3.арбитрын ажиллагаанд оролцогч талуудын нэр, оршин суугаа /оршин байгаа/ хаяг, утас, факсын дугаар, цахим шуудангийн хаяг;

160^2.4.4.арбитрын үндсэн шийдвэр гарсан огноо, газар;

160^2.4.5.өргөдөл гаргагч арбитрын үндсэн шийдвэрийг хүлээн авсан огноо;

160^2.4.6.арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах үндэслэл.

160^2.5.Энэ хуулийн 160^2.4-т заасан өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

160^2.5.1.арбитрын үндсэн шийдвэрийн эх хувь буюу түүний нотариатаар баталгаажуулсан хуулбар, хэрэв үндсэн шийдвэр гадаад хэлээр бичигдсэн бол түүний монгол хэл дээрх албан ёсны орчуулга;

160^2.5.2.арбитрын хэлэлцээрийн эх хувь буюу түүний нотариатаар баталгаажуулсан хуулбар, хэрэв хэлэлцээр гадаад хэлээр бичигдсэн бол түүний монгол хэл дээрх албан ёсны орчуулга;

160^2.5.3.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

160^2.5.4.арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах үндэслэлээ нотлох баримт;

үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдлийг хянан хэлэлцэх журам[29]", 160^4-т "Арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдлийг хэлэлцсэн тухай шүүхийн тогтоол[30]", 160^5-д "Шүүхийн ажиллагааг хаалттай явуулах[31]" харилцааг зохицуулахаар хуульчилсан. Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйл болон эдгээр зохицуулалтад үндэслэн

160^2.5.5.арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдөлд гарын үсэг зурсан этгээдийн бүрэн эрхийг нотолсон баримт бичиг буюу итгэмжлэл.

160^2.6.Шүүх энэ зүйлд заасан журмыг зөрчиж гаргасан өргөдлийг буцааж, уг зөрчлийн талаар мэдэгдэнэ.

29 160^3.1.Шүүх арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдлийг хүлээж авснаас хойш энэ хуульд заасан журмын дагуу 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

160^3.2.Шүүх арбитрын хэлэлцээрийн талуудын хүсэлтээр арбитрын хэргийг энэ хуульд заасан журмаар гаргуулан авч болно.

160^3.3.Шүүх хуралдаан болох огноо, цаг, газрыг арбитрын маргаанд оролцогч талуудад мэдэгдэнэ. Уг мэдэгдлийг хүлээн авсан этгээд шүүх хуралдаанд ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.

160^3.4.Шүүх Арбитрын тухай хуулийн 47.2-т заасан арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл байгаа эсэхийг талуудын өргөдлийн шаардлага болон татгалзлаа үндэслэж байгаа, шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтыг шинжлэх замаар тогтооно.

30 160^4.1.Шүүх арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах тухай маргааныг хянан хэлэлцэж арбитрын үндсэн шийдвэрийг хэвээр үлдээх, эсхүл бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгох тухай тогтоол гаргана.

160^4.2.Энэ хуулийн 160^4.1-д заасан тогтоолд хуульд зааснаас гадна доор дурдсан зүйлийг тусгана:

160^4.2.1.маргаж байгаа шийдвэрийн тухай мэдээлэл, түүнийг гаргасан газар;

160^4.2.2.маргаж байгаа шийдвэрийг гаргасан арбитрч буюу арбитрын бүрэлдэхүүн;

160^4.2.3.арбитрын хэлэлцээрийн талуудын нэр;

160^4.2.4.арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдлийн агуулга;

160^4.2.5.шүүхээс гаргаж байгаа шийдвэрийн үндэслэл;

160^4.2.6.арбитрын үндсэн шийдвэрийг хэвээр үлдээсэн, эсхүл бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгосон тухай заалт.

160^4.3.Энэ зүйлд заасан тогтоол эцсийн шийдвэр байна.

31 160^5.1.Арбитрын ажиллагааны аль нэг тал энэ бүлэгт заасан өргөдөл, хүсэлтийг хянан хэлэлцэх шүүхийн ажиллагааг хаалттай явуулах тухай хүсэлт гаргасныг Монгол Улсын нийтлэг ашиг сонирхолд харшлахгүй гэж шүүх үзсэн бол уг ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хаалттай явуулахаар шийдвэрлэж болно.

НИХДЗШШ-ийн тогтоолд хууль зүйн дүн шинжилгээ хийсний зэрэгцээ эрдэмтэд, судлаачдын үзэл баримтлал, холбогдох эх сурвалжийг ашиглаж хууль зүйн дүгнэлт хийснээр шүүх арбитрын тухай хуулийг хэрэглэхэд хуулийн хэм хэмжээ нь тодорхой байх, арбитрын ажиллагаан дахь шүүхийн оролцоо ойлгомжтой байх шаардлагын хүрээнд Арбитрын тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар бүлгийн 47 дугаар зүйлийг боловсронгуй болгох чиглэлээр дараах санал дэвшүүлж судалгааны дүгнэлт хэсэгт тусгав.

2

ДҮГНЭЛТ

Арбитрын үндсэн шийдвэрт ИХДЗШШШ-ийн оролцооны талаар судалсны үр дүнд дараах дүгнэлтэд хүрэв. Үүнд:

1. Хууль зүйн дүн шинжилгээ хийж судалсан НИХДЗШШШ-ийн 31 тогтоолоос арбитрын үндсэн шийдвэрийг хэвээр үлдээсэн 15 тогтоол байсан бөгөөд эдгээрт дүн шинжилгээ хийсний үр дүнд:

   Нэгдүгээрт, зохигчдын эрхийг ямар нэгэн байдлаар зөрчөөгүй, арбитрын алдаагүй ажиллагаа явуулсан болох нь хэрэг хянан шийдвэрлэх журам, арбитрын шийдвэрийн агуулгаас харагдав.

   Хоёрдугаарт, эдгээр шийдвэрийг гаргасан арбитрын бүрэлдэхүүн тухайн маргаанд хууль зүйн үндэслэл бүхий дүгнэлт хийж, арбитрын ажиллагааны хувьд хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан шийдвэрлэсэн, арбитрын үндсэн шийдвэрийн агуулга, хэлбэр нь хуульд заасны дагуу бичигдсэн арбитрын сайн туршлага байна гэж үзэв. Эдгээр үндэслэлээр арбитрын шийдвэрийг НИХДЗШШ хэвээр үлдээн шийдвэрлэжээ.

2. Хууль зүйн дүн шинжилгээ хийж судалсан НИХДЗШШШ-ийн 31 тогтоолоос арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн 16 тогтоол байв. Эдгээрийг нэг бүрчлэн судалж үзэхэд Арбитрын тухай хуулийн 47.2.1.а-д заасан үндэслэлээр 1 тогтоол, 47.2.1.б-д заасан үндэслэлээр 2 тогтоол, 47.2.1.в-д заасан үндэслэлээр 5 тогтоол, 47.2.1.г-д заасан үндэслэлээр 5

тогтоол, 47.2.1-д заасан үндэслэлээр 1 тогтоол, 47.2.1.а болон 47.2.1.в заалтыг хамтад нь үндэслэсэн 1 тогтоол, өмнө үйлчилж байсан Арбитрын тухай хуулийн 40.2.5-д заасан үндэслэлээр 1 тогтоолыг тус тус хүчингүй болгосон байв. Арбитрын шийдвэрийг хүчингүй болгосноор арбитрын журмаар уг маргааныг дахин хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэхэд цаг хугацаа алдах, нэмэлт зардал төлөх гэх мэт арбитрын ажиллагааны хүндрэлтэй байдал үүсэж байгаа нь зохигчдын эрхийг зөрчих хууль зүйн үр дагавар бий болгож буй тул тухайн арбитрын бүрэлдэхүүн цаашдаа үүнд зайлшгүй анхаарч, хариуцлагатай байх шаардлагатай байна. Үүний зэрэгцээ НИХДЗШШ уг хэм хэмжээг хэрэглэхэд хуулийн заалтыг тодорхой, ойлгомжтой байлгах зорилгоор арбитрын шийдвэрийг хүчингүй болгохтой холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хууль зүйн болон практикийн хэрэгцээ шаардлага байна гэж дүгнэлээ. Иймд судалгааны хүрээнд Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлд буй хэм хэмжээг боловсронгуй болгох чиглэлээр санал дэвшүүлж, дүгнэлтийн нэг хэсэг болгон тусгасан болно.

3. Арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах өргөдөл гаргагч талууд дийлэнх тохиолдолд НИХДЗШШ-ийн арбитрын шийдвэрийг хүчингүй болгох эрх хэмжээнд хамааралгүй асуудлаар өргөдөл гаргасан байдал ажиглагдав. Ингэснээр шүүхийн ачааллыг нэмэгдүүлэх, арбитрын ажиллагаа, арбитрын шийдвэрийн биелэлтэд хугацаа алдагдуулах гэх мэт үр дагавар бий болгох магадлалтай байна.

4. Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах өргөдөл гаргагчдын нийтлэг алдаа дутагдал нь хуульд заасан хугацаанд шүүхэд хандан арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах өргөдөл гаргахаасаа өмнө арбитрын ажиллагааны явцад арбитрын бүрэлдэхүүнд хандаж аливаа гомдлоо гарган шийдвэрлүүлэх, хэрэв шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд хандах хуульд заасан эрхээ эдлэх асуудалд анхаарах нь бага байна гэж үзлээ. Уг

эрхээ эдлээгүй тохиолдолд Арбитрын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аль нэг тал нь энэ хуульд зааснаас өөрөөр талууд тохиролцож болох боломжтой заалтын талаар, эсхүл арбитрын хэлэлцээрийн аль нэг шаардлагыг биелүүлээгүй болохыг мэдэж байсан боловч тэр тухай даруй, эсхүл тогтоосон хугацааны дотор гомдол гаргалгүйгээр арбитрын ажиллагаанд үргэлжлүүлэн оролцсон бол түүнийг гомдол гаргах эрхээсээ татгалзсан гэж үзнэ" хэмээн зааснаар гомдол гаргах эрхээсээ татгалзсанд тооцох зохицуулалт байгааг анхаарч, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох нь зүйтэй.

5. Гадаадын зарим улс орны арбитрын эрх зүйн зохицуулалтыг судлахдаа ХБНГУ, ОХУ, Япон Улс, Швед Улс, БНХАУ-ыг сонгон Арбитрын тухай хуулийн арбитрын шийдвэрийг хүчингүй болгохтой холбогдох харилцааны эрх зүйн зохицуулалтыг харьцуулан авч үзэхэд ХБНГУ, ОХУ, Японы Арбитрын тухай хуулийн зохицуулалт нь дээр дурдсан НҮБ-ын Олон улсын худалдааны эрхийн комиссын Олон улсын арилжааны арбитрын загвар хуулийн үндсэн үзэл баримтлал, зохицуулалтыг тусгасан бол Швед, БНХАУ-ын Арбитрын тухай хуулийн зохицуулалтын агуулга нь загвар хуулийн заалттай ойролцоо агуулгатай боловч эдгээр улсад зарим онцлог бүхий хэм хэмжээ үйлчилдэг байна. Дээрх орнуудын арбитрын шийдвэрийг хүчингүй болгохтой холбоотой эрх зүйн зохицуулалтаас Монгол Улсын Арбитрын тухай хуульд дараах зохицуулалтуудыг тусгах боломж байна гэсэн дүгнэлтэд хүрэв. Үүнд:

– ОХУ-ын Арбитрын тухай хуульд буй "Талуудын арбитрын хэлэлцээрт байнгын арбитраар маргаанаа шийдвэрлүүлэх, уг хэлэлцээрт арбитрын шийдвэр эцсийнх байна хэмээн тохиролцсон тохиолдолд арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах боломжгүй" гэсэн агуулгатай хэм хэмжээ;

– БНХАУ-ын Арбитрын тухай хуульд буй "нотлох баримт хуурамчаар үйлдсэн, нотлох баримтыг зориуд, санаатайгаар арбитрт ирүүлээгүй, арбитрын шийдвэр гаргасан арбитрын бүрэлдэхүүн ашиг сонирхлын зөрчилтэй, авлига авсныг өргөдөл гаргагч нотолсон тохиолдолд арбитрын шийдвэрийг хүчингүй болгох" гэсэн агуулгатай хэм хэмжээ.

6. НҮБ-ын Олон улсын худалдааны эрхийн комиссын Олон улсын арилжааны арбитрын загвар хуулийн 34 дүгээр зүйлд буй арбитрын шийдвэрт гомдол гаргах өргөдлийн зохицуулалтыг дэлхийн улс орнууд хүлээн зөвшөөрч арбитрын тухай үндэсний хуульдаа загварчлан тусгах түгээмэл хандлага байна. Үүний нэг нь Монгол Улс бөгөөд дээрх загвар хуулийн зохицуулалтыг Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлд хуульчлан, даган мөрдөж байна. Гэсэн хэдий ч "Арбитрын үндсэн шийдвэрийг НИХДЗШШ хүчингүй болгосноор арбитрын ажиллагааг удаашруулах, зардлыг нь өсгөх, маргаан шийдвэрлэх арбитрын ажиллагааны үр нөлөөг бууруулах сөрөг үр дагавар үүсэж байгааг шийдвэрлэхэд чиглэсэн хууль зүйн зохицуулалт бий болгох, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хууль зүйн хэрэгцээ, шаардлага бий" гэсэн судалгааны таамаглалын хүрээнд дараах дүгнэлтэд хүрэв:

– Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлд зохицуулсан арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулахтай холбогдох харилцааны зохицуулалт ЮНСИТРАЛ-ын загвар хуульд нийцсэн, мөн бидний судалж үзсэн сайн туршлага бүхий орнуудын зохицуулалттай ижил хэдий ч НИХДЗШШ Арбитрын тухай хуулийг хэрэглэхэд хуульчилсан хэм хэмжээ илүү тодорхой байх шаардлагатай гэж үзсэн тул уг хэм хэмжээг дараах байдлаар боловсронгуй болгож өөрчлөх хууль зүйн болон практикийн хэрэгцээ шаардлага байна гэж дүгнэв. Үүнд:

47 дугаар зүйл. Арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгох тухай өргөдөл гаргах

47.1. Талууд арбитрын үндсэн шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ хуулийн 47.2, 47.3-т заасан үндэслэл, журмын дагуу арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдлөө шүүхэд гаргана. Өргөдөл гаргагч нь энэ хуулийн 47.2-т заасан үндэслэлийг нотлох баримтаар нотлох үүрэгтэй.

47.2. Энэ хуулийн 47.5-д заасан шүүх нь арбитрын үндсэн шийдвэрийг зөвхөн дараах үндэслэлээр хүчингүй болгоно:

47.2.1. Арбитр энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан арбитрын хэлэлцээрийн шаардлага хангаагүй хэлэлцээр бүхий маргааныг шийдвэрлэсэн нь тогтоогдсон бол;

47.2.2. Талуудын тохиролцон сонгосон улсын хуульд заасан арбитрын хэлэлцээрийн шаардлага хангаагүй хэлэлцээр бүхий маргааныг арбитр шийдвэрлэсэн нь тогтоогдсон бол;

47.2.3. Талуудад арбитрч томилох болон арбитрын ажиллагааны талаар Арбитрын тухай хууль, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэмд заасны дагуу зохих ёсоор мэдэгдээгүйн улмаас талууд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, бусад оролцогчдыг арбитрын ажиллагаанд оролцуулахгүйгээр маргааныг шийдвэрлэсэн бол;

47.2.4. Арбитрын бүрэлдэхүүн нэхэмжлэлийн шаардлагад тусгаагүй, хамааралгүй маргааны талаар үндсэн шийдвэр гаргасан тохиолдолд энэ талаар шийдвэрлэсэн хэсгийг нэхэмжлэлийн шаардлагад тусгасан асуудлаар гаргасан шийдвэрээс салгах боломжтой бол арбитрын шийдвэрийн холбогдох хэсгийг, нэхэмжлэлийн шаардлагад тусгасан асуудлаар гаргасан шийдвэрээс салгах боломжгүй бол арбитрын шийдвэрийг бүхэлд нь;

47.2.5. Энэ хууль болон арбитрын ажиллагааны журам зөрчсөн болох нь тогтоогдсон бол;

47.2.6. Монгол Улсын хуулиар уг маргаан арбитрын харьяаллын маргаан биш болох нь тогтоогдвол;

47.2.7. Арбитрын үндсэн шийдвэр Монгол Улсын нийтлэг ашиг сонирхлыг зөрчсөн бол.

Арбитрын тухай хуулийн 47.3, 47.4, 47.5 дугаар зүйлүүдийг хэвээр үлдээх боломжтой зохицуулалтууд гэж үзлээ.

Арбитрын үндсэн зардал болон нэмэлт зардлын хэмжээг тооцох журмын 3 дугаар зүйлийн 3.11-д "Арбитрын тухай Монгол Улсын хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэгт заасан үндэслэлээр арбитрын шийдвэрийг шүүх хүчингүй болгосон тохиолдолд арбитрын ажиллагааг дахин эхлүүлэхээр хүсэлт гаргасан тал нэхэмжлэлийн үнийн дүнгээс тооцон энэхүү журмын дагуу төлбөл зохих арбитрын зардлаас 50 хувиар тооцож арбитрын зардлыг дахин төлнө. Энэхүү заалт нь сөрөг нэхэмжлэлд мөн адил хамаарна", 3.12-т "Энэхүү журмын 3.11-д заасан үндэслэлээр арбитрын ажиллагаа дахин эхэлсэн тохиолдолд сөрөг нэхэмжлэл гаргасан бол арбитрын зардлыг энэхүү журамд заасны дагуу ердийн журмаар төлнө", 3.13-т "Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т заасан үндэслэлээр арбитрын шийдвэр хүчингүй болж арбитрын ажиллагаа дахин эхэлсэн тохиолдолд нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлсэн бол энэхүү журмын 3 дугаар зүйлийн 3.11-д заасан хэмжээгээр арбитрын зардлыг төлөхөөс гадна нэмэгдүүлсэн шаардлагын хэмжээгээр ердийн журмаар нэмж төлнө" гэсний дагуу арбитрын шийдвэрийг хүчингүй болгосноор зохигчид арбитрын нэмэлт зардал гаргах, цаг хугацаа алдах гэх мэт үр дагавар гарч байгаа нь арбитрын үндсэн шийдвэрийг НИХДЗШШ хүчингүй болгох талаарх эрх зүйн зохицуулалтыг сайжруулах асуудлыг илэрхийлж байна гэж үзэв.

2

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Ном, сурах бичиг, гарын авлага

1. Ж.Амарсанаа нар. Процессын эрх зүй. УБ., 2014.
2. Д.Аюуш. Арбитр ба арбитрч. УБ., 2004.
3. Б.Батбаяр, А.Түвшинтулга. Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухааны ном зүйн бүртгэл. УБ., 2014.
4. М.М.Богуславский. Олон улсын хувийн эрх зүй. УБ., 2008.
5. С.Должин. Монгол Улсын арбитрын процессын эрх зүй. УБ., 2017.
6. Д.Дүгэржав. Арбитрын тухай хуулийн товч тайлбар. УБ., 2017.
7. Д.Уянга. Олон улсын арилжааны арбитр: Маргаан шийдвэрлэх асуудал. УБ., 2002.
8. Монголын Үндэсний Арбитр, Арбитр болон олон улсын худалдааны эрх зүйн актын эмхэтгэл. УБ., 2012.
9. Монголын Үндэсний Арбитрын шийдвэрлэсэн хэргийн эмхэтгэл /2006-2011/. УБ., 2012.
10. Монголын Олон улсын арбитрын шийдвэрийн түүвэрлэсэн эмхэтгэл /2012-2019/. УБ., 2020.
11. Монгол Улс дахь Арбитрын байгууллага. Түүхэн товчоон /1930-2020/. УБ., 2020.
12. Монгол Улс дахь Арбитрын эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл. УБ., 2020.
13. Арбитрын сэдэвт эрдэм шинжилгээний нийтлэлийн эмхэтгэл. УБ., 2020.
14. Олон улсын арилжааны арбитр. УБ., 2009.
15. Т.Мөнхжаргал. Арбитрын процессын эрх зүй. УБ., 2008.
16. Т.Мөнхжаргал, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй. Ерөнхий анги. УБ., 2008.

17. Ж.Наранцацрал нар. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй. Гарын авлага. УБ., 2007.
18. М.Сувд, Ц.Ундрах. Олон улсын эрхзүй. УБ., 2012.
19. Эрх зүйн процесс-эрх зүйн шинэтгэл /Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл/. УБ., 2017.

Үндэсний хууль тогтоомжийн акт

1. Монгол Улсын Үндсэн Хууль. 1992.
2. Иргэний хууль. 2002.
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. 2002.
4. Арбитрын тухай хууль. 2003, 2017.
5. Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм. 2017.
6. Монголын Олон улсын арбитраас Түр арбитрт дэмжлэг үзүүлэх тухай дүрэм. 2014.
7. Арбитрын үндсэн болон нэмэлт зардлын хэмжээг тооцох журам. 2018.

Олон улсын гэрээ, конвенцууд

1. Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх тухай Нью-Йоркийн конвенц. 1958.
2. НҮБ-ын Олон улсын худалдааны эрхийн комисс /ЮНСИТРАЛ/-ын Арбитрын дүрэм. 2010.
3. НҮБ-ын Олон улсын худалдааны эрхийн комиссын Олон улсын арилжааны арбитрын загвар хууль. 1985.

Гадаад улсын хууль

1. German Arbitration Act The following provisions of the Arbitral Proceedings Reform Act have entered into force on 1 January 1998. Subsequent amendments, i.a. by the Civil Procedure Reform Act of 27 Jul. 2001 and the Law of Contracts Reform Act of 26 Nov. 2001 have been incorporated. Article 1, No. 7 of the Arbitral Proceedings Reform Act, Chapter VII, Recourse against award, Section 1059.

2. Russian federation law on international commercial arbitration, The law no 5338-1 in force since July 7, 1993 as amended on December 3, 2008; December 29, 2015, Section vii. Recourse against award, Article 34.
3. Arbitration act, Act No. 138 of August 1, 2003, Chapter VII Setting Aside of Arbitral Award, Article 44.
4. Arbitration Law of the People's Republic of China, Chapter V Application for Setting Aside Arbitration Award, Article 58.
5. The Swedish Arbitration Act (SFS 1999:116).

Цахим эх сурвалж

www.arbitr.mn

1. https://uncitral.un.org/en/texts/arbitration/modellaw/commercial_arbitration/status

ХАВСРАЛТ

АРБИТРЫН ҮНДСЭН ШИЙДВЭРИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН ШҮҮХИЙН ТОГТООЛУУД

2017 он

1. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 21 дүгээр тогтоол
2. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 279 дүгээр тогтоол
3. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 111 дүгээр тогтоол

2018 он

1. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 332 дугаар тогтоол
2. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 59 дүгээр тогтоол
3. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 380 дугаар тогтоол
4. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 249 дүгээр тогтоол
5. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 356 дугаар тогтоол
6. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 323 дугаар тогтоол

7. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 363 дугаар тогтоол
8. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатын шүүхийн 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 210/ШТ2018/00049 дүгээр тогтоол

2019 он

1. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 86 дугаар тогтоол
2. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 260 дугаар тогтоол
3. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 455 дугаар тогтоол
4. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 254 дүгээр тогтоол
5. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 364 дүгээр тогтоол

АРБИТРЫН ҮНДСЭН ШИЙДВЭРИЙГ ХЭВЭЭР ҮЛДЭЭСЭН ШҮҮХИЙН ТОГТООЛУУД

1. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 502 дугаар тогтоол
2. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 66 дугаар тогтоол
3. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 315 дугаар тогтоол
4. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 421 дүгээр тогтоол
5. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 210ШТ2017/00463 дугаар тогтоол

6. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 210ШТ2018/00065 дугаар тогтоол
7. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 437 дугаар тогтоол
8. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 72 дугаар тогтоол
9. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 429 дүгээр тогтоол
10. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 132 дугаар тогтоол
11. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 82 дугаар тогтоол
12. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 276 дугаар тогтоол
13. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 444 дүгээр тогтоол
14. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 34 дүгээр тогтоол
15. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 158 дугаар тогтоол

3 ГЭНЭТИЙН БУЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧНИЙ ШИНЖТЭЙ ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛААС ҮҮССЭН ХЭРЭГ МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА

БАТТӨРИЙН ЭНХБАЯР

Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш.

Монголын Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлдэг. 1991 онд ОХУ-ын Эрхүү хотын Политехникийн дээд сургуулийг инженер мэргэжлээр, 2000 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйн бакалаврын зэрэгтэй төгссөн, мөн түс сургуульд хууль зүйн үхааны магистрын зэрэг хамгаалсан. Сүтай, Билиг Дээд сургуульд багш, 2007 оноос хойш Отгонтэнгэр Их сургуульд багшаар ажиллаж байна.

БАУРЖАНЫ ДОСЖАН

Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, судлаач.

Б.Досжан нь Дотоод хэргийн их сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгсөж, 2016 онд Бүгд Найрамдах Турк Улсын Улудаг Их сургуулийн Хууль зүйн сургуульд "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлт" сэдвээр магистрын зэрэг хамгаалсан.

Судлаачид:
Баттөрийн Энхбаяр (LL.M.)
Бауржаны Досжан (LL.M.)

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ 178
УДИРТГАЛ 179

НЭГ. ГЭНЭТИЙН БУЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧНИЙ ШИНЖТЭЙ ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ 183
1.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын тухай ойлголт, онцлог 183
1.2. Гэрээний эрх зүйн маргааныг гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас хянан шийдвэрлэх нь, түүний эрх зүйн үр дагавар 188

ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ 199
2.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын тухай зарим статистик мэдээлэл ба шийдвэр сонгон судалсан үндэслэл 199
2.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлыг тогтоосон тухай шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ 209

3

2.3. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалд хамааруулаагүй тухай шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ.....245
2.4. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлыг нотлоогүй тухай шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ.....249
2.5. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын тухай тайлбар, бусад нотлох баримтыг үнэлээгүй шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ.....258

ГУРАВ. ГЭНЭТИЙН БУЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧНИЙ ШИНЖТЭЙ ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТУХАЙ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ...262
3.1. ОХУ-ын эрх зүйн зохицуулалт 262
3.2. Франц Улсын эрх зүйн зохицуулалт 266
3.3. Герман Улсын эрх зүйн зохицуулалт.....268
3.4. АНУ болон Английн эрх зүйн зохицуулалт 269

ДҮГНЭЛТ, САНАЛ.....274
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ.....280

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИХ	Иргэний хууль
ИХШХШтХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
МҮХАҮТ	Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОБГ	Онцгой байдлын газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОХУ	Оросын Холбооны Улс
СБД	Сүхбаатар дүүрэг
УДШ	Улсын Дээд шүүх
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

3

УДИРТГАЛ

Монгол Улсын холбогдох хууль, олон улсын гэрээ, конвенц, Улсын Дээд шүүх (УДШ)-ийн тайлбар, зөвлөмж болон бусад баримт бичигт хүндэтгэн үзэх үндэслэл болох гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлыг тодорхойлсон тодорхойлолтыг шүүх хэрхэн хэрэглэж байгаад дүн шинжилгээ хийх нь тус зохицуулалтын нэг мөр хэрэглээг хангахад чухал ач холбогдолтой юм. Мөн энэхүү ойлголтыг онолын хувьд зарим улсын хууль тогтоомжид хэрхэн тусган хэрэглэж байгааг өөрийн орны эрх зүйн зохицуулалттай харьцуулан судлахыг зорилоо. Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна. Үүнд:

- Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлыг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг судлах, мөн энэхүү онцгой нөхцөл байдлын талаарх өөрийн орны болон зарим улс орны эрх зүйн баримт бичиг, эрх зүйн хэм хэмжээнд дүн шинжилгээ хийх;
- Шүүх хуулийг зөв тайлбарлаж хэрэглэхэд хуулийн зохицуулалт тодорхой, ойлгомжтой эсэхэд дүгнэлт хийх;
- Шүүх гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал ба талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс гэрээний хугацааг үргэлжлүүлэх, сунгахыг шаардах боломжгүй нөхцөл байдлын тухай эрх зүйн зохицуулалтыг зөв хэрэглэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх;

– Энэхүү нөхцөл байдлын улмаас нийгмийн аль салбарт ямар төрлийн эрх зүйн маргаан илүү үүсэж байгаа болон түүний учир шалтгааныг тодорхойлох зэрэг зорилт тавив.

Энэхүү судалгааны хүрээнд 2016-2021 оны хооронд гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас үүссэн иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн анхан, давах, хяналтын шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийлээ. Учир нь гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдалтай холбоотой, ялангуяа Ковид-19 цар тахлын улмаас урт хугацаатай гэрээний үүргээс үүссэн маргаан сүүлийн жилүүдэд шүүхэд олноор шийдвэрлэгдэж байгаа юм. Одоогийн байдлаар дэлхий дахинд тархсан Ковид-19 цар тахлын улмаас Засгийн газраас 2019-2021 оны хооронд хэрэгжүүлсэн арга хэмжээ нь ажил хөдөлмөр хийх, бизнес эрхлэх боломж нөхцөлийг хумьж, бүрэн зогсоосноор хувь хүн, хуулийн этгээд, улс орны санхүү, эдийн засагт сөргөөр нөлөөлж байна. Үүний улмаас иргэн, хуулийн этгээд зээлийн эргэн төлөлт, түрээсийн төлбөр, сургалтын төлбөр, ажил гүйцэтгэх, худалдах, худалдан авах зэрэг гэрээгээр бусдын өмнө хүлээсэн үүргээ эс биелүүлэхэд хүрч байгаа тул гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын гэрээнээс үүдэлтэй маргаан олширч байгаа юм.

2016-2021 оны хооронд гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас үүссэн хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн нийт 100 гаруй шийдвэрийг уншиж судлан, үүнээс 20 хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн шийдвэрүүдийг сонгосон. Уг хэрэг маргааныг анхан, давах болон хяналтын шатны шүүхээс шийдвэрлэсэн нийт 32 шийдвэрт дүн шинжилгээ хийсэн. Шүүхийн эдгээр шийдвэрийг сонгохдоо шүүхээс гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалд хамааруулсан ихэнх нөхцөл байдлыг тусгахыг

чиглэл болгосноос гадна тухайн нөхцөлийг гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөлд хамааруулан дүгнээгүй, зохигчид түүнийг нотлоогүй болон талуудын тайлбар, бусад нотлох баримтыг шүүхээс үнэлээгүй шүүхийн шийдвэрүүдийг жишээ болгон авсан болно. Мөн тухайн төрлийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийх явцад нийтэд илэрхий үйл баримт болох "Ковид-19" цар тахлын улмаас үүссэн маргааныг шийдвэрлэхдээ түүнийг шүүх гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал гэж дүгнэсэн эсэх, дүгнээгүй тохиолдлыг тайлбарласан үндэслэл, зохигчид тухайн нөхцөл байдлыг хэрхэн нотолж байгаа зэрэгт дүгнэлт хийхийг зорьсон юм.

Талууд гэрээ байгуулснаар үүргийн эрх зүйн харилцаа үүсэх бөгөөд гэрээгээр тохиролцсон үүргээ тогтоосон газар, хугацаанд нь зохих ёсоор, шударгаар биелүүлэх зарчим үйлчилдэг. Гэвч гэрээ байгуулсны дараа гэрээний аль нэг талын гэм буруугаас үл хамаарсан урьдчилан харах, тооцоолох боломжгүй гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас үүрэг болон хариу үүргийн харьцаа их хэмжээгээр алдагдаж гэрээний нэг тал үүргээ биелүүлэх боломжгүй болдог. Дүн шинжилгээний үр дүнд шүүх дээрх нөхцөл байдлын улмаас үүссэн маргааныг хянан шийдвэрлэсэн шийдвэрийн хууль хэрэглээний хувьд төсөөтэй болон ялгамжтай талыг нь тодорхойлох замаар судална. Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын тухай нотлох баримтыг хэрхэн үнэлж байгаа байдалд дүн шинжилгээ хийнэ.

Цаашид дэлхийн уур амьсгалын дулаарал, экологийн тогтворгүй байдал болон улс орнуудыг хамарсан халдварт өвчин зэргээс гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын цар хүрээ өргөжин тэлж байгаа тул үүнтэй холбоотой иргэний хэрэг маргааныг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа ч ихсэх хандлагатай байна.

Иргэний хууль болон бусад хууль, Улсын Дээд шүүхийн тайлбарт гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын эрх зүйн зохицуулалтын утга агуулгыг ерөнхий байдлаар тусгасан гэж үзэж байгаа тул шүүх ямар нөхцөл байдлыг гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал гэж үзэх, холбогдох хэм хэмжээг оновчтой хэрэглэн шийдвэрлэж байгаа эсэхийг тодруулах зорилгоор шүүхийн шийдвэрт судалгаа хийж байгаа болно. Энэхүү судалгаа гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас үүссэн иргэний хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн шийдвэрийн чанарыг сайжруулахад чухал нөлөө үзүүлэх юм.

3

НЭГ. ГЭНЭТИЙН БУЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧНИЙ ШИНЖТЭЙ ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

1.1. ГЭНЭТИЙН БУЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧНИЙ ШИНЖТЭЙ ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ОНЦЛОГ

Судлаачид гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын тухай ойлголт, түүнд ямар ямар нөхцөл байдал хамаарахыг дараах байдлаар тодорхойлсон байна. Тухайлбал, Д.Наранчимэг "Давагдашгүй хүч гэж үүрэг хүлээгчийн болзошгүй аюулыг урьдчилан мэдэж байсан, мэдэх ёстой байсан ч тухайн үед өөрт байгаа хэрэгслээрээ уг аюулыг зайлуулж чадахгүй байх байсан нөхцөл байдал юм", О.Жамбалдорж "Иргэний хуульд заасан гэнэтийн шинжтэй онцгой нөхцөл байдал гэж үүрэг бүхий этгээд урьдчилан мэдэж байсан бол зайлуулж болох байсан боловч урьдчилан мэдэх бололцоогүй бөгөөд гэнэтийн учраас зайлуулах боломжгүй онцгой тохиолдол (казус)-ыг хэлнэ. Жишээлбэл, гэнэтийн хүчний шинжтэй онцгой тохиолдлоор байшингаас ямар нэг зүйл унаж хохирол учруулсан бол тухайн байшин барилгын өмчлөгч буюу эзэмшигч хариуцлага хүлээхгүй" (ИХ-ийн 500 дугаар зүйлийн 2 дахь хэсэг)[1] гэжээ.

Давагдашгүй хүчин зүйл (латинаар Vis major, англиар Force majeure, insujrable forc, оросоор непреодолимая сила) гэдэг нь гэрээний нөхцөлийг эс биелүүлэх үр дүнг үүсгэсэн онцгой ба дийлдэшгүй нөхцөл байдал юм. Давагдашгүй хүчин зүйлийн үр

[1] О.Жамбалдорж нар. Монгол Улсын иргэний эрх зүй (Эдийн баялгийн эрх, Оюуны өмчийн эрх зүй). II дэвтэр, 2006, 257 дахь тал (ISBN 99929-0-008-3).

дүнд гэрээний нэг тал нь нөгөө талдаа өөрийн эрхгүй хохирол учруулагч болдог. Давагдашгүй хүчин зүйлийг тодорхойлох ерөнхий зарчимд үүрэг биелүүлэхэд саад болсон хүчин зүйл бүхий үйлдэл болох объектив ба үнэмлэхүй шинжтэй нөхцөл байдал хамаарах бөгөөд объектив ба үнэмлэхүй байдал нь гэм хор учруулагчид төдийгүй бүхэнд хамааралтай байх ёстой. Үүрэг гүйцэтгэх боломжгүй байдал нь үүрэг гүйцэтгэгчийн хувьд бэрхшээлтэй төдий бус үнэмлэхүй байх ёстой. Хууль тогтоомж болон гэрээгээр байгалийн гамшиг (газар хөдлөлт, үер зэрэг) буюу хүн төрөлхтний мэдлэг, боломжийн орчин үеийн түвшинд тодорхойлох буюу урьдчилан харах боломжгүй (эсхүл тодорхойлох боломжтой боловч зайлуулах боломжгүй) бусад нөхцөл байдал хамаарагдана. Давагдашгүй хүчин зүйлийг голчлон дараах хоёр хэсэгт ангилна:

a) Байгалийн гамшигт үзэгдэл – газар хөдлөлт, үер, зуд, гал түймэр, хуй салхи, ган зэрэг;

b) Нийгмийн амьдралын зарим нөхцөл байдал – дайны ажиллагаа, халдварт өвчин, улсын ба салбарын хэмжээний ажил хаялт, төрийн байгууллагын хориглосон эрх зүйн акт (хорио цээр тогтоох, тодорхой чиглэлд тээвэрлэлтийг зогсоох, олон улсын санкц хэрэглэсний улмаас тодорхой улсад худалдааны гүйлгээг хориглох) ба бусад.

Дэлхийн улсуудын иргэний эрх зүйн бүхий л тогтолцоонд давагдашгүй хүчин зүйл нь хариуцлагаас чөлөөлөх нөхцөл байдал болдог байна[2].

[2] С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг, Dictionary of Law (Гурав дахь хэвлэл). 2011, 165-166 дахь тал (ISBN 978-99929-0-353-8).

А. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалд хамаарах тохиолдлуудын талаарх хуулийн зохицуулалт

Барилгын тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Гаалийн тухай хууль зэрэг хуульд гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас хууль, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд саад, бэрхшээл учирсан үед хариуцлагаас чөлөөлөгдөх, түүнийг нотлох, нөгөө талд энэ тухай мэдэгдэх зэрэг харилцааг зохицуулсан ч ямар нөхцөл байдал хамаарах тухай тодорхой заагаагүй байна. Харин Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.41 дэх хэсэгт "…. нийтийг хамарсан дайчилгаанд хамрагдсан, нийтийг хамарсан аюулт халдварт өвчний улмаас хорио цээр тогтоосон бүсэд хоригдсон, галын болон байгалийн гэнэтийн аюул, эсхүл давагдашгүй хүчин зүйл /усны үер, ган, зуд, аюултай цасан болон шороон шуурга, газар хөдлөлт/" зэрэг нөхцөл байдлыг хүндэтгэн үзэх шалтгаанд хамааруулахаар заажээ.

Улсын Дээд шүүх зарим хуулийн хүндэтгэн үзэх шалтгаантай холбоотой заалтыг тайлбарласан байна. Жишээ нь, Улсын Дээд шүүхийн 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай зөвлөмжийн 2.1 дэх хэсэгт хүндэтгэн үзэх шалтгаан гэдэгт "… бусад байдлаас шалтгаалсан бодит, тодорхой нөхцөлийг ойлгох нь зүйтэй" гэж тайлбарласан бол Улсын Дээд шүүхийн 2006 оны 07 дугаар сарын 03-ны 33 дугаар тогтоол буюу Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай тогтоолын 28 дахь хэсэгт "…хорио цээрийн дэглэм тогтоогдсон, байгалийн болон нийтийг хамарсан гамшиг тохиолдсон зэрэг өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар гомдол гаргах боломжгүй байсан байдлыг хүндэтгэн үзэх шалтгаан гэж үзнэ" хэмээн тайлбарлажээ.

Манай улсын зарим хууль болон Улсын Дээд шүүхийн тайлбарт "байгалийн болон нийтийг хамарсан гамшиг" энэхүү нөхцөл байдалд хамаарах тухай заасан байна. Үүнд:

1. Гал түймэр болон байгалийн гамшиг болох усны үер, ган, зуд, аюултай цасан болон шороон шуурга, газар хөдлөлт;

2. Нийтийг хамарсан аюулт халдварт өвчний улмаас хорио цээр тогтоосон бүсэд хоригдсон болон дайчилгаанд хамрагдсан зэрэг нөхцөл байдлыг заажээ.

Б. Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх журам

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэгт Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим нь "давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх"-ээр заажээ. Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын даргын 2020 оны 01дүгээр сарын 24-ний өдрийн А/12а дугаартай тушаалын хавсралтаар Force majeure /гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл/ болон hardship /хүнд нөхцөл байдал/-ийг гэрчлэх журам баталсан. Уг журмын 1.2 дахь хэсгийн 1.2.1 дэх заалтад "Force majeure" буюу гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, урьдчилан сэргийлж, шинжлэх ухаан, техникийн ололтыг ашиглан даван гарах боломжгүй дараах саад тотгор тохиолдсоны улмаас талууд гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй хүрэхийг хэлнэ гэж зохицуулсан:

1. Зарласан болон зарлаагүй дайн, зэвсэгт мөргөлдөөн, бослого, гадаадын түрэмгийлэл, хорлон сүйтгэх үйл ажиллагаа, хувьсгал;

2. Байгалийн бүх төрлийн гамшиг /хүчтэй салхи шуурга, хар салхи, газар хөдлөлт, хүчтэй давлагаа, үер, цас, зуд, ган гачиг, их хэмжээний бороо, аянга цахилгаан, гал түймэр г.м/;

3. Тэсрэлт, дэлбэрэлт, машин, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн эвдрэл, цахилгааны ноцтой гэмтэл;

4. Бүх төрлийн хязгаар хориг, өвчин, тахал, хорио цээр, хариуцлагаас чөлөөлөгдөх хүсэлтэй талын аж ахуйн нэгжид тохиолдсон ажил зогсолт, ажил хаялт гэх мэт;

5. Төрийн албан тушаалтны хуулийн дагуух болон хууль бус үйлдэл, эс үйлдэл, эрх зүйн акт, тушаал, захирамж, ажлын байр татан буугдах, эд хөрөнгө дайчлан хураах, нийгэмчлэх зэрэг саад тотгор тохиолдсон үед гэрчилгээ олгохоор зохицуулжээ.

Дээрх журамд гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалд хамаарах нөхцөл байдлыг хууль болон УДШ-ийн тайлбарт зааснаас илүү өргөн хүрээнд тодорхойлжээ.

Иргэний хууль, бусад хууль болон Улсын Дээд шүүхийн тайлбарт хүндэтгэн үзэх үндэслэл, шалтгаантай холбоотой зохицуулалт байгаа бөгөөд түүнд гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал хамаарах тухай заасан байна. Гэхдээ гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалд ямар ямар нөхцөл байдал хамаарах тухай бүрэн тодорхой зохицуулалт дутагдаж байгаа юм.

Иймээс шүүх зарим тохиолдолд “Force majeure” буюу гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн тухай МҮХАҮТ-ын журам, уг байгууллагаас гаргасан гарын авлагыг шийдвэрийнхээ үндэслэх хэсэгт заасан байна.[3] Энэ нь шүүх ИХШХШтХ-ийн 10 дугаар зүйлд заасан хууль, олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх зарчимтай зөрчилдөнө.

Ийнхүү гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалд ямар ямар нөхцөл байдал хамаарах тухай хуульд тодорхой заагаагүй байх буюу энэ хэм хэмжээ нь амьдралд үүссэн тодорхой тохиолдлуудыг шийдвэрлэхэд “шүүгчид эрх хэмжээ

[3] К банкны нэхэмжлэлтэй АИ ХХК-д холбогдох маргааны тухай Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 08 дугаар сарын 11-ний 4848 дугаартай шийдвэр (102/2016/00000/И).

олгосон" зохицуулалт юм[4]. Иймээс энэхүү нөхцөл байдалтай холбоотой үүссэн хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдийг судалж, дүгнэлт хийх нь ач холбогдолтой юм.

1.2. ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН МАРГААНЫГ ГЭНЭТИЙН БУЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧНИЙ ШИНЖТЭЙ ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН УЛМААС ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ НЬ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ҮР ДАГАВАР

А. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалтай холбоотой маргааныг хянан шийдвэрлэхдээ олон улсын гэрээ, конвенц хэрэглэх тухай

1980 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр Вена хотноо байгуулсан "Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай НҮБ-ын конвенц" *(Convention on International Sale of Goods)*[5]-ыг Монгол Улс 1997 онд хүлээн зөвшөөрч нэгдэн орсон[6].

Энэ конвенцын 79 дүгээр зүйлд *"Аль нэг тал цургээ гүйцэтгээгүй нь тууний хяналтаас гадна орших саад бэрхшээлээс болсон бөгөөд гэрээ байгуулах цед уг саад бэрхшээлийг тооцох, туунээс зайлсхийх буюу туунийн ур дагаврыг нь давж гарах арга замыг урьдчилан тооцох аргагүй байсныг дээрх тал тус тус нотолбол тухайн тал цурэг гүйцэтгээгүйн хариуцлагыг хүлээхгүй"* тухай зохицуулжээ. Энэхүү зохицуулалтаар үүрэг гүйцэтгэгчийн хяналтаас гадуур бий болох нөхцөл байдал гэрээний

[4] Б.Буянхишиг. "Хууль дээдлэх ёс" сэтгүүл. 2017, №61, Хувийн эрх зүйн тодорхойгүй нэр томьёо ба шүүгчийн эрх хэмжээ. 141 дэх тал.

[5] 1980 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр Вена хотноо байгуулсан "Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай НҮБ-ын конвенц"-д 2019 оны 5 дугаар сарын байдлаар нийт 91 улс нэгдэж ороод байна, https://uncitral.un.org/en/about.

[6] https://legalinfo.mn/law/details/10100?lawid=10100.

үүргийг биелүүлэх боломжгүй нөхцөл үүсгэх тохиолдолд үүрэг гүйцэтгэгч хариуцлагаас чөлөөлөгдөнө.

Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан олон улсын гэрээ, конвенцыг шүүх бага хэрэглэж байгаа буюу судалгааны явцад уншиж судалсан хэргээс нэг л хэргийг шүүх хянан шийдвэрлэхдээ[7] дээрх конвенцын 79 дүгээр зүйлийг хэрэглэж шийдвэрлэсэн байна. Харин зарим хэргийг хянан шийдвэрлэхэд хариуцагч энэхүү конвенцын дээрх зүйл, заалтыг үндэслэж татгалзлаа тайлбарласан байх боловч шүүх хариуцагчийн тайлбарт бүрэн дүгнэлт хийгээгүй байна.[8]

Б. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалтай холбоотой маргааныг шийдвэрлэхдээ Иргэний хууль хэрэглэх тухай

ИХ-ийн 221 дүгээр зүйлд "Хүндэтгэн үзэх үндэслэлээр талууд гэрээнээс татгалзах" асуудлыг зохицуулсан бөгөөд түүнд гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал хамаарах тухай заасан. "Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал, эсхүл талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс гэрээний хугацааг үргэлжлүүлэх, сунгахыг шаардах боломжгүй нөхцөл байдлыг хүндэтгэн үзэх үндэслэл гэж үзнэ" гэж ИХ-ийн 221 дүгээр зүйлийн 221.2 дахь хэсэгт заасан.

Талууд хүндэтгэн үзэх шалтгаанаар гэрээг цуцалснаар (221 дүгээр зүйл) хүлээсэн үүргээ (цаашид) гүйцэтгэхийг гэрээний аль нэг талд тулган хүлээлгэх боломжгүй болно. Нөгөө талаас гэрээг цуцлах нь удаан хугацаанд мөрдөхөөр байгуулсан гэрээний харилцаанд гарч болзошгүй, урьдчилан хараагүй нөхцөл

[7] ИССМ ХХК-ийн нэхэмжлэлтэй Ватт ХХК-д холбогдох гэрээний маргаан (102/ШШ2019/00895),

[8] Н.Д-гийн нэхэмжлэлтэй хариуцагч Б.О, Л.Ө нарт холбогдох гэрээний маргаан (102/ШШ2020/03405),

байдлыг тооцож, харгалзан үзэхээр гэрээнд заасан хэрэгсэл байж болдог. Нэгэнт байгуулсан гэрээг дагаж мөрдөх зарчим үүгээр хязгаарлагдахгүй. Харин эсрэгээр гэрээний үндэс суурь үгүйсгэгдэж, үгүй болох нь онцгой тохиолдолд хэрэглэгдэхээр хязгаарлагдсан, гэрээний үүргээс ангижрах эрх зүйн нэг боломжийг үндэслэж нотолдог.[9]

Иймээс шүүх шийдвэрийн үндэслэх хэсэгтээ хүндэтгэн үзэх ямар нөхцөл байдал тохиолдсон, энэ нь ИХ-ийн заалттай нийцэж байгаа эсэхэд дүгнэлт хийж, шийдвэрийнхээ тогтоох хэсэгт ИХ-ийн 221 дүгээр зүйлийг хэрэглэнэ. Гэвч зарим тохиолдолд, жишээ нь, ИХШХШтХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсэгт "... нийтэд илэрхий үйл баримт хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой байвал түүнийг дахин нотлохгүй" гэж заасан бөгөөд дэлхий нийтэд тархсан Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хөл хорио тогтоосон Улсын Онцгой комиссын шийдвэр нийтэд илэрхий үйл баримт тул дахин нотлохгүй[10] хэмээн шийдвэрийнхээ үндэслэх хэсэгт заасан боловч тогтоох хэсэгтээ ИХ-ийн 221 дүгээр зүйлийг хэрэглээгүй байна.

Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэрээ дуусгавар болох тохиолдолд ИХ-ийн ерөнхий ангийн 78.1.3, 221 дүгээр зүйлээс гадна энэ талаар зохицуулсан үүргийн эрх зүйн тусгай ангийн зүйл, заалт болох 255.1.3, 319.2, 321.3, 352.5.3, 356, 373.4, 384.2, 393.7, 419.2, 427.2, 499.2, 500.2 дугаар зүйлүүдийг шүүх хэрэглэж шийдвэрлэхээр зохицуулжээ.

9 Й.Кают нар. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. 2015, 423 дахь тал.

10 Т.Б-гийн нэхэмжлэлтэй ЭГБ сургалтын байгууллагад холбогдох сургалтын төлбөр гаргуулах иргэний хэргийн тухай Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 09 дүгээр сарын 30-ны 183/ШШ2020/02603 дугаартай шийдвэр (183/2020/02606/И).

В. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас үүссэн маргааныг шийдвэрлэхдээ нотлох баримтыг үнэлэх талаар

ИХШХШтХ-ийн 37 дугаар зүйлд хэргийн бодит нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай аливаа баримтат мэдээлэл нотлох баримт болох бөгөөд энэ нь дараах үндсэн шинжийг нэгэн зэрэг агуулж байх тухай заасан:

1. Хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий буюу хэрэгт хамааралтай байх;
2. Хуульд заасан арга хэрэгслээр олж авсан байх.

Энэ шинжийг агуулсан нотлох баримт нь зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн тайлбар ... зэрэг нотолгооны хэрэгслээр тогтоогдох тухай ИХШХШтХ-ийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэгт заасан.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэгт МҮХАҮТ "давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх" тухай заасан. Гэвч ИХШХШтХ-ийн дээрх зохицуулалтаар гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас үүссэн маргааныг шүүх хянан шийдвэрлэхдээ тухайн нөхцөл байдлыг зөвхөн энэхүү гэрчилгээгээр нотолно гэж үзэхээргүй байна.

Судалгаа хийсэн 117 шүүхийн шийдвэрт 30 төрлийн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал байгаагаас 16 нь байгаль, цаг уурын шинжтэй байв.

Зохигчид гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлыг нотолж, жишээ нь, байгаль, цаг уурын давагдашгүй хүчин зүйл тохиолдсон тухай Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, тухайн нутаг дэвсгэрийн Цаг уур, орчны шинжилгээний газар, Засаг даргын албан бичиг, тодорхойлолт бичгийн нотлох баримт ба гэрчийн мэдүүлгийг

хэрэгт нотлох баримтаар өөрөө болон шүүхээр бүрдүүлүүлэн хэрэгт хавсаргасан байна.

Гэтэл шүүх гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлтэй тулгарсныг гэрчилж баталгаажуулсан Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээг МҮХАҮТ-аас гаргуулаагүй байх тул нотлоогүй хэмээн шийдвэрлэсэн зарим шийдвэр байна.[11]

Мөн төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагааны улмаас гэрээний үүргээ биелүүлж чадаагүй 14 тохиолдол байх ба түүнийг гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалд тооцож үнэлсэн[12] боловч зарим тохиолдолд хавтаст хэрэгт төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр авагдсан ч нотлоогүй[13] гэх тохиолдол байна. Эрх бүхий байгууллагын шийдвэрийн улмаас гэрээний нэг тал үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон нөхцөл байдлыг шүүх гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалд хамааруулахдаа зарим тохиолдолд эргэлзээтэй шийдвэрийг үнэлж хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Тухайлбал, сумын Засаг даргын өргөн мэдүүлснээр газрыг тусгай хэрэгцээнд авах тухай шийдвэрийг аймаг, сумын ИТХ гаргахаар Газрын тухай хуульд (шинэчилсэн найруулгад) заасан байх боловч газрыг тусгай хэрэгцээнд авах тухай сумын Засаг даргын албан бичгийг[14] үндэслэн давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал гэж дүгнэсэн нь эргэлзээтэй байна.

Ковид-19 цар тахлын улмаас гадаад улс орон болон Монгол Улсад хөл хорио тогтоосон, Монгол Улсын хилээр орох, гарах хөдөлгөөнийг хориглосны улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ гүй-

[11] ЧТ ХХК-ийн нэхэмжлэлтэй Увс аймгийн УДХС ТӨХК-д холбогдох гэрээний маргааны тухай Увс аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 05 дугаар сарын 13-ны 184 дугаартай шийдвэр (152/2019/00115/И).

[12] Э Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын нэхэмжлэлтэй А ХХК-д холбогдох гэрээний маргаан (184/ШШ2019/02761).

[13] МВС ХХК-ийн нэхэмжлэлтэй ААК ХХК-д холбогдох гэрээний маргаан (00128).

[14] ИССМ ХХК-ийн нэхэмжлэлтэй Ватт ХХК-д холбогдох гэрээний маргаан (102/ШШ2019/00895).

цэтгэх боломжгүй болсонтой холбоотой 2020 оноос 2021 оны 05 дугаар сарын хооронд 35 маргаан хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт судалгаа хийсэн болно.

ИХШХШтХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсэгт "... нийтэд илэрхий үйл баримт хэрэг хянан шийдвэрлэхэд холбогдолтой байвал түүнийг дахин нотлохгүй" тухай заасан бөгөөд Ковид-19 цар тахал нь нийтэд илэрхий үйл баримт юм. Гэвч түүний улмаас үүссэн маргааныг шүүх дараах байдлаар хянан шийдвэрлэжээ. Үүнд:

а) Ковид-19 цар тахал нь нийтэд илэрхий үйл баримт тул дахин нотлохгүй бөгөөд гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалд хамаарна. Жишээ нь, С ХХК-ийн нэхэмжлэлтэй АП ХХК-д холбогдох гэрээний маргаан[15];

б) Ковид-19 цар тахлын улмаас бизнесийн үйл ажиллагаа доголдсон, зогссон тухай нотлоогүй байна. МҮХАҮТ-аас гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ гаргуулаагүй тул нотлоогүй;[16]

в) Хэргийн оролцогчид Ковид-19 цар тахлын улмаас гэрээний үүргээ биелүүлээгүй тухай тайлбарласан боловч түүнийг огт үнэлэхгүй, дүгнэлт хийхгүйгээр хэргийг хянан шийдвэрлэсэн[17] гэх мэт шийдвэрүүд байна.

---

15 С ХХК-ийн нэхэмжлэлтэй АП ХХК-д холбогдох гэрээний маргаан хянан шийдвэрлэсэн Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 1343 дугаартай магадлал (181/2020/00733/И), http://new.shuukh.mn/irgendavah/15766/view

16 https://shuukh.mn/single_case/102593?daterange=2021-01-01%20-%202021-05-01&id= 1&court_cat=1&bb=1

17 http://new.shuukh.mn/irgenanhan/100906/view

Г. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас үүсэх эрх зүйн үр дагавар

ИХ-ийн 206 дугаар зүйлд үүргийг тогтоосон газар, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэх тухай заасан. Хэрэв үүрэг зөрчсөн бол хохирлыг нөхөн төлөх үүрэг үүснэ. Дараах гурван нөхцөл бүрдсэн тохиолдолд хохирлыг нөхөн төлөх үүрэг үүснэ:

1. Тухайн хохирол учрах үед хохирогч болон хохирол учруулагчийн хооронд үүргийн харилцаа үүссэн байх;
2. Хохирол учруулагч нь уг үүргийн харилцаанд хүлээсэн үүргээ зөрчсөн байх;
3. Хохирол учруулагчийн буруугаас уг үүрэг зөрчигдсөн байх.[18]

Мөн гэрээний тогтвортой байдал, талуудын хариуцлага, итгэлцлийг нэмэгдүүлэхийн тулд тодорхой хугацаа харгалзалгүй, үндэслэлгүйгээр гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах тохиролцоог ИХ-ийн 189 дүгээр зүйлээр хязгаарласан байдаг. Мөн талууд гэрээнээс татгалзаж болохгүй үндэслэлийг ИХ-ийн 225 дугаар зүйлийн 225.4 дэх хэсэгт заасан.

Гэвч үүрэг гүйцэтгэх явцад үүргийн гүйцэтгэлд саад болох нөхцөл байдал үүсэж болох бөгөөд энэ тухай ИХ-ийн 209, 219-227 дугаар зүйл болон гэрээний эрх зүйн зарим зүйлд заасан тухай дээр дурдсан.

Тухайлбал, үүрэг гүйцэтгэгч гэм буруугүй буюу хүндэтгэн үзэх шалтгааны улмаас үүрэг гүйцэтгэх боломжгүй бодит нөхцөл байдал бий болсноор гэрээг дуусгавар болгох, хариуцлагаас чөлөөлөгдөх эрх зүйн үр дагавар үүсдэг. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал, эсхүл талуудын

[18] Й.Кают нар. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. 2015, 416 дахь тал.

эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс гэрээний хугацааг үргэлжлүүлэх, сунгахыг шаардах боломжгүй нөхцөл байдлыг хүндэтгэн үзэх үндэслэл гэж үзнэ" хэмээн ИХ-ийн 221 дүгээр зүйлд заажээ.

Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэрээ цаашид үргэлжлэх боломжгүй болж гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болон хариуцлагаас чөлөөлөх нөхцөл байдал үүснэ. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалд ИХ-ийн 221 дүгээр зүйлд хүндэтгэн үзэх шалтгаан байсан болох нь баримтаар тогтоогдсон тохиолдолд төлбөрийн үлдэгдлийг төлж чадаагүй хугацаа хожимдуулсан явдалд хариуцагч гэм буруугүй гэж шүүх үзэж, хүү, алданги төлөх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болдог.

Улсын Дээд шүүх гэрээний эрх зүйн зарим маргааны хууль хэрэглээ болон гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахад анхаарах асуудлуудын талаар дараах зөвлөмжийг өгчээ. Тухайлбал, хүчин төгөлдөр байгуулагдсан гэрээг хууль буюу гэрээнд заасны дагуу гэрээний нэг талын хүсэл зоригоор буцаахыг гэрээнээс татгалзах гэнэ. Харин хууль буюу гэрээнд заасны дагуу нэг тал хүсэл зоригоо илэрхийлснээр хүчин төгөлдөр гэрээний хэрэгжсэн хэсэг хэвээр үлдэж, үүргийн харилцааг цаашид дуусгавар болгохыг гэрээг цуцлах гэнэ.

Гэрээнээс татгалзах тохиолдолд талууд гэрээгээр өгсөн авснаа буцаадаг бол гэрээг цуцлахад цуцлах хүртэлх гэрээний харилцаа хэвээр үлдэж, цуцалснаас хойших үр дагаврыг талууд шийдвэрлэдэг ялгаа байдаг. Гэрээг цуцлах ойлголт ихэвчлэн урт хугацаатай үүргийн харилцаанд, харин гэрээнээс татгалзах явдал хиймэгц биелэх буюу гэрээгээр олж авсан зүйлийг харилцан буцаах боломжтой хэлцэлд хэрэглэгдэнэ. Ямар тохиолдолд гэрээг цуцлах, гэрээнээс татгалзах ойлголт хэрэглэгдэхийг зөвхөн гэрээний хугацаа бус, хэлцлийн дагуу нэгэнт хэрэгжсэн харилцааг буцаах боломжгүй болсон, эсвэл талууд гэрээгээр

авсан зүйлээ харилцан буцааж өгөх боломжтой буюу гэрээг анхны байдалд эргүүлж авчрах боломжтой эсэхээс хамаарч тодорхойлно. Урт хугацаатай гэрээнд зөвхөн гэрээг цуцлах ойлголт байдаг гэж үзэх нь өрөөсгөл болно.

Гэрээний эрх зүйн маргаанд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах асуудлыг шийдвэрлэхэд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл, журмыг зохицуулсан ИХ-ийн ерөнхий ангийн 204, 205, 221, 225, 227 дугаар зүйлээс гадна энэ талаар зохицуулсан үүргийн эрх зүйн тусгай ангийн зүйл, заалт нь хэрэглэвэл зохих хууль мөн. Тусгайлсан зарим зохицуулалтын хувьд тухайн гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах журмыг шууд зохицуулсан бол зарим тохиолдолд үүргийн нийтлэг үндэслэлийг хэрэглэх нөхцөлөөр зохицуулжээ. Гэрээг цуцлах, гэрээнээс татгалзах тохиолдолд гэрээг дуусгавар болгох хүсэл зориг адилхан агуулагддаг. Энэ утгаараа ИХ-ийн үүргийн нийтлэг зохицуулалтад зөвхөн гэрээнээс татгалзах журмыг зохицуулсан боловч уг журмын зарим зохицуулалт гэрээг цуцлах тохиолдолд хамааралтай. ИХ-ийн 204, 221, 225, 227 дугаар зүйл гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах аль ч үед хэрэглэгдэнэ. Харин ИХ-ийн 205 дугаар зүйлд гэрээнээс татгалзсанаас үүсэх үр дагаврыг зохицуулсан байх тул гэрээг цуцлахад хэрэглэгдэх зохицуулалт биш байна. ИХ-ийн 204 дүгээр зүйлийн 204.1-д зааснаар аль нэг тал нь гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах бол энэ тухай нөгөө талдаа мэдэгдэх ёстой гэжээ. Мэдэгдэхэд хуулиар хэлбэрийн шаардлага тавиагүй тул мэдэгдсэн байдлыг тогтоосон нотолгооны хүрээнд дүгнэлт өгнө[19] гэжээ тодорхой жишээгээр тайлбарлаж зөвлөсөн байна.

Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэх боломжгүй байдалд хүрсэн нь түүний гэм буруугаас болоогүй байдаг.

[19] Монгол Улсын Дээд шүүхийн 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн "Гэрээний зарим эрх зүйн маргааны хууль хэрэглээ болон гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахад анхаарах асуудлууд" зөвлөмжийн 2 дахь хэсэг.

ИХ-д аливаа этгээдийн хариуцлагыг тооцохдоо эх газрын эрх зүйн тогтолцоонд мөрддөг гэм буруугийн зарчмыг (ялангуяа хохирол арилгах нөхцөлд) удирдлага болгодог. Энэ нь Англи-Саксоны эрх зүйн тогтолцооноос ялгарах онцлог билээ.[20]

Объектив болон субьектив хүчин зүйлсийн нөлөөллөөр үүрэг дуусгавар болох тохиолдол цөөнгүй. Тухайлбал, байгалийн гамшиг (гал, усны аюул, газар хөдлөлт гэх мэт)-аас шалтгаалан үүргийн зүйл устсан бол үүргийг биет байдлаар биелүүлэх боломжгүй болно. Энд объектив хүчин зүйлийн нөлөөлөл байгаа учраас гэм буруугийн асуудал яригдахгүй[21] тул хариуцлага хүлээлгэх боломжгүй юм.

Гэнэтийн (шинжлэх ухааны түвшинд урьдчилан тогтоох, тогтоосон ч урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах боломжгүй) байхаас гадна жирийн нөхцөлд хамаарахгүй (өвөл, салхи гарах, бороо, мөндөр, цас орох гэх мэт) онцгой буюу зөвхөн үүрэг хүлээсэн этгээдэд нөлөөлөөгүй, нийтийг хамарсан, зарим тохиолдолд бүх нутаг дэвсгэр, бүх хүн амыг хамарсан (ган гачиг, гал түймэр, газар хөдлөлт, Ковид-19 зэрэг хүн, амьтны халдварт өвчин) нөхцөл байдлыг гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал гэнэ. Иймээс шүүх гэм буруугүй гэж үзэж хариуцлагаас чөлөөлдөг. Жишээ нь, зохигчдын байгуулсан гэрээнд байгалийн давагдашгүй хүчин зүйлд өртсөн тохиолдолд гэрээний төлбөр төлөх үүргээс хариуцагчийг чөлөөлөхгүй гэж тохирсон нь үүрэг гүйцэтгэх хугацааг хэтрүүлснээс үүсэх хариуцлага буюу алдангиас чөлөөлөхгүй байх үндэслэл болохгүй. Учир нь хариуцагч гэрээнд үнэнч байх зарчмын хүрээнд авсан зүйлийнхээ төлбөрийг заавал төлөх үүрэг хүлээх боловч үүргээ хугацаандаа биелүүлэхэд нь байгалийн давагдашгүй хүчин зүйл

[20] Бат-Эрдэнийн Буянхишиг. Үүргийн эрх зүйн ерөнхий анги. Анхны хэвлэл, 2013, 155 дахь тал (ISBN 978-99962-2-373-0).

[21] Даваасүрэнгийн Наранчимэг. Иргэний эрх зүйн үндсэн асуудал. I дэвтэр, 1999, 84 дэх тал.

нөлөөлсөн бол гэм буруутайгаар үүргээ зөрчсөнд тооцох учиргүй тул алданги төлөх үүрэг үүсэхгүй, хэрэв алданги төлөх үүрэг ногдуулбал шударга ёсны зарчимд нийцэхгүй[22] гэж шүүх шийдвэрлэсэн байна.

Харин зарим тохиолдолд талууд гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас хариуцлагаас чөлөөлөгдөх асуудлыг гэрээндээ зохицуулаагүй[23] тул гэрээнд заасан үүрэг, хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэлгүй хэмээн шийдвэрлэсэн нь бодит үнэн, хэргийн үйл баримттай нийцэхээргүй юм.

Гэрээг сайн дурын үндсэн дээр хүсэл зоригоо илэрхийлж чөлөөтэй байгуулдаг ч талуудын тэгш эрхийг хангах зарчимд нийцэж байх шаардлагатай тул гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын талаар зохицуулсан ИХ-ийн 221 дүгээр зүйлийн 221.2 дахь хэсэг болон тухайн тодорхой үүргийн харилцаанд энэ нөхцөл байдлын улмаас талуудад үүсэх эрсдэлийг хуваарилсан хэм хэмжээг хэрэглэж шийдвэрлэх нь хууль зүйн үндэслэлтэй болно.

[22] https://shuukh.mn/single_case/101048?daterange=2020-01-01%20-%20021-06-21&id=1&court_cat=1&bb=1&fbclid=IwAR0vQyIwctVqXbWK1qY 7tv DzpDxWqq0lrMeS3AF TXY 4ju9mCLg rPYyvExQo

[23] А ББСБ ХХК-ийн нэхэмжлэлтэй хариуцагч О.М, Д.А нарт холбогдох зээлийн гэрээний маргааны тухай Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 183/ШШ2020/00435 дугаартай шийдвэр (182/2019/01390/И).

3

ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1. ГЭНЭТИЙН БУЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧНИЙ ШИНЖТЭЙ ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТУХАЙ ЗАРИМ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ БА ШИЙДВЭР СОНГОН СУДАЛСАН ҮНДЭСЛЭЛ

Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нэхэмжлэгч тал гэрээ цуцлах, үндсэн зээл, төлбөр болон хүү, алданги төлүүлэхээр нэхэмжлэл гаргажээ. Хариуцагч тал гол төлөв гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсны улмаас хүү, нэмэгдүүлсэн хүү, алданги төлөхөөс татгалзаж маргасан байна. Анхан шатны шүүхээс гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдал биш гэсэн 9, тухайн үед биш гэсэн 3, гэрээнд заагаагүй гэсэн 8, гэрээнд болон хуульд заасан хугацаанд мэдэгдээгүй гэсэн 5 буюу тухайн нөхцөл байдалд хамааруулаагүй нийт 25 шийдвэр, нотлоогүй 26, тайлбар, нотлох баримт үнэлээгүй 21, мөн гэж үзсэн 45 шийдвэр, бүгд 117 шийдвэрт судалгаа хийсэн. Эдгээр нөхцөл байдлаас хамааран алданги, нэмэгдүүлсэн хүү, торгууль зэрэг гэрээний хариуцлагатай холбоотой зарим шаардлагыг хангаж, заримыг нь хангахаас татгалзсан, эсхүл багасгаж шийдвэрлэсэн байна. Давж заалдах, хяналтын шатны шүүх доод шатны шүүхийнхээ тухайн нөхцөл байдлыг гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалд

хамааруулаагүй, нотлоогүй, үнэлээгүй нийт 72 шийдвэрээс 5[24] тохиолдлын алдааг залруулан шийджээ.

Харин шүүх гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал мөн бөгөөд нотлогдсон гэж дүгнэсэн 45 хэргээс алданги, нэмэгдүүлсэн хүү, торгуулиас чөлөөлж шийдвэрлэсэн 12 шийдвэр байна. Мөн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал болсныг нэхэмжлэгч хүлээн зөвшөөрсөн зэрэг бусад үндэслэлээр алданги, нэмэгдүүлсэн хүү, торгууль нэхэмжлээгүй 33 шийдвэр байна.

Ийнхүү 2016-2021 оны хооронд гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас маргаан үүсэж шүүхээр шийдвэрлүүлсэн 117 хэрэг маргааныг судлахад нийт 22 салбарыг хамарсан гэнэтийн буюу давагдашгүй 30 төрлийн хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдал тохиолдсон тухай хэргийн оролцогчид тайлбарлаж, нотлох баримт гаргасан 16 төрлийн маргааныг шүүх хянан шийдвэрлэсэн байна. Энэхүү маргаан нь гол төлөв газар тариалан, мал аж ахуй, барилга зэрэг салбарт цаг агаар, байгалийн гамшигт үзэгдлүүд болох ган, аадар бороо, салхи, үер, дулаарал, мал, амьтны гоц халдварт өвчин ба эрх бүхий байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа зэргийн улмаас үүсжээ. Энэ нөхцөл байдалтай холбоотой маргаанд худалдах, худалдан авах гэрээ, зээлийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ, түрээсийн гэрээтэй холбоотой маргаан дийлэнх хувийг нь эзэлж байсан бөгөөд тэдгээрийг түүвэрлэн харуулж байна.

[24] С ХХК-ийн нэхэмжлэлтэй АП ХХК-д холбогдох гэрээний маргааны Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 1343 дугаартай магадлал (181/2020/00733/И).

Хүснэгт №1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл илүү тохиолдож буй салбар, түүний улмаас үүсэж байгаа маргааны төрөл ба шүүхийн шийдвэрт тэдгээрийн эзлэх хувь

Давагдашгүй хүчин зүйлийн нэр	Тоо	Хувь	**Салбар**	Тоо	Хувь	**Маргааны төрөл**	Тоо	Хувь
Ковид-19	35	29.9	Хувийн бизнес	5	4.3	Зээлийн гэрээ	38	32.5
Мал, амьтны халдварт өвчин	5	4.3	Газар тариалан	27	23.1	Худалдах, худалдан авах гэрээ	36	30.8
Аадар бороо, салхи	2	1.7	Хүнсний үйлдвэр	6	5.1	Хөлсөөр ажиллах гэрээ	4	3.4
Үер	5	4.3	Боловсрол	4	3.4	Зээлээр худалдах, худалдан авах гэрээ	5	4.3
Ган	15	12.8	Уул уурхай	6	5.1	Ажил гүйцэтгэх гэрээ	16	13.7
Гал түймэр	7	6.0	Аялал жуулчлал	3	2.6	Түрээсийн гэрээ	5	4.3

Хүснэгт №1-ийн үргэлжлэл

Төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа	14	12.0	Зам тээвэр	10	8.5			
Гадаад улсын төрийн байгууллагын шийдвэр	1	0.9	Барилга	15	12.8			
Эдийн засгийн хүндрэл	8	6.8	Үйлчилгээ	4	3.4			
			Мал аж ахуй	10	8.5			
			Эрчим хүч, дулаан	4	3.4			
Нийт	**92**			**94**			**104**	

Эдгээр давагдашгүй хүчин зүйл түлхүү тохиолдож байгаа салбарууд болон тэдгээрийн улмаас үүссэн маргааны төрлийг шалгуур болгон дараах шийдвэрүүдийг сонгож дүн шинжилгээ хийсэн болно.

Хүснэгт №2. Дүн шинжилгээ хийсэн шүүхийн шийдвэрүүд

№	Шүүхийн шийдвэрийн үндэслэл	Шийд-вэрийн он	Шүүхээр шийдвэрлэгдсэн байдал	Маргааны төрөл	Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл	Эрхэлсэн үйл ажиллагаа, хамаарах салбар
1	Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлыг тогтоосон тухай шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ	2016	Хоёр шатны шүүх	Цахилгаан эрчим хүчээр хангах, түүнийг хэрэглэх гэрээ	Эдийн засгийн хүнд нөхцөл байдал	Эрчим хүч, дулаан
		2016	Гурван шатны шүүх	Худалдах, худалдан авах гэрээ	Ган	Газар тариалан
		2017	Гурван шатны шүүх	Зээлийн гэрээ	Гал	Хүнсний үйлдвэрлэл
		2017	Гурван шатны шүүх	Зээлийн гэрээ	Үер	Уул уурхай (нөхөн сэргээлт)
		2017	Нэг шатны шүүх	Худалдах, худалдан авах гэрээ	Үер	Уул уурхай
		2017	Нэг шатны шүүх	Хөлсөөр ажиллах гэрээ	Аадар бороо, салхи	Мал аж ахуй

Хүснэгт №2-ын үргэлжлэл

1		2018	Нэг шатны шүүх	Худалдах, худалдан авах гэрээ	Ган гачиг	Газар тариалан
		2018	Нэг шатны шүүх	Аялал жуулчлалын гэрээ	Гадаад улсын төрийн байгууллагын шийдвэр	Аялал жуулчлал
		2018	Нэг шатны шүүх	Ажил гүйцэтгэх гэрээ	Үер	Зам тээвэр
		2019	Нэг шатны шүүх	Ажил гүйцэтгэх болон түрээсийн хосолсон гэрээ	Төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр	Барилга
		2019	Нэг шатны шүүх	Зээлийн гэрээ	Шүлхий өвчин	Мал аж ахуй
		2020	Хоёр шатны шүүх	Худалдах, худалдан авах гэрээ	Ковид-19 (Төрийн байгууллагын шийдвэр)	Барилга
		2020	Хоёр шатны шүүх	Хөлсөөр ажиллах гэрээ	Ковид-19	Боловсрол
		2021	Нэг шатны шүүх	Худалдах, худалдан авах гэрээ	Хүчтэй салхи, аадар бороо, мөндөр	Газар тариалан

2	Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалд хамааруулаагүй тухай шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ	2020	Хоёр шатны шүүх	Зээлийн гэрээ	Ган гачиг	Газар тариалан
3	Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлыг зохигчид нотлоогүй тухай шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ	2019	Нэг шатны шүүх	Ажил гүйцэтгэх гэрээ	Их хэмжээний цас орж зам, даваа хаагдсан	Зам тээвэр /авто тээвэр/
		2020	Хоёр шатны шүүх	Зээлийн гэрээ	Ковид-19	Хувийн бизнес
		2020	Нэг шатны шүүх	Зээлийн гэрээ	Ковид-19	Хувийн бизнес
4	Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын тухай тайлбар, нотлох бусад баримтыг үнэлээгүй шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ	2020	Нэг шатны шүүх	Худалдах, худалдан авах гэрээ	Ковид-19	Үйлчилгээ
		2021	Нэг шатны шүүх	Зээлийн гэрээ	Ковид-19	Үйлчилгээ

Мөн шүүхийн цахим сангаас түүвэрлэсэн нийт шийдвэрт гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын талаарх талуудын тайлбар, нотлох баримтыг шүүх дараах байдлаар үнэлж шийдвэрлэсэн байна.

Хүснэгт №3. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлыг хэрхэн үнэлсэн тухай шүүхийн шийдвэр ба нотлох баримт, нийт шийдвэрт тэдгээрийн эзлэх хувь

№	Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлыг шүүх хэрхэн үнэлсэн тухай	Тоо	Хувь
1	Мөн буюу нотолсон	45	38.5
2	Биш бөгөөд хамааруулаагүй үндэслэл – Биш /гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдалд хамаарахгүй/	9	7.7

Хэрэгт хавсаргасан нотлох баримтууд	Тоо	Хувь
Тайлбарласан боловч нотлох баримт гараагүй	55	47
Нотлох баримт гаргасан эсэх нь тодорхойгүй буюу нотлох баримт гаргасан талаар шийдвэрт тусгаагүй	14	12
Цаг уур, орчны шинжилгээний газрын албан бичиг, тодорхойлолт	8	11.1
ОБЕГ, Онцгой байдлын газрын дүгнэлт /улсын байцаагч, шинжээчийн дүгнэлт/, тодорхойлолт	13	11.1

2			
	– Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын үед биш	3	2.6
	– Гэрээнд заагаагүй	8	6.8
	– Гэрээнд болон хуульд заасан хугацаанд мэдэгдээгүй	5	4.3
3	Нотлоогүй	26	22.2
4	Үнэлээгүй	21	17.9

МҮХАҮТ-ын давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ	11	9.4
МҮХАҮТ-ын хүнд нөхцөл байдлын гэрчилгээ	5	4.3
Хохирол тогтоосон акт, хохирлын үнэлгээний тайлан, дүгнэлт	1	0.9
Талууд маргаагүй, хүлээн зөвшөөрсөн тайлбар	3	2.6
Гэрээний нэг талдаа хүргүүлсэн болон хариу албан бичиг	4	3.4
Төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа	10	8.5
Засаг даргын шийдвэр, тодорхойлолт, албан бичиг	4	3.4
Шинжээчийн дүгнэлт	3	2.5
Гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ	1	0.9
Гэрчийн мэдүүлэг	2	1.7
Эмчлүүлэгчийн карт	1	0.9
Прокурорын тогтоол /дүгнэлт/	1	0.9

Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалтай холбоотой тайлбар, нотлох баримтыг шүүх хэрхэн үнэлсэн байдлыг шалгуур болгон шүүхийн шийдвэрийн агуулгад хийх дүн шинжилгээг дөрвөн хэсэгт хуваажсудаллаа.

Ковид-19 цар тахалтай холбоотой 35 маргаан байх бөгөөд түүний 2-т нь МҮХАҮТ-аас давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ авсан ба 1-д нь үүргээ биелүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэнийг нөгөө талдаа мэдэгдсэн тухай шүүхийн шийдвэрт заажээ. Нотлох баримт гаргаагүй нийт 55 шийдвэрийн 32 нь Ковид-19 цар тахалтай холбоотой маргаан байна.

Хэрэгт авагдсан нотлох баримтыг шүүхийн шийдвэрээс судлахад 14 шийдвэрт нь гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдалтай холбоотой ямар нотлох баримт гаргасан, эсхүл гаргаагүй тухай шийдвэртээ тусгаагүй байгаа болно.

Байгаль, цаг уурын шинжтэй гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл илүү их тохиолдож байгаа тул хэрэгт Цаг уур, орчны шинжилгээний газрын албан бичиг, тодорхойлолт, ОБЕГ, Онцгой байдлын газрын дүгнэлт /улсын байцаагч, шинжээчийн дүгнэлт/, тодорхойлолт, МҮХАҮТ-ын давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ хавсаргасан нь ихэнх хувийг эзэлж байна. Мөн төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагааны улмаас маргаан үүсэж байгаа нь дээрх нотлох баримтын судалгаанаас харагдаж байна.

2.2. ГЭНЭТИЙН БУЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧНИЙ ШИНЖТЭЙ ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ТОГТООСОН ТУХАЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Дараах хүчин зүйлсийг гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал гэж шүүх дүгнэжээ:

1. Төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр[25]
2. Ковид-19 цар тахал[26]
3. Мал, амьтны халдварт шүлхий өвчин[27]
4. Гал түймэр[28]
5. Хүчтэй салхи, аадар бороо, мөндөр[29]
6. Эдийн засгийн хүнд нөхцөл[30]
7. Гадаад улсын төрийн байгууллагын шийдвэр[31]

---

25 Э Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын нэхэмжлэлтэй А ХХК-д холбогдох гэрээний маргааны тухай Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 10 дугаар сарын 31-ний 184/ШШ2019/02761 дугаартай шийдвэр (184/2019/01956/И).

26 С ХХК-ийн нэхэмжлэлтэй хариуцагч АП ХХК-д холбогдох гэрээний маргааны тухай Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 05 дугаар сарын 05-ны 181/ШШ2020/01180 дугаартай шийдвэр (181/2020/00733/И).

27 МХ сангийн нэхэмжлэлтэй хариуцагч Т ХХК-д холбогдох зээлийн гэрээний үүрэгт 1,500,000,000 төгрөг гаргуулах хэргийн тухай Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатын шүүхийн 2019 оны 04 дүгээр сарын 30-ны 184/ШШ2019/01122 дугаартай шийдвэр (184/2019/00689/И).

28 Т банкны нэхэмжлэлтэй ГГУ ХХК, ГХУ ХХК, Б.А, Өмнөговь аймгийн ИТХ-д холбогдох зээлийн гэрээний тухай Өмнөговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 01 дүгээр сарын 10-ны 20 дугаартай шийдвэр (143/2016/00354/И).

29 ОБЕГ-ын нэхэмжлэлтэй М ХХК-д холбогдох гэрээний маргааны тухай Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 02 дугаар сарын 02-ны 183/ШШ2021/00285 дугаартай шийдвэр (183/2020/1181/И).

30 ШТ ХХК-ийн нэхэмжлэлтэй ЭБЦТС ТӨХК-д холбогдох гэрээний маргааны тухай Орхон аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 06 дугаар сарын 16-ны 00844 дугаартай шийдвэр (142/2016/00775/И).

31 Б.А-гийн нэхэмжлэлтэй ТТ ХХК-д холбогдох гэрээний маргааны тухай Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 04-ний 1936 дугаартай шийдвэр (182/2018/02096/И).

8. Ган[32]
9. Аадар бороо, салхи[33]
10. Аадар бороо, үер[34]
11. Хортон шавьж /нугын бор эрвээхэй/[35]

Тохиолдол 1. ШТ ХХК нь ЭБЦТС ТӨХК-тай 2014 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Цахилгаан эрчим хүчээр хангах, хэрэглэх гэрээ байгуулж, хоёр удаа сунгасан байна. Гэрээний дагуу талууд 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр тооцоо нийлж, үндсэн өр, алдангийн тооцоог гаргажээ. ШТ ХХК нь Орхон аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжаар "Төлбөрийн чадваргүй"-д тооцогдож, компанийг дахин хөрөнгөжүүлэх хоёр жилийн төлөвлөгөөний дагуу ажиллаж байгаа. Тус ХХК-ийг өөрсдийн үйл ажиллагаанаас шалтгаалахгүй үндэслэлээр эдийн засгийн хүнд нөхцөл байдалд орсныг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэг, МҮХАҮТ-ын дүрмийн 2 дугаар зүйлийн 2.3.13-т заасны дагуу "Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдлын баталгаа гаргах журам"-ын дагуу МҮХАҮТ-аас нотолж, Хүнд нөхцөл байдлын /Hardship/ гэрчилгээ олгосон байна. Тиймээс ШТ ХХК нь алдангийг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргажээ. Харин хариуцагч гэрээний холбогдох зохицуулалтаар алданги тооцох үндэслэлтэй гэж маргасан.

---

[32] ОБГ-ын нэхэмжлэлтэй ТӨ ХХК-д холбогдох гэрээний маргааны тухай Дархан-Уул аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 06 дугаар сарын 06-ны 666 дугаартай шийдвэр (135/2018/00611/N/).

[33] Зэвсэгт хүчний ... дугаар ангийн нэхэмжлэлтэй Д.Б, В.М, Г.Р нарт холбогдох гэрээний маргааны тухай Орхон аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 27-ны 00008 дугаартай шийдвэр (142/ШШ2018/00008).

[34] СГ-гийн нэхэмжлэлтэй УАӨСЗД-д холбогдох гэрээний маргааны тухай Увс аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 29-ний 933 дугаартай шийдвэр (152/2018/00897/И/).

[35] ЗНО ХХК-ийн нэхэмжлэлтэй МА ХХК-д холбогдох гэрээний маргааны тухай Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 102/ШШ2021/00066 дугаартай шийдвэр (102/2020/02647/И).

Шүүхээс хэргийг шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүхээс талуудын хооронд байгуулагдсан цахилгаан эрчим хүчээр хангах, түүнийг хэрэглэх гэрээний 2.7-д "Форс мажор /байгалийн гэнэтийн аюул, аянга, хүчтэй салхи шуурга, мөстөлт, усны үер, газар хөдлөлт, гал түймэр гэх мэт/-ын үеэр шугам тоноглолд гэмтэл, саатал гарсан нөхцөлд хэрэглэгчид учирсан хохирлыг хангагч хариуцахгүй гэх зохицуулалт байгаа боловч уг гэрээнд хүнд нөхцөл байдлын буюу Hardship-ийн тодорхой нөхцөл байдал бий болбол хэрхэн шийдвэрлэхийг тусгаагүй байна. Иймд Эрчим хүчээр хангах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 31 дүгээр зүйлийн 31.3-т заасныг баримтлан ШТ ХХК-ийн алданги хүчингүй болгуулах шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгожээ.

Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүх шийдвэр гаргахдаа ИХШХШтХ-ийн 116 дугаар зүйлийн 116.2-т заасан хуулийн шаардлагыг хангаагүй байна гэж үзжээ[36].

Хэрэгт авагдсан нотлох баримтаас ШТ ХХК нь эрчим хүч ашигласны төлбөрөө төлж байсан боловч 2015 оны 8 дугаар сараас эхлэн молибдены дэлхийн зах зээлийн ханшны үнэ 2014 оны мөн үеийнхээс 2.0-2.5 дахин унаж буурсан, валютын ханш өссөн зэрэг эдийн засгийн шинжтэй шалтгааны улмаас 2015 оны жилийн эцэст санхүүгийн ихээхэн хэмжээний (жаран тэрбум гаруй төгрөгийн) алдагдалд орсон. МУХАҮТ-ын 2015, 2016 оны 01/188 тоот гэрчилгээгээр ШТ ХХК-д гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй "хүнд нөхцөл байдал" үүссэнийг тодорхойлсон болох нь нотлогдсон тул ИХ-ийн 221 дүгээр зүйл, 221.2-т заасан нөхцөл байдал үүссэн гэж үзсэн байна.

Талууд 2016 онд цахилгаан эрчим хүчээр хангах, түүнийг хэрэглэх гэрээг хоёр жилийн хугацаагаар сунгах үед ИХ-ийн 220 дугаар зүйлийн 220.3-т заасан "талууд өөрчлөгдсөн нөхцөл

[36] ШТ ХХК-ийн нэхэмжлэлтэй ЭБЦТС ТӨХК-д холбогдох гэрээний маргаан (00844). http://new.shuukh.mn/irgendavah/3066/view

байдалд гэрээг зохицуулах арга хэмжээг тэргүүн ээлжид авах" үүргээ хариуцагч тал биелүүлээгүй гэж үзэхээр байна. Иймээс давж заалдах шатны шүүх ИХШХШтХ-ийн 10.4-т заасан хэм хэмжээг хэрэглэж, ИХ-ийн 221 дүгээр зүйлийн 221.2, 232 дугаар зүйлийн 232.6-д заасныг баримтлан анхан шатны шүүхийн шийдвэрийг буюу алдангийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

1. Анхан шатны шүүх шийдвэрийнхээ үндэслэл хэсэгт гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл *(Force Majeure)*, хүнд нөхцөл байдал *(Hardship)* зэргийг ялган тодорхойлж, тус гэрээнд хүнд нөхцөл байдлыг зохицуулсан зохицуулалт байхгүй гэх үндэслэлээр нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

2. Харин давж заалдах шатны шүүх хүнд нөхцөл байдал үүссэн тухай дүгнэлт хийж ИХШХШтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг баримтлан ИХ-ийн 221 дүгээр зүйл, 221.2 дахь хэсгийг төсөөтэй хэрэглэж, нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаж шийдвэрлэсэн байна.

3. ИХ-ийн 220 дугаар зүйлийн 220.3 дахь хэсэгт заасан үүргийг хариуцагч тал биелүүлээгүй гэж үзэхээр байна гэсэн боловч ИХ-ийн 221 дүгээр зүйл, 221.2 дахь хэсгийг төсөөтэй хэрэглэсэн нь эргэлзээтэй байна. Харин ИХ-ийн 220 дугаар зүйлийг хэрэглэн шүүх шийдвэрээ гаргах үндэслэлтэй байсан гэж үзэхээр байна.

Тохиолдол 2. 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр ургамал хамгааллын бодис худалдах, худалдан авах гэрээ байгуулсан боловч хариуцагч тал 2015 онд байгалийн давагдашгүй хүчин зүйл - гангийн улмаас ургац алдсан гэх үндэслэлээр гэрээний үүргээ

хугацаандаа гүйцэтгээгүй тул маргаан үүсэж, нэхэмжлэгч тал нь үндсэн төлбөр, алданги нэхэмжилсэн.

Хариуцагч тал 2015 онд байгалийн давагдашгүй хүчин зүйл - гангийн улмаас ургац алдсан тухай тайлбарласан бөгөөд үлдсэн 40 гаруй сая төгрөгийн бодисыг буцаагаад авах тухай хүсэлт тавьсан. Ш ХХК нь "Буцаахгүй, танай компани нэгэнт дараа жил хэрэглэх тул дараа жил хэрэглэ" гэсэн. Иймээс нэхэмжилж байгаа мөнгөн дүнгээс алдангийг зөвшөөрөхгүй тухай тайлбар гаргасан байна.

Шүүхээс хэргийг шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүх ИХ-ийн 262 дугаар зүйлийн 262.1, 232 дугаар зүйлийн 232.5-д зааснаар нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаж шийдвэрлэсэн байна[37].

Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүх хэрэгт цугларсан нотлох баримт үнэлж дүгнэх хуульд заасан журмыг бүрэн хэрэгжүүлж чадаагүй, тухайн маргаантай харилцаанд хамаарах хэрэглэвэл зохих хуулийн зарим заалтыг зөв сонгон хэрэглээгүй, алдаа гаргасныг дараах үндэслэлээр залруулах боломжтой гэж үзсэн байна.

Хариуцагч гэрээ байгуулж үүрэг хүлээснээс хойш 2015 онд болсон байгалийн ган буюу гэрээ байгуулах үед талуудад мэдэгдэх боломжгүй нөхцөл байдлаас шалтгаалан гэрээнд заасан үүргийг хугацаандаа гүйцэтгэх боломжгүй болсон тухайгаа нэхэмжлэгчид удаа дараа мэдэгдэж, нэхэмжлэгч үүрэг гүйцэтгэх хугацааг хойшлуулж 2016 оны 9 дүгээр сар хүртэл гэрээний үүргээ гүйцэтгэх хугацааг хариуцагчид олгосон болох нь зохигчдын

[37] Ш ХХК-ийн нэхэмжлэлтэй Б төв ХХК-д холбогдох худалдах, худалдан авах гэрээний тухай Төв аймгийн сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 12 дугаар сарын 13-ны 151/ШШ2016/01288 дугаартай шийдвэр (151/2016/01050/И).

тайлбараар нотлогджээ. Гэтэл нэхэмжлэгч нь хариуцагчийн тайлбарыг үгүйсгэж маргаагүй байхад анхан шатны шүүх хариуцагчийг буруутгаж, гэрээг сунгасан, хариуцагч үүргээ зохих ёсоор биелүүлсэн гэх байдал тогтоогдоогүй гэж үзсэн нь хэргийн бодит байдалд нийцээгүй, зохигчдын тайлбарыг зөв үнэлж чадаагүй, талуудын маргаагүй үйл баримтыг нотлогдсон гэж үзсэн нь иргэний процессын эрх зүйн зарчимд нийцэхгүй дүгнэлт болжээ.

Хэргийн нөхцөл байдлаас үзвэл талууд 2015 оны 6 дугаар сард буюу гэрээ байгуулах үед мэдэгдэх боломжгүй нөхцөл байдал болох ган болсон нь орон нутгийн цаг уурын байгууллага, МҮХАҮТ-аас олгосон байгалийн давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ зэрэг баримтаар нотлогдсон байх тул ИХ-ийн 220 дугаар зүйлийн 220.3-т заасан "гэрээний талууд өөрчлөгдсөн нөхцөл байдалд гэрээг зохицуулах арга хэмжээг тэргүүн ээлжид авах үүрэгтэй" гэсэн үүргийг зөвхөн хариуцагчид хүлээлгэх боломжгүй юм.

Иймд ИХ-ийн 222 дугаар зүйлийн 222.2 дахь хэсэгт заасны дагуу хариуцагчийг хууль болон гэрээний үүргээ зөрчсөн, үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй гэж үзэх боломжгүй байна. Хэдийгээр гэрээний талууд гэрээгээр үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн 0.5 хувиар хугацаа хэтрүүлсэн хоног тутамд алданги төлөхөөр тохиролцсон байгаа ч нэхэмжлэгчийн алданги шаардах эрхийн үндэслэлийг үгүйсгэх дээрх үйл баримт тогтоогдож байх тул алдангийн шаардлагыг хангах эрх зүйн үндэслэл байхгүй[38] гэж үзсэн байна.

Хяналтын шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан давж заалдах шатны шүүхийн магадлал хууль

[38] Ш ХХК-ийн нэхэмжлэлтэй Б төв ХХК-д холбогдох худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой хэргийн тухай Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 02 дугаар сарын 16-ны 223/МА2017/00004 дугаартай магадлал (151/2016/01050/И).

ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлага хангасан байна. ИХ-ийн 222 дугаар зүйлийн 222.2, 221 дүгээр зүйлийн 221.2 дахь хэсгийг үндэслэн хариуцагчийг гэм буруугүй гэж үзэж, алданги төлөх хариуцлагаас чөлөөлсөн нь үндэслэлтэй[39] хэмээн уг маргааны эцэслэн шийдвэрлэсэн байна.

Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

1. Давж заалдах болон хяналтын шатны шүүх хариуцагчийн алдангитай холбоотой татгалзлаа нотолсон нотлох баримтуудыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үнэлжээ.

2. Харин анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэлд хариуцагчийн гаргасан Төв аймгийн Эрдэнэсант сумын Цаг уур, орчны шинжилгээний Эрдэнэсант өртөөний даргын тодорхойлолтыг үндэслэн олгосон МҮХАҮТ-ын давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ байгаа эсэх тухай заагаагүй бөгөөд эдгээр нотлох баримтыг огт үнэлээгүй байна. Харин энэхүү алдааг дээд шатны шүүхүүд залруулж, хариуцагчийн гаргаж өгсөн дээрх нотлох баримтуудыг магадлал, тогтоолдоо дурдаж, хэрхэн үнэлсэн тухайгаа тодорхой бичжээ.

3. Давах болон хяналтын шатны шүүхээс хариуцагч гэрээнд заасан хугацаанд үүргээ зохих ёсоор биелүүлээгүй хугацаа хожимдуулсан нь хүндэтгэн үзэх шалтгаантай байсан тул түүнийг гэм буруугүй гэж үзэж, ИХ-ийн 221 дүгээр зүйлийн 221.2 дахь хэсгийг хэрэглэн алданги төлөх хариуцлагаас чөлөөлсөн нь хууль зүйн үндэслэлтэй байна.

4. Харин гурван шатны шүүх талуудын хооронд байгуулсан гэрээнд гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой

[39] Ш ХХК-ийн нэхэмжлэлтэй Б төв ХХК-д холбогдох худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой хэргийн тухай Монгол Улсын Дээд шүүхийн 2017 оны 05 дугаар сарын 19-ний 001/ХТ2017/00663 дугаартай тогтоол (151/2016/01050/И).

нөхцөл байдлын улмаас хариуцлагаас чөлөөлөх тухай заалт байсан эсэхийг дурдаагүй байна. Учир нь шүүх талуудын хооронд байгуулсан гэрээнд дээрх нөхцөл байдал тохиолдсон үед гэрээний хариуцлагаас чөлөөлөх заалт байхгүй байна, эрсдэлийг зөвхөн нэг тал нь хүлээхээр тохирсон, эсхүл хариуцлага хүлээхийг хориглохоор харилцан тохирсон зэргээс хамааран нэмэгдүүлсэн хүү болон алдангиас чөлөөлж, эсхүл чөлөөлөхгүйгээр шийдвэрлэж байгаа болно.

Тохиолдол 3. Т банк, зээлдэгч ГГУ ХХК-ийг төлөөлж гүйцэтгэх захирал Б.А нар 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдөр зээлийн гэрээ байгуулжээ. Хууль болон зээлийн гэрээнд заасны дагуу хариуцагч /зээлдэгч/ ГГУ ХХК нь зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу гэрээний үүргээ биелүүлж байсан боловч 2016 оны 05 дугаар сарын 10-ны өдөр компанийн үйлдвэрийн байранд гал түймэр гарч, тоног төхөөрөмж, үл хөдлөх эд хөрөнгө нь устсан байна. Энэ нь Өмнөговь аймгийн Прокурорын газрын 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 136 дугаар тогтоолын хуулбар, Гамшиг судлалын хүрээлэнгийн 2016 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 9/143 тоот Шинжээчийн дүгнэлтийн хуулбар /хх-444-446/-аар тогтоогдсон байна. Нэхэмжлэгч тал зээлийн үлдэгдэл ба үндсэн хүү, нэмэгдүүлсэн хүү нэхэмжилжээ.

Хариуцагч ИХ-ийн 221.1 дэх хэсэг, зээлийн гэрээний 6.2.3-т барьцааны зүйл устсан тохиолдолд гэрээ дуусгавар болохоор заасан тул 2016 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс зээлийн гэрээг дуусгавар болсон гэж үзэж хүү, нэмэгдүүлсэн хүүг хүлээн зөвшөөрөхгүй, харин үндсэн зээлээ төлөхийг хүлээн зөвшөөрч байна гэж байр суурьиа тодорхойлсон.

Шүүхээс хэргийг шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүхээс нэхэмжлэгч Т банк нь барьцааны зүйл үрэгдсэн, ашиглах боломжгүй болсныг мэдмэгц зээлийн гэрээнд

заасны дагуу гэрээг цуцлах ёстой байсан боловч энэ эрхээ хэрэгжүүлээгүй гэж үзэх үндэстэй юм. **Гэрээг цуцлах гэдэг нь** хууль буюу гэрээнд заасны дагуу нэг тал хүсэл зоригоо илэрхийлснээр хүчин төгөлдөр гэрээний хэрэгжсэн хэсэг хэвээр үлдээж, үүргийн харилцааг цаашид дуусгавар болгохыг ойлгодог. Гэрээг цуцлах, гэрээнээс татгалзах тохиолдолд гэрээг дуусгавар болгох хүсэл зориг адилхан агуулагддаг бөгөөд ИХ-ийн 221 дүгээр зүйл нь гэрээг цуцлахтай холбоотой хуулийн зохицуулалт юм. ИХ-ийн 221 дүгээр зүйлийн 221.1, 221.2 дахь хэсгийг хэрэглэн хариуцагч талын үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө гал түймрийн улмаас устаж үгүй болсон нь хүндэтгэн үзэх үндэслэл бөгөөд хугацаа харгалзахгүйгээр гэрээг цуцлах эрхтэй гэж дүгнэлээ. ИХ-ийн 204 дүгээр зүйлийн 204.1-д зааснаар аль нэг тал нь гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах бол энэ тухай нөгөө талдаа мэдэгдэх ёстой. Мэдэгдэхэд хуулиар хэлбэрийн шаардлага тавиагүй тул гал түймэр гарсан 2016 оны 05 дугаар сарын 10-ны өдрийг зээлийн гэрээг цуцалсан хугацаа гэж тооцохоор байна. Гэрээг цуцалснаар үүргийн харилцаа дуусгавар болох учир үүргийн харилцаанаас үүсэх шаардах эрх мөн дуусгавар болох тул нэхэмжлэгч Т банк нь 2016 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс хойш зээлийн үндсэн хүү, нэмэгдүүлсэн хүүг хариуцагчаас шаардах эрхгүй[40] гэж шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхээс тухайн нөхцөл байдлыг гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл хэмээн дүгнэснийг буруутгаагүй.[41]

Хяналтын шатны шүүх хоёр шатны шүүх хэрэгт авагдсан нотлох баримтад тулгуурлан гэрээний хүчин төгөлдөр байдал,

---

[40] Т банкны нэхэмжлэлтэй ГГУ ХХК, ГХУ ХХК, Б.А, Өмнөговь аймгийн ИТХ-д холбогдох зээлийн гэрээний тухай Өмнөговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 01 дүгээр сарын 10-ны 20 дугаартай шийдвэр (143/2016/00354/И).

[41] Т банкны нэхэмжлэлтэй ГГУ ХХК, ГХУ ХХК, Б.А, Өмнөговь аймгийн ИТХ /итгэмжлэгдсэн төлөөлөгч М.Х/-д холбогдох гэрээний маргаан (10). http://new.shuukh.mn/irgendavah/7220/view

гэрээ цуцлах болсон шалтгаан, хугацаа, гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал зэрэг маргааны үйл баримтын талаар бүрэн эрхийнхээ хүрээнд эрх зүйн хувьд зөв дүгнэлт хийсэн байх ба уг дүгнэлтийг үгүйсгэх үндэслэлгүй байна гэжээ.

Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

1. Хариуцагчийн үйл ажиллагаа явуулдаг үйлдвэр шатсан үйл баримтыг гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал гэж гурван шатны шүүх дүгнэсэн нь үндэслэлтэй байна.

2. Анхан шатны шүүх хариуцагч талын үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө гал түймрийн улмаас устаж үгүй болсон нь хүндэтгэн үзэх үндэслэл бөгөөд хугацаа харгалзахгүйгээр гэрээг цуцлах эрхтэй гэж дүгнэсэн. Гэрээ цуцлах талаар үндэслэл бүхий тайлбарлаж, ИХ-ийн 221.2 дахь хэсгийг хэрэглэж шийдвэрлэсэн байна. ИХ-ийн 204 дүгээр зүйлийн 204.1-д зааснаар аль нэг тал нь гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах бол энэ тухай нөгөө талдаа мэдэгдэх ёстой. Хариуцагч тал мэдэгдсэн тухай тайлбарыг нэхэмжлэгч няцаагаагүй бөгөөд мэдэгдэхэд хуулиар хэлбэрийн шаардлага тавиагүй тул гал түймэр гарсан өдрийг зээлийн гэрээг цуцалсан хугацаа гэж тооцсон. Иймээс гэрээг цуцалснаар үүргийн харилцаа дуусгавар болохоос гадна үүргийн харилцаанаас үүсэх шаардах эрх мөн дуусгавар болдог тул гал түймэр гарсан өдрөөс хойш нэхэмжлэлийн шаардлагаас зээлийн үндсэн хүү, нэмэгдүүлсэн хүүг хариуцагчаас шаардах эрхгүй тухай үндэслэлтэй дүгнэжээ.

Тохиолдол 4. Ч.Б нь ОИ ББСБ ХХК-тай 2015 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр үл хөдлөх эд хөрөнгүүдээ барьцаалан зээлийн гэрээ байгуулсан. Ч.Б нь зээлийн төлбөрөө хугацаандаа төлөөгүй

тул нэхэмжлэгч үндсэн зээл, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүү, нотариатын зардал нэхэмжилсэн.

Хариуцагч тал хүчтэй аадар бороо орж, голын усны түвшин нэмэгдэж үер болсон. Уг үерт бүх техник, тоног төхөөрөмж, эд хөрөнгө, байрлаж байсан гэрээ урсгаж алдсан. Үерт автсан эд хөрөнгөөс дахин ашиглах боломжтой хөрөнгө үлдээгүй. Энэхүү нөхцөл байдлыг ОИ ББСБ ХХК-д удаа дараа мэдэгдсэн боловч тус ХХК нь зээлийн гэрээг цуцлаагүй үргэлжлүүлэн хүү, нэмэгдүүлсэн хүү тооцсоор байсан нь үндэслэлгүй хэмээн маргасан байна.

Шүүхээс хэргийг шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүх хариуцагч нь зээлийн гэрээний дагуу зээлийг зориулалтаар нь зарцуулж нөхөн сэргээлтийн ажиллагааг гүйцэтгэх явцад үерт өртсөний улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал бий болсон байх тул 2016.07.13-ны өдрөөс хойших зээлийн гэрээний хүү, нэмэгдүүлсэн хүү төлөх үүргээ биелүүлээгүй нь хариуцагчийн гэм буруугаас болоогүй байна. Иймээс ИХ-ийн 222 дугаар зүйлийн 222.2 дахь хэсэгт зааснаар 2016.07.13-наас хойших зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.[42]

Давж заалдах шатны шүүх ИХ-ийн 221 дүгээр зүйлийн 221.2 дахь хэсэгт заасны дагуу гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал, хүндэтгэн үзэх үндэслэлээр нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэснийг буруутгах үндэслэл хэргийн баримтаар тогтоогдсонгүй[43] гэжээ.

---

[42] ОИ ББСБ-ын нэхэмжлэлтэй Ч.Б-д холбогдох зээлийн гэрээний маргаан (183/ШШ2017/02299). http://new.shuukh.mn/irgenanhan/72936/view

[43] ОИ ББСБ-ын нэхэмжлэлтэй Ч.Б-д холбогдох зээлийн гэрээний маргаан (183/2017/02412/И). http://new.shuukh.mn/irgendavah/8406/view

Хяналтын шатны шүүх хугацаа хэтрэхэд хүргэсэн нөхцөл байдал нь үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугаас болоогүй бол үүрэг гүйцэтгэгчийг хугацаа хэтрүүлсэн гэж үздэггүй ИХ-ийн 222 дугаар зүйлийн 222.2-т заасан зохицуулалтын агуулгад нийцжээ. Хариуцагчийн үйл ажиллагаа явуулж байсан нутаг дэвсгэрт аадар бороо орж, үер буусны улмаас эд хөрөнгө эвдэрч гэмтсэн болох нь МҮХАҮТ-ын гэрчилгээгээр тогтоогдсон байна[44] гэжээ.

Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

1. Анхан шатны шүүх ИХ-ийн 222 дугаар зүйлийн 222.2 дахь хэсэг, давж заалдах, хяналтын шатны шүүх 221 дүгээр зүйлийн 221.2 дахь хэсгийг хэрэглэж шийдвэр гаргасан байна. Харин хяналтын шатны шүүх ИХ-ийн 221 дүгээр зүйлийг хэрэглэх эсэх талаар дүгнэлт хийгээгүй байна.

2. Гурван шатны шүүх хэрэгт авагдсан нотлох баримтыг бүх талаас нь бүрэн, эргэлзээгүй талаас нь үнэлж шийдвэр гаргасан байна. Шүүхийн шийдвэрт үүргийн гүйцэтгэлийг биелүүлэх боломжгүй гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тухай нотолсон МҮХАҮТ-ын гэрчилгээг үнэлж шийдвэр гаргасан байна.

3. Гэвч ИХ-ийн 221 дүгээр зүйлийн зохицуулалт тухайн нөхцөл байдалтай хэрхэн нийцэж байгаа талаар шийдвэртээ заасан бол хууль хэрэглээний хувьд чухал жишээ болох байжээ.

Тохиолдол 5. Н ХХК болон Ч.Б нарын хооронд 2015 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр газрын тосны бүтээгдэхүүн зээлээр худалдах, худалдан авах гэрээ байгуулагдаж, нэхэмжлэгч нь стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх, хариуцагч нь тогтсон хугацаанд (2015 оны 10 дугаар сарын 16)

[44] http://new.shuukh.mn/irgenhyanalt/4033/view

үнийг төлөхөөр харилцан тохирсон боловч бүрэн төлөөгүй байна. Н ХХК нь гэрээний үлдэгдэл төлбөр, алданги нэхэмжилсэн бол хариуцагч Ч.Б нь хүчтэй аадар бороо орж, голын усны түвшин нэмэгдэн гэнэтийн үер болж, гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тул алдангиас чөлөөлж өгнө үү гэжээ.

Шүүхээс хэргийг шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүх хариуцагчид тохиолдсон гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал, эрүүл мэндийн нөхцөл байдлыг нь харгалзан хүндэтгэн үзэх үндэслэлтэй гэж үзэж алдангийг ИХ-ийн 232 дугаар зүйлийн 232.8-д заасны дагуу 50 хувь багасгаж шийдвэрлэсэн байна.[45]

Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

1. Шүүх гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал гэж дүгнэсэн байх боловч ИХ-ийн 232 дугаар зүйлийн 232.8 дахь хэсэгт заасны дагуу алдангийн хэмжээг 50 хувь багасгаж шийдвэрлэсэн байна. Харин ИХ-ийн 221 дүгээр зүйлийг хэрэглээгүйн үндэслэл тодорхой бус байна.

2. Мөн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлыг нотолсон ямар нотлох баримт хэрэгт авагдсан тухай шийдвэртээ заагаагүй байна.

Тохиолдол 6. **Нэхэмжлэгч тал** туслах аж ахуйн малчдад хөлсөөр ажиллах гэрээний дагуу шилжүүлж өгсөн мал устан үгүй болж, нийт 4,460,000 төгрөгийн хохирол учирсан тул энэхүү хохирлыг тухайн малчдаар төлүүлэх шаардлага гаргасан.

---

[45] Н ХХК-ийн нэхэмжлэлтэй Ч.Б-д холбогдох гэрээний маргаан (183/2017/02805/И). http://new.shuukh.mn/irgenanhan/72971/view

Хариуцагч тал Д.Б, В.М, Г.Р нар нь "Бидний буруутай үйлдлийн улмаас болж мал үхэж үрэгдээгүй, байгалийн гамшгаас болсон тул нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй" гэсэн байна.

Шүүхээс хэргийг шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүхээс Орхон аймгийн Засаг даргын Ажлын хэсэг байгуулах тухай 2017 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/375 дугаартай захирамж, Монгол Улсын Онцгой комиссын нарийн бичгийн дарга, онцгой байдлын хурандаа М.Э-гийн Орхон аймгийн ОБГ-аас бичсэн илтгэх хуудас, ажлын хэсгийн 2017 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 01 тоот хурлын тэмдэглэл, аймгийн Онцгой комиссын 2017 оны 06 дугаар сарын 29, 30-ны өдрийн 03, 04 дугаартай тэмдэглэл, гэрэл зургууд зэрэг нотлох баримтыг шинжлэн судалж, цаг агаарын аюулт үзэгдэл буюу хүчтэй аадар бороо, салхи гарсныг тогтоосон. Иймээс хариуцагч Д.Б, В.М, Г.Р нарт гэрээгээр шилжүүлсэн мал үхэж үрэгдсэн нь тэдний гэм буруутай үйл ажиллагаанаас шалтгаалаагүй, харин гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас устаж үрэгдсэн. Иймээс ИХ-ийн 101 дүгээр зүйлийн 101.7-д зааснаар өмчлөгч эрсдэлийг хариуцахаар зохицуулсан байх тул нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна[46].

Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

1. Шүүх хэрэгт хариуцагчдаас авагдсан нотлох баримтуудыг бүрэн үнэлж, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь үндэслэлтэй байна.

2. Харин шүүх гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал тохиолдсон тухай буюу эд хөрөнгө

[46] Зэвсэгт хүчний ... дугаар ангийн нэхэмжлэлтэй Д.Б, В.М, Г.Р нарт холбогдох гэрээний маргаан (142/ШШ2018/00008). http://new.shuukh.mn/irgenanhan/77773/view

устаж үгүй болсон нөхцөлийг дүгнэсэн боловч ИХ-ийн 221 дүгээр зүйлийг хэрэглээгүй. Гэхдээ ИХ-ийн 101 дүгээр зүйлийн 101.7 дахь хэсгийг хэрэглэж шийдвэрлэсэн нь үндэслэлтэй юм.

Тохиолдол 7. Дархан-Уул аймгийн ОБГ нь ТӨ ХХК-тай Улсын нөөцийн бараа материал зээлээр олгох гэрээг 2017 оны 05 дугаар сард байгуулж 85 тонн үрийн улаан буудайн урьдчилгаа төлүүлж, үлдэгдэл төлбөрийг төлөх хугацаа тогтоож зээлээр олгосон. ТӨ ХХК нь гэрээний үүргээ хугацаандаа биелүүлээгүй тул үндсэн төлбөр, алданги гаргуулахаар нэхэмжилсэн байна.

Хариуцагч тал "Дархан-Уул аймгийн ОБГ-аас зээлээр олгосон үрийн будааг хугацаандаа төлөх байсан боловч байгалийн давагдашгүй хүчин зүйл буюу ган болж үрийн будаагаа хурааж чадаагүй. Дархан-Уул аймгийн ОБГ-ын төлөөлөгч хэд хэдэн удаа манай талбай дээр ирж үрийн будааны тариалалттай танилцсан. Бид үрийн будааны үндсэн төлбөр төлөхийг хүлээн зөвшөөрч байна, харин алданги тооцсоныг хүлээн зөвшөөрөхгүй" гэж маргасан байна.

Шүүхээс хэргийг шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүхээс "ТӨ ХХК-ийн Төв аймгийн Цээл суманд байрлалтай 420 га түрээсийн талбайд хийсэн тариалалт байгалийн гамшиг гангийн улмаас 100 хувь ургац алдсан. Иймээс байгалийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан ургац алдсанаас хариуцагч ТӨ ХХК гэрээний үүргээ биелүүлээгүй байдал үүссэн нь тогтоогдож байх тул алданги гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй" болгож шийдвэрлэсэн байна.[47]

[47] ОБГ-ын нэхэмжлэлтэй ТӨ ХХК-д холбогдох гэрээний маргаан (666). http://new.shuukh.mn/irgenanhan/78493/view

Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

1. Үүрэг гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ тогтоосон хугацаанд нь биелүүлээгүй шалтгаанаа гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлаас болсон тухай тайлбарыг шүүх үнэлж шийдвэрээ гаргасан. Харин ган болсон тухай нотолсон өөр нотлох баримтыг шүүх шийдвэртээ заагаагүй.

2. Шүүх шийдвэртээ "гэнэтийн буюу байгалийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан ургац алдсанаас хариуцагч гэрээний үүргээ биелүүлээгүй байдал үүссэн нь тогтоогдож байх тул алданги гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх нь зүйтэй" гэсэн байх боловч ИХ-ийн 221 дүгээр зүйлийг хэрэглээгүй.

Тохиолдол 8. 2018 оны 5 дугаар сарын 07-ны өдөр Аялал жуулчлалын гэрээ байгуулагдаж, ТТ ХХК нь 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрөөс 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийг дуустал Бүгд Найрамдах Солонгос Улсын Чэжү аралд аялуулах үйлчилгээ үзүүлэх, Б.А нь үйлчилгээний хөлс төлөх үүрэг харилцан хүлээсэн байна. Б.А нь 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдөр МИАТ ХК-ийн ОМ 7309 нислэгээр БНСУ руу ниссэн боловч тодорхойгүй шалтгааны улмаас тус улсын хилээр нэвтэрч чадалгүй 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Монгол Улсад буцаж ирсэн. Иймээс Б.А нь ТТ ХХК-ийг гэрээний үүргээ биелүүлээгүй хэмээн гэрээний дагуу төлсөн төлбөрөө нэхэмжилсэн байна.

Хариуцагч тал "Гэрээний 5.1-д "Аливаа улс орнуудын хилийн шалган нэвтрүүлэх эрх бүхий байгууллага шалтгааныг үл тайлбарлан иргэдийг өөрийн улсын хилээр нэвтрүүлэхээс татгалзах эрхтэй байдаг. Хэрэв жуулчин нь аль нэгэн улсын хилээр нэвтрэх, хилээр гарах үед саатуулагдан, аяллаа үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд аяллын үнийг буцаан олгохгүй

бөгөөд жуулчны хил дээр саатах, нутаг буцах зардал болон сэтгэл санааны хохирлыг аялал жуулчлал зохион байгуулагч хариуцахгүй", 5.5-д "Аялал жуулчлал зохион байгуулагч нь жуулчны хөтөлбөрт хамрагдах үеийн аюулгүй байдал, тав тухтай аялах нөхцөлийг хангана", 5.7-д "Аялал эхлэхээс өмнө жуулчинд аяллын бичиг баримтын иж бүрдлийг (зорчих тээврийн хэрэгслийн тийз, аяллын хөтөлбөр, аяллын санамж, даатгалын гэрээ гэх мэт) хүлээлгэн өгнө" гэж заасны дагуу манай компани 2018 оны 6 дугаар сарын 07-ны өдөр Б.А-д санамж бичиг танилцуулсан. Б.А нь тухайн санамж бичиг болон гэрээний нөхцөлүүдийг бүрэн уншиж танилцаад хүлээн зөвшөөрч гарын үсгээ зурж баталгаажуулсан. Иймд нэхэмжлэгчийн хил дээр саатуулагдсан явдалд манай байгууллага ямар ч буруугүй байна" гэсэн.

Шүүхээс хэргийг шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүхээс "Гэрээ биелэгдэх боломжгүй буюу гэрээ цуцлагдсан нөхцөл байдал нь талуудын хэн алины буруутай үйлдлээс болоогүй, харин гадаад улсын төрийн байгууллагын шийдвэрээс шалтгаалан бий болжээ" гээд ИХ-ийн 370 дугаар зүйл 370.1, 373 дугаар зүйлийн 373.4-т зааснаар нэхэмжлэгч Б.А-гийн төлсөн төлбөрийн 50 хувийг хариуцагчаас гаргуулж шийдвэрлэсэн байна.[48]

Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

1. Бүгд Найрамдах Солонгос Улсын эрх бүхий байгууллага аялагчийг тухайн улсын хилээр нэвтрүүлээгүй шийдвэрийг гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал гэж шүүх дүгнэсэн.

[48] Б.А-гийн нэхэмжлэлтэй "ТТ" ХХК-д холбогдох гэрээний маргаан (1936). http://new.shuukh.mn/irgenanhan/79523/view

2. Талуудын хооронд байгуулагдсан аялал жуулчлалын гэрээн дэх талуудын хэн алины хүсэл зоригоос үл шалтгаалах нөхцөл байдал үүсэж, аялагчийн эрх, ашиг сонирхол зөрчигдөх тохиолдолд тухайн үйл ажиллагааг зохион байгуулагч хариуцахгүй гэсэн зохицуулалт нь аялал зохион байгуулагчид давуу байдал бий болгосон, нөгөө талаас аялагчийн хуулиар хамгаалагдсан эрх ашиг болон ИХ-ийн холбогдох зохицуулалттай зөрчилдөж байгааг шүүх шийдвэртээ тусган хуульд заасан холбогдох зохицуулалтыг хэрэглэж үндэслэлтэй шийдвэрлэсэн байна.

3. Шүүх тухайн харилцааг зохицуулсан ИХ-ийн нарийвчилсан зохицуулалтыг удирдлага болгон шийдвэр гаргасан нь үндэслэлтэй байна.

Тохиолдол 9. УАӨСЗД-ын Тамгын газар болон С.Г нарын хооронд 2018 оны 6 дугаар сард гүүр барих ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдсан. Ажил гүйцэтгэгч С.Г нь 2018 оны 7 дугаар сарын 17-ны өдөр Дунд голын гүүрийг 100 хувь барин гүйцэтгэж, ашиглалтад хүлээлгэж өгсөн. Ажил гүйцэтгэгч ажлын хөлсний үлдэгдэл 1,600,000 төгрөг авах байсан боловч 2018 оны 7 дугаар сарын 19-ний өдөр тус сумын нутаг дэвсгэрт их хэмжээний аадар бороо орсны улмаас Дунд гол дээр барьсан гүүр усанд урсаж эвдэрсэн учир ажил гүйцэтгүүлэгч үлдсэн төлбөрийг төлөөгүй. Иймд ажил гүйцэтгэгч үлдсэн төлбөрийг гаргуулахаар шүүхэд хандсан байна.

Шүүхээс хэргийг шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүхээс зохигчдын хооронд байгуулагдсан ажил гүйцэтгэх гэрээний дагуу ажил гүйцэтгэгч С.Г нь гэрээгээр тохирсон хугацаандаа гүйцэтгэсэн ажлын үр дүнг 100 хувийн гүйцэтгэлтэй хүлээлгэн өгсөн болох нь хэрэгт авагдсан 2018 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн ажлын хэсгийн тайлан дүгнэлтээр

тогтоогдож байх тул нэхэмжлэгч нь ажлын хөлсний үлдэгдэл төлбөрийг шаардах эрхтэй. Мөн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас тухайн гүүр ашиглах боломжгүй болсон нь аймгийн ОБГ-ын гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн 2018 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн гамшиг, аюулт үзэгдэл, осол гарсан тухай 08 дугаар актаар тогтоогдож байх тул нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаж шийдвэрлэжээ.[49]

Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

1. Гэрээний зүйл гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас устаж үгүй болсон бөгөөд нэхэмжлэгчийн буруутай үйл ажиллагаанаас болоогүй болохыг шүүх холбогдох байгууллагуудын шийдвэр, дүгнэлтийг үндэслэн тогтоосон нь үндэслэлтэй.

2. Шүүх дээрх шийдвэрийг гаргахдаа шийдвэрийн үндэслэх болон тогтоох хэсэгт гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдалтай холбогдох хуулийн зохицуулалт тусгаж хэрэглээгүй байна. Иймээс шүүх тухайн нөхцөл байдлыг тогтоосон холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг нотлох баримтаар үнэлэн шийдвэрлэхдээ хуулийн холбогдох зохицуулалт хэрэглэх, тус нөхцөл байдлыг хэрхэн зүйлчилж байгааг шийдвэртээ тусгах шаардлагатай.

Тохиолдол 10. 2012 оны 7 дугаар сард ИССМ ХХК нь В ХХК-тай барилга байгууламж барих, өмчлөх, ашиглах эрх шилжүүлэх гэрээ байгуулсан. 2012 оны 10 дугаар сарын 08-ны өдөр ИССМ ХХК ажил гүйцэтгэж эхэлсэн боловч 2013 оны 05 дугаар сарын 14-ний өдөр хариуцагч талаас "... гэрээний 37.2

[49] С.Г-гийн нэхэмжлэлтэй УАӨСЗД-д холбогдох гэрээний маргаан (152/2018/00897/И). http://new.shuukh.mn/irgenanhan/81195/view

дахь хэсэгт зааснаар давагдашгүй хүчин зүйл үүссэн тул ажлаа түр хугацаагаар зогсоох тухай", 2013 оны 10 дугаар сарын 31-ний өдөр гэрээ цуцлах тухай мэдэгдлийг тус тус нэхэмжлэгчид хүргүүлсэн. Мэдэгдэлд Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргын 2013 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн албан бичигт дурдсан нөхцөл буюу тухайн барилга баригдаж байгаа газрыг тусгай хэрэгцээнд авахтай холбоотой нөхцөл байдал арилаагүй, гэрээнд зааснаар давагдашгүй хүчин зүйлд тооцогдож байгаа тул ИХ-ийн 221 дүгээр зүйлд зааснаар гэрээг цуцалж байгаа тухай мэдэгдэл хүргүүлсэн байна. Талууд Ханбогд сумын Засаг даргаас ирүүлсэн албан бичгийн дагуу барилга барих газрыг эзэмших, ашиглах боломжгүй болсон тул гэрээ цуцлагдсан талаар маргаагүй, харин энэхүү албан бичиг нь гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалд хамаарах эсэх талаар болон гэрээ цуцалсантай холбоотой зардал, хохирол төлөх эсэх тухай маргасан байна.

Шүүхээс хэргийг шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүх "Давагдашгүй хүчин зүйл гэдэгт талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, урьдчилан сэргийлж, шинжлэх ухаан, техникийн ололт ашиглан даван гарах боломжгүй тодорхой саад тотгор тохиолдсоны улмаас талууд гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүйд хүрэхийг ойлгодог. Гэрээний нэр томьёо хэсэгт дурдагдсан дараах нөхцөл байдлыг давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал гэдэгт ойлгоно гэх тайлбарын е)-д Ажил гүйцэтгэгч гэрээг зөрчсөнөөс бусдаар Засгийн газрын байгууллагын гаргасан алдааны улмаас олгоогүй, эсхүл шинэчлээгүй, эсхүл хүчин төгөлдөр бус зөвшөөрөл зэрэг талууд гэрээний дагуу хүлээсэн үргээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн биелүүлэх боломжгүй байдалд шууд хүргэж буй тохиолдлуудыг ойлгоно гэж заасан байх бөгөөд энэ нөхцөл байдал үүсэж, гэрээ цуцлагдсан" гэж дүгнэсэн.

Мөн шүүх Монгол Улсын 1997 оны 07 дугаар сарын 09-ний өдөр нэгдэн орсон 1980 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Вена хотноо байгуулсан Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай НҮБ-ын конвенцын 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсгийг хэрэглэж, "талуудын хооронд байгуулсан гэрээн дэх давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэний улмаас гэрээг цуцалсны хохирол төлөхтэй холбоотой зарим заалт нь олон улсын гэрээ буюу нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд нийцээгүй, талуудын тэгш эрх, шударга ёсны зарчимд нийцээгүй ... байх тул ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.1 дэх хэсэгт зааснаар хүчин төгөлдөр бус" гэж дүгнэсэн.[50]

Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

1. Ханбогд сумын Засаг даргын албан бичгийг үндэслэн давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн гэж дүгнэсэн нь эргэлзээтэй. Учир нь Газрын тухай хуулийн гуравдугаар бүлэгт тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлснийг үндэслэн газрыг аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээнд авах, түүний хэмжээ, зааг, ашиглах журмыг аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ тогтоохоор заасан байна.

2. Мөн шүүх давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн гэж дүгнэсэн боловч шийдвэрийнхээ үндэслэх болон тогтоох хэсэгт ИХ-ийн 221 дүгээр зүйлийг хэрэглээгүй байна.

3. Харин шүүх Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай НҮБ-ын конвенцын 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсгийг шийдвэрийнхээ үндэслэх хэсэгт хэрэглэсэн нь сайн талтай байна.

---

50 ИССМ ХХК-ийн нэхэмжлэлтэй В ХХК-д холбогдох ажил гүйцэтгэх, түрээсийн гэрээний маргаан, Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 102/ШШ2019/00895 дугаартай шийдвэр (102/2017/02404/И).

Тохиолдол 11. 2017 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан "Өвөл, хаврыг өнтэй давъя" арга хэмжээний хүрээнд уг яамны харьяа МХ сан ба Т ХХК-ийн хооронд 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр ОХУ-аас малын өвс, тэжээл импортлон оруулж ирэх тухай зээлийн гэрээ байгуулсан. Харин гэрээний хугацаа дуусахад хариуцагч тал зээлээ бүрэн төлөөгүй тул нэхэмжлэгч МХ сан нь үндсэн зээл, алданги гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлага гаргасан байна.

Хариуцагч тал нь ОХУ-аас малын тэжээл импортлон оруулж Өвөрхангай аймгийн төв болон өвөлжилт хүндэрсэн Бүрд, Есөнзүйл, Хайрхандулаан, Баян-Өндөр сумдын малчдад зээлээр борлуулсан. Гэтэл Өвөрхангай аймгийн төв болох Арвайхээр сум болон Хархорин, Бүрд, Өлзийт сумдад малын гоц халдварт шүлхий өвчин илэрч, аймгийн Засаг даргын захирамжаар аймгийн Онцгой комисс тухайн нутаг дэвсгэрийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн. Хариуцагч МХ санд бичсэн хүсэлт, хариу албан бичиг, Онцгой байдлын газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны албан бичгүүд, мал, амьтны гаралтай гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдон Өвөрхангай аймгийн болон Бүрд сум, Арвайхээр сум, Есөнзүйл сумын нутаг дэвсгэрт хорио цээр тогтоосон тухай Засаг даргын захирамжууд зэрэг бичмэл баримтуудыг шүүхэд хүсэлт гарган бүрдүүлжээ. Иймээс үндсэн зээлээ эргэн төлөхийг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд харин алдангийг хэрэгсэхгүй болгож өгөх тухай маргасан байна.

Шүүхээс хэргийг шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүх нэхэмжлэгч тал зээлийн төлбөрийг хугацаа хэтрүүлэн шилжүүлж байсан, малын гоц халдварт өвчин гарч гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэнээс хариуцагч зээлээр худалдан авсан өвс тэжээлээ

борлуулах боломжгүй байсан үйл баримт буюу хэргийн нөхцөл байдлыг харгалзан ИХ-ийн 232 дугаар зүйлийн 232.8 дахь хэсэгт заасны дагуу алдангийн хэмжээ илт их гэж дүгнээд гуравны нэг хувийн хэмжээгээр багасгаж шийдвэрлэсэн байна[51].

Давж заалдах шатны шүүх талуудын байгуулсан гэрээний 3.2-т зээлдэгч нь цаг агаарын төлөв байдлыг урьдчилан тооцсоны үндсэн дээр орон нутагт тэжээл борлуулах цэгүүд байгуулж тэжээл нөөцлөх арга хэмжээ авах ба гарч болох аливаа эрсдэлийг бүрэн хариуцахаар талууд тохиролцжээ.

Харин анхан шатны шүүх хэргийн нөхцөл байдлыг харгалзан ИХ-ийн 232 дугаар зүйлийн 232.8 дахь хэсэгт заасны дагуу шүүх эрх хэмжээнийхээ хүрээнд алдангийг багасгасныг буруутгах үндэслэлгүй зэрэг үндэслэлээр давж заалдах гомдлыг хангахгүй орхисон байна.[52]

Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

1. Шүүх хэрэгт хавсаргасан нотлох баримтуудыг үндэслэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал гэж үзсэн боловч хариуцагчийг алдангиас бүрэн чөлөөлөөгүй харин алдангийн гуравны нэг хувийг чөлөөлсөн байна. Харин хоёр шатны шүүх “хэргийн нөхцөл байдлыг харгалзан” алдангийн хэмжээг багасгасан хэмээн дүгнэснээс бус, яагаад ИХ-ийн 222 дугаар зүйлийн 222.1 дэх хэсгийг хэрэглэж алдангиас чөлөөлөөгүй тухай дүгнэлт хийгээгүй байна.

---

[51] МХ сангийн нэхэмжлэлтэй хариуцагч Т ХХК-д холбогдох зээлийн гэрээний тухай Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 04 дүгээр сарын 30-ны 184/ШШ2019/01122 дугаартай шийдвэр (184/2019/00689/И).

[52] МХ сангийн нэхэмжлэлтэй хариуцагч Т ХХК-д холбогдох зээлийн гэрээний тухай Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 1260 дугаартай магадлал (184/2019/00689/И).

2. Давж заалдах шатны шүүх талуудын байгуулсан гэрээний 3.2 дахь заалтын дагуу зээлдэгч эрсдэлийг бүрэн хариуцах агуулгатай гэж дүгнэсэн байх боловч малын гоц халдварт шүлхий өвчин нь цаг агаартай холбоогүй тул энэхүү гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас хариуцагчийг хариуцлагаас чөлөөлөх хууль зүйн үндэслэлтэй байсан гэж дүгнэхээр байна. Харин Улсын Дээд шүүх уг хэргийг хянан шийдвэрлэсэн тухай тогтоолыг цахим сангаас олоогүй болно.
3. Мөн давж заалдах шатны шүүх талуудын хоорондбайгуулсан гэрээнд "нэхэмжлэгч зээлийн мөнгийг хариуцагчийн дансанд байршуулах тухай үүрэг гүйцэтгэх хугацааг тодорхой заагаагүй" хэмээн дүгнэсэн нь эргэлзээтэй байна. Учир нь уг гэрээ нь өвлийн улиралд өвөлжилт хүндрэхээс өмнө ОХУ-аас тэжээл импортлон малчдад зээлээр борлуулах үндсэн зорилго агуулж байгаад дүгнэлт хийгээгүй.

Харин МХ сангийн нэхэмжлэлтэй хариуцагч ББГ ХХК-д холбогдох өөр хэрэгт хариуцагч нь хорио цээрийн дэглэм тогтоосон тухай Өвөрхангай аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын болон тус аймгийн Онцгой байдлын газрын албан бичгүүд, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээг хэрэгт гарган өгчээ.

Шүүх ИХ-ийн 221 дүгээр зүйлийн 221.1, 222 дугаар зүйлийн 222.2-т зааснаар хариуцагч ББГ ХХК-ийг давагдашгүй хүчин зүйлийн улмаас зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй гэж үзэх үндэслэл тогтоогдож байх тул зээлийн үлдэгдлийг хариуцагчаас гаргуулж нэхэмжлэгч МХ санд олгож, харин алдангийг хариуцагч ББГ ХХК хариуцах үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн байна.[53]

[53] Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны МХ сангийн нэхэмжлэлтэй ББГ ХХК-д холбогдох зээлийн гэрээний маргааны тухай Өвөрхангай аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 04 дүгээр сарын 02-ны 173 дугаартай шийдвэр (145/2018/00793/И).

Ийнхүү нэг цаг хугацаанд, нэг орон нутагт, адил нөхцөлтэй байгуулагдсан гэрээнүүдийн маргааныг шүүхүүд өөр өөрөөр шийдвэрлэсэн нь ИХ-ийн 221 дүгээр зүйлийн 221.2 дахь хэсгийг нэг мөр хэрэглэхгүй байгааг харуулж байна.

Тохиолдол 12. С ХХК нь АП ХХК-тай 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдөр цахилгааны утас худалдах, худалдан авах гэрээ байгуулсан. Нэхэмжлэгч тал С ХХК нь үндсэн төлбөр, алданги гаргуулахаар шаардсан байна. Хариуцагч АП ХХК "Ковид-19 өвчний тархалттай холбоотойгоор 2020 оны 2 дугаар сард, зам хаасны улмаас 2020 оны 3 дугаар сард гэрээнд заасны дагуу ажил гүйцэтгэх боломж хязгаарлагдсаны улмаас барилгын ажил зогсож, цахилгааны утасны төлбөр шилжүүлэх ажил тасалдсан. Үндсэн төлбөрийн үлдэгдлийг зөвшөөрч байгаа бөгөөд харин ИХ-ийн 222 дугаар зүйлийн 222.2, 232 дугаар зүйлийн 232.8 дахь заалт, гэрээний 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан давагдашгүй хүчин зүйлийн талаарх зохицуулалтын дагуу алдангийн зарим хэсгийг багасгах" тухай тайлбар гаргасан.

Шүүхээс хэргийг шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүх "Хариуцагч тайлбараа шүүхэд баримтаар нотлоогүй буюу 2020 оны 2 сарын 19-ний өдрийг хүртэлх хугацаанд хариуцагчийн гүйцэтгэж байсан барилгын ажил ямар явцтай байгаад зогссон, барилгын ажил зогсоход халдварт өвчний тархалт болон төрийн байгууллагын шийдвэрээс өөр бусад нөхцөл байдал нөлөөлөөгүй, мөн хариуцагчтай гэрээ байгуулсан хэчнээн захиалагч гэрээнд заасан төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй, ийнхүү төлбөр төлөх үүргээ захиалагчид биелүүлээгүй нь халдварт өвчний тархалт болон төрийн байгууллагын шийдвэрээс шалтгаалсан гэдгийг шүүхэд баримтаар нотлоогүй тул давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон, үүрэг гүйцэтгэх хугацаа хэтэрсэн нь АП ХХК-ийн гэм буруугаас болоогүй гэх тайлбарыг

үндэслэл бүхий тайлбар гэж шүүх шууд хүлээн авах боломжгүй. Мөн алдангийн хэмжээг илт их гэж үзэх үндэслэлгүй байна" гээд алдангийн тооцооллыг зөвтгөн хангаж шийдвэрлэжээ.[54]

Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүх хэрэгт цугларсан нотлох баримтыг үнэлж дүгнэх зарим нөхцөл байдалд хуульд заасан журмыг бүрэн хэрэгжүүлж чадаагүй, тухайн маргаантай харилцаанд хамаарах хэрэглэвэл зохих хуулийн зарим заалтыг зөв сонгон хэрэглээгүй алдаа гаргасныг өөрчлөх боломжтой гэж үзсэн байна.

Талууд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар тооцож анз, алданги төлнө гэж тохиролцсон нь ИХ-ийн 232 дугаар зүйлийн 232.6 дахь хэсэгт заасанд нийцсэн. Гэвч дээрх гэрээний 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлага /алданги, торгууль/-аас чөлөөлөгдөх үндэслэл болно гэж тохиролцсон байна.

Монгол Улсад шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор авсан арга хэмжээ нь нийтэд илэрхий үйл баримт тул ИХШХШтХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсэгт зааснаар дахин нотлох шаардлагагүй гэж үзсэн бөгөөд алдангийг хариуцагчийн зөвшөөрсөн хэмжээгээр хангаж, үлдсэн хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

1. Анхан шатны шүүх Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас болж төлбөр төлөх боломжгүй болсон тухай нотлох баримтыг шүүхэд гаргаагүй тул үндсэн төлбөрөөс гадна алдангитай холбоотой шаардлагыг хангаж шийдвэрлэсэн.

[54] С ХХК-ийн нэхэмжлэлтэй АП ХХК-д холбогдох гэрээний маргаан. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 181/ШШ2020/01180 дугаартай шийдвэр (181/2020/00733/И).

2. Харин давж заалдах шатны шүүх Ковид-19 цар тахлын улмаас төрийн байгууллагын шийдвэр гарч хөдөлгөөн хязгаарласан нь нийтэд илэрхий үйл баримт тул дахин нотлохгүй хэмээн алдангийг хариуцагчийн зөвшөөрсөн хэмжээнд хангасан нь үндэслэлтэй байна.

3. Давж заалдах шатны шүүх хариуцагчийг гэрээнд заасан хугацаанд үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаа хожимдуулсан нь хүндэтгэн үзэх шалтгаантай байсан тул гэм буруугүй гэж үзсэн боловч ИХ-ийн холбогдох зохицуулалтыг шийдвэрийнхээ үндэслэх болон тогтоох хэсгүүдэд дурдаагүй байна.

Тохиолдол 13. 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдөр талууд сургуулийн өмнөх боловсрол, сургалтын гэрээ байгуулсан. Гэвч Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн цэцэрлэгийн үйл ажиллагааг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр зогсоох шийдвэр гарч гэрээний хугацаа дуусах хүртэл хүүхэд цэцэрлэгт яваагүй байна. Харин сургалтын байгууллага хүүхэд цэцэрлэгт яваагүй хугацааны төлбөрийг буцаан өгөхөөс татгалзсан тул маргаан үүсжээ.

Хариуцагч тал гэрээний хугацаа нь 2019 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 2020 оны 05 дугаар сарын 31-ний өдөр хүртэл бөгөөд төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр гарах хүртэл сургалтын үйл ажиллагаа явуулсан хугацаа 50 хувийг давж байгаа учраас нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй гэж маргасан байна.

Шүүхээс хэргийг шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг буюу 2019 оны 09 дүгээр сарын 01-нээс 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр хүртэлх хугацааны төлбөрийг бодож, шилжүүлсэн

нийт төлбөрөөс хасаж шийдвэрлэсэн. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсэгт зааснаар дэлхий нийтэд тархсан Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Улсын Онцгой комиссын шийдвэрээр хөл хорио тогтоосонтой холбоотой сургууль, цэцэрлэгийн танхимын сургалтын үйл ажиллагааг зогсоосон нь нийтэд илэрхий үйл баримт байна. ИХ-ийн 367 дугаар зүйлийн 367.1 дэх хэсэгт зааснаар нэхэмжлэгч нь сургалтад хамрагдаагүй хугацааны сургалтын төлбөрийг буцаан шаардах эрхтэй байна.

Хариуцагч "Гэрээнд зааснаар эцэг, эх хүүхдээ гэрээний хугацааны 50 хувь хүртэлх хугацаанд цэцэрлэгт хамруулсны дараа гэрээг дуусгавар болгохоор хүсэлт гаргасан бол гэрээний үүргээ бүрэн гүйцэтгээгүй ба элсэх хүүхдийн тоо хязгаарласны торгуулийг цэцэрлэгт хамрагдаагүй үлдсэн хугацаанд ногдох төлбөрөөс 20 хувиар суутган авч эцэг эхэд буцаан олгоно гэсний дагуу төлбөрөөс 20 хувийг суутгуулна" гэсэн нь үндэслэлгүй юм. Тодруулбал, талуудын байгуулсан гэрээ хэрэгжих боломжгүй болсон дээрх нөхцөлд хэн аль нь буруутай гэх үндэслэлгүй тул талуудын байгуулсан гэрээний хариуцлага ногдуулсан заалтыг хэрэгжүүлэх боломжгүй[55] гэсэн байна.

Давж заалдах шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан журмын дагуу явуулсан боловч хэрэгт авагдсан нотлох баримт болон зохигчдын тайлбарыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2 дахь хэсэгт нийцүүлэн дүгнээгүйгээс шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий болж чадаагүй байна.

Хариуцагч байгууллагад гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй хүндэтгэн үзэх нөхцөл байдал бий болсон байх тул

[55] Т.Б-гийн нэхэмжлэлтэй ЭГБ сургалтын байгууллагад холбогдох сургалтын төлбөр гаргуулах хөлсөөр ажиллах гэрээний үүрэгтэй холбоотой иргэний хэргийн тухай Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 09 дүгээр сарын 30-ны 183/ШШ2020/02603 дугаартай шийдвэр (183/2020/02606/И).

нэхэмжлэгч нь ИХ-ийн 367 дугаар зүйлийн 367.1, 221 дүгээр зүйлийн 221.1 дэх хэсэгт зааснаар гэрээнээс татгалзах буюу хугацаанаас нь өмнө цуцлахаар шаардах эрхтэй. Гэрээний аль нэг тал гэрээнээс татгалзсан тохиолдолд ИХ-ийн 205 дугаар зүйлийн 205.1 дэх хэсэгт зааснаар гэрээний дагуу шилжүүлсэн зүйлээ буцаан шаардах үр дагавар үүснэ. Мөн хуулийн 205 дугаар зүйлийн 205.6 дахь хэсэгт ийнхүү гэрээ цуцалсан тохиолдолд нэхэмжлэгч нь хариуцагч байгууллагын сургалтын үйл ажиллагаа явуулахад гарах зайлшгүй зардлыг нөхөн төлөх үүрэгтэй болно.

Талуудын хоорондын гэрээний 7.5.2-т гэрээг цуцалсан тохиолдолд хариуцагч нь төлбөрийн 20 хувьд (сургалтад хамрагдаж эхэлснээс хойш) суутгал хийх талаар заахдаа "торгууль" гэсэн үгээр илэрхийлжээ. Гэрээний энэхүү заалт нь заавал биелэгдэх шинжтэй нэмэлт үүрэг тогтоосон буюу ИХ-ийн 232 дугаар зүйлийн 232.5 дахь хэсэгт заасан торгуулийн үүрэг үүсэх гэхээсээ илүү хариуцагчид үүсэх зайлшгүй зардлын талаар гэрээний нөгөө талд мэдэх боломж олгосон баримт гэж үзэхээр байна. Гэрээний дээрх заалтыг ИХ-ийн 202 дугаар зүйлийн 202.2.10-т заасан өөрт учирсан бодит зардлаас хэт давсан нөхөн төлбөр шаардахаар санал тогтоосон гэж үзэхгүй. Иймд хариуцагч байгууллагад гарах зайлшгүй зардлыг нэхэмжлэлээс суутган, нэхэмжлэлийн зарим хэсгийг хангах нь ИХ-ийн 205 дугаар зүйлийн 205.1, 205.6 дахь хэсэгт заасантай нийцнэ. Дээр дурдсан үндэслэлээр нэхэмжлэгчийн төлсөн сургалтын төлбөрийн үлдэгдлийн 20 хувийг зайлшгүй зардалд суутган, үлдэгдэл төгрөгийг хариуцагч байгууллагаас гаргуулан нэхэмжлэгчид олгохоор анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн байна.[56]

[56] Т.Б-гийн нэхэмжлэлтэй ЭГБ сургалтын байгууллагад холбогдох сургалтын төлбөр гаргуулах иргэний хэргийн тухай Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 12 дугаар сарын 7-ны 210/МА2020/02299 дугаартай магадлал (183/2020/02606/И).

Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

1. Анхан шатны шүүх Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор гарсан шийдвэртэй холбоотойгоор цэцэрлэгийн үйл ажиллагаа зогссон үйл баримтыг нийтэд илэрхий үйл баримт тул дахин нотлохгүй хэмээн зөв дүгнэсэн. Мөн давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн энэхүү дүгнэлтийг буруутгаагүй байна.

2. Харин давж заалдах шатны шүүх талуудын байгуулсан гэрээнд нэхэмжлэгчийн төлсөн сургалтын төлбөрийн үлдэгдлийн 20 хувийг "торгууль" гэдэг үгээр илэрхийлснээс бус "зайлшгүй зардал" гэж үзэж анхан шатны шүүхэд өөрчлөлт оруулсан нь үндэслэлгүй байна.

   Учир нь гэрээнд "гэрээний үүргээ бүрэн гүйцэтгээгүй ба элсэх хүүхдийн тоо хязгаарласны торгууль" гэж тодорхой заасан байна. Иймээс анхан шатны шүүхийн "Гэрээ хэрэгжих боломжгүй болсон нь хэн аль нь буруутай гэх үндэслэлгүй тул талуудын байгуулсан гэрээний хариуцлага ногдуулсан заалтыг хэрэгжүүлэх боломжгүй" хэмээн дүгнэсэн нь үндэслэлтэй юм.

   ИХ-ийн 198 дугаар зүйлийн 198.1 дэх хэсэгт гэрээг тайлбарлахдаа түүний үгийн шууд утгыг анхаарна. Зохигчдын хооронд хийгдсэн гэрээ нь ИХ-ийн 200 дугаар зүйлийн 200.1 дэх хэсэгт заасан ... стандарт нөхцөлтэй гэрээ байх ба стандарт нөхцөлийг илэрхийлсэн үг хэллэгийн утга санаа ойлгомжгүй бол түүнийг санал хүлээн авагч талд ашигтайгаар тайлбарлана гэж ИХ-ийн 201 дүгээр зүйлийн 201.1 дэх хэсэгт заасан. Иймээс давж заалдах шатны шүүх гэрээний агуулгыг буруу тайлбарлаж хууль хэрэглээний алдаа гаргажээ гэж үзэхээр байна.

3. Анхан шатны шүүх "хүндэтгэн үзэх үндэслэлээр гэрээг цуцалсан тохиолдолд ажиллагч нь гэрээ цуцлах хүртэл

хугацаанд гүйцэтгэсэн ажлынхаа хөлсийг шаардах эрхтэй” гэж ИХ-ийн 367 дугаар зүйлийн 367.1, 221 дүгээр зүйлийг хэрэглэж дүгнэсэн нь үндэслэлтэй байна.

4. Харин давж заалдах шатны шүүх Ковид-19 цар тахлыг гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал гэж дүгнэсэн анхан шатны шүүхийн шийдвэрийг буруутгаагүй боловч Иргэний хуулийг 221 дүгээр зүйлийг хэрэглээгүй байна.

5. "Талуудын хооронд 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хүртэл үйлчлэх сургуулийн өмнөх боловсрол, сургалтын гэрээ буюу хөлсөөр ажиллах гэрээ нь урт хугацаатай байгуулагдсан гэрээ бөгөөд уг гэрээг цуцалсан байна" гэж анхан шатны шүүх үндэслэлтэй дүгнэсэн. Гэтэл давж заалдах шатны шүүх ИХ-ийн 205 дугаар зүйлийн 205.1, 205.6 дахь заалтаар зүйлчлэн хуулийг буруу хэрэглэжээ. Учир нь Монгол Улсын Дээд шүүх "Гэрээнээс татгалзах тохиолдолд талууд гэрээгээр өгсөн, авснаа буцаадаг бол гэрээг цуцлахад цуцлах хүртэлх гэрээний харилцаа хэвээр үлдэж, цуцалснаас хойших үр дагаврыг талууд шийдвэрлэдэг ялгаа байдаг. Гэрээг цуцлах ойлголт ихэвчлэн урт хугацаатай үүргийн харилцаанд, харин гэрээнээс татгалзах явдал хиймэгц биелэх буюу гэрээгээр олж авсан зүйлийг харилцан буцаах боломжтой хэлцэлд хэрэглэгдэнэ. ИХ-ийн 204, 221, 225, 227 дугаар зүйл гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах аль ч үед хэрэглэгдэнэ. Харин ИХ-ийн 205 дугаар зүйлд гэрээнээс татгалзсанаас үүсэх үр дагаврыг зохицуулсан байх тул гэрээг цуцлахад хэрэглэгдэх зохицуулалт биш байна"[57] гэж тайлбарласан.

6. Мөн Б.У, Б.С нарын нэхэмжлэлтэй ЭГБ сургалтын байгууллагад холбогдох Ковид-19 цар тахлын улмаас хөлсөөр ажиллах гэрээг цуцалсан өөр маргааныг Нийслэлийн давж

[57] УДШ-ийн 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн зөвлөмжийн 2 дахь хэсэг.

заалдах шатны шүүх[58] шийдвэрлэхдээ дээрх шийдвэртэй адилхан шийдвэрлэжээ.

Иймээс манай улсад хэдийгээр шүүхийн шийдвэрийг жишиг болгон хэрэглэдэггүй ч анхан шатны шүүх төстэй маргааныг хянан шийдвэрлэхдээ дээд шатны шүүхийн шийдвэрийг "харгалзан үзэх" тохиолдол байдаг гэдэгт анхаарах шаардлагатай юм.

Тохиолдол 14. М ХХК нь ОБЕГ-ын Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газартай 2017 оны 5 дугаар сарын 5-ны өдөр байгуулсан гэрээний дагуу стандартын шаардлага хангасан Дархан 144 сортын 88 тонн үрийн буудайн урьдчилгаа төлбөр төлж, Булган аймгийн Сэлэнгэ сум дахь улсын нөөцийн цэгээс авчээ. Нэхэмжлэгчийн зүгээс хариуцагч М ХХК нь худалдах, худалдан авах гэрээний үүргээ Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д зааснаар хугацаанд нь, зохих ёсоор биелүүлээгүй тул үрийн улаан буудайн үлдэгдэл төлбөр, алданги нэхэмжилсэн байна.

Хариуцагч тал М ХХК нь Монгол орны 2015 оны зуны улирлын цаг агаарын байдал, хэт халалт, 2017 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 17-19 цагийн хооронд болсон хүчтэй салхи, аадар бороо, мөндрийн улмаас ургац алдсан тул төлбөрөө төлж чадаагүй нь байгалийн гамшиг буюу давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан болох нь МҮХАҮТ-ын давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ, Орхон суманд тариалангийн үйл ажиллагаа явуулж буй М ХХК-ийн талбайд хохирол тогтоосон акт, Булган аймгийн ОБЕГ-ын Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн дүгнэлтээр тогтоогдож байна. Иймд 17 га талбай буюу тариалалт явуулсан нийт талбайд эзэлж буй хэмжээ болох 2.86 хувиар алданги тооцон төлөх хүсэлт гаргасан байна.

[58] Б.У, Б.С нарын нэхэмжлэлтэй ЭГБ сургалтын байгууллагад холбогдох сургалтын төлбөр гаргуулах иргэний хэргийн тухай Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 12 дугаар сарын 18-ны 02402 дугаартай магадлал (183/2020/02534/И).

Шүүхээс хэргийг шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүх хариуцагч М ХХК-аас үрийн улаан буудайн үлдэгдэл төлбөр, алданги нэхэмжилсэн нь үндэслэлтэй байх боловч анзын хэмжээ илт их байгааг харгалзан ИХ-ийн 232 дугаар зүйлийн 232.8 дахь хэсэгт зааснаар шүүх алдангийг багасгаж шийдвэрлэх нь зүйтэй. Учир нь хариуцагч үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нөхцөл нь байгалийн гамшиг буюу давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан болох нь хариуцагчийн гаргасан нотлох баримтаар тогтоогдож байна. Иймээс 17 га нь нийт талбайн 2.86 хувийг эзэлж байх бөгөөд хариуцагч М ХХК-ийн ургац хурааж авах боломжтой талбай буюу 2.86 хувиар алданги тооцон төлүүлэх үндэслэлтэй гэж үзсэн байна. Иймд шүүхээс ИХ-ийн 243 дугаар зүйлийн 243.1, 232 дугаар зүйлийн 232.6, 232.8 дахь хэсгийг баримтлан нэхэмжлэлийн зарим хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.[59]

Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

1. Шүүх хариуцагчийг давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас үүрэг гүйцэтгэх боломжгүй тухай дүгнэлт хийхдээ нотлох баримтуудыг бүрэн үнэлж шийдвэрлэсэн.

2. Шүүх нэхэмжлэгчийн шүүхэд гаргасан алдангийг нягталж тогтоохдоо ИХ-ийн 232 дугаар зүйлийн 232.8 дахь хэсэгт зааснаар алдангийг багасгаж шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэн шалтгаан нь гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалтай холбогдох боловч ИХ-ийн холбогдох зохицуулалтыг хэрэглэн үндэслэл болгон тайлбарлаагүй байна.

---

[59] ОБЕГ-ын нэхэмжлэлтэй М ХХК-д холбогдох гэрээний маргаан (183/ШШ2021/00285). http://new.shuukh.mn/irgenanhan/100715/view

Шүүхээс гаргасан дээрх шийдвэрүүдэд дараах нэгдсэн дүгнэлт хийж болохоор байна.

Хууль хэрэглээний хувьд:

1. Эдийн засгийн хүнд нөхцөл байдалтай холбоотой үүссэн маргааныг шүүх шийдвэрлэхдээ ИХ-ийн 220 дугаар зүйлийн 220.3 дахь хэсэгт заасан үүргийг хариуцагч тал биелүүлээгүй гэж үзэхээр байна гэсэн боловч ИХ-ийн 221 дүгээр зүйл, 221.2 дахь хэсгийг төсөөтэй хэрэглэж шийдвэрлэсэн[60] нь эргэлзээтэй байна. Харин ИХ-ийн 220 дугаар зүйлийг хэрэглэн шүүх шийдвэрээ гаргах үндэслэлтэй байсан гэж үзэхээр байна.

2. Шүүх хариуцагчийг гэрээнд заасан хугацаанд үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаа хожимдуулсан нь хүндэтгэн үзэх шалтгаантай байсан тул түүнийг гэм буруугүй гэж үзэж ИХ-ийн 221 дүгээр зүйлийн 221.2 дахь хэсгийг хэрэглэн алданги төлөх хариуцлагаас чөлөөлсөн нь хууль зүйн үндэслэлтэй байна.

3. Гэрээ цуцлах, гэрээнээс татгалзах үндэслэлүүдийг ялган тодорхойлж, гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэрээ цуцалсны үр дагаварт дүгнэлт хийж, цуцалсны дараах зээлийн үндсэн хүү, нэмэгдүүлсэн хүү төлөхөөс чөлөөлж шийдвэрлэсэн нь зөв байна.

4. Шүүх гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал гэж дүгнэсэн байх боловч ИХ-ийн 232 дугаар зүйлийн 232.8 дахь хэсэгт заасны дагуу алдангийн хэмжээг 50 хувь болон бусад хэмжээгээр багасгаж шийдвэрлэсэн байна. Харин ИХ-ийн 222 дугаар зүйлийн 222.1 дэх хэсгийг

[60] ШТ ХХК-ийн нэхэмжлэлтэй ЭБЦТС ТӨХК-д холбогдох гэрээний маргаан (00844). http://new.shuukh.mn/irgendavah/3066/view

хэрэглэж алдангиас бүрэн чөлөөлөөгүй тухай дүгнэлт хийгээгүй байна.

5. Шүүх гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалтай холбоотой харилцааг зохицуулсан ИХ-ийн тусгай ангид заасан, жишээ нь, ИХ-ийн 370 дугаар зүйлийн 370.1, 373 дугаар зүйлийн 373.4[61] дэх хэсэгт заасан хэм хэмжээг хэрэглэн хэрэг шийдвэрлэсэн нь үндэслэлтэй юм.

6. Шүүх Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай НҮБ-ын конвенцын 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсгийг шийдвэрийнхээ үндэслэх хэсэгт хэрэглэж шийдвэр гаргасан сайн талтай байна.

7. Шүүх нэг цаг хугацаанд, нэг орон нутагт, адил нөхцөлтэй байгуулагдсан гэрээний маргааныг өөр өөрөөр шийдвэрлэсэн нь ИХ-ийн 221 дүгээр зүйлийн 221.2 дахь хэсгийг нэг мөр хэрэглэхгүй байгааг харуулж байна. Жишээ нь, МХ сангийн нэхэмжлэлтэй хариуцагч Т ХХК,[62] ББГ ХХК-д[63] холбогдох хэрэг.

Нотлох баримт үнэлэх ажиллагааны хувьд:

1. Шүүх нотлох баримтыг зарим тохиолдолд үнэлээгүй алдааг дээд шатны шүүх нь залруулж, нотлох баримтыг үнэлж, үндэслэл бүхий шийдвэр гаргаж байна.

---

61 Б.А-гийн нэхэмжлэлтэй ТТ ХХК-д холбогдох гэрээний маргаан (1936). http://new.shuukh.mn/irgenanhan/79523/view

62 МХ сангийн нэхэмжлэлтэй хариуцагч Т ХХК-д холбогдох зээлийн гэрээний тухай Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 4 дүгээр сарын 30-ны 184/ШШ2019/01122 дугаартай шийдвэр (184/2019/00689/И).

63 МХ сангийн нэхэмжлэлтэй ББГ ХХК-д холбогдох зээлийн гэрээний маргааны тухай Өвөрхангай аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 4 дүгээр сарын 2-ны 173 дугаартай шийдвэр (145/2018/00793/И).

2. Үүрэг гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ тогтоосон хугацаанд нь биелүүлээгүй шалтгаанаа гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлаас болсон тухай тайлбарыг үнэлж шүүх шийдвэр гаргасан байна. Харин уг нөхцөл байдлыг нотолсон өөр нотлох баримт хэрэгт байсан эсэх талаар шүүх шийдвэртээ заагаагүй байна.

3. Шүүх барилга баригдаж байгаа газрыг тусгай хэрэгцээнд авах тухай сумын Засаг даргын албан бичгийг үндэслэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн гэж үзсэн нь эргэлзээтэй юм. Учир нь Газрын тухай хуулийн гуравдугаар бүлэгт зааснаар тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлснийг үндэслэн газрыг аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээнд авах, түүний хэмжээ, зааг, ашиглах журмыг аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ тогтоохоор заасан байна.

4. Анхан шатны шүүх Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас болж төлбөр төлөх боломжгүй болсон тухай нотлох баримтыг шүүхэд гаргаагүй тул үндсэн төлбөрөөс гадна алдангитай холбоотой шаардлагыг хангаж шийдвэрлэсэн бол давж заалдах шатны шүүх Ковид-19 цар тахлын улмаас төрийн байгууллагын шийдвэр гарч хөдөлгөөн хязгаарласан нь нийтэд илэрхий үйл баримт тул дахин нотлохгүй хэмээн алдангийг хариуцагчийн зөвшөөрсөн хэмжээнд хангасан нь үндэслэлтэй байна.

2.3. ГЭНЭТИЙН БУЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧНИЙ ШИНЖТЭЙ ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛД ХАМААРУУЛААГҮЙ ТУХАЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Дүн шинжилгээ хийсэн 117 шүүхийн шийдвэрийн 25-д нь тухайн үед тохиолдсон нөхцөл байдлыг гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдалд хамаарахгүй гэж дараах үндэслэлээр шийдвэрлэсэн байна. Үүнд:

1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдалд хамаарах тохиолдол биш тухай 9 шийдвэр;

2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдал болохоос өмнө, эсвэл дараа нь үүргээ биелүүлэх боломж байсан тухай 3 шийдвэр;

3. Энэ нөхцөл байдлын тухай гэрээнд заагаагүй тухай 8 шийдвэр;

4. Энэхүү нөхцөл байдал тохиолдсон тухай гэрээнд болон хуульд заасан хугацаанд нэг талдаа мэдэгдээгүй тухай 5 шийдвэр байна.

Дээрх хэдэн үндэслэлээр гэрээний нэг талыг үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй хэмээн хариуцлагаас чөлөөлөөгүй шүүхийн шийдвэрүүдийг дурдвал:

1. Талууд гэрээндээ гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас хариуцлагаас чөлөөлөгдөх тухай зохицуулаагүй;[64]

[64] А ББСБ ХХК-ийн нэхэмжлэлтэй хариуцагч О.М, Д.А нарт холбогдох зээлийн гэрээний маргааны тухай Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 183/ШШ2020/00435 дугаартай шийдвэр (182 /2019/01390/И).

2. Уурхайд хөрсний гулсалт үүсэж, уурхайн хана хэд хэдэн удаа нурсан нь байгаль орчны улсын байцаагчийн тодорхойлолтыг үндэслэн МҮХАҮТ-аас олгосон давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээгээр нотлогдсон боловч гэрээнд зааснаар нэхэмжлэгчид мэдэгдээгүй;[65]

3. Дэлхийн уур амьсгалын дулаарлын улмаас олон жилийн цэвдэг хөрс гэсэлтэд орсноор барилгын суурь, даацын болон хамар хананууд хэв гажилтад орсон, хагарал үүссэн нь байгалийн давагдашгүй хүчин зүйл мөн боловч хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн;[66]

4. Монгол Улсад үүсээд буй уул уурхайн зах зээлийн хямрал, төмрийн баяжмалын дэлхийн зах зээлийн үнийн уналт[67] буюу эдийн засгийн хүндрэл тохиосон;

5. Гэрийн паарны боолт сулраагүй задарсан буюу давагдашгүй хүчин зүйл тохиолдож, бусдын эд хөрөнгөд гэм хор учруулсан гэх хариуцагчийн тайлбарыг шүүх гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдалд хамаарахгүй;[68]

6. Чихрийн шижин өвчин нь гоц халдварт өвчин биш[69] гэж дүгнэсэн зэрэг шийдвэрүүд байна.

---

[65] ПО ХХК-ийн нэхэмжлэлтэй ДМ-д холбогдох түрээсийн гэрээний маргааны тухай Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 00803 дугаартай шийдвэр (182/2018/02456/И).

[66] О сумын хүүхдийн цэцэрлэгийн нэхэмжлэлтэй ЦС ХХК-д холбогдох ажил гүйцэтгэх гэрээний маргааны тухай Завхан аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 111 дугаартай шийдвэр (140/2015/00039/И).

[67] МП ХХК-ийн нэхэмжлэлтэй АХ ХХК-д холбогдох гэрээний маргааны тухай Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 07 дугаар сарын 04-ний 404 дугаартай шийдвэр (101/2016/4622/И).

[68] С.О-гийн нэхэмжлэлтэй Н.Н-д холбогдох гэм хор учруулснаас эд хөрөнгийн хохирол гаргуулах тухай Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 04 дүгээр сарын 27-ны 01003 дугаартай шийдвэр (184/2017/01247/И).

[69] МК ХХК-ийн нэхэмжлэлтэй Ш.З-д холбогдох гэрээний маргааны тухай Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 10 дугаар сарын 17-ны 5458 дугаартай шийдвэр (102/2016/06591/И).

Зээлийн гэрээтэй холбоотой маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр нь судалгаа хийсэн нийт шийдвэрийн 32.5 хувь, газар тариалангийн салбарын маргаан шийдвэрлэсэн шийдвэр 23.1 хувь буюу хамгийн их хувийг эзэлж байгаагаас гадна "гэрээндээ тохиролцоогүй" гэх үндэслэлээр гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалд хамааруулаагүй шийдвэр дийлэнх хувийг эзэлж байх тул дараах шийдвэрт дүгнэлт хийсэн болно.

Тохиолдол 1. Зээлдэгч 2015 оны 06 дугаар сарын 15-ны өдөр зээлийн болон барьцааны гэрээ байгуулсан, зээлийн гэрээний хугацаа дуусахад зээлээ бүрэн төлөөгүй тул маргаан үүссэн байна.

Хариуцагч тал нь газар тариалангийн бизнес эрхэлдэг бөгөөд ган гачгийн улмаас ургац алдаж, орлогогүй болсон. Энэ нь Цаг уур, орчны шинжилгээний газрын 2019 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 2/684 тоот албан бичиг, Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн 2019 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 09/166 тоот албан бичгээр нотлогдоно. Иймээс нэхэмжлэлийн шаардлагаас зарим хүү, нэмэгдүүлсэн хүүг хэрэгсэхгүй болгох тухай тайлбар гаргасан байна.

Шүүхээс хэргийг шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүх нэхэмжлэгч А ББСБ ХХК-аас үндсэн зээлийн төлбөр болон зээлийн үндсэн хүү, хэтэрсэн хугацааны хүүг шаардсан нь ИХ-ийн 451 дүгээр зүйлийн 451.1, 452 дугаар зүйлийн 452.1, 453 дугаар зүйлийн 453.1 дэх хэсгийн зохицуулалтад нийцэж байгаа боловч нэмэгдүүлсэн хүүг зээлийн үлдэгдэл болон үндсэн хүүгээс тооцсоныг зөвтгөн, нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Харин гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал тохиолдсон бол зээлийн төлбөрөөс хэсэгчлэн болон бүхэлд нь чөлөөлөхөөр

тохиролцоогүй тул зээлдэгчийг хариуцлагаас чөлөөлөх хууль зүйн үндэслэлгүй[70] гэжээ.

Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүх нь хэргийн үйл баримтын талаар үндэслэл бүхий дүгнэлт хийж, нотлох баримтыг тухайн хэрэгт хамааралтай, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлж, хэрэглэвэл зохих хуулийг зөв тайлбарлан хэрэглэсэн байх тул шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий болжээ[71] гэж дүгнэсэн.

Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

1. Хариуцагчид гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалд хамаарах ган гачгийн улмаас зээлийн төлбөрөөс бүхэлд нь чөлөөлөх тухай тайлбар гаргаагүй, харин хүү, нэмэгдүүлсэн хүүг багасгах тухай тайлбарласан байна. Гэтэл анхан шатны шүүх "талууд гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал тохиолдсон тохиолдолд зээлийн төлбөрөөс хэсэгчлэн болон бүхэлд нь чөлөөлөхөөр тохиролцоогүй..." хэмээн дүгнэжээ.

2. ИХ-ийн 222 дугаар зүйлийн 222.2-т зааснаар хугацаа хэтрэхэд хүргэсэн нөхцөл байдал нь үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугаас болоогүй бол үүрэг гүйцэтгэгчийг хугацаа хэтрүүлсэн гэж үздэггүй тухай хуулийн заалт хэрэглээгүй.

3. Анхан болон давж заалдах шатны шүүх гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын тухай тайлбар, нотлох баримтад дүгнэлт хийгээгүй.

---

70 А ББСБ ХХК-ийн нэхэмжлэлтэй хариуцагч О.М, Д.А нарт холбогдох зээлийн гэрээний маргааны тухай Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 183/ШШ2020/00435 дугаартай шийдвэр (182/2019/01390/И).

71 А ББСБ ХХК-ийн нэхэмжлэлтэй хариуцагч О.М, Д.А нарт холбогдох зээлийн гэрээний маргааны тухай Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 5 дугаар сарын 11-ний 210/МА2020/01022 дугаартай магадлал (182/2019/01390/И).

а) ИХШХШтХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй, хэргийг бүхэлд нь хянах тухай заасан. Хариуцагч хэдийгээр давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдолдоо ган гачгийн улмаас тариа ургаагүй, ургац алдсан хэмээн шууд бичээгүй ч шүүх гомдлын агуулгаар хязгаарлагдахгүйгээр хэргийг бүхэлд нь хянах үүрэгтэй.

б) Хариуцагч "гэрээ зөрчигдөх болсон шалтгаан, нөхцөлөө баримттай өгсөөр байхад нэхэмжлэгч хүлээж аваагүй" тухай давж заалдах шатны шүүхэд тайлбарласан боловч шүүх зөвхөн 1 дүгээр хавтаст хэргийн 26 дахь талд авагдсан нотлох баримтыг үнэлжээ. Харин хариуцагчид хавтаст хэргийн 183-188, 189 дүгээр талд Цаг уур, орчны шинжилгээний газар, Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн зэрэг байгууллагын албан бичгүүд, Засгийн газрын 286 дугаар тогтоолын дагуу 10 хоног тутамд хийсэн гангийн байдлын үнэлгээ зэрэг нотлох баримтуудыг хэрэгт хавсаргасан тухай тайлбарлажээ.

2.4. ГЭНЭТИЙН БУЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧНИЙ ШИНЖТЭЙ ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫГ НОТЛООГҮЙ ТУХАЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Дүн шинжилгээ хийсэн шийдвэрүүдээс 26 шүүхийн шийдвэрт буюу судалгаа хийсэн нийт шийдвэрийн 22.2 хувьд нь энэхүү нөхцөл байдлыг нотлоогүй гэж шүүх үзсэн байна. ИХ-ийн 221 дүгээр зүйл болон ИХШХШтХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсэгт заасан "нийтэд илэрхий үйл баримт хэрэг хянан шийдвэрлэхэд холбогдолтой байвал түүнийг дахин нотлохгүй" тухай зохицуулалтыг зөв хэрэглэж, тайлбарлаагүй бөгөөд энэхүү

нөхцөл байдлыг зөвхөн МҮХАҮТ-аас олгодог гэрчилгээг үндэслэж нотлогдсон гэж үзэх тухай шийдвэрүүдийг судалгааны үндэслэл, шаардлагатай уялдуулан сонгож дүн шинжилгээ хийлээ.

Шүүх дараах үндэслэлээр гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлыг нотлоогүй хэмээн дүгнэсэн байна:

1. Ковид-19 цар тахлын улмаас гэрээний үүргээ хугацаандаа биелүүлээгүйг гэрчилсэн, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлтэй тулгарсан, хүнд нөхцөлд орсныг гэрчилж, баталгаажуулсан гэрчилгээ МҮХАҮТ-аас аваагүй;[72]

2. 4.5 мм тунадас орж, цасны зузаан 2 см, 17-18-нд 0.5-6.4 мм тунадас орж, цасны зузаан 16 см болсныг тодорхойлсон Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын тодорхойлолт, гэрчийн мэдүүлэг хэрэгт байгаа боловч МҮХАҮТ-аас давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ аваагүй;[73]

3. Ковид-19 цар тахлын улмаас бизнесийн үйл ажиллагаа доголдож зогсон, орлогогүй болсон гэх тайлбараа нотлоогүй;[74]

4. Концессын гэрээ нь гэрээний талуудаас үл шалтгаалах нөхцөл байдлаар үргэлжлэх боломжгүй болсныг Эрчим хүчний яамны 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн В/4587 дугаартай албан бичиг нотолно гэж тайлбарласан хэдий ч давагдашгүй хүчин зүйл тохиолдсон талаар баталгаа, тодорхойлолт гаргаагүй;[75]

---

72 П ББСБ ХХК-ийн нэхэмжлэлтэй Э.Б-д холбогдох зээлийн гэрээний тухай Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 09 дүгээр сарын 30-ны 183/ШШ2020/02623 дугаартай шийдвэр (183/2020/02876/И).

73 ЧТ ХХК-ийн нэхэмжлэлтэй Увс аймгийн УДХС ТӨХК-д холбогдох гэрээний маргааны тухай Увс аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 05 дугаар сарын 13-ны 184 дугаартай шийдвэр (152/2019/00115/И).

74 Х ХХК-ийн нэхэмжлэлтэй хариуцагч Д.Э, Б.А, Ш.О нарт холбогдох гэрээний маргааны тухай БЗД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 29-ний 101/ШШ2021/0380 дугаартай шийдвэр (101/2020/04330/И).

75 МВС ХХК-ийн нэхэмжлэлтэй ААК ХХК-д холбогдох гэрээний маргааны тухай

5. Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 өвчнөөс шалтгаалан зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээг ИХ-ийн 282 дугаар зүйлийн 282.2 дахь хэсэгт зааснаар багасгуулах агуулга бүхий тайлбар гаргаж байх боловч ИХ-ийн 221 дүгээр зүйлийн 221.2 дахь хэсэгт заасан нөхцөл байдал тогтоогдоогүй;[76]
6. Хариуцагч "Азаргыг чоно идсэн тул давагдашгүй хүчин зүйл" гэж маргасан боловч шүүх "Азарга чононд идүүлсэн гэх баримт байхгүй"[77] гэж дүгнэсэн зэрэг шийдвэрүүд байна.

Тохиолдол 1. Увс аймгийн УДХС ТӨХК болон ЧТ ХХК хоёр хоорондоо 2016 оны 8 дугаар сарын 19-ний өдөр "Нүүрс тээвэрлэлтийн гэрээ" байгуулжээ. Гэрээний дагуу нүүрс тээвэрлэх үүргээ гүйцэтгэж байх үед цаг агаар муудаж 16 см хэмжээтэй цасан бүрхүүл үүсэж, зам хаагдан хүнд даацын машин явах боломжгүй болсон. Үүнээс шалтгаалан жолооч нарын тээврийн хөлс нэмэгдэн, илүү зардал гарсан боловч түүнийг цаг хугацаанд нь гаргаж өгөөгүйн улмаас үүссэн алданги нэхэмжилсэн тухай иргэний хэргийг шүүх хянан шийдвэрлэсэн байна.

Нэхэмжлэгч тал гэнэтийн буюу байгалийн давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэнийг нотлох зорилгоор гэрчийн мэдүүлэг авхуулж, тухайн үеийн гэрэл зураг, 2016 оны 10 дугаар сарын 09-нд Түргэн сумын нутаг дэвсгэр болох Улаандаваа, Улаанзуух гэх газруудад 4.5 мм тунадас орж, цасны зузаан 2 см, 17-18-нд 0.5-6.4 мм тунадас орж, цасны зузаан 16 см болсныг тодорхойлсон Увс аймгийн Ус, цаг уур,

---

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 00128 дугаартай магадлал (183/2019/02560/И).

76 ТБ ХХК-ийн нэхэмжлэлтэй Э ХХК-д холбогдох гэрээний маргааны тухай Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 1169 дугаартай шийдвэр (102/2020/00768/И).

77 ДЧ-гийн нэхэмжлэлтэй ЧН-д холбогдох гэрээний маргааны тухай Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 05 дугаар сарын 05-ны 182/ШШ2020/00984 дугаартай шийдвэр (182/2020/00975/И).

орчны шинжилгээний төвийн даргын тодорхойлолт зэрэг нотлох баримтыг хэрэгт хавсаргажээ.

Хариуцагч тал "Нэхэмжлэгч нь уурхайгаас нүүрс тээвэрлэж байх хугацаанд байгалийн хүндрэлтэй үзэгдэл буюу цас их орж халтиргаа гулгаа их болсны улмаас нэхэмжлэгч тойруу зам сонгон аюулгүй байдлыг ханган ажиллаж байсан. Гэвч гэрээний хугацаанд гарч болзошгүй зардал, төлбөрийн талаар гэрээнд тусгагдаагүй тул ЧТ ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгох" тухай тайлбар гаргасан байна.

Шүүхээс хэргийг шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүх "Талууд гэрээний үүргээ биелүүлж байх явцад талуудын хүсэл зориг, хяналтаас гадуур, урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд МҮХАҮТ-д хандан, холбогдох баримт бичиг бүрдүүлж өгсний эцэст байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсоныг нотолсон давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ олгодог. Энэхүү үйл ажиллагаа хийгдээгүй байх тул ажил гүйцэтгэгч ЧТ ХХК-ийг ажлаа гүйцэтгэх явцад байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсон гэж үзэх боломжгүй юм. Гэрч Х.М-ийн шүүхэд өгсөн мэдүүлэг нь өөр баримтаар нотлогдохгүй байх тул түүний мэдүүлгийг шийдвэрийн үндэслэл болгох боломжгүй байна. Хэрэв нэхэмжлэгч байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсоныг нотолсон бол гэрээний дагуу талуудын маргааныг зохицуулахаар байна" гэж нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон үндэслэлээ тайлбарлажээ[78].

[78] ЧТ ХХК-ийн нэхэмжлэлтэй Увс аймгийн УДХС ТӨХК-д холбогдох ажил гүйцэтгэх гэрээний маргааныг шийдвэрлэсэн Увс аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 05 дугаар сарын 13-ны 184 дугаартай шийдвэр (152/2019/00115/И).

Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

1. Хариуцагч нь байгалийн хүндрэлтэй үзэгдэл үүссэн тухай нэхэмжлэгчийн тайлбартай маргаагүй байна. Мөн нэхэмжлэгч хэрэгт Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын тодорхойлолт хавсаргажээ. Гэтэл шүүх "Гэрч ХМ-ийн шүүхэд өгсөн мэдүүлэг нь өөр баримтаар нотлогдохгүй байх тул түүний мэдүүлгийг шийдвэрийн үндэслэл болгох боломжгүй" гэж гэрчийн мэдүүлгийг үнэлсэн нь эргэлзээтэй байна.

2. Дээрх нотлох баримтуудыг шүүх бүрэн, эргэлзээгүй талаас нь үнэлээгүй, мөн "МҮХАҮТ-аас гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ аваагүй тул давагдашгүй хүчин зүйл тохиолдсон гэж үзэхгүй" хэмээн дүгнэсэн уг шүүхийн шийдвэрийг үндэслэл бүхий шийдвэр гэх боломжгүй юм.

Тохиолдол 2. Талууд 2019 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр 40,000,000 төгрөгийг сарын 3.5 хувийн хүүтэй, 6 сарын хугацаатай зээлүүлэх зээлийн гэрээ, үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ, фидуцийн гэрээ тус тус байгуулжээ. "Зээлдэгч зээл авснаас хойш зээлийн эргэн төлөх хугацааг байнга хэтрүүлдэг" хэмээн нэхэмжлэгч үндсэн зээл, хүү, нэмэгдүүлсэн хүү нэхэмжилж, барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулах нэхэмжлэлийн шаардлага гаргасан. Хариуцагч тал "Давагдашгүй хүчин зүйл болох дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахал гарч, Монгол Улс онц байдал зарласан бөгөөд миний хувийн бизнес бүрэн зогссон. Учир нь Монгол Улс хилээ хааснаас зээлээ төлөх боломжгүй болсон боловч үндсэн зээлээ төлнө, харин хүү, нэмэгдүүлсэн хүү нэхэмжилсэн нь үндэслэлгүй" гэж маргасан байна.

Шүүхээс хэргийг шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаж шийдвэрлэжээ[79]. Харин хариуцагч "Дэлхий нийтийн хэмжээнд гарсан цар тахалтай холбоотойгоор иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа зогсож, орлого багассан. Гэтэл шүүх нийтэд илэрхий үйл баримтыг маргаантай холбон авч үзээгүй" гэх үндэслэлээр гомдол гаргасан байна.

Давж заалдах шатны шүүх зээл, зээлийн хүүгийн тооцоог зөвтгөж, анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан. Мөн "Хариуцагч нь ИХ-ийн 222 дугаар зүйлийн 222.1.1-д заасснаар үүргээ хугацаанд нь биелүүлээгүй байх тул хугацаа хэтрүүлсэн гэж үзнэ. Хариуцагч гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүйд Force majeure /гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл/ нөлөөлсөн гэх боловч тухайн байдлаа баримтаар нотлоогүй. "Force majeure" - гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, урьдчилан сэргийлж, шинжлэх ухаан, техникийн ололт ашиглан даван гарах боломжгүй саад тотгор тохиолдсоны улмаас талууд гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүйд хүрэхийг ойлгох юм.

Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлтэй тулгарсан, хүнд нөхцөлд орсныг гэрчилж, баталгаажуулсан гэрчилгээ, тодорхойлолтыг хариуцагч шүүхэд гаргаагүйг дурдах нь зүйтэй"[80] гэжээ.

[79] П ББСБ ХХК-ийн нэхэмжлэлтэй Э.Б-д холбогдох зээлийн гэрээний тухай Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 09 дүгээр сарын 30-ны 183/ШШ2020/02623 дугаартай шийдвэр (183/2020/02876/И).

[80] П ББСБ ХХК-ийн нэхэмжлэлтэй Э.Б-д холбогдох гэрээний тухай 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 00125 дугаартай магадлал (183/2020/02876/И).

Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал болох Ковид-19 цар тахлын тухай хариуцагч тайлбарласан боловч анхан шатны шүүх огт дүгнэлт хийлгүй, орхигдуулсан байна.

2. Харин давж заалдах шатны шүүх хугацаа хэтрүүлсэн болон Ковид-19 цар тахал гарч гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн талаар дурдсан боловч МҮХАҮТ-аас түүнийг нотолсон гэрчилгээг шүүхэд гаргаагүй гэж дүгнэсэн нь ИХШХШтХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсэгт заасан заалтыг хэрэглээгүй байна.

3. “Force majeure” нь хэдийгээр олон улсад хэрэглэдэг нэр томьёо боловч Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн”, ИХШХтХ-д “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг монгол хэлээр явуулж, төрийн албан хэрэг хөтлөх бичгээр бичиж баримтжуулна” хэмээн заасан тул түүнийг шүүх ИХ-д заасан нэр томьёо, агуулгаар хэрэглэж, шүүхийн шийдвэрт тусгах нь дээрх зарчмуудад нийцнэ.

Тохиолдол 3. Х ХХК нь ДЭ-тэй 2018 оны 08 дугаар сарын 28-ны өдөр зээлийн гэрээг хүүтэй, 48 сарын хугацаатай, эргэлтийн хөрөнгийн зориулалтаар байгуулж, зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор Б.А, Ш.О нарын үл хөдлөх хөрөнгийг барьцаалж, барьцааны гэрээ байгуулан, түүнийгээ улсын бүртгэлд бүртгүүлжээ. Харин зээлдэгч зээлийн гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тул маргаан үүссэн байна.

Хариуцагч тал “Зээлийн эргэн төлөлтийг хуваарьт тохиролцсоны дагуу хугацаанд нь төлж байсан. Гэвч дэлхий нийтийг хамарсан цар тахалтай холбоотойгоор бизнесийн үйл ажиллагаа

зогссон тул зээлийн хүүгийн төлбөрийг хэрэгсэхгүй болгох”-ыг шүүхээс хүсжээ.

Шүүхээс хэргийг шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүх “Зээлийн болон барьцааны гэрээ нь ИХ-ийн 451 дүгээр зүйлийн 451.1, 451.2, 452 дугаар зүйлийн 452.1, 452.2, 156 дугаар зүйлийн 156.1, 156.2-т заасан шаардлагыг хангасан хүчин төгөлдөр гэрээ байна. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль (2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан)-ийн 10 дугаар зүйлд төв банк болон арилжааны банкнаас авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар заасан бөгөөд тус зүйлийн 10.7-д “Ипотекийн зээлийн эргэн төлөлтийн хугацааг зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн үлдэгдэл хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр нийт 6 сараар хугацааг сунгах асуудлыг Засгийн газартай хамтран хэрэгжүүлнэ” гэж заажээ.

Хариуцагч ДЭ-гийн зээл нь дээр дурдсан хуульд заасан ипотекийн зээлд хамаарахгүй боловч хариуцагч нь Ковид-19 цар тахал гарсантай холбогдуулан зээлийн эдийн засагчтай уулзаж, зээлийн хүүг зогсоолгох хүсэлт гаргасан гэх тайлбар гаргаж байх боловч зээлийн гэрээний хугацааг сунгах хүсэлтийг нэхэмжлэгч байгууллагад гаргасан эсэх нь баримтаар тогтоогдохгүй байна. Иймд нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаж, шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд барьцааны зүйл болох үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулж, үүргийн гүйцэтгэлийг хангуулах үндэслэлтэй”[81] хэмээн шийдвэрлэжээ.

[81] Х ХХК-ийн нэхэмжлэлтэй хариуцагч Д.Э, Б.А, Ш.О нарт холбогдох зээлийн гэрээний маргааны тухай БЗД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 29-ний 101/ШШ2021/0380 дугаартай шийдвэр (101/2020/04330/И).

Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

1. Шүүх Ковид-19 цар тахал гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал мөн эсэхэд дүгнэлт хийгээгүй ба цар тахлын улмаас бизнесийн үйл ажиллагаа доголдож зогсон, орлогогүй болсон гэх тайлбараа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.2, 38 дугаар зүйлийн 38.1-д зааснаар баримтаар нотлоогүй хэмээн дүгнэжээ. Шүүх ийнхүү дүгнэснээрээ ИХШХШтХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсэгт заасан "Нийтэд илэрхий үйл баримт хэрэг хянан шийдвэрлэхэд холбогдолтой байвал түүнийг дахин нотлохгүй" тухай заалтыг буруу ойлгож хэрэглэсэн байна.

2. Шүүх ИХ-ийн 221, ИХШХШтХ-ийн 40 дүгээр зүйлийг хэрэглээгүй атлаа Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг шийдвэрийнхээ үндэслэх хэсэгт заасан нь тодорхойгүй байна.

Дээрх шүүхийн шийдвэрүүдэд дараах дүгнэлт хийж болохоор байна:

1. Шүүх ИХ-ийн 221, ИХШХШ тухай хуулийн 40 дүгээр зүйлийг хэрэглээгүй.

2. Нэхэмжлэгч нь байгалийн хүндрэлтэй үзэгдэл үүссэн тухай хариуцагчийн тайлбартай маргаагүй, мөн уг нөхцөл байдлыг нотолсон Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга-гын тодорхойлолт, гэрчийн мэдүүлэг зэрэг нотлох баримт байгаа боловч МҮХАҮТ-аас гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ аваагүй тул давагдашгүй хүчин зүйл тохиолдсон гэж үзэхгүй хэмээн шийдвэрлэсэн.

Ийнхүү шүүх анхдагч нотлох баримтыг үнэлэхгүй харин дамжмал нотлох баримтаар хэргийн үйл баримтыг нотолно гэж байгаа нь үндэслэлгүй юм.

3. “Force majeure” нь хэдийгээр олон улсад хэрэглэдэг нэр томьёо боловч ИХ-д түүнтэй дүйх зохицуулалт байгаа тул шүүх тухайн зохицуулалтыг хэрэглэн цаашид шийдвэрлэх шаардлага урган гарч байна.

2.5. ГЭНЭТИЙН БУЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧНИЙ ШИНЖТЭЙ ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТУХАЙ ТАЙЛБАР, БУСАД НОТЛОХ БАРИМТЫГ ҮНЭЛЭЭГҮЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал, түүний дотор Ковид-19 цар тахлын улмаас Засгийн газар, УОК-оос гаргасан шийдвэрүүдээс хамааран гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй талаараа хэргийн оролцогчид тайлбарласан байна. Гэтэл дүн шинжилгээ хийсэн шүүхийн 21 шийдвэрт буюу нийт шийдвэрийн 17.9 хувьд нь шүүх нотлох баримтыг үнэлээгүй ажээ. Ийнхүү цар тахлын улмаас ихэнх улс орон хил, гаалиа хаасан, хөл хорио тогтоосон үед гадаад худалдаа болон бизнесийн бусад үйл ажиллагаа явуулах боломжгүй болсны улмаас маргаан үүссэн зарим хэргийг шүүх шийдвэрлэхдээ эрх бүхий байгууллагаас гарсан шийдвэрүүдэд дүгнэлт хийгээгүй, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээг хэрэглээгүй байна.

Тохиолдол 1. Нэхэмжлэгч Н.Д нь өөрийн найз Б.Э, Д.Э нараар дамжуулан Энэтхэг улсад суух Л.Ө, Б.О нараас 100,000 ширхэг маск худалдан авахаар тохирч төлбөрийг шилжүүлжээ. Харин Л.Ө, Б.О нар маскийг дутуу нийлүүлсэн тул маргаан үүсэж нэхэмжлэгч гэрээнээс татгалзаж, дутуу өгсөн маскийн

үнэ болох 17,600,000 төгрөгийг буцаан гаргуулах шаардлага гаргасан.

Хариуцагчдын хувьд дутуу шилжүүлсэн маскийн төлбөрийг төлөх талаар маргахгүй, харин Монгол Улс 1997 онд нэгдэн орсон, 1980 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр Нэгдсэн Үндэстний Байгууллагаас баталсан Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай конвенцын 79 дүгээр зүйлд "Аль нэг тал үүргээ гүйцэтгээгүй, түүний хяналтаас гадна орших саад бэрхшээлээс болсон бөгөөд гэрээ байгуулах үед уг саад бэрхшээлийг тооцох, түүнээс зайлсхийх буюу үр дагаврыг нь давж гарах арга замыг урьдчилан тооцох аргагүй байсныг талууд нотолбол тухайн тал үүрэг гүйцэтгээгүйн хариуцлагыг хүлээхгүй" гэж заасан. Дэлхий нийтээр тархсан цар тахлаас болж Энэтхэг улсын хилээр маск гаргахыг хориглосон, Монгол Улс хилээ хааснаар гэрээний үүрэг гүйцэтгэх хугацаа хойшлогдсон тухай тайлбарлажээ.

Тохиолдол 2. ТНУК ХХК нь 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдөр "Сав, баглаа боодлын үйлдвэр" төслийн зориулалтаар зээл болон барьцааны гэрээ байгуулан ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас 500,000,000 төгрөгийг 60 сарын хугацаатай, жилийн 3 хувийн хүүтэйгээр зээлжээ. Харин зээлдэгч нь гэрээний хугацаа хэтрүүлж, зээлээ төлөөгүй гэж нэхэмжлэгч тал гэрээг цуцалж, зээл, хүү, алданги, нотариатын зардал нэхэмжилжээ. Мөн шүүх хуралдаанд **прокурор оролцож** нэхэмжлэлийн шаардлагыг дэмжсэн байна.

Хариуцагч тал "Гэрээний 3.3-т алданги тооцно гэж заасан боловч үйлдвэрийн тоног төхөөрөмжөө Хятад Улсаас импортоор оруулж ирээд сав, баглаа үйлдвэрлэх процессын туршилт, тохируулга хийж байтал Ковид-19 гарч улсын хэмжээнд онц байдал үүсэн, үйлдвэрийн үйл ажиллагаа бүрэн зогсож гэрээнд заасан үүргээ биелүүлэх боломжгүй болсон. Иймээс давагдашгүй

хүчин зүйлийн улмаас алданги төлөх боломжгүй" гэж маргасан байна.

Шүүхээс хэргийг шийдвэрлэсэн байдал

1. Шүүх эхний хэргийн хувьд нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаж шийдвэрлэсэн[82].

2. Харин хоёр дахь хэргийн хувьд нэхэмжлэгч талын гэрээ цуцалсан хугацааг тогтоож, түүнээс хойших хугацаанд зээл, хүү, алданги нэхэмжлэх үндэслэлгүй, ИХШХШтХ-ийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийг үндэслэн нотариатын хөлсийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Харин хариуцагч талын "...Ковид 19 цар тахлын улмаас үйлдвэр баригдаагүй, Хятад Улсаас тоног төхөөрөмж ирээгүй..." гэх тайлбарыг үндэслэн алдангиас чөлөөлөх үндэслэлгүй байна хэмээн шийдвэрлэжээ[83].

Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

Хэргийн оролцогчид Ковид-19 цар тахлын улмаас гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тухайд манай улсын нэгдэн орсон Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай НҮБ-ын конвенцын тодорхой заалтыг үндэслэн тайлбарлажээ. Гэвч шүүх шийдвэр гаргахдаа уг конвенцыг хэрэглээгүй ба хэрэглээгүй учир шалтгааныхаа үндэслэлийг тайлбарлаагүй байна.

---

82 Н.Д-гийн нэхэмжлэлтэй хариуцагч Б.О, Л.Ө нарт холбогдох худалдах, худалдан авах гэрээний маргааны тухай Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 11 дүгээр сарын 11-ний 102/ШШ2020/03405 дугаартай шийдвэр (102/2020/03098/И).

83 ЖДҮГ-ын нэхэмжлэлтэй хариуцагч ТНУК ХХК, иргэн Б.Э, Э.У, Ш.М, Ө,М, Д.Д нарт холбогдох зээлийн гэрээний маргааны тухай БЗД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 02 дугаар сарын 10-ны 101/ШШ2021/00525 дугаартай шийдвэр (101/2020/04207/И).

Мөн шүүх Ковид-19 цар тахлыг ИХ-ийн 221-д заасан хүндэтгэн үзэх шалтгаан мөн эсэхэд огт дүгнэлт хийхгүй, эсвэл дурдаад өнгөрч байна. Тухайлбал, шүүх "Хариуцагч талын Ковид-19 цар тахалтай холбоотой тайлбарыг үндэслэн алдангиас чөлөөлөх үндэслэлгүй" хэмээн дүгнэхдээ ямар нотлох баримтыг үндэслэсэн, ИХ хуулийг 221 дүгээр зүйлийг яагаад хэрэглээгүй тухайдаа үндэслэлтэй дүгнэлт хийгээгүй байна.

Иймээс шүүх нийтэд илэрхий үйл баримтын талаар материаллаг болон процессын хууль хэрэглэж, үндэслэлтэй дүгнэлт хийх шаардлага байна. Шүүхээс талуудын хэрэгт хамааралтай, ач холбогдолтой нотлох баримт болон тайлбарт дүгнэлт хийснээр шүүхэд олон түмний итгэх итгэл сайжрах, хуулийг зөв хэрэглэх, тайлбарлах практик тогтох юм.

ГУРАВ. ГЭНЭТИЙН БУЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧНИЙ ШИНЖТЭЙ ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТУХАЙ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

3.1. ОХУ-ЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

ОХУ-ын Иргэний хуульд гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн талаар 401-р зүйлдээ дараах байдлаар тусгажээ.

401 дүгээр зүйл. Үүрэг зөрчсөний улмаас хүлээлгэх хариуцлага, үндэслэл

1. Үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй гэм буруутай (санаатай эсвэл болгоомжгүй) этгээд хариуцлага хүлээнэ. Үүргийн мөн чанар, нөхцөлөөс хамааран түүнийг биелүүлэхэд шаардлагатай урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээ авсан этгээдийг гэм буруугүй гэж үзнэ.

2. Үүргээ зөрчсөн этгээд гэм буруугүй тухайгаа нотолно.

3. Хууль, эсвэл гэрээнд өөрөөр заагаагүй бол аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх явцад үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй этгээд давагдашгүй хүчин зүйлийн улмаас, өөрөөр хэлбэл, онцгой бөгөөд зайлшгүй /гарцаагүй, дийлдэшгүй/ нөхцөл байдлын улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй байснаа нотлоогүй бол хариуцлага хүлээнэ. Энэ нөхцөл байдалд зах зээл дээр шаардлагатай бараа байхгүй, үүрэг гүйцэтгэгч үүргээ биелүүлэхэд шаардагдах эд хөрөнгө дутагдсанаас хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь хамаарахгүй.

4. Үүргээ санаатайгаар зөрчсөн тохиолдолд хариуцлагаас чөлөөлөх, эсвэл хязгаарлахаар урьдчилан тохиролцож болохгүй.[84]

ОХУ-ын Дээд шүүх нь ИХ-ийн 401 дүгээр зүйлийн агуулгыг дараах байдлаар дэлгэрүүлэн тайлбарласан байна.[85]

1. Үүрэг гүйцэтгэгч үүргээ биелүүлээгүй үндэслэлээ нотлоогүй бол гэм буруутайд тооцогдоно. Үүрэг гүйцэтгэгч үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй нь түүний буруу биш бол гэм буруугүй болохоо нотлох үүрэгтэй (ОХУ-ын ИХ-ийн 401.2).

   Хэрэв үүрэг гүйцэтгэгч үүргээ зөрчсөн, эсвэл гэм хор учруулсан нь түүний гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага хүлээхээр бол хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болсон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг нотлох үүрэг хүлээнэ (ОХУ-ын ИХ-ийн 401.3).

2. ОХУ-ын ИХ-ийн 401 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар үүрэг гүйцэтгэгч үүргээ санаатай зөрчөөгүй тохиолдолд хариуцлагаас чөлөөлөх юм уу түүнийг багасгах нөхцөлийг гэрээндээ тохирсон бол түүнийг нотлох үүрэгтэй.

   Хариуцлагаас чөлөөлөх, эсвэл хязгаарлах тухай урьдчилан байгуулсан хэлэлцээр нь үүргээ санаатайгаар зөрчсөнөөр хүлээх хариуцлагаас чөлөөлөхгүй (ОХУ-ын ИХ-ийн 401.4). Үүргээ санаатай зөрчөөгүй гэдгээ тухайн этгээд нотолно (ОХУ-ын ИХ-ийн 401.1 ба 2). Жишээ нь, талууд

---

84 Гражданский кодекс Российской Федерации от 21 октября 1994 года. URL: http://ivo.garant.ru/#/document/10164072/paragraph/2056:0 (дата обращения: 06.06.2021.

85 Постановление Пленума Верховного Суда РФ от 24 марта 2016 г. N7 "О применении судами некоторых положений Гражданского кодекса Российской Федерации об ответственности за нарушение обязательств". URL: http://ivo.garant.ru/#/document/71360358/paragraph/1:2 (дата обращения: 06.06.2021).
Үүрэг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тухай ОХУ-ын Иргэний хуулийн зарим заалтыг шүүхээс хэрэглэх тухай ОХУ-ын Дээд шүүхийн Бүгд хурлын 2016 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 7 дугаартай тогтоол.

хариуцлагаас чөлөөлөх эсвэл хязгаарлахаар тохирсон бол үүрэг гүйцэтгэгч үүргээ санаатай зөрчөөгүй буюу үүргээ биелүүлэхийн төлөө туйлын бага боловч санаа тавьж, анхааралтай, хянамгай хандсанаа нотолно.

3. ОХУ-ын ИХ-ийн 401 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу давагдашгүй хүчин зүйл нь тухайн нөхцөлд онцгой ба гарцаагүй /дийлдэшгүй/ шинжтэй байна.

   Онцгой шинж нь ердийн үед тохиолддоггүй онцгой нөхцөл байдлыг /үзэгдэл, хүчин зүйл/ хэлнэ. Хуульд өөрөөр заагаагүй бол үүрэг гүйцэтгэгчтэй ижил төстэй үйл ажиллагаа явуулж байгаа хэн боловч уг нөхцөл байдал /үзэгдэл, хүчин зүйл/ үүсэхээс зайлсхийх, эсвэл түүний үр дагаврыг арилгаж чадахааргүй нөхцөл байдлыг гарцаагүй /дийлдэшгүй/ нөхцөл байдал гэж ойлгоно. Үүрэг гүйцэтгэгч үүргээ биелүүлэхэд шаардлагатай эд хөрөнгөгүй болох, түүнтэй харилцагч талууд нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчих, түүнийг төлөөлж буй этгээдүүд хууль бус үйл ажиллагаа явуулах зэрэг үүрэг гүйцэтгэгчийн хүсэл зориг ба үйлдлээс хамаарсан нөхцөл байдлыг давагдашгүй хүчин зүйл гэж үзэхгүй.

4. Хэрэв үүргийг гүйцэтгэх боломжтой байвал давагдашгүй хүчин зүйл үүссэнээр гэрээг цуцлахгүй.

   Давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас хугацаа хожимдуулснаар үүргийг гүйцэтгүүлэх шаардлагагүй болсон бол үүрэг гүйцэтгүүлэгч гэрээнээс татгалзах эрхтэй. Энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэгч давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэний улмаас үүргийн гүйцэтгэл хойшлогдсоноос учирсан хохирлыг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хариуцахгүй (ОХУ-ын ИХ-ийн 401.3, 405.2).

5. Үүрэг гүйцэтгэгч нь давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүрэг гүйцэтгүүлэгчид учруулсан хохирлыг багасгах

боломжит бүх арга хэмжээг авах, уг нөхцөл байдлын тухай мэдэгдэх үүрэгтэй, энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгчид учирсан алдагдлыг /хохирлыг/ нөхөн төлөх үүрэгтэй.[86]

Шүүхээс давагдашгүй хүчин зүйл гэж тооцсон тодорхой нөхцөл байдлуудад, жишээ нь, байгалийн гамшигт үзэгдэл болох, их хур тунадас унах, голын усны түвшин хэт нэмэгдэх, үер болох, тэнгэрийн биет /солир/ унах, ган гачиг тохиох, цэргийн ажиллагаа /дайн болох/ явагдах, террорист халдлага болох зэрэг нөхцөл байдлыг оруулжээ. Шүүх дараах нөхцөл байдлуудыг давагдашгүй хүчин зүйлд тооцоогүй байна, жишээ нь, эдийн засгийн хямрал, эдийн засгийн хориг арга хэмжээ, гадаадын валюттай харьцах рублийн ханшны уналт, банкны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, төлбөр тооцооны үйлчилгээг зогсоох, гуравдагч этгээдийн хууль бус үйлдэл, жишээ нь, хулгай, гэмт хэрэг үйлдэх, гуравдагч этгээдийн буруутай үйлдлийн улмаас гал түймэр, зам тээврийн осол гарах, төлбөрийн чадваргүй болох (дампуурах), тухайн улиралд ердийн тохиолддог агаарын нөхцөлд үүрэг гүйцэтгэх[87] зэрэг болно.

ОХУ-ын ИХ-д давагдашгүй хүчин зүйл нь ердийн үед тохиолддоггүй буюу тухайн нөхцөлд онцгой ба мөн хэн ч ямар нэгэн арга хэмжээ авч түүний үр дагаврыг багасгах, тогтоон барьж чадахааргүй гарцаагүй /дийлдэшгүй/ шинжтэй байх тухай заасан. Гэхдээ үүрэг гүйцэтгэгч үүрэг гүйцэтгүүлэгчид учрах хохирлыг багасгах боломжит бүх арга хэмжээг авах,

---

86 Постановление Пленума Верховного Суда РФ от 24 марта 2016 г. N7 "О применении судами некоторых положений Гражданского кодекса Российской Федерации об ответственности за нарушение обязательств". URL: http://ivo.garant.ru/#/document/71360358/paragraph/1:2 (дата обращения: 06.06.2021).

87 Яровенко Василий Григорьевич. Всё, что нужно знать о непреодолимой силе (форс-мажоре). URL: https://zakon.ru/blog/2020/7/27/nepreodolimaya_sila_forsmazhor_aktualnye_voprosy_sudebnaya_praktika_podborka_primernyh_uslovij_dogo

түүнд давагдашгүй хүчин зүйл тохиолдсон болон авсан арга хэмжээнийхээ тухай мэдэгдэх үүрэг хүлээдэг. Үүрэг гүйцэтгэгч энэхүү нөхцөл байдлыг нотолсноор хариуцлагаас чөлөөлөгдөхөөр зохицуулсан. Мөн давагдашгүй хүчин зүйлд хамаарахгүй нөхцөл байдлуудын агуулга, утга санааг хууль болон тайлбарт зааснаараа онцлог байна.

Манай улсын ИХ-ийн 219 дүгээр зүйлийн 219.4 дэх хэсэг дэх "Үүрэг гүйцэтгэгч санаатайгаар үүргээ зөрчсөн тохиолдолд учирсан хохирлыг арилгах үүргээс түүнийг чөлөөлөхөөр урьдчилан тохиролцож болохгүй", 221 дүгээр зүйлийн 221.4 дэх хэсэг дэх "Эрх бүхий этгээд гэрээ цуцлах үндэслэл байгааг мэдсэнээс хойш ердийн боломжит хугацааны дотор гэрээнээс татгалзаж болно" зэрэг зохицуулалт нь ОХУ-ын ИХ-ийн дээрх зохицуулалттай төсөөтэй байна.

3.2. ФРАНЦ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Францын иргэний эрх зүй нь Европын зарим улс орны иргэний эрх зүй дэх "Боломжгүй зүйл үүрэг үүсгэхгүй" гэх зарчим *(Impossibilium nulla obligation est)*-ыг удирдлага болгодог[88]. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл буюу Францын иргэний эрх зүй дэх "*force majeure*" нэршил нь Ромын эрх зүй дэх "*vis maior*"-ыг эх сурвалж болгосон[89].

1804 оны Францын Иргэний хуульд гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийг нарийвчлан тайлбарлаагүй боловч хуулийн 1147, 1148 дугаар зүйлүүдэд гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийг урьдчилан харах, зайлсхийх боломжгүйгээр өрийн (үүрэг) гүйцэтгэлийг биелүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж

[88] Mustafa Dural. Borçlunun Sorumlu Olmadığı Sonraki İmkansızlık (BK.117). Fakülteler Matbaası, İstanbul, 1976, 1 дэх тал.

[89] Söğütlü Erişgin, Özlem. Roma Hukukunda Contractus (Sözleşme) Kavramı ve Sözleşmesel Sorumluluk Ölçütleri. Ankara, 2016, 228 дахь тал.

зүйлчилсэн байна[90]. Уг хуульд 2016 онд нэмэлт, өөрчлөлт оруулж 1218/I хэсэгт гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийг *“гэрээгээр ццсэх харилцааны цндсэн дээр зээлдэгч (ццрэг гцйцэтгэгч)-ийн хяналтаас гадна гэрээ байгуулах цед урьдчилан мэдэх боломжгцй, шаардлагатай арга хэмжээ авахаар төлөвлөх боловч өрийн (ццрэг) гцйцэтгэлийг биелццлэх боломжгцй нөхцөл байдал”* гэх байдлаар тодорхойлсон байна[91].

Францын иргэний эрх зүй дэх гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл нь гэрээ байгуулагч талуудын хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас гэрээний үүргийг байнга болон хэсэг хугацаанд биелүүлэх боломжгүй болох нөхцөл байдалд хэрэглэгдэх зохицуулалттай юм[92].

Гэрээ байгуулсны дараа бий болох гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс байнгын хэв шинжтэй үргэлжлэх явцад гэрээний үүрэг (өрийн буцаан төлөлт) хуульд заасан үндэслэлээр *(ipsu iure)* дуусгавар болно[93].

---

90 Puelinckx. Frustration, Hardship, Force Majeure, Imprévision, Wegfall der Geschäftsgrundlage, Unmöglichkeit, Changed Circumstances, A Comperative Study in English, French, German and Japanese Law. “Journal of International Arbitration”, Vol. III, I. 2, 47-66, 56 дахь тал. https://www.trans-lex.org/128100/_/puelinckx-ah-frustration-hardship-force-majeure-imprйvision-wegfall-der-geschдftsgrundlage-unmцglichkeit-changed-circumstances-3-jintl-arb-1986-no-2-at-47-et-seq/.

91 Дэлгэрэнгүйг: https://admi.net/code/index-CCIVILL0.html.

92 David Rene. Frustration of Contract in French Law, Comparative Legislation and International Law. Vol. XXVIII, I. 3-4, 12 дахь тал. https://www.jstor.org/stable/754645.

93 Kokarin, I./Van der Weide, J. Force Majeure and Unforeseen Change of Circumstances. The Case of Embargoes and Currency Fluctations (Russian, German and French Approaches). “Russian Law” Journal, Vol. III, I. 3, 72 дахь тал. https://www.russianlawjournal.org/jour/article/view/94/103.

3.3. ГЕРМАН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Германы иргэний эрх зүйд гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэх ойлголтыг үүрэг гүйцэтгэгчээс үл шалтгаалах боломжгүй нөхцөл байдлын хүрээнд томьёолжээ.[94]

Германы ИХ-ийн 313, 314 дүгээр зүйлд урт хугацааны гэрээг хүндэтгэх шалтгаанаар цуцлах, хүнд нөхцөл бүхий гэдэг ойлголтод эдийн засгийн хувьд тодорхой нөхцөл үүсэж үүрэг биелүүлэх боломжгүй байх зэрэг тохиолдлыг *(hardship)* хуульчилсан бол мөн хуулийн 275 дугаар зүйлд биелүүлэх боломжгүй нөхцөлийг тусгасан байна. Тус зүйлд үүргийн гүйцэтгэлийг объектив болон онолын хувьд биелүүлэх боломжгүй нөхцөл үүссэн байх шаардлагатай байдлаар хуульчилсан.[95] Ямар нөхцөл байдлыг давагдашгүй хүчин зүйл буюу биелүүлэх боломжгүй зүйл гэж үзэх талаар тухайн хуульд дараах байдлаар ерөнхийлөн тусгасан. Тухайлбал, давагдашгүй, биелүүлэх боломжгүй хүчин зүйл нь үүрэг гүйцэтгэгчийн хүсэл зориг, удирдлагаас гадуур нөхцөл байдал бий болох, гэрээ байгуулахаас өмнө тухайн нөхцөлийг урьдчилан мэдэх боломжгүй байсан, бий болсон нөхцөл байдлыг арилгах боломжгүй байх зэргээр тодорхойлсон.[96]

275 дугаар зүйл дэх биелүүлэх боломжгүй хүчин зүйл, 313, 314 дүгээр зүйлүүд дэх хүнд нөхцөлийг Германы иргэний эрх зүйд дараах байдлаар ялган тайлбарладаг. Эдгээр нөхцөл байдал үүрэг гүйцэтгэх нөхцөлийг төвөгтэй болгож, эдийн засгийн хувьд маш их зардлаар үүрэг гүйцэтгэх шаардлагатай юм уу үүрэг

[94] Puelinckx. Frustration, Hardship, Force Majeure, Imprévision, Wegfall der Geschäftsgrundlage, Unmöglichkeit, Changed Circumstances, A Comperative Study in English, French, German and Japanese Law. “Journal of International Arbitration”, Vol. III, I. 2, 47-66, 60 дахь тал. https://www.trans-lex.org/128100/_/puelinckx-ah-frustration-hardship-force-majeure-imprévision-wegfall-der-geschäftsgrundlage-unmöglichkeit-changed-circumstances-3-jintl-arb-1986-no-2-at-47-et-seq/.

[95] Topuz, Canbolat. Türk-İsviçre ve Alman Borçlar Hukukunda İmkansızlığın Düzenlenişi. AÜHFD, C.LVII, S.3, 700 дахь тал. https://jurix.com.tr/article/13264.

[96] Brunner. Force Majeure and Hardship Under General Contract Principles, Exemption for Non-Performance in International Arbitration. The Hague, Kluwer Law International, 2009, 86 дахь тал. https://www.trans-lex.org/100970/_/exemption-for-non-performance-in-international-arbitration-2009/.

гүйцэтгэх боломжгүй нөхцөл бий болгодог. Ялгагдах гол онцлог нь, хүнд нөхцөл байдалд үүрэг гүйцэтгэгч (өр төлөгч)-ийн үүрэг гүйцэтгэх нөхцөл эдийн засгийн хувьд их хэмжээний хор хохирол учруулахуйц байна. Харин давагдашгүй хүчин зүйлийн хувьд үүргийн гүйцэтгэл биелэх боломжгүй нөхцөл байдал бий болсон байхыг ойлгоно[97].

3.4. АНУ БОЛОН АНГЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

FRUSTRATION THEORY болон IMPRACTICABILITY

Дээрх зохицуулалтын агуулгыг тодорхойлохдоо Англи, Америкийн эрх зүйн тогтолцооны гэх байдлаар гарчиглаж байгаа боловч гол төлөв энэхүү эрх зүйн тогтолцоог эх сурвалж болгож буй Англи, Америк болон бусад улсын гэрээний эрх зүйн хүрээнд бий болох гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалд хэрэглэгдэх эрх зүйн хэм хэмжээг чухалчлан авч үзсэн. Англи-Америкийн эрх зүйн тогтолцоонд гэрээний үндсэн дээр бий болсон үүргүүд нь тухайн үүргийн биелэлтийн баталгаа болдог.[98] Тус зохицуулалтад давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан гэрээний үүрэг гүйцэтгэх агуулга бүхий харилцааг товчхон зохицуулсан бөгөөд давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан гэрээний үүргийг биелүүлэх боломжгүй нөхцөл үүсэх нь үүрэг гүйцэтгэгчийг гэрээний бүхий л үүргээс бүрэн чөлөөлөх нөхцөл болохгүй. Энэхүү зохицуулалтаар гэрээний талууд гэрээнд тусгасан үүргүүдийг бүрэн гүйцэтгэх зорилгоор давагдашгүй хүчин зүйл, нөхцөл үүссэн тохиолдолд авах арга хэмжээний талаар гэрээнд шинэ нөхцөл оруулах

---

97 Мөн тэнд, 84 дэх тал.

98 Atamer. Satıcının Sözleşmeye Aykırı Davranışı Ekseninde CISG'ın İfa Engelleri Sisteminde Genel Bakış. Milletlerarası Satım Hukuku, 1. Baskı, İstanbul, XII Levha Yayınları, 2008, 225 дахь тал. https://dergipark.org.tr/en/download/article-file/826122.

байдлаар зохицуулалт хийсэн[99]. Английн эрх зүйн тогтолцоонд гэрээний үүргийг биелүүлэхэд саад учруулахуйц нөхцөл байдалд *(давагдашгүй хүчин зүйл)* хүрсэн тохиолдолд гэрээ дуусгавар болно[100].

Америкийн эрх зүйн тогтолцоонд давагдашгүй хүчин зүйлийг хэрэгжихгүй нөхцөл *(impracticable)* болон биелшгүй байдал *(impracticability)* гэх байдлаар тодорхойлон зохицуулсан. АНУ-ын Арилжааны нэгдсэн хуулийн 2-615 дугаар зүйлд зааснаар "биелшгүй байдал" гэдэгт гэрээний эдийн засгийн байдлыг тасалдуулах нөхцөл байдлыг урьдчилан таамаглах байдлаар гэрээ байгуулах *(Газрын тосны хомсдолоос болж үнийн хөөргөдөл бий болох, Суэцийн суваг хаагдсанаас болж барааны үнэ өсөх)*, тухайн нөхцөл байдал бий болсноор гэрээний үүрэг хэрэгжихгүй нөхцөл байдалд хүрэхийг ойлгох бөгөөд энэ нь үүрэг гүйцэтгэгчийн хүсэл зоригоос үл хамаарах шалтгаан юм.[101] Гэрээний үүргийг биелүүлэх боломжгүй нөхцөл үүсэхэд гэрээг түдгэлзүүлэх, дуусгавар болгох арга хэмжээ авах бөгөөд гэрээний үүргийг гүйцэтгэх нөхцөл эдийн засгийн хувьд ихээхэн хор хохирол учруулахуйц байна[102].

Франц, Германы иргэний эрх зүй, Англи, Америкийн эрх зүйн тогтолцоо дахь гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал нь томьёоллын хувьд өргөн агуулга

99 Başak Baysal. Sözleşmenin Uyarlanması, 1.Baskı, XII Levah Yayınları, İstanbul, 2009, 50 дахь тал.

100 Puelinckx. Frustration, Hardship, Force Majeure, Imprévision, Wegfall der Geschäftsgrundlage, Unmöglichkeit, Changed Circumstances, A Comperative Study in English, French, German and Japanese Law. "Journal of International Arbitration", Vol. III, I. 2, 47-66, 51 дэх тал. https://www.trans-lex.org/128100/_/puelinckx-ah-frustration-hardship-force-majeure-imprévision-wegfall-der-geschäftsgrundlage-unmöglichkeit-changed-circumstances-3-jintl-arb-1986-no-2-at-47-et-seq/.

101 Rivkin. Lex Mercatoria and Force Majeure. Transnational Rules in International Commercial Contracts, International Chamber of Commerce, Publication no.480/4, 1993, 166-167 дахь тал. https://www.trans-lex.org/116100/_/rivkin-david-r-lex-mercatoria-and-force-majeure-in:-gaillard-transnational-rules-in-international-commercial-arbitration-paris-1993-at-161-et-seq/.

102 Almeida Prado. Le Hardship dans Le Droit du Commerce International. Bruxelles, Feduci, Bruylant, 2003, 45-47 дахь тал. https://www.persee.fr/doc/ridc_0035-3337_2006_num_58_4_19496_t12_1295_0000_1.

илэрхийлэх бөгөөд тухайн эрх зүйн тогтолцоо дахь гэрээ, түүний биелэгдэх байдалд гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал хэрхэн нөлөөлөх, тус нөхцөл байдлыг хэрхэн томьёолж зохицуулалт хийх, Монгол Улсын ИХ дахь холбогдох зохицуулалт бүхий гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлаас тэдгээрийн ялгаатай болон ижил төстэй талуудыг энд тусгахыг чухалчиллаа. Францын иргэний эрх зүй дэх "Force majeure", Германы иргэний эрх зүй дэх "давагдашгүй хүчин зүйл", "Hardship", Английн эрх зүйн тогтолцоо дахь "Frustration", Америкийн эрх зүйн тогтолцоо дахь "Impracticability" зэрэг ойлголтыг товчхон дурдсан бөгөөд эдгээр улсын холбогдох зохицуулалтууд нь ерөнхий агуулгын хувьд "гэрээний талуудын хүсэл зоригоос үл шалтгаалах нөхцөл байдал буюу гэрээг байгуулах үед урьдчилан таамаглах болон сэргийлэх арга хэмжээ авах, гэрээний талууд гэрээгээр хүлээх үүргээ биелүүлэх боломжгүй болох" зэрэг байдлаар ойлгогдож байна.

Францын ИХ-д гэрээний талуудын хяналтаас гадуур, зайлсхийх боломжгүй нөхцөл байдлыг гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэж үзэх бөгөөд талууд гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй нөхцөл байдлын үргэлжлэх хугацааг байнга болон хэсэг хугацаанд гэх байдлаар илэрхийлсэн байна. Монгол Улсын ИХ-д гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын үргэлжлэх хугацааны талаар тодорхойлсон зохицуулалт байхгүй байна. Францын ИХ-д заасан гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал буюу "*Force majeure*" гэх франц нэршил 1980 оны "Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай НҮБ-ын конвенц"-д мөн хэрэглэгддэг.

Германы иргэний эрх зүйд гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэх ойлголтыг үүрэг гүйцэтгэгчээс үл шалтгаалах, боломжгүй нөхцөл байдлын хүрээнд тодорхойлсон нь Монгол,

ОХУ, Франц зэрэг улсын иргэний хууль тогтоомж дахь гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлыг тодорхойлох ерөнхий агуулгатай нийцэж байна.

Судлаачид бүтээл, сурах бичигтээ давагдашгүй хүчин зүйлийг нэр томьёоллын хувьд Unmöglichkeit хэмээн тодорхойлдог боловч Unmöglichkeit-ийг шууд байдлаар давагдашгүй хүчин зүйл гэж ойлгох боломжгүй, харьцангуй өргөн утга агуулдаг. Unmöglichkeit нь үүргийн гүйцэтгэл боломжгүй болох нөхцөл бөгөөд ийм нөхцөлд зарим тохиолдолд давагдашгүй хүчин зүйлс нөлөөлдөг. Unmöglichkeit нь Монгол Улсын ИХ-ийн 219, 249-д цухас дурдагдсан ойлголт юм.

Монгол Улсын Иргэний хууль дахь гэнэтийн буюу давагдашгүй шинжтэй онцгой нөхцөл байдал нь Английн эрх зүйн тогтолцоон дахь *Frustration*-ээс ялгаатай бөгөөд уг ойлголт буюу *frustration*-ий зохицуулалт харьцангуй өргөн. Тухайлбал, гэрээ байгуулагчдын аль нэг тал нь давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдол нь тухайн үүрэг гүйцэтгэгчийг үүргээс бүрэн чөлөөлөх нөхцөл болохгүй гэж үздэг. Энэ нь Монгол Улсын Иргэний хууль дахь холбогдох зохицуулалттай ижил бөгөөд манай улсын хувьд гэрээний үүрэг биелүүлээгүй байх нөхцөл нь гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлаас бий болсон эсэх, тус нөхцөл байдал цаг хугацааны хувьд болон нийт үүргийн гүйцэтгэлийг бүхэлд нь биелүүлэх боломжгүй нөхцөлд хүргэсэн эсэхээс шалтгаалж үүрэг гүйцэтгэгчийг үүргийн гүйцэтгэлээс ямар хэмжээгээр чөлөөлөх тухай ойлголт байдаг.

Америкийн эрх зүйн тогтолцоо буюу АНУ-ын Арилжааны нэгдсэн хуульд тусгалаа олсон *impracticable* буюу гэрээг биелүүлэх боломжгүй, гэрээний биелшгүй байдал нь гэрээний үндсэн дээр үүрэг гүйцэтгэгч үүргийн гүйцэтгэлийг өөрийн хүсэл зоригоос үл шалтгаалах нөхцөл байдлын улмаас биелүүлэх боломжгүй болох гэсэн байдлаар тодорхойлогддог. Гэрээний талууд гэрээ

байгуулах явцад үүрэг гүйцэтгэхэд саад учруулахуйц эдийн засгийн шинжтэй нөхцөл байдлуудыг урьдчилан таамаглах байдлаар гэрээ байгуулахыг шаарддаг. Гэрээний үүрэг гүйцэтгэгч ямар ч тохиолдолд үүргээ бүрэн гүйцэтгэх шаардлага нь тухайн үүрэг гүйцэтгэгчид эдийн засгийн ихээхэн хохирол учруулахуйц байна. Дээрх зохицуулалт нь Монгол Улсын Иргэний хууль дахь гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал, түүний зохицуулалтаас ялгаатай байх бөгөөд Монгол Улсын хувьд үүрэг гүйцэтгэхэд эдийн засгийн хувьд үүрэг гүйцэтгэгчид их хэмжээний хохирол учрахуйц, эсхүл үүрэг гүйцэтгэх нөхцөл нь эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл бий болгох үүргийг биелүүлэх боломжгүй байдлыг *Hardship* буюу хүнд нөхцөл гэж үзэж байгаа юм. Хэдийгээр дээрх нөхцөл байдлыг хүнд нөхцөл байдал гэж үзэж байгаа боловч Монгол Улсын ИХ-д хүнд нөхцөл байдлыг албан ёсоор тодорхойлсон зохицуулалт байхгүй байгаа бөгөөд шүүхээс энэ төрлийн маргааныг шийдвэрлэх үед ИХШХШтХ-ийн холбогдох зохицуулалтыг үндэслэн ИХ-ийн 221-ийг төсөөтэй хэрэглэж байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлыг хүндэтгэн үзэх үндэслэл гэж ИХ-ийн 221 дүгээр зүйлийн 221.2-т заасан байх ба хүндэтгэн үзэх шалтгаан байсан болох нь баримтаар тогтоогдсон нөхцөлд үүргээ биелүүлээгүй, хугацаа хожимдуулсан иргэн, хуулийн этгээдийг гэм буруугүй гэж үзэж хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болдог. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас үүссэн хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дараах байдлаар дүгнэлт хийлээ. Үүнд:

Хууль хэрэглээний хувьд:

1. Гэрээнд заасан хугацаанд үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаа хожимдуулсан нь хүндэтгэн үзэх шалтгаантай байсан бөгөөд нотлогдсон тохиолдолд гэм буруугүй гэж үзэж ИХ-ийн 221 дүгээр зүйлийн 221.2 дахь хэсэг ба гэрээний нарийвчилсан заалтыг хэрэглэн алданги, нэмэгдүүлсэн хүү төлөхөөс чөлөөлөн шийдвэрлэж байна.

2. Гэрээ цуцлах, гэрээнээс татгалзах үндэслэлүүдийг ялган тодорхойлж, гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэрээ цуцалсны үр дагаварт дүгнэлт хийж, цуцалсны дараах зээлийн үндсэн хүү, нэмэгдүүлсэн хүү төлөхөөс чөлөөлж шийдвэрлэсэн нь зөв байна. Гэвч анхаарах хэд хэдэн асуудал байна. Үүнд:

   - Шүүх гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал гэж дүгнэсэн байх боловч ИХ-

ийн 232 дугаар зүйлийн 232.8 дахь хэсэгт заасны дагуу алдангийн хэмжээг 50 хувь болон өөр хэмжээгээр багасгаж шийдвэрлэсэн байна. Харин ИХ-ийн 222 дугаар зүйлийн 222.1 дэх хэсгийг хэрэглэж алдангиас бүрэн чөлөөлөөгүй тухай дүгнэлт хийгээгүй;

- Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай НҮБ-ын конвенцыг хэрэглэсэн шийдвэр[103] манайд байх боловч хангалттай бус байна. Жишээ нь, Энэтхэг, Хятад улсаас бараа худалдах, худалдан авах явцад Ковид-19 цар тахал гарч гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсны улмаас үүссэн маргаан;[104]
- Шүүх нэг цаг хугацаанд, нэг орон нутагт, адил нөхцөлтэй байгуулагдсан гэрээний маргааныг өөр өөрөөр шийдвэрлэсэн нь ИХ-ийн 221 дүгээр зүйлийн 221.2 дахь хэсгийг нэг мөр ойлгож, хэрэглэхгүй байгааг харуулж байна. Жишээ нь, МХ сангийн нэхэмжлэлтэй хариуцагч Т ХХК,[105] ББГ ХХК-д[106] холбогдох хэрэг;
- ИХ-ийн 221 дүгээр зүйл болон бусад хэм хэмжээг шийдвэрийнхээ үндэслэх болох тогтоох хэсэгт заахгүй байна;

---

[103] ИССМ ХХК-ийн нэхэмжлэлтэй В ХХК-д холбогдох ажил гүйцэтгэх, түрээсийн гэрээний маргааны тухай Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 102/ШШ2019/00895 дугаартай шийдвэр (102/2017/02404/И).

[104] Н.Д-гийн нэхэмжлэлтэй хариуцагч Б.О, Л.Ө нарт холбогдох худалдах, худалдан авах гэрээний маргааны тухай Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 11 дүгээр сарын 11-ний 102/ШШ2020/03405 дугаартай шийдвэр (102/2020/03098/И).

[105] МХ сангийн нэхэмжлэлтэй хариуцагч Т ХХК-д холбогдох зээлийн гэрээний тухай Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 04 дүгээр сарын 30-ны 184/ШШ2019/01122 дугаартай шийдвэр (184/2019/00689/И).

[106] МХ сангийн нэхэмжлэлтэй ББГ ХХК-д холбогдох зээлийн гэрээний маргааны тухай Өвөрхангай аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатын шүүхийн 2019 оны 04 дүгээр сарын 02-ны 173 дугаартай шийдвэр (145/2018/00793/И).

3. Эдийн засгийн хүнд нөхцөл байдал тохиолдоход авах арга хэмжээг гэрээнд нарийвчлан заагаагүй тул ИХШХШтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг үндэслэн ИХ-ийн 221 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэж шийдвэрлэсэн хэрэг;[107]

4. Шүүх "Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимаас гаргасан гарын авлагад ....форс мажорт хамаарахгүй гэж заажээ"[108] гэж шийдвэрийнхээ үндэслэх хэсэгтээ заажээ. Ийнхүү шүүх МҮХАҮТ-ын гарын авлага хэрэглэж шийдвэр гаргасан нь хууль хэрэглэх зарчимд харш юм. Мөн шүүх шийдвэртээ "форс мажор", "force majeure", "hardship" зэрэг гадаад хэлээр бичигдсэн нэр томьёог галиглаж, эсхүл латин үсгээр бичиж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан "Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн", ИХШХШтХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг монгол хэлээр явуулж, төрийн албан хэрэг хөтлөх бичгээр бичиж баримтжуулна" зэрэг заалтыг зөрчиж байна гэж хэлж болохоор байна.

Нотлох баримт үнэлэх зарим ажиллагааны хувьд:

1. Шүүх гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын талаар хавтаст хэрэгт ямар нотлох баримт гаргасан, түүнийг хэрхэн үнэлсэн тухай шийдвэртээ заахгүй байна;

2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй зарим эргэлзээтэй нотлох баримтыг бүх талаас нь, бүрэн бодитой үнэ-

[107] ШТ ХХК-ийн нэхэмжлэлтэй ЭБЦТС ТӨХК-д холбогдох гэрээний маргаан (00844). http://new.shuukh.mn/irgendavah/3066/view

[108] К банкны нэхэмжлэлтэй АИ ХХК-д холбогдох гэрээний маргааны тухай Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 08 дугаар сарын 11-ний 4848 дугаартай шийдвэр (102/2016/00000/И).

лэхгүй байна. Жишээ нь, Ковид-19 цар тахалтай холбоотой үүссэн маргааныг шийдвэрлэхдээ түүний улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тухай нотлох баримтыг шүүхэд гаргаагүй, тайлбарыг үнэлэхгүй байх, эсхүл нийтэд илэрхий үйл баримт тул дахин нотлохгүй гэхчлэн дүгнэснээс хамааран нэмэгдүүлсэн хүү, алдангитай холбоотой шаардлагыг хангах, заримыг нь хангах, хэрэгсэхгүй болгох зэрэг шийдвэр гаргасан байна.

3. Шүүх "Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын тухай гэрээнд заагаагүй" гэх үндэслэлээр гэрээний хариуцлагаас чөлөөлөхгүй гэж шийдвэрлэж байна. Гэтэл уг нөхцөл байдлын улмаас гэрээний үүргийг биелүүлэх, үргэлжлүүлэх боломжгүй болсон нь бодитой буюу нотлогдож байдаг. Энэ тухай судалгааны 3.2 дахь хэсэгт дүгнэсэн болно.

4. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал тохиолдсон талаар тайлбарлаж, Ус, цаг уур, орчны шинжилгээний газар, Засаг даргын тодорхойлолт, гэрчийн мэдүүлэг зэрэг нотлох баримт хавтаст хэрэгт байгааг дурдсан боловч МҮХАҮТ-ын гэрчилгээ байхгүй тул уг нөхцөл байдлыг нотлоогүй гэж үзсэн байна. Энэ тухай судалгааны ажлын 3.3 дахь хэсэгт шүүхийн зарим шийдвэрт дүгнэлт хийсэн.

Шүүх нотлох баримтыг үнэлэхгүй, эсхүл бүрэн үнэлээгүй байх бөгөөд үнэлээгүй шалтгаан, үндэслэлээ шийдвэртээ заахгүй байгаа тухайд энэхүү судалгааны 3.4 дэх хэсгээс харж болно.

Шүүхийн шийдвэрт хийсэн судалгаа болон дээрх дүгнэлтийг үндэслэн дараах санал гаргаж байна. Үүнд:

1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас үүссэн тухайн маргаантай харилцаанд

хамаарах ИХ-ийн 221 дүгээр зүйл, олон улсын гэрээ, конвенц болон бусад хэм хэмжээг хэрэглэхдээ шүүхийн шийдвэрийн үндэслэх болон тогтоох хэсэгт зааж байх;

2. Шүүх "ИХ-ийн 204, 221, 225, 227 дугаар зүйл гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах аль ч үед хэрэглэгдэнэ. Харин ИХ-ийн 205 дугаар зүйлд гэрээнээс татгалзсанаас үүсэх үр дагаврыг зохицуулсан байх тул гэрээг цуцлахад хэрэглэгдэх зохицуулалт биш"[109] гэсэн зөвлөмжийг гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас үүссэн маргааныг хянан шийдвэрлэж, шийдвэр гаргахдаа анхаарч байх;

3. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн эсэх тухай тайлбар хийж, хавтаст хэрэгт авагдсан ямар нотлох баримтаар нотлогдож, эсхүл нотлогдохгүй байгаа тухай дүгнэлт хийх;

4. Зохигчид гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай нотлох баримтыг холбогдох байгууллагаас гаргуулж, нотлох баримтаар хавтаст хэрэгт хавсаргасан тохиолдолд шүүх МҮХАҮТ-аас гэрчилгээ дахин авахыг шаардах нь цаг хугацаа, хүнд суртал, чирэгдлийг нэмэгдүүлэх үр дагавар үүсгэж байгааг анхаарах;

5. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд авсан олон арга хэмжээ, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрийн улмаас нийгэм, эдийн засгийн олон салбарын үйл ажиллагаа доголдож, зарим үед зогсонги байдалд орсноор иргэн, хуулийн этгээд бусдын өмнө хүлээсэн үүргээ бүрэн болон зохих ёсоор биелүүлж чадахгүйд хүрсэн нь

[109] УДШ-ийн 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн зөвлөмжийн 2 дахь хэсэг.

шүүхийн шийдвэрт дүгнэлт хийх явцад тогтоогдож байна. Учир нь судалгаа хийсэн 117 шийдвэрийн 29.9 хувийг Ковид-19 цар тахалтай холбоотой шийдвэр эзэлж байх тул Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны тайланд тухайн жил, улиралд хэдэн хэрэг хянан шийдвэрлэсэн талаар тусгах шаардлагатай байна. Энэ нь Ковид-19 цар тахалтай холбоотой нийгэм, эдийн засгийн хямрал, хүндрэл бэрхшээлийн үр дагаврыг багасгах, арилгах чиглэлээр төрийн болон бусад байгууллагаас хэрэгжүүлэх үйл ажиллагаа, авах арга хэмжээг тодорхойлоход чухал нөлөө үзүүлж болох юм.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Дүн шинжилгээ хийсэн шийдвэр

1. А ББСБ ХХК-ийн нэхэмжлэлтэй хариуцагч О.М, Д.А нарт холбогдох зээлийн гэрээний маргааны тухай Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 183/ШШ2020/00435 дугаартай шийдвэр (182/2019/01390/И).
2. А ББСБ ХХК-ийн нэхэмжлэлтэй хариуцагч О.М, Д.А нарт холбогдох зээлийн гэрээний маргааны тухай Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 05 дугаар сарын 11-ний 210/МА2020/01022 дугаартай магадлал (182/2019/01390/И).
3. Б.А-гийн нэхэмжлэлтэй “ТТ” ХХК-нд холбогдох аялал жуулчлалын гэрээний маргааны тухай Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 04-ний 1936 дугаартай шийдвэр (182/2018/02096/И).
4. ЖДҮГ-ын нэхэмжлэлтэй хариуцагч ТНУК ХХК, иргэн Б.Э, Э.У, Ш.М, Ө.М, Д.Д нарт холобгдох гэрээний маргааны тухай БЗД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 02 дугаар сарын 10-ны 101/ШШ2021/00525 дугаартай шийдвэр (101/2020/04207/И).
5. Зэвсэгт хүчний ... дугаар ангийн нэхэмжлэлтэй Д.Б, В.М, Г.Р нарт холбогдох хөлсөөр ажиллах гэрээний маргааны тухай Орхон аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 27-ны 00008 дугаартай шийдвэр (142/ШШ2018/00008).

6. ИССМ ХХК-ийн нэхэмжлэлтэй Ватт ХХК-д холбогдох гэрээний маргааны тухай Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 102/ШШ2019/00895 дугаартай шийдвэр (102/2017/02404/И).
7. МХ сангийн нэхэмжлэлтэй хариуцагч Т ХХК-д холбогдох зээлийн гэрээний үүрэгт 1,500,000,000 төгрөг гаргуулах хэргийн тухай Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 04 дүгээр сарын 30-ны 184/ШШ2019/01122 дугаартай шийдвэр (184/2019/00689/И).
8. Н ХХК-ийн нэхэмжлэлтэй Ч.Б-д холбогдох худалдах, худалдан авах болон арилжааны гэрээний маргааны тухай Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 16-ны 2514 дугаартай шийдвэр (183/2017/02805/И).
9. Н.Д-гийн нэхэмжлэлтэй хариуцагч Б.О, Л.Ө нарт холбогдох гэрээний маргааны тухай Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 11 дүгээр сарын 11-ний 102/ШШ2020/03405 дугаартай шийдвэр (102/2020/03098/И).
10. ОБГ-ын нэхэмжлэлтэй ТӨ ХХК-нд холбогдох худалдах, худалдан авах гэрээний маргааны тухай Дархан-Уул аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 06 дугаар сарын 06-ны 666 дугаартай шийдвэр (135/2018/00611/N/).
11. ОБЕГ-ын нэхэмжлэлтэй М ХХК-д холбогдох худалдах, худалдан авах гэрээний маргааны тухай Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 02 дугаар сарын 02-ны 183/ШШ2021/00285 дугаартай шийдвэр (183/2020/1181/И).
12. ОИ ББСБ-ын нэхэмжлэлтэй Ч.Б-д холбогдох Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн гэрээний маргааны тухай Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 10 дугаар сарын 25-ны 2299 дугаартай шийдвэр (183/ШШ2017/02299).
13. ОИ ББСБ-ын нэхэмжлэлтэй Ч.Б-д холбогдох Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн

гэрээний маргааны тухай Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 01 дүгээр сарын 22-ны 00266 дугаартай магадлал (183/2017/02412/И).

14. ОИ ББСБ-ын нэхэмжлэлтэй Ч.Б-д холбогдох Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн гэрээний маргааны тухай Улсын Дээд шүүхийн 2018 оны 05 дугаар сарын 08-ны 001/ХТ2018/00733 дугаартай тогтоол.
15. П ББСБ ХХК-ийн нэхэмжлэлтэй Э.Б-д холбогдох зээлийн гэрээний тухай Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 09 дүгээр сарын 30-ны 183/ШШ2020/02623 дугаартай шийдвэр (183/2020/02876/И).
16. П ББСБ ХХК-ийн нэхэмжлэлтэй Э.Б-д холбогдох зээлийн гэрээний тухай 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 00125 дугаартай магадлал (183/2020/02876/И).
17. С ХХК-ийн нэхэмжлэлтэй АП ХХК-д холбогдох худалдах, худалдан авах гэрээний маргааны тухай Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 05 дугаар сарын 05-ны 181/ШШ2020/01180 дугаартай шийдвэр (181/2020/00733/И).
18. С ХХК-ийн нэхэмжлэлтэй АП ХХК-д холбогдох худалдах, худалдан авах гэрээний маргааны тухай Нийслэлийн Иргэ-ний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 06 дугаар сарын 22-ны 1343 дугаартай магадлал (181/2020/00733/И).
19. СГ-гийн нэхэмжлэлтэй УАӨСЗД-д холбогдох ажил гүйцэтгэх гэрээний маргааны тухай Увс аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 29-ний 933 дугаартай шийдвэр (152/2018/00897/И/).
20. Т банкны нэхэмжлэлтэй ГГУ ХХК, ГХУ ХХК, Б.А, Өмнөговь аймгийн ИТХ-д холбогдох зээлийн гэрээний тухай Өмнөговь аймгийн Эрүү, иргэний давж заалдах шатны шүүхийн 2017 оны 01 дүгээр сарын 10-ны 20 дугаартай шийдвэр (143/2016/00354/И).
21. Т банкны нэхэмжлэлтэй ГГУ ХХК, ГХУ ХХК, Б.А, Өмнөговь аймгийн ИТХ-д холбогдох зээлийн гэрээний тухай Өмнөговь

аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 03 дугаар сарын 09-ний 10 дугаартай магадлал (240/2017/0400/И).

22. Т банкны нэхэмжлэлтэй ГГУ ХХК, ГХУ ХХК, Б.А, Өмнөговь аймгийн ИТХ-д холбогдох зээлийн гэрээний тухай Монгол Улсын Дээд шүүхийн 2017 оны 06 дугаар сарын 06-ны 001/ХТ2017/00742 дугаартай тогтоол (143/2016/00354/И).
23. Ш ХХК-ийн нэхэмжлэлтэй Б төв ХХК-д холбогдох худалдах, худалдан авах гэрээний тухай Төв аймгийн сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 12 дугаар сарын 13-ны 151/ШШ2016/01288 дугаартай шийдвэр (151/2016/01050/И).
24. Ш ХХК-ийн нэхэмжлэлтэй Б төв ХХК-д холбогдох худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой хэргийн тухай Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 02 дугаар сарын 16-ны 223/МА2017/00004 дугаартай магадлал (151/2016/01050/И).
25. Ш ХХК-ийн нэхэмжлэлтэй Б төв ХХК-д холбогдох худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой хэргийн тухай Монгол Улсын Дээд шүүхийн 2017 оны 05 дугаар сарын 19-ний 001/ХТ2017/00663 дугаартай тогтоол (151/2016/01050/И).
26. Т.Б-гийн нэхэмжлэлтэй ЭГБ сургалтын байгууллагад холбогдох сургалтын төлбөр гаргуулах иргэний хэргийн тухай Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 09 дүгээр сарын 30-ны 183/ШШ2020/02603 дугаартай шийдвэр (183/2020/02606/И).
27. Т.Б-гийн нэхэмжлэлтэй ЭГБ сургалтын байгууллагад холбогдох сургалтын төлбөр гаргуулах иргэний хэргийн тухай Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 12 дугаар сарын 07-ны 210/МА2020/02299 дугаартай магадлал (183/2020/02606/И).
28. Х ХХК-ийн нэхэмжлэлтэй хариуцагч Д.Э, Б.А, Ш.О нарт холбогдох гэрээний маргааны тухай БЗД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 01 дүгээр арын 29-ний 101/ШШ2021/0380 дугаартай шийдвэр (101/2020/04330/И).

29. ЧТ ХХК-ийн нэхэмжлэлтэй Увс аймгийн УДХС ТӨХК-д холбогдох гэрээний маргааны тухай Увс аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 05 дугаар сарын 13-ны 184 дугаартай шийдвэр (152/2019/00115/И).
30. ШТ ХХК-ийн нэхэмжлэлтэй ЭБЦТС ТӨХК-д холбогдох цахилгаан эрчим хүчээр хангах, түүнийг хэрэглэх гэрээний маргааны тухай Орхон аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 06 дугаар сарын 16-ны 00844 дугаартай шийдвэр (142/2016/00775/И).
31. ШТ ХХК-ийн нэхэмжлэлтэй ЭБЦТС ТӨХК-д холбогдох цахилгаан эрчим хүчээр хангах, түүнийг хэрэглэх гэрээний маргааны тухай Орхон аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 09 дүгээр сарын 06-ны 00144 дугаартай магадлал (142/2016/00775/И).

Бусад шийдвэр

1. ДЧ-гийн нэхэмжлэлтэй ЧН-д холбогдох гэрээний маргааны тухай Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 05 дугаар сарын 05-ны 182/ШШ2020/00984 дугаартай шийдвэр (182/2020/00975/И).
2. К банкны нэхэмжлэлтэй АИ ХХК-д холбогдох гэрээний маргааны тухай Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 08 дугаар сарын 11-ний 4848 дугаартай шийдвэр (102/2016/00000/И).
3. МВС ХХК-ийн нэхэмжлэлтэй ААК ХХК-д холбогдох гэрээний маргааны тухай Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 00128 дугаартай магадлал (183/2019/02560/И).
4. МК ХХК-ийн нэхэмжлэлтэй Ш.З-д холбогдох гэрээний маргааны тухай Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 10 дугаар сарын 17-ны 5458 дугаартай шийдвэр (102/2016/06591/И).

5. МП ХХК-ийн нэхэмжлэлтэй АХ ХХК-д холбогдох гэрээний маргааны тухай Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 07 дугаар сарын 04-ний 404 дугаартай шийдвэр (101/2016/4622/И).
6. МХ сангийн нэхэмжлэлтэй ББГ ХХК-д холбогдох зээлийн гэрээний маргааны тухай Өвөрхангай аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 04 дүгээр сарын 02-ны 173 дугаартай шийдвэр (145/2018/00793/И).
7. О сумын хүүхдийн цэцэрлэгийн нэхэмжлэлтэй ЦС ХХК-д холбогдох ажил гүйцэтгэх гэрээний маргааны тухай Завхан аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 111 дугаартай шийдвэр (140/2015/00039/И).
8. ПО ХХК-ийн нэхэмжлэлтэй ДМ-д холбогдох түрээсийн гэрээний маргааны тухай Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 00803 дугаартай шийдвэр (182/2018/02456/И).
9. С.О-гийн нэхэмжлэлтэй Н.Н-д холбогдох гэм хор учруулснаас эд хөрөнгийн хохирол гаргуулах тухай Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 04 дүгээр сарын 27-ны 01003 дугаартай шийдвэр (184/2017/01247/И).
10. ТБ ХХК-ийн нэхэмжлэлтэй Э ХХК-д холбогдох гэрээний маргааны тухай Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 1169 дугаартай шийдвэр (102/2020/00768/И).
11. Э Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын нэхэмжлэлтэй А ХХК-д холбогдох гэрээний маргааны тухай Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 10 дугаар сарын 31-ний 184/ШШ2019/02761 дугаартай шийдвэр (184/2019/01956/И). http://new.shuukh.mn/irgenanhan/88802/view (Хамгийн сүүлд зочилсон: 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдөр).

Хууль

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
2. Ашигт малтмалын тухай хууль (шинэчилсэн найруулга), 2006 он.
3. Барилгын тухай хууль, 2016 он.
4. Гаалийн тухай хууль (шинэчилсэн найруулга), 2008 он.
5. Иргэний хууль, 2002 он.
6. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он.
7. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, 2020 он.
8. Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай НҮБ-ын конвенц, 1997 он.
9. Татварын ерөнхий хууль (шинэчилсэн найруулга), 2019 он.

Эрх зүйн бусад акт

1. Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 33 дугаар тогтоол буюу Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай тогтоол.
2. Монгол Улсын Дээд шүүхийн 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай зөвлөмж.
3. Монгол Улсын Дээд шүүхийн 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн” Гэрээний зарим эрх зүйн маргааны хууль хэрэглээ болон гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахад анхаарах асуудлууд” зөвлөмж.

Ном, сурах бичиг

1. Бат-Эрдэнийн Буянхишиг. Үүргийн эрх зүйн ерөнхий анги. (Анхны хэвлэл), 2013 он.
2. С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг, Dictionary of Law (Гурав дахь хэвлэл), 2011 он.

3. Д.Наранчимэг. Иргэний эрх зүйн үндсэн асуудал. I дэвтэр, 1999 он.
4. О.Жамбалдорж нар. Монгол Улсын Иргэний эрх зүй (Эдийн баялгийн эрх, Оюуны өмчийн эрх зүй). II дэвтэр, 2006 он.
5. Й.Кают. Монгол Улсын шинэ иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй (Шүүхийн шийдвэр, тогтоол бичих арга техник), гарын авлага. 2015 он.
6. Й.Кают. Монгол Улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, 2015 он.
7. Т.Мөнхжаргал. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, 2008 он.
8. Ж.Оюунтунгалаг. Иргэний эрх зүй (ерөнхий анги), 2020 он.
9. Шинжлэх ухааны академийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэн, Хууль зүйн судалгааны төв, Процессын эрх зүй (онол, туршлага). 2013 он.
10. Шинжлэх ухааны академийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэн, Хууль зүйн судалгааны төв, Процессын эрх зүйн толь (гарын авлага). 2014 он.

Гадаад эх сурвалж

1. Almeida Prado. Le Hardship dans Le Droit du Commerce International, Bruxelles, Feduci, Bruylant, 2003, 45-47 дахь тал. https://www.persee.fr/doc/ridc_0035-3337_2006_num_58_4_19496_t12_1295_0000_1.
2. Atamer. Satıcının Sözleşmeye Aykırı Davranışı Ekseninde CISG'ın İfa Engelleri Sisteminde Genel Bakış. Milletlerarası Satım Hukuku, 1. Baskı, İstanbul, XII Levha Yayınları, 2008. https://dergipark.org.tr/en/download/article-file/826122.
3. Başak Baysal. Sözleşmenin Uyarlanması, 1.Baskı, XII Levah Yayınları, İstanbul, 2009.
4. Brunner. Force Majeure and Hardship Under General Contract Principles, Exemption for Non-Performance in International Arbitration, The Hague,

Kluwer Law International, 2009. https://www.trans-lex.org/100970/_/exemption-for-non-performance-in-international-arbitration-2009/.

5. Гражданский кодекс Российской Федерации от 21 октярбря 1994 года, URL: https://ivo.garant.ru/#/document/10164072/paragraph/2056:0
6. David Rene. Frustration of Contract in French Law, Comparative Legislation and International Law, Vol. XXVIII, I. 3-4 дэх тал. https://www.jstor.org/stable/754645.
7. Draetta. Force Majeure Clauses in International Trade Practice - La Force Majeure dans la Pratique du Commerce International", **International Trade Practice**. https://heinonline.org/HOL/AuthorProfile?collection=journals&search_name=Draetta,%20Ugo&base=js.
8. Kokarin, I./Van der Weide, J.: Force Majeure and Unforeseen Change of Circumstances. The Case of Embargoes and Currency Fluctations (Russian, German and French Approaches), "Russian Law" Journal, Vol. III, I. 3, 72 дахь тал. https://www.russianlawjournal.org/jour/article/view/94/103.
9. Mustafa Dural. Borçlunun Sorumlu Olmadığı Sonraki İmkansızlık (BK.117), Fakülteler Matbaası, İstanbul, 1976.
10. Puelinckx. Frustration, Hardship, Force Majeure, Imprévision, Wegfall der Geschäftsgrundlage, Unmöglichkeit, Changed Circumstances A Comperative Study in English, French, German and Japanese Law, "Journal of International Arbitration", Vol. III, I. 2, 47-66 дахь тал. https://www.trans-lex.org/128100/_/puelinckx-ah-frustration-hard ship-force-majeure-imprévision-wegfall-der-geschäftsgrundlage-unmöglichkeit-changed-circumstances-3-jintl-arb-1986-no-2-at-47-et-seq/.
11. Rivkin. Lex Mercatoria and Force Majeure, Transnational Rules in International Commercial Contracts, International Chamber of Commerce, Publication no. 480/4, 1993. https://www.trans-lex.org/116100/_/rivkin-david-r-lex-mercatoria-and-force-majeure-in:-gaillard-transnational-rules-in-international-commercial-arbitration-paris-1993-at-161-et-seq/.
12. Söğütlü Erişgin, Özlem. Roma Hukukunda Contractus (Sözleşme) Kavramı ve Sözleşmesel Sorumluluk Ölçütleri, Ankara, 2016.

13. Постановление Пленума Верховного Суда РФ от 24 марта 2016 г. N7 “О применении судами некоторых положений Гражданского кодекса Российской Федерации об ответственности за нарушение обязательств”. URL: http://ivo.garant.ru/#/document/71360358/paragraph/1:2 (дата обращения: 06.06.2021).
14. Яровенко Василий Григорьевич. Всё, что нужно знать о непреодолимой силе (форс-мажоре). URL: https://zakon.ru/blog /2020/7/27/ nepreodolimaya_sila_forsmazhor_aktualnye_voprosy_sudebnaya_praktika_podborka_primernyh_uslovij_dogo.

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ХАРИУЦСАН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

ДАШНЯМЫН ЗОЛЖАРГАЛ (LL.M., MBA)

Өмгөөллийн DB&GTS ХХН-ийн гишүүн хуульч

Өмгөөллийн DB&GTS ХХН-ийн Гүйцэтгэх захирал тэрээр Монголын санхүү, банк, хөрөнгийн зах зээлийн чадварлаг мэргэжилтний нэг бөгөөд компанийн эрх зүй, эрчим хүч, эрдэс баялгийн салбараар мэргэшсэн хуульч юм. Хуулийн зөвлөх үйлчилгээний хувийн салбарт 15 дахь жилдээ ажиллаж байгаа. Түүнээс өмнө Монголын томоохон арилжааны банканд хуульчаар ажиллахын зэрэгцээ МУИС-ийн Хууль зүйн сургууль, "Билиг" дээд сургуульд хичээл зааж байсан туршлагатай. МУИС-ийн Хууль зүйн сургуулийг олон улсын эрх зүйн бакалавр, АНУ-ын Оклахомагийн Их сургуулийг бизнесийн удирдлагын магистр, АНУ-ын Харвардын Их сургуулийн Хуулийн сургуулийг хууль зүйн магистр зэрэгтэй түс түс дүүргэсэн. Chambers & Partners, Legal500, IFLR зэрэг олон улсын хуульчдын зэрэглэл тогтоодог байгууллагаас Д.Золжаргал, түүний удирдаж ирсэн хуулийн фирмийг олон жилийн турш өндөр үнэлсэн байдаг.

АЛТАНГЭРЭЛИЙН БЯМБАЖАРГАЛ (S.J.D.)

МУИС-ийн Хууль зүйн сургуульд төрийн захиргаа, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй, Үндсэн хуулийн процессын эрх зүй, харьцуулсан эрх зүйн хичээл заадаг. Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн даргын хувиар эрдэм шинжилгээний ажил, бүтээл туурвил, улирал тутмын "Эрх зүй" сэтгүүлийг эрхлэн гаргах ажил хариуцан ажиллаж байв. 2021 оноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөхөөр томилогдон ажиллаж байна.

МУИС-ийн Хууль зүйн сургуулийг дүүргэж, БНСУ-ын Күүкминий Их сургуульд хууль зүйн докторын зэрэг хамгаалсан.

НАРАНЧУЛУУНЫ ОТГОНЧИМЭГ (LL.M.)

Захиргааны эрх зүйн чиглэлээр мэргэшсэн судлаач бөгөөд УДШ-ийн Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал, УИХ-ын Тамгын газар, олон улсын хөгжлийн хөтөлбөрүүдэд зөвлөх зэргээр мэргэжлээрээ 23 жил ажилласан туршлагатай хуульч юм. 2021 оны 11 дүгээр сараас Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна. МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр магистрын зэрэгтэй, Лондоны Kings college-ийг хууль зүйн магистр зэрэгтэй төгссөн.

ГАНЧУЛУУНЫ ОЮУНБОЛД (LL.M.)

Криминологи, эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын чиглэлээр мэргэшин судалдаг ба практик болон судалгааны байгууллагад 20 жил ажилласан туршлагатай. Цагдаагийн академийг эрх зүйч, Хүмүүнлэгийн ухааны Их сургуулийг англи хэл-менежерийн бакалавр зэрэгтэй төгсөж, 2007 онд "Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хугацаа" сэдвээр хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан. Түүнчлэн академик болон бодлогын судалгааны чиглэлээр дангаар, бусадтай хамтран 40 орчим судалгааны ажил, 20 гаруй сурах бичиг, гарын авлага боловсруулж нийтийн хүртээл болгосон. Хуульч, хууль сахиулагчийг чадавхжуулах хүрээнд 10 орчим жил сургагч багшаар ажиллаж байна.

СҮХЭЭГИЙН БИЛГҮҮН (LL.M.)

Тэрээр хууль зүйн судалгаа, сургалт, шүүхийн захиргааны чиглэлээр ажилладаг.

МУИС-ийн Хууль зүйн сургуульд суралцаж "Монгол Улсад эрх зүйн зайлшгүй процессыг төлөвшүүлэх нь" сэдвээр, Япон Улсын Кьюшюгийн Их сургуульд суралцаж "Монгол Улс дахь нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалах тогтолцоог бэхжүүлэх нь" сэдвээр хууль зүйн магистрын зэрэг түс түс хамгаалсан. Харьцуулсан эрх зүй, хүний эрхийн чиглэлээр судалгаа хийдэг.

ISBN 978-9919-9926-3-7